МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТУШААЛ ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудын албан хэрэгцээнд зориулав*

УЛААНБААТАР ХОТ
2017 он

# АГУУЛГА


1. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122 дугаар конвенц 4
2. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 88 дугаар конвенц 8
3. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181 дүгээр конвенц 15
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (шинэчилсэн найруулга) 23
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 47
6. Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 59
7. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 79
8. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 109
9. Эдийн засгийг сэргээх хөтөлбөр батлах тухай 128
10. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2015-2025 он 134
11. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам 142
12. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам батлах тухай 160
13. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам 166
14. Азийн хөгжлийн банкны Ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд эргэн төлөгдсөн эх үүсвэрээс зээл олгох журам шинэчлэн батлах тухай 167
15. Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журмыг шинэчлэн батлах тухай 171
16. Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175
17. Ажил, мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх чиглэл /2016-2020 он/ батлах тухай 176
18. Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам батлах тухай 184
19. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам батлах тухай 190
20. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай 199
21. Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай 226
22. Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх тухай 230
23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай 234
24. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж батлах тухай 241
25. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний гэрээний загвар, тайлангийн маягт батлах тухай. 260
26. Статистик мэдээлэл 314

# МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГЫН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 122 ДУГААР КОНВЕНЦ

*(Монгол улс 1976 онд соёрхон баталсан.)*

1964 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталж, 1966 оны 7 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон*

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь,

Олон улсын хөдөлмөрийн товчооны Удирдах Зөвлөлөөс 1964 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Женев хотноо зарлан хуралдуулсан 48 дугаар чуулганаараа,

бүх нийтээр ажил, хөдөлмөр эрхэлж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилт бүхий хөтөлбөрийг дэлхийн улс орнуудад хэрэгжүүлэхэд дэмжиж идэвхжүүлэх үүргийг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага өөртөө хүлээснийг Филадельфийн тунхаглалд сайшаасан болон ажилгүйдэлтэй тэмцэх, амьжиргааны хэвийн нөхцлийг хангахуйц хөдөлмөрийн хөлсний баталгааг бүрэлдүүлэхийн чухлыг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн оршил хэсэгт заасныг анхааралдаа авч,

“Бүх хүн, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйсний ялгаанаас үл хамааран эрх чөлөө, нэр төр, тэгш боломж, эдийн засгийн найдвартай байдлын нөхцөлд өөрийн оюун санааны хөгжил болон материаллаг аж байдлыг хангуулах эрх эдэлнэ” гэж уг тунхаглалын үндсэн зорилт болон зарласны дагуу хөдөлмөр эрхлэлтийн бодлогод эдийн засаг, санхүүгийн бодлогын асуудлын нөлөөллийг авч үзэж судлах нь Филадельфийн тунхаглалыг хэрэгжүүлэхэд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гүйцэтгэх үүрэг мөн болохыг анхааралдаа авч,

“Хүн бүр ажилгүйдлээс хамгаалуулах, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлд хийх ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх эрхээ эдэлнэ” хэмээн Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасныг анхааралдаа авч,

хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой шууд холбоо бүхий харилцааг зохицуулах чиглэлээр үйлчилж буй олон улсын хөдөлмөрийн конвенц, зөвлөмж, ялангуяа Хөдөлмөр эрхлэлтийн албаны тухай конвенц, зөвлөмж, Мэргэжлийн чиг баримжааны тухай 1949 оны зөвлөмж, Мэргэжлийн сургалтын тухай 1962 оны зөвлөмж, Алагчилахгүй байх /ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/ тухай конвенц, зөвлөмж зэргийг харгалзан,

эдгээр эрхийн акт нь үр бүтээлтэй, бүрэн, чөлөөтэй ажил эрхлэлтийн бодлогын үндсэн дээр эдийн засгийн хөгжлийн олон улсын хөтөлбөрийн илүү өргөн хүрээний асуудалд багтах ёстойг харгалзан,

хөдөлмөр эрхлэлтийн бодлогын асуудлыг тус Чуулганаар авч хэлэлцсэний үндсэн дээр түүнийг олон улсын конвенц хэлбэрээр хүлээн авахаар шийдвэрлэж,

нэг мянга есөн зуун жаран дөрвөн оны долдугаар сарын есний өдөр дараахь конвенцийг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 1964 оны конвенц гэж нэрлэхээр тохиролцон батлав:

* Монгол Улс 1976.11.24-нд соёрхон батласан.

*1 дүгээр зүйл*

1. Гишүүн орон бүр бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийг устгах, ажиллах хүчний хэрэгцээг хангах, амьдралын түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжил, түүний өсөлтийг урамшуулах зорилгоор үр ашигтай, бүрэн, чөлөөт хөдөлмөр эрхлэлтийн сонголтод дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн идэвхтэй бодлогыг гол зорилго болгон зарлаж, хэрэгжүүлнэ.

2. Энэ бодлого нь дараахь зорилтыг хангахад чиглэгдэнэ:

(a) ажил эрж байгаа ба ажилд ороход бэлэн бүх хүнийг зохих ажлаар хангах,

(b) уг ажил нь бүтээлч шинж чанартай байх явдлыг хангах,

(c) ажилчдыг арьс өнгө, шашин шүтлэг, улс төрийн үзэл, нийгмийн байдал, гарал үүсэл, хүйсээр үл ялгаварлан өөрт нь тохирох ажлаар хангаж, ажил сонгож авах эрх чөлөөг эдлүүлэн, ажилчин бүрийг мэргэжил эзэмших буюу авьяас чадлаа дүүрэн ашиглах бололцоогоор хангана.

3. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого нь эдийн засгийн хөгжлийн хэмжээ, үе шат, ажил эрхлэлтийн талаархи зорилго болон нийгэм, эдийн засгийн бусад бодит зорилгуудын хоорондын холбоо уялдааг зохих ёсоор тусгах ба энэ нь үндэсний нөхцөл байдал, практик үйл ажиллагаатай нийцүүлж хэрэгжүүлнэ.

*2 дугаар зүйл*

Гишүүн орон бүр өөрийн үндэсний нөхцөл байдалд нийцсэн аргын тусламжтайгаар дараахь зүйлийг хийнэ:

(a) 1 дүгээр зүйлд тодорхойлсон зорилтыг биелүүлэхийн тулд, нийгэм, эдийн засгийнхаа бодлоготой уялдуулсан арга хэмжээг авч цаашид хянан өөрчилж байна.

(b) дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд, шаардлага гарсан нөхцөлд нарийвчилсан хөтөлбөр боловсруулах арга хэмжээ авна.

*3 дугаар зүйл*

Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор авч явуулах арга хэмжээнүүдэд хамаарагдах хүмүүс ялангуяа ажил олгогч ба ажилчин тэдний төлөөлөгчдийн харилцан туршлага солилцуулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор ажил эрхлэлтийн бодлогын талаар явуулах зөвлөгөөнд нэг адил оролцуулж байна.

*4 дүгээр зүйл*

Энэхүү Конвенцийг соёрхон батласан тухай албан ёсны баримт бичгийг Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд бүртгүүлэхээр илгээнэ.

*5 дугаар зүйл*

1. Энэхүү Конвенц нь соёрхон батласан тухай батламж жуух бичгээ Ерөнхий захиралд бүртгүүлсэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн улсуудын хооронд үйлчилнэ.

2. Энэхүү Конвенц Ерөнхий захирал гишүүн хоёр улсын соёрхон батласан тухай батламж жуух бичгийг бүртгэснээс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

3. Түүнээс хойш энэхүү Конвенц аливаа гишүүн улсын хувьд соёрхон батласан тухай батламж жуух бичгээ бүртгүүлсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа тус тус хүчин төгөлдөр болно.

*6 дугаар зүйл*

1. Энэхүү Конвенцийг соёрхон батласан аливаа гишүүн улс түүнийг анх хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жилийн дараа Конвенцийг цуцлах тухай хүсэлтээ Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд илгээн бүртгүүлснээр Конвенцийг цуцалж болно. Цуцлалт тухайн хүсэлтийг бүртгэснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Конвенцийг соёрхон батласан аливаа гишүүн улс өмнөх хэсэгт дурдсан арван жилийн хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор энэ зүйлд заасан Конвенцийг цуцлах эрхийг хэрэгжүүлээгүй тохиолдолд дараагийн арван жилийн хугацаанд уг Конвенцийг дагаж мөрдөх бөгөөд цаашид энэ зүйлд тодорхойлсон журмын дагуу арван жил дуусах бүр тус Конвенцийг цуцлах эрхтэй байна.

*7 дугаар зүйл*

1. Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн улсаас хүлээн авсан соёрхон батласан тухай батламж жуух бичиг, мэдэгдэл болон цуцлалтын бүртгэлийн тухай гишүүн улс бүрт мэдэгдэнэ.

2. Ерөнхий захирал соёрхон батласан тухай хоёр дахь батламж жуух бичгийг хүлээн авч бүртгэсэн талаар Байгууллагын гишүүн улсуудад мэдэгдэхдээ энэхүү Конвенц хүчин төгөлдөр болох он, сар, өдрийг сануулна.

*8 дугаар зүйл*

Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал өмнөх зүйлүүдэд заасан журмаар бүртгэсэн соёрхон батласан тухай батламж жуух бичиг, мэдэгдэл болон цуцлалтын тухай бүрэн мэдээг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлд заасан ёсоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлэхээр илгээнэ.

*9 дүгээр зүйл*

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай хэмээн үзэх бүртээ энэхүү Конвенцийн хэрэгжилтийн талаар Ерөнхий Бага хуралд илтгэн, улмаар бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хянаж өөрчлөх асуудлыг Бага хурлаар хэлэлцүүлэхээр оруулах тухай шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл

1. Энэхүү Конвенцийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хянан өөрчилсөн шинэ Конвенцийг Бага хурлаар баталж, тэрхүү Конвенцид өөрөөр заагаагүй бол:

(a) Хянан өөрчилсөн шинэ Конвенц хүчин төгөлдөр болох тохиолдолд аливаа гишүүн улсын хувьд түүнийг соёрхон баталмагц энэхүү Конвенц нь дээрх 9 дүгээр зүйлийн заалтаас үл харгалзан нэн даруй /ipso jure/ хүчингүй болно.

(b) Хянан өөрчилсөн шинэ Конвенц хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн энэхүү Конвенцийг гишүүн улсууд соёрхон батлахыг зогсооно.

2. Энэхүү Конвенц нь түүнийг соёрхон батласан бөгөөд хянан өөрчилсөн шинэ Конвенцийг соёрхон батлаагүй гишүүн улсын тухайд аливаа тохиолдолд хэлбэр, агуулгын хувьд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

*11 дүгээр зүйл*

Энэхүү Конвенцийн англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 88 ДУГААР КОНВЕНЦ

*(Монгол улс 2016 онд соёрхон баталсан.)*

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь,

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөхөөс 1948 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Сан-Франциско хотноо зарлан хуралдуулсан гучин нэгдүгээр чуулганаараа,

Чуулганы хэлэлцэх хэргийн дөрөв дэх асуудал болсон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах талаар тодорхой саналыг батлахаар шийдвэрлэж,

эдгээр саналыг олон улсын конвенцийн хэлбэрт оруулахаар шийдвэрлэж,

нэг мянга есөн зуун дөчин найман оны долдугаар сарын есний энэ өдөр доорх конвенцийг Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 1948 оны конвенц гэж нэрлэхээр тогтож батлав:

### *1 дүгээр зүйл*

1. Энэхүү конвенцид оролцогч Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр хөдөлмөр эрхлэлтийн улсын үнэ төлбөргүй үйлчилгээг зохион байгуулах буюу зохион байгуулалтыг нь хангана.

2. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үндсэн үүрэг нь хөдөлмөрийн зах зээлийн хамгийн боломжой шилдэг зохион байгуулалтыг хүн амын бүрэн хөдөлмөр эрхлэлтийн бий болгож, бэхжүүлэх ба үйлдвэрлэх хүчийг хөгжүүлж, ашиглахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийн салшгүй хэсэг болгон шаардлагатай үед төрийн болон төрийн хувийн хэвшлийн холбогдох этгээдүүдтэй хамтран хангах явдал мөн.

### *2 дугаар зүйл*

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь үндэсний эрх бүхий байгууллагын удирдлага доор ажиллах хөдөлмөрийн товчооны үндэсний тогтолцооноос бүрдэнэ.

### *3 дугаар зүйл*

1.Уг тогтолцоо нь тухайн улсын газар зүйн хэсэг бүрт үйлчлэхэд хангалттай тооны, мөн ажил олгогчид ба ажилчдын хувьд тохиромжтой байрлал бүхий орон нутгийн болон зохистой тохиолдолд бүс нутгийн товчоодын сүлжээнээс бүрдэнэ.

(а) Уг сүлжээний зохион байгуулалтыг :

(i) эдийн засгийн үйл ажиллагааны болон ажил эрхлэгч хүн амын хуваарилалтанд томоохон өөрчлөлт гарсан тухай бүр,

(ii) туршилтын хугацаанд хуримтлуулсан туршлагаа үнэлэхэд хяналт шаардлагатай гэж эрх бүхийн байгууллага үзсэн тухай бүр хянан үзнэ.

(b)Ийнхүү хянан үзсэний үр дүнд хянан өөрчлөн шаардлагатай гэж үзсан бол хянан өөрчилнө.

*4 дүгээр зүйл*

1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулж, үйл ажиллагааг нь хангах, мөн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний бодлогыг боловсруулахад ажил олгогчид ба ажилчдын төлөөлөгчдийг хамтран ажиллуулахын тулд зөвлөх хороодын тусламжтайгаар зохих арга хэмжээ авна.

2. Иймд арга хэмжээний хүрээнд нэг буюу түүнээс дээш үндэсний зөвлөх хороо, шаардлагатай бол бүс нутгийн ба орон нутгийн зөвлөх хороондыг байгуулна.

3. Эдгээр хорооны бүрэлдэхүүнд орох ажил олгогчид ба ажил олгогчдын төлөөлөгчдийг нь ажил олгогчид ба ажилчдын төлөөлөгчдийн байгууллагуудтай (хэрэв ийм байгууллага байдаг бол) зөвлөлдсөний дараа тэнцүү тооны харьцагаар томилно.

*5 дугаар зүйл*

Ажлын сул орон тоонд ажилчдын томилох асуудалтай холбогдсон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ерөнхийн бодлогыг энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлд тусгагдсан зөвлөх хороодын тусламжтайгаар ажил олгочид ба ажилчдын төлөөлөгчидтэй зөвлөлдсөний дараа боловсруулна.

*6 дугаар зүйл*

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг ажиллагчдыг үр дүнтэйгээр ажилд авч, томилох явдлыг хангах үүднээс зохион байгуулах бөгөөд энэ зорилгоор дараахь арга хэмжээ авна:

(a)Тохирох ажил эрж олоход нь ажилчдад нь туслах, мөн шаардлага хангах ажилчдыг олоход нь ажил олгогчдод тулслах бөгөөд үндэсний түвшинд боловсруулсан журмын дагуу ялангуяа:

(i) ажил хайж буй хүмүүсийг бүртгэх, тэдний мэргэжлийн ур чадвар, туршлага, хүсэл сонирхлын талаар тэмдэглэл хөтлөх, тэдэнд ажил олгохын тулд ярилцлага хийх, шаардлагатай бол тэдний биеийн байдал, мэргэжлийн чадамжийг шалгах, зохих тохиолдолд мэргэжлийн удирдамж чиглэл авах буюу мэргэжлийн сургалт, давтан сургалтад хамрагдахад нь туслалж,

(ii) ажил олгогчдоос хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд мэдэгдсэн ажлын сул орон тоо болон тэдний хайж буй ажилчдын хангавал зохих шаардлагын тухай нарын тодорхой мэдээлэл олж авч,

(iii) ур чадвар, бие бялдарын хувьд тэнцэж тохирох хүнийг сул ажлын байранд илгээж,

(iv) ажил хайгч анх хандсан товчоо нь түүнийг тохирох ажлын байранд томилох боломжгүй эсхүл сул ажлын байранд тохирох ажилчин олох боломжгүй, эсхүл ийм арга хэмжээ авах шаардлагатай бусад тохиолдолд ажил хайгч болон ажлын байрыг хөдөлмөр эрхлүүлэлтийн нэг товчооноос нөгөө товчоонд шилжүүлнэ:

(b)Мөн дараах зорилгоор зохих арга хэмжээ авна:

(i) олон янзын мэргэжлийн хүрээний хөдөлмөр эрхлэлтийн эрэлтэд хөдөлмөрийн шаардлагатай нөөцийн нийлүүлэлтийг тохируулан зохицуулахын тулд мэргэжлийн шилжих хөдөлгөөнийг дэмжих,

(ii) ажилдчыг газарт шилжихэд нь тохирсон хөдөлмөр эрхлэх боломж бүхий газарт шилжихэд туслалцаа үзүүлэхийн тулд газарзүйн хувьд шилжих хөдөлгөөнийг дэмжих,

(iii) нутгийн ажилчдыг орон нутгийн нийлүүлэлт эсхүл эрэлт түр зуур үл зохицолдох тохиолдлыг зохицуулах зорилгоор ажилчдыг нэг бүрээс нөгөө бүс рүү түр хугацаагаар шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

(iv) холбогдох засгийн газрууд нь зөвшөөрсөн тохиолдолд ажилчдыг нэг орноос нөгөө оронд шилжин ажиллахад нь дэмжлэг үзүүлэх:

(c)зохих тохиолдолд эрх бүхий бусад байгууллага, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлтэй хамтран тухайн улсын нийт нутаг дэвсгэр, мөн янз бүрийн үйлдвэрлэлийн салбар, мэргэжил, газар нутаг дахь хөдөлмөрийн зах зээлийн байдал, түүний хөгжлийн хэтийн төлөвийн талаарх боломжит бүхий л мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийх, мөн уг мэдээллийг төрийн эрх бүхийн байгууллага, ажил олгогчдын ба ажилчдын холбогдох байгууллага, олон нийтэд системтэйгээр шуурхай ил болгох:

(d)ажилгүйдлын даатгал, тусламжийг мөн ажилгүйчүүдийн байдлыг хөнгөвчлөх бусад арга хэмжээг эрхлэн зохицуулах талаар хамтран ажиллах:

(e)хөдөлмөр эрхлэлтийн таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засгийн төлөвлөлтөнд нь төрийн болон хувийн хэвшлийн бусад этгээдэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх.

*7 дугаар зүйл*

Дараах зорилгоор арга хэмжээ авна:

(a)хөдөлмөрийн янз бүрийн товчоодын үйл ажиллагааг аль нэг мэргэжил, аж үйлдвэрийн салбараар (тухайлбал хөдөө аж ахуй болон дагнасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг ашигтай гэж үзсэн аливаа бусад салбараар ) дагнасан шинж чанартай болгоход дэмжлэг үзүүлэх,

(b)ажил хайчдын доторх тодорхой хэсэг, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг зохих ёсоор хангах.

*8 дугаар зүйл*

Хөдөлмөр эрхлэлтийн болон мэргэжлийн чиглэл өгөх үйлчигээний хүрээнд өсвөр насныханд зориулсан тусгай арга хэмжээ санаачлан боловсруулна.

*9 дүгээр зүйл*

1.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнууд нь төрийн албан хаагчид байх бөгөөд тэдний эрх зүйн байдал, ажлын нөхцөл нь засгийн газрын өөрчлөлт болон гадны зүй бус нөлөөллөөс хараат бус байж, тухайн албаны шаардлагад нийцсэн хэмжээнд тогтвортой ажлын байраар хангадсан байна.

2.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтныг ажилд авахдаа үндэсний хууль тогтоомжоор заагдсан төрийн албанд сонгон шалгаруулах аливаа нөнцөл, болзлыг баримтлахын хамт гагцхүү ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн түвшинг харгалзан шалгаруулж ажилуулна.

3.Мэргэжлийн түвшинг тодорхойлох арга замыг эрх бүхий байгууллага тогтооно.

4.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчигээний ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхийн тулд зохих бэлтгэл сургалтад хамрагдсан байна.

*10 дугаар зүйл*

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний болон зохих тохиолдолд төрийн эрх бүхий бусад байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг ажил олгогчид ба ажилчид сайн дурын үндсэн дээр бүрэн ашиглахыг дэмжихэд чиглэсэн боломжит бүх арга хэмжээг ажил олгогчид ба ажилчдын байгууллага, сонирхогч бусад этгээдтэй хамтран авч хэрэгжүүлнэ.

*11 дүгээр зүйл*

Эрх бүхий байгууллагууд нь хөдөлмөр эрхлэлтийн улсын үйлчилгээ болон ашгийн төлөө бус хөдөлмөр эрхлэлтийн хувийн товчоонд хороондын үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

*12 дугаар зүйл*

1.Хэрэв гишүүн орны нутаг дэвсгэр дэх газар нутгийн том хэсгүүдэд хүн ам сийрэг суурьшсанаас эсхүл тухайн нутгийн хөгжлийн түвшингээс шалтгаалан эрх бүхийн байгууллага энэхүү конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл эрх бүхий байгууллага нь газар нутгийн тэдгээр хэсгийг  энэхүү конвенцийн үйлчлэх хүрээнд огт хамааруулахгүй байх, эсхүл зохистой гэж үзсэн хэд хэдэн үйлдвэр, аж ахуйн нэгж буюу мэргэжлээс бусад хүрээнд үйлчлэхгүй байхаар шийдвэрлэж болно.

2.Гишүүн бүр Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 22 дугаар зүйлд нийцүүлэн энэхүү конвенцийн талаар хэрэгжилтийн талаар гаргах жил тутмын тайлангийн анхдугаар илтгэлдээ энэ зүйлийг заалтыг хэрэглэх болсон газар нутгийн аливаа хэсэг, мөн уг заалтыг хэрэглэх болсон шалтгааныг заана. Гишүүн нь анхын жилийн тайланг гаргасны дараа уг тайланд заасан хэсгээс бусад газарт энэ зүйлийн заалтыг хэрэглэж болохгүй

3.Энэ зүйлийн заалтыг хэрэглэж буй гишүүн бүр дараа дараагийн жилийн тайландаа энэ зүйлийг заалтыг хэрэглэхээ больсон газар нутгийн аливаа хэсгийг тодорхой заана.

*13 дугаар зүйл*

1.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1946 оны шийдвэрийн дагуу өөрчилсөн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 35 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт дурдсан нутаг дэвсгэрээс бусад тэрхүү зүйлд дүрдсан нутаг дэвсгэрийн хувьд, энэхүү конвенцийг соёрхон баталсан гишүүн түүний соёрхон батлсны дараа аль болох богино хугацаанд дор дурдсан мэдэгдлийг Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд илгээнэ.

(a)конвенцийн заалтыг өөрчлөхгүйгээр хэрэглэх үүрэг авч байгаа газар нутаг дэвсгэрийн тухай:

(b)конвенцийн заалтыг ямар нэг өөрчлөлттэй хэрэглэх үүрэг авч байгаа нутаг дэвсгэр болон тэдгээр өөрчлөлтийн тухай нарийвчилсан мэдээ:

(c)конвенцийг хэрэглэхгүй нутэг дэвсгэр болон энэ тохиолдолд түүнийг хэрэглэж болохгүй шалтгааны тухай:

(d)шийдвэр хэрхэн гаргахдаа азнаж буй нутаг дэвсгэрийн тухай:

2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b) дэд хэсэгт дурдсан үүргүүд нь соёрхон баталсан баримт бичгийн салшгүй хэсэг бөгөөд түүнтэй адил хүчинтэй байна.

3.Аль ч гишүүн шинэ мэдэгдэл хийж, энэ зүйлийн 1 дэх хэсгийн (b), (c) эсхүл (d) дэд хэсэгт дурдсаны дагуу анхны мэдэгдлээ урьд хийсэн тайлбараасаа бүхэлд нь буюу хэсэгчилэн татгалзаж болно.

4.Аль ч гишүүн энэхүү конвенцийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг цуцалж болох хугацаанд урьдах аливаа мэдэгдлийнхээ нөхцөлийг өөрчилж, тодорхой нутаг дэвсгэрт үйлчлэх нөхцөлийг талаарх шинэ мэдэгдлийг Ерөнхий захиралд илгээж болно.

*14 дүгээр зүйл*

1.Бүрэлдэхүүнд нь багтдаг боловч энэхүү конвенцид холбондох асуудлууд өөрийн нь шууд эрх мэдэлд багтах нутаг дэвсгэрийн засаг захиргаатай тохиролцсоны үндсэн дээ түүний гадаад харилцааг нь хариуцдаг тус байгууллагын гишүүн тухайн нутаг дэвсгарийн нэрийн өмнөөс энэхүү конвенцийн дагуу үүрэг хүлээхээ Олон улсны хөдөлмөрийн товчооны Ерөнхийн захиралд мэдэгдэж болно.

(a) Байгууллагын хоёр буюу хэд хэдэн гишүүнээс тэдний хамтын удирдлагад байгаа нутаг дэвсгэрийн хувьд,

(b) Нэгдсэн Үндэсний Байгууллагын дүрэм буюу тухайн нутаг дэвсгэрт холбогдох ямар нэгэн хүчин төгөлдөр тогтоолын үндсэн дээр аль нэг нутаг дэвсгэрийг удирдах үүрэг бүхий олон улсын аливаа засаг захиргаа тухайн нутаг дэвсгэрийн хувьд,

(c) энэхүү конвенцийн дагуу үүрэг хүлээж буй тухайгаа Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхийн захиралд мэдэгдэж болно.

2.Энэ зүйлийн өмнөх заалтад дурдсаны дагуу Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд илгээх мэдэгдэлд тухайн нутаг дэвсгэрт конвенцийн заалтыг өөрчлөлттэй буюу өөрчлөлтгүй хэрэглэхийг заах бөгөөд конвенцийн заалтыг өөрчлөлттэй хэрглэх тухай мэдэгдэлд заасан бол уг өөрчлөлтийн тухай түүнд тодорхой дурдана.

3.Сонирхогч гишүүн, гишүүд буюу олон улсын засаг захиргаа нь хэдийд ч шинэ мэдэгдэл гаргаж, урьд хийсэн аливаа мэдэгдэлд заасан аливаа өөрчлөлтийг хэрэглэх эрхээсээ бүрэн буюу зарим хэсгээс нь татгалзаж болно.

4.Сонирхогч гишүүн, гишүүн буюу олон улсын засаг захиргаа нь конвенцийн 17 зүйлийн заалтын дагуу түүнийг цуцалж болох хугацаанд урьдах аливаа мэдэгдлийнхээ нөхцөлийг өөрчилсөн тухай болон конвенцийг хэрэглэж байгаа нөхцөлийн тухай шинэ мэдэгдлийг Ерөнхий захиралд илгээж болно.

*15 дугаа зүйл*

Энэхүү конвенцийн соёрхон баталсан тухай албан ёсны баримт бичгийг Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд бүртгүүлэхээр илгээнэ.

*16 дугаар зүйл*

1.Энэхүү конвенц нь соёрхон баталсан тухай батламж жуух бичгээ Ерөнхий захиралд бүртгүүлсэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Гишүүн улсуудын хувьд заавал биелүүлэх хүчинтэй байна.

2.Энэхүү конвенц Ерөнхий захирал Гишүүн хоёр улсын соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг бүртгэсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

3.Түүнээс хойш энэхүү конвенцийг соёрхон баталсан тухай батлаж жуух бичгээ бүртгүүлсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа тус тус хүчин төгөлдөр болно.

*17 дугаар зүйл*

1.Энэхүү конвенцийг соёрхон баталсан аливаа гишүүн улс түүнийг анх хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жилийн дараа конвенцийг цуцлах тухай хүсэлтээ Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхийн захиралд илгээн бүртгүүлснээр конвенцийг цуцалж болно. Цуцлалт тухайн хүсэлтийг бүртгэснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2.Энэхүү конвенцийг соёрхон баталсан аливаа гишүүн улс нь өмнөх хэсэгт дурдсан арван жилийн хугацаа дууснаас хойш нэг жилийн дотор энэ зүйлд заасан конвенцийг цуцлах эрхийг хэрэгжүүлээгүй тохиолдолд дараагийн арван жилийн хугацаанд уг конвенцийг заавал биелүүлэх бөгөөд цаашид энэ зүйлд заасан журмын дагуу арван жилийн хугацаа дуусах бүрт энэхүү конвенцийг цуцлах эрхтэй байна.

*18 дугаар зүйл*

1.Олон улсын хөдөлмөртйн товчооны Ерөнхий захирал Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүдээс хүлээн авсан соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, мэдэгдэл болон цуцлалтыг бүртгэсэн тухайн Байгууллагын гишүүн бүрт мэдэгдэнэ.

2.Соёрхон баталсан тухай хоёр дахь батламж жуух бичгийг хүлээн авч бүртгэсэн талаар Байгууллагын гишүүдэд мэдэгдэхдээ Ерөнхий захирал Байгууллагын гишүүдэд мэдэгдэхдээ Ерөнхий захирал Байгууллагын гишүүдийн анхаарлыг энэхүү конвенц хүчин төгөлдөр болгох он, сар, өдөрт хандуулна.

*19 дугаар зүйл*

1.Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал өмнөх зүйлүүдэд заасан журмаар бүртгэсэн соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, мэдэгдэл болон цуцлалтын тухай бүрэн мэдээг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлд заасан ёсоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлэхээр илгээнэ.

*20 дугаар зүйл*

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай хэмээн үзэх бүртээ энэхүү конвенцийн хэрэгжилтийн тухай Ерөнхий Бага хуралд илтгэж, конвенцийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хянаж өөрчлөх тухай асуудлыг Бага хурлын хэлэлцэх хэсэгт оруулах талаар шийдвэрлэнэ.

*21 дүгээр зүйл*

1.Энэхүү конвенций бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хянан өөрчилсөн шинэ конвенцийг Бага хурлаар баталж, тэрхүү шинэ конвенцид өөрөөр заагаагүй бол:

(a) Хянан өөрчилсөн шинэ конвенц хүчин төгөлдөр болсон нөхцөлд аливаа гишүүний хувьд түүнийг соёрхон баталманц энэхүү конвенц нь дээрх 17 дугаар зүйлийн заалтаас үл хамааран нэн даруй хүчингүй болно;

(b) Хянан өөрчилсан шинэ конвенц хүчин төгөрдөр болох өдрөөс эхлэн энэхүү конвенц гишүүд соёрхон батлахад хаалттай болно.

2.Энэхүү конвенц нь түүнийг соёрхон баталсан бөгөөд хянан өөрчисөн шинэ конвенцийг соёрхон батлаагүй гишүүний тухайд аливаа тохиолдолд хэлбэр, агуулгын хувьд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

*22 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 181 ДҮГЭЭР КОНВЕНЦ

*(Монгол улс 2016 онд соёрхон баталсан.)*

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 1997 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Женев хотноо зарлан хуралдуулсан наян тав дугаар чуулганаараа,

Хөдөлмөр эрхлэлтийн төлбөртэй байгууллагын тухай 1949 оны (шинэчлэгдсэн) конвенцийн заалтыг анхааран,

Хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагаан дахь уян хатан байдлын чухал болохыг ойлгон,

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь 1994 онд 81 дүгээр чуулганаараа Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 1949 оны (шинэчлэгдсэн) конвенцийг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага үргэлжлүүлэн хянаж үзэх шаардлагатай гэсэн санал гаргасныг сануулж,

Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын ажиллаж байгаа нөхцөл байдал нь дээр дурдсан конвенц батлагдах үеийнхтэй харьцуулахад эрс өөрчлөгдсөнийг тооцон,

хэвийн ажиллаж байгаа хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын гүйцэтгэх үүргийг ойлгож,

ажилчдыг янз бүрийн ёс бус үйлдлээс хамгаалах шаардлагатайг сануулж, нийгэмлэг байгуулах эрхийг хамгаалах, хамтын хэлэлцээ, нийгмийн хэлэлцээг дэмжих зайлшгүй шаардлага нь хэвийн ажиллагаатай аж үйлдвэрийн харилцаатай тогтолцооны зайлшгүй бүрдэл хэсэг болохыг хүлээн зөвшөөрч,

Хөдөлмөр эрхлэлтийн албыг зохион байгуулах тухай 1948 оны конвенцийг анхаарч,

Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны конвенц, Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны конвенц, Байгууллага байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай 1949 оны конвенц, Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 1958 оны конвенц, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 1973 оны конвенц, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлээс хамгаалах тухай 1988 оны конвенц, түүнчлэн Цагаач ажиллагсдын

тухай 1949 оны конвенц (шинэчлэгдсэн), Цагаач ажиллагсдын тухай 1975 оны конвенц (нэмэлт зүйл)-ийн ажилтан элсүүлэх, байршуулахтай холбоотой заалтыг сануулж,

Чуулганы хэлэлцэх асуудлын дөрөвт тусгагдсан Хөдөлмөр эрхлэлтийн төлбөртэй албаны тухай 1949 оны (шинэчлэгдсэн) конвенцийг хянаж үзэхтэй холбогдсон хэд хэдэн саналыг хүлээн авахаар шийдэж,

Тэдгээр саналыг олон улсын конвенцийн хэлбэрт оруулахаар шийдвэрлэж,

Нэг мянга есөн зуун ерөн долоон оны зургадугаар сарын арван есний өдөр дараах конвенцийг Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 1997 оны конвенц гэж нэрлэхээр тогтож батлав.

*1 дүгээр зүйл*

1. Энэхүү конвенцийн зорилгоор "хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага" гэж хөдөлмөрийн зах зээлийн дараах үйлчилгээнээс нэг эсхүл хэд хэдийг нь үзүүлж байгаа, төрийн байгууллагаас хараат бус, аливаа хувь хүн, эсхүл хуулийн этгээдийг ойлгоно.

(a) хөдөлмөр эрхлэхэд ажлын байрны санал болон эрэлттэй нийцүүлэхэд чиглэгдсэн үйлчилгээ бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага нь энэ үед үүсэж болох хөдөлмөр эрхлэлтийн харилцааны нэг тал болохгүй.

(b) ажилчдад үйлдвэрлэлийн даалгавар өгч, уг даалгаврын биелэлтэд хяналт тавьдаг хувь хүн, эсхүл хуулийн этгээд (дор "хэрэглэгч аж ахуй" гэх) байж болох гуравдагч талын мэдэлд шилжүүлэх зорилгоор хөлслөн авах үйлчилгээ;

(c) хөдөлмөр эрхлэхэд ажлын байрны санал болгон эрэлттэй нийцүүлэхээр ажил олгогчдын болон ажилчдын илүү төлөөлөл бүхий байгууллагуудтай зөвлөлдсөний дараа эрх бүхий байгууллагаас тодорхойлдог, ажил хайхтай холбогдсон, мэдээлэл өгөх гэх мэт бусад үйлчилгээ.

2. Энэхүү конвенцийн зорилгоор "ажилчид" гэсэн нэр томьёонд ажил хайгчид хамаарна.

3. Энэхүү конвенцийн зорилгоор "ажилчдын хувийн мэдээллийг боловсруулах" гэж хэн болохыг нь тогтоосон, эсхүл тогтоож болох ажилчдад хамаарах мэдээллийг цуглуулах, хадгалах, сонгох, шилж авах, тараах эсхүл аливаа өөр байдлаар уг мэдээллийг ашиглахыг хэлнэ.

*2 дугаар зүйл*

1.Энэхүү конвенц нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагад хамаарна.

2. Энэхүү конвенц нь ажиллагсдын бүх ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарт хэрэглэгдэнэ. Конвенцийг далайчдыг элсүүлэх, ажилд авахад хэрэглэхгүй.

3. Энэхүү конвенцийн нэг зорилго нь түүний заалтын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үйл ажиллагааг зөвшөөрөх, түүнчлэн тэдгээрийн үйлчилгээг авч байгаа ажилчдыг хамгаалахад оршино.

4. Сонирхогч ажил горилогчдын болон ажилчдын илүү төлөөлөл бүхий байгууллагатай зөвлөлдсөний дараа гишүүд:

(a) хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагаас 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нэг, эсхүл хэд хэдэн үйлчилгээг тодорхой ангиллын ажилчдад, эдийн засгийн үйл ажиллагааны салбарт үзүүлэхийг тодорхой нөхцөл байдлын дагуу хориглож болно.

(b) эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой салбарт ажиллаж байгаа ажилчдыг, эсхүл ийм ажилчдын нэг хэсгийг, хэрвээ тэд өөр байдлаар зохих хамгаалалтад хамрагдсан бол тодорхой нөхцөл байдлын дагуу энэхүү конвенцийн хэрэглэх хүрээнд хамааруулахгүй байж болно.

5. Энэхүү конвенцийг соёрхон баталж байгаа Гишүүн улс нь 4 дэх хэсэгт дурсдсанаар хориг тогтоосон буюу конвенцийг хэрэглэх хүрээнд хамаарахгүй болгосон бүх тохиолдол, шалтгаанаа Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Дүрмийн 22 дугаар зүйлийн дагуу тайландаа тусгасан байна.

*3 дугаар зүйл*

1. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын эрх зүйн байдлыг үндэсний хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд нийцүүлэн, ажил олгогчдын болон ажилчдын илүү төлөөлөл бүхий байгууллагатай зөвлөлдсөний дараа тодорхойлно.

2. Гишүүн улс нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үйл ажиллагаа зохицуулах нөхцлийг, хэрвээ эдгээр нөхцөл нь холбогдох хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд өөрөөр зохицуулагдаагүй буюу тодорхойлогдоогүй бол зөвшөөрөл буюу гэрчилгээ олгох тогтолцоонд нийцүүлэн тодорхойлно.

*4 дүгээр зүйл*

1 дүгээр зүйлд заасан үйлчилгээ үзүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагаар дамжуулан ажил эрхэлж байгаа ажилчдын эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээ хийх эрхийг хангах арга хэмжээ авна.

*5 дугаар зүйл*

1. Хөдөлмөр эрхлэх болон тодорхой ажил хийх бололцоо бий болгоход адил тэгш боломж, хандлагыг дэмжих зорилгоор гишүүн нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага арьс, өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, эсхүл үндэсний хууль тогтоомж, практик үйл ажиллагаагаар хориглосон нас буюу хөгжлийн бэрхшээл гэх зэрэг бусад хэлбэрээр алагчилахгүйгээр ажилчдад үйлчилгээ үзүүлэхийг баталгаажуулж өгнө.

2. Энэхүү зүйлийн нэг дэх хэсгийг хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага бусдаас дор, таагүй нөхцөл байдалд байгаа ажилчдад ажил хайх үйл ажиллагаанд нь туслах тусгай үйлчилгээ үзүүлэх, эсхүл зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой байхаар хэрэгжүүлнэ.

*6 дугаар зүйл*

Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагаас ажилчдын хувийн мэдээллийг боловсруулах үйл ажиллагаа нь:

(a) эдгээр мэдээллийг хамгаалах, үндэсний хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд нийцүүлэн ажилчдын хувийн нууцыг хүндэтгэн үзэх байдлаар явагдах;

(b) сонирхсон ажилчдын мэргэшил, мэргэжлийн дадлага туршлага болон үүнд шууд хамаарах аливаа бусад мэдээлэлтэй холбогдох асуудлаар хязгаарлагдана.

*7 дугаар зүйл*

1. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага нь ажилчдаас шууд, эсхүл шууд бусаар, бүрэн, эсхүл хэсэгчлэн ямар ч хураамж болон бусад зардал авахгүй.

2. Холбогдох ажиллагсдын ашиг сонирхлын үүднээс ажил олгогчдын болон ажиллагсдын илүү төлөөлөл бүхий байгууллагатай зөвлөлдсөний дараа эрх бүхий байгууллагаас тодорхой ангиллын ажиллагсдад, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үзүүлж байгаа тодорхой төрлийн үйлчилгээнд энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг хамааруулахгүй байх зөвшөөрөл олгож болно.

3. Энэ зүйлийн 2 дах хэсгийн дагуу зөвшөөрөл олгосон Гишүүн улс нь ийм зөвшөөрлийн тухай мэдээллийн шалтгааныг нь зааж Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Дүрмийн 22 дугаар зүйлийн дагуу танилцуулж байгаа тайландаа оруулсан байна.

*8 дугаар зүйл*

1. Гишүүн улс нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагаас өөрийн нутаг дэвсгэр дээр элсүүлж авсан буюу хөдөлмөрийг нь зохицуулсан цагаач ажилчдыг зохих хамгаалалтаар хангах, тэдэнд хандсан ёс бус үйлдэл гаргуулахгүй байх шаардлагатай ба зохистой бүх арга хэмжээг ажил олгогчдын болон ажилчдын илүү төлөөлөл бүхий байгууллагатай зөвлөлдсөний дараа өөрийн бүрэн эрхийн хүрээнд, мөн шаардлагатай тохиолдолд бусад гишүүдтэй хамтран хэрэгжүүлнэ. Эдгээр нь хууран мэхэлж, ёс бус үйлдэлд оролцсон хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагыг шийтгэх, түүний дотор хориглохыг тусгасан хууль тогтоомжийг хамруулна.

2. Хэрвээ өөр улсад ажиллуулахаар тухайн улсын ажилчдыг элсүүлж байгаа бол холбогдох Гишүүн улс нь ажилчдыг элсүүлэх, байршуулах, хөдөлмөр эрхлүүлэхэд хууран мэхлэх, ёс бус үйлдэл гаргуулахаас урьдчилан сэргийлэхээр хоёр тал хэлэлцээр байгуулахыг авч үзнэ.

*9 дүгээр зүйл*

Гишүүн улс нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагаар хүүхдийн хөдөлмөр ашиглахгүй байх, эсхүл санал болгохгүй байх явдлыг хангах арга хэмжээ авна.

*10 дугаар зүйл*

Эрх бүхий байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэжиг бүхий ёс бус үйлдэл болон хууран мэхлэх тухай гомдлыг хянаж барагдуулахад ажил олгогчдын болон ажилчдын илүү их төлөөлөл бүхий байгууллагыг оролцуулах зохих техник, шийдвэрлэх журмыг хангасан байна.

*11 дүгээр зүйл*

Гишүүн улс нь 1 дүгээр зүйлийн 1 (b) дэд хэсэгт дурдсанаар хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын хөлсөлж авсан ажилчдыг зохих ёсоор хамгаалах дор дурдсан асуудалд хамаарах шаардлагатай арга хэмжээг үндэсний хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд нийцүүлэн хэрэгжүүлнэ:

(a)эвлэлдэн нэгдэх;
(b) хамтын хэлэлцээ;
(c)хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ;
(d)ажлын цагийн үргэлжлэл болон хөдөлмөрийн бусад нөхцөл;
(e)хууль тогтоомжоор тогтоосон нийгмийн даатгалын тэтгэмж;
(f)сургалтад хамрагдах бололцоо;
(g)хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хамгаалалт;
(h)үйлдвэрлэлийн осол буюу мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор;
(i)эхчүүдийн эрхийн хамгаалалт, жирэмсний ба амаржсаны тэтгэмж, хүүхдийн эцэг эхийн хамгаалалт ба тэтгэмж

*12 дугаар зүйл*

Гишүүн улс нь 1 дүгээр зүйлийн 1 (b) дэд хэсэгт дурдсан үйлчилгээг үзүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага болон хэрэглэгч аж ахуй дор дурдсан асуудалд хамаарах зохих хариуцлагыг үндэсний хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд нийцүүлэн тодорхойлж ногдуулна:

(a)хамтын хэлэлцээ;
(b)хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ;
(c)ажлын цагийн үргэлжлэл болон хөдөлмөрийн бусад нөхцөл;
(d)хууль тогтоомжоор тогтоосон нийгмийн даатгалын тэтгэмж;
(e)сургалтад хамрагдах бололцоо;
(f)хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хамгаалалт;
(g)үйлдвэрлэлийн осол буюу мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн олговор;
(h)байгууллага дампуурах буюу татан буугдах үед, ажиллагсдад олгох нөхөн олговор;
(i)эхчүүдийн эрхийн хамгаалалт, жирэмсний ба амаржсаны тэтгэмж, хүүхдийн эцэг эхийн хамгаалалт ба тэтгэмж;

*13 дугаар зүйл*

1. Гишүүн улс нь ажил олгогчдын болон ажилчдын илүү төлөөлөл бүхий байгууллагатай зөвлөлдсөний дараа үндэсний хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд нийцүүлж хөдөлмөр эрхлэлтийн төрийн болон хувийн байгууллагын хоорондох хамтын ажиллагааг дэмжих нөхцөлийг боловсруулж, байгуулан, үе үе хянан шалгана.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл нь дараахь асуудлаар төрийн эрх бүхий байгууллага эцсийн шийдвэр гаргах зарчимд суурилна:

(a) хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг боловсруулах;
(b) ийм бодлого хэрэгжүүлэхэд зориулагдсан улсын сан ашиглах, эсхүл зарцуулалтад нь хяналт тавих;

3. хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага нь эрх бүхий байгууллагад уг байгууллагаас тогтоосон давтамжтайгаар түүнд шаардлагатай мэдээллийг ийм мэдээллийн нууц шинж чанартай эсэхийг харгалзан мэдээлэл өгнө;

(a) үндэсний хууль тогтоомж, практик үйл ажиллагааны дагуу хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын бүтэц болон үйл ажиллагаатай танилцах боломжийг эрх бүхий байгууллагад олгож байгаа;

(b) статистикийн зориулалт бүхий;

4. Эрх бүхий байгууллага нь эдгээр мэдээллийг нэгтгэж, тогтмол давтамжтайгаар олон нийтэд зарлаж байна.

*14 дүгээр зүйл*

1. Энэхүү конвенцийн заалтыг хууль тогтоомж, эсхүл үндэсний практик үйл ажиллагаанд нийцэж байгаа аливаа байдлаар, тухайлбал шүүхийн шийдвэр, арбитрын шийдвэр, эсхүл хамтын гэрээнд хэрэглэнэ.

2. Энэхүү конвенцид үр нөлөө өгч байгаа заалтын хэрэгжилтэд хөдөлмөрийн үйлчилгээний хяналтын, эсхүл төрийн эрх бүхий бусад байгууллага хяналт тавина.

3. Энэхүү конвенцийг зөрчсөн тохиолдолд эрхийг хамгаалах хангалттай арга хэрэгсэл, тэр дундаа шаардлагатай тохиолдолд арга хэмжээ авах замаар конвенцийг үр ашигтай хэрэглэнэ.

*15 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь Төлбөртэй хөдөлмөр эрхэлтийн байгууллагад ажилчид элсүүлэх, байршуулах, хөлслөх асуудлыг нь зохицуулсан олон улсын бусад конвенцийн дагуу хамаарч болох илүү таатай заалтыг үл хөндөнө.

*16 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь Төлбөртэй хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тухай 1949 оны (шинэчлэгдсэн) конвенц болон Төлбөртэй хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тухай 1933 оны конвенцийг шинэчилж байна.

*17 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг соёрхон баталсан тухай албан ёсны баримт бичгийг Олон улсын хөдөлмөрийн товчооны ерөнхий захиралд бүртгүүлэхээр илгээнэ.

*18 дугаар зүйл*

1. Энэхүү конвенц нь зөвхөн соёрхон баталсан тухайгаа Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд бүртгүүлсэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүдэд л хүчин төгөлдөр байна.

2. Энэхүү конвенц нь ерөнхий захирал хоёр гишүүн улсын соёрхон баталсныг бүртгэсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

3. Түүнээс хойш энэхүү конвенц нь аливаа Гишүүн улсын хувьд соёрхон баталснаа бүртгүүлсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа тус тус хүчин төгөлдөр болно.

*19 дүгээр зүйл*

1.Энэхүү конвенцийг соёрхон баталсан аливаа Гишүүн улс түүнийг анх хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жилийн дараа конвенцийг цуцлах тухай хүсэлтээ Олон улсын хөдөлмөрийн товчооны ерөнхий захиралд илгээн бүртгүүлснээр конвенцоос гарч болно.

2.Ийнхүү гарах нь тухайн хүсэлтийг бүртгэснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү конвенцийг соёрхон баталсан аливаа Гишүүн улс нь өмнөх хэсэгт дурдсан арван жилийн хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор энэ зүйлд заасан конвенцоос гарах эрхийг хэрэгжүүлээгүй тохиолдолд дараагийн арван жилийн хугацаанд уг конвенцийг заавал биелүүлэх бөгөөд цаашид энэ зүйлд заасан журмын дагуу арван жилийн хугацаа дуусах бүрт энэхүү конвенцийг цуцлах эрхтэй байна.

*20 дугаар зүйл*

1. Олон улсын хөдөлмөрийн товчооны ерөнхий захирал нь Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Гишүүдийн соёрхон баталсан мэдэгдэл болон конвенцоос гарсныг бүртгэсэн тухайгаа Байгууллагын гишүүн бүрт мэдэгдэнэ.

2. Ерөнхий захирал нь соёрхон баталсан тухай хоёр дахь бүртгэлийн талаар Байгууллагын гишүүдэд мэдэгдэхдээ Байгууллагын гишүүдийн анхаарлыг энэхүү конвенц хүчин төгөлдөр болох огноонд хандуулна.

*21 дүгээр зүйл*

Олон улсын хөдөлмөрийн товчооны ерөнхий захирал өмнөх зүйлд заасан журмаар бүртгэсэн соёрхон баталсан, мэдэгдэл болон конвенцоос гарсан бүртгэлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлд заасан ёсоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

*22 дугаар зүйл*

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд энэхүү конвенцийн хэрэгжилтийн тухай тайланг Ерөнхий Бага хуралд илтгэж, конвенцийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь өөрчлөх тухай асуудлыг Бага хурлын хэлэлцэх хэрэгт оруулах талаар шийдвэрлэнэ.

*23 дугаар зүйл*

1. Энэхүү конвенцийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь өөрчилсөн шинэ конвенцийг Бага хурлаар баталж, тэрхүү шинэ конвенцид өөрөөр заагаагүй бол;

(a) өөрчилсөн шинэ конвенц хүчин төгөлдөр болсон нөхцөлд аливаа гишүүний хувьд түүнийг соёрхон баталмагц энэхүү конвенц нь дээрх 17 дугаар зүйлийн заалтаас үл хамааран нэн даруй хүчингүй болох;

(b) өөрчилсөн шинэ конвенц хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн энэхүү конвенц гишүүд соёрхон батлахад хаалттай байна.

2. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон баталсан боловч өөрчилсөн шинэ конвенцийг соёрхон батлаагүй гишүүний тухайд хэлбэр, агуулгын хувьд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

*24 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийн англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэр нь адил хүчинтэй байна.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хот

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж**

2.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Нийгмийн халамжийн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“ажил хайгч” гэж ажилгүй, ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн болон хандсан иргэнийг;

3.1.2.“ажилгүй иргэн” гэж ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэнийг;

3.1.3.“ажилгүй” гэж Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаагүй, түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ, контракт, Иргэний хуулийн[8] 359

дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах гэрээгээр ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхлээгүй байхыг;

3.1.4.“ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ, контракт, Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

3.1.5.“ажил идэвхтэй хайж байгаа” гэж аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлж ажлын байрны талаар мэдээлэл авах, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газрын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого хийснийг;

*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

3.1.6.“ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн” гэж хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, эрүүл мэндийн шалтгаанаар ажлаа өөрчлөх шаардлагатай болсон, эрхэлж байсан хувийн аж ахуй нь эрсдэлд орсны улмаас сэргээх боломжгүй болсон тухайгаа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржид мэдэгдэж, бүртгүүлсэн иргэнийг;

*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

3.1.7.“ажил олоход хүндрэлтэй иргэн” гэж хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д заасан иргэн, хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг;

3.1.8.“хувиараа хөдөлмөр эрхлэгч“ гэж дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлэн бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг иргэнийг;

3.1.9.“малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;

3.1.10.“ажилд зуучлах” гэж ажил хайж байгаа иргэнд хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон ажил олоход, ажил олгогчид эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ажилтан олоход туслалцаа үзүүлэх үйлчилгээг;

3.1.11.“бизнес инкубацийн үйлчилгээ” гэж хувиараа хөдөлмөр эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэхийг хүссэн иргэн, түүнчлэн малчинд мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх, үйлдвэрлэлийн байр түрээслүүлэх зэргээр дэмжлэг үзүүлж, аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэхийг.

3.1.12.“бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч” гэж 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнийг.

*/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/*

**4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим, төрийн бодлогын чиглэл**

4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчим баримтална:

4.1.1.иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах;

4.1.2.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ адил тэгш, нээлттэй, ил тод байх;

4.1.3.иргэн сайн дурын үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтэд хамрагдах;

4.1.4.ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөрлөх тэгш эрх, адил боломжийг хангах;

4.1.5.нийгмийн түншлэлийг дэмжих;

4.1.6.олон нийтийн оролцоонд тулгуурлах.

4.2.Төрөөс хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараах бодлогын чиглэлийг баримтална:

4.2.1.хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшинг хангах;

4.2.2.ажиллах хүчнийг хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх;

4.2.3.хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн иргэний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх;

4.2.4.хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгааг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанар, үр ашгийг дээшлүүлэх;

4.2.5.ажиллах хүчний дотоодын зах зээлийг эзэмших, гадаадын зах зээлд мэргэшил, чадвар дээшлүүлэх;

**5 дугаар зүйл.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих**

5.1.Төрөөс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих талаар дараах арга хэмжээг жил бүр авч хэрэгжүүлнэ:

5.1.1.үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах талаар судалгаа хийх, гэрээ, хэлэлцээр байгуулах;

5.1.2.экспортлох зориулалттай үйлдвэрлэл эрхлэх болон ажлын байр олноор нэмэгдүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид эхний ээлжид зээл олгох, бий болгосон ажлын байрны тоог харгалзан татварын хөнгөлөлт үзүүлэх;

5.1.3.алслагдсан болон эдийн засгийн сул хөгжилтэй бүс нутагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, эсхүл төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан зарчмаар хөрөнгө оруулах;

5.1.4.Засгийн газраас тодорхойлсон бусад арга хэмжээ.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан арга хэмжээг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

*/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*
*/Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**6 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр**

6.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

6.1.1.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ;

6.1.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ.

6.2.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

6.2.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

6.2.2.ажилд зуучлах;

6.2.3.ажилгүйдлийн тэтгэмж олгох;

6.2.4.нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;

6.2.5.бусад үйлчилгээ.

6.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ:

6.3.1.хөдөлмөрт бэлтгэх;

6.3.2.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

6.3.3.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;

6.3.4.ажил олгогчийг дэмжих;

6.3.5.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;

6.3.6.ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

6.3.7.хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр.

6.4.Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж олгох нөхцөл, журмыг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.

6.5.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

**7 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хамрах хүрээ**

7.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана.
*/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

**8 дугаар зүйл.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ**

8.1.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ хамаарна.

8.2.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилан болон хэсэг, бүлгээр зохион байгуулна.

8.3.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид ажил,

мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

8.4.Хөдөлмөрийн бирж ажил, мэргэжлийн чиг баримжаа олгоход ашиглах гарын авлага, түгээмэл мэргэжил бүрээр танилцуулга бэлтгэж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

8.5.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын агуулга, сургагч багшид тавих шаардлагыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд тогтооно.
*/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/*

**9 дүгээр зүйл.Ажилд зуучлах**

9.1.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж нь бүртгэсэн ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна.
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

9.2.Хөдөлмөрийн хувийн биржийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллага бүртгэж, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоно.
*/Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

9.3.Энэ хуулийн 9.1-д заасан үйлчилгээний хүрээнд иргэнийг ажилд зуучлах боломжгүй бол хөдөлмөрийн хувийн бирж уг иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд хамруулахаар аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд мэдэгдэнэ.
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

9.4.Энэ хуулийн 9.2-т заасан мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хөдөлмөрийн хувийн биржид уг нэгдсэн сүлжээнд бүртгэгдсэн ажил хайгчдаас ажилд зуучлуулсан болон оруулсан хүний тоогоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тогтоосон тарифаар тооцож санхүүжилт олгох бөгөөд хөдөлмөрийн хувийн бирж нь ажилд зуучлуулсан иргэнээс шууд ба шууд бус байдлаар үйлчилгээний төлбөр авахыг хориглоно.

9.5.Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

**10 дугаар зүйл.Хөдөлмөрт бэлтгэх**

10.1.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ нь ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд хүнтэй харилцах ур

чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан зохицоход нь туслах зэрэг зайлшгүй хэрэгцээт багц үйлчилгээ, дэмжлэг, туслалцааны хэлбэртэй байна.

10.2.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний үйлчилгээ, дэмжлэг, туслалцааг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

**11 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах**

11.1.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт нь иргэнд үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалт, явуулын болон зайны сургалт, шавь сургалтын зэрэг хэлбэрээр богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх зорилготой байна.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

11.2.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт нь ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх зорилготой байна.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

11.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.5-д заасан журмын дагуу гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж болно.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

11.4.Энэ хуулийн 11.2-т заасан иргэний сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлнэ.

11.5.Энэ хуулийн 11.2-т зааснаас бусад иргэн хөдөлмөр эрхлэлтийн сургалтад өөрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасан Ажилгүйдлийн даатгалын сангийн зардлаар хамрагдаж болно.

11.6.Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэний мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах ажлыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллага зохион байгуулах бөгөөд мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
*/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хууль, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт, 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

11.7.Гадаад улсад хөдөлмөр эрхэлж, тодорхой мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний хүсэлт, нотлох баримт бичгийг үндэслэн мэргэжлийн ур чадварыг

нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллага үнэлж, баталгаажуулна.
*/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хууль, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт, 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

11.8.Ялтан, хугацаат цэргийн алба хаагчид зориулан хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төслийг хэрэгжүүлж болно.

**12 дугаар зүйл.Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих**
*/Энэ зүйлийн гарчигт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

12.1.Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих арга хэмжээ нь иргэний ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхлэх санаачилгыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэрэгслээр дэмжин туслах хэлбэртэй байна.
*/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

12.2.Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох бөгөөд уг сангаас олгох жижиг зээлийг банкаар дамжуулан олгоно.
*/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

12.3.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид таван сая хүртэл, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд арван сая хүртэл төгрөгийн зээлийг 2 жил хүртэл хугацаагаар олгоно.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

12.4.Ажил олоход хүндрэлтэй иргэн материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл зэргийг худалдан авахад зориулж жижиг зээл авсан бол зээлийн хүүгийн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн төлнө.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

12.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ хуулийн 12.2-т заасны дагуу олгож байгаа зээлийн хүүгийн хэмжээ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсан банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байна.

12.6.Энэ хуулийн 12.2-т заасны дагуу олгож байгаа жижиг зээлд батлан даалт гаргаж болно.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

12.7.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

12.8.Бизнес инкубацийн үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

12.8.1.бизнесийн санаа олсон иргэнийг аж ахуй эрхлэх сургалтад хамруулах, төсөл боловсруулахад нь туслах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

12.8.2.бизнесийн төсөл боловсруулж, шалгарсан иргэнд шаардлагатай тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байр түрээслүүлэх, тодорхой хугацаагаар түрээсийн хөнгөлөлт үзүүлэх;

12.8.3.бизнесийн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, түншлэлийн харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх;

12.8.4.энэ хуулийн 12.4-т заасан зээл олгох, хөнгөлөлт үзүүлэх, бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;
*/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

12.8.5.бусад.

12.9.Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн ажлын байр бий болговол түүнд бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлж, энэ хуулийн 12.3, 12.4-т заасан зээл, хөнгөлөлт үзүүлж болно.

**13 дугаар зүйл.Ажил олгогчийг дэмжих**

13.1.Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ нь ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажиллуулахтай холбоотой гарсан зардлыг ажил олгогчид бүрэн болон хэсэгчлэн нөхөн төлөх, ажил олгогчийн бий болгосон ажлын байранд тухайн иргэнийг тогтвортой ажиллахыг урамшуулах зорилго бүхий санхүүгийн дэмжлэгийн хэлбэрээр хэрэгжинэ.

13.2.Ажилгүйдлийн даатгалын сангаас тодорхой нөхцөл, шаардлагыг хангасан ажил олгогчид ажлын байр хадгалах зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан санхүүгийн дэмжлэг олгох нөхцөл, шаардлагыг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар тогтооно.

13.4.Гэрээний үндсэн дээр бусдаар малаа маллуулж байгаа мал бүхий иргэнийг энэ хуулийн 13.1-д заасан ажил олгогчид хамааруулна.

**14 дүгээр зүйл.Нийтийг хамарсан ажил зохион байгуулах**

14.1.Нийтийг хамарсан ажлыг ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон ажилгүй иргэнийг түр хугацаагаар ажиллуулах, орлого нэмэгдүүлэх төрөл бүрийн арга хэмжээний хэлбэрээр зохион байгуулна.

14.2.Нийтийг хамарсан ажлын хөтөлбөрийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага орон нутгийн нөөц бололцоо, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж, нутгийн захиргааны байгууллага болон

аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

14.3.Байгалийн гамшиг, давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн сэргээх зорилгоор аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагаас нийтийг хамарсан ажлын түр хөтөлбөр хэрэгжүүлж болно.
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

14.4.Нийтийг хамарсан ажлын хөлс, тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас, бусад зардлыг орон нутгийн төсвөөс болон аж ахуйн нэгж, байгууллага гаргана.

14.5.Нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлын хэмжээг ажлын онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

14.6.Нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

**15 дугаар зүйл.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих**

15.1.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор энэ хуульд заасннаас гадна дараах дэмжлэг үзүүлнэ:

15.1.1.ажил олоход хүндрэлтэй иргэнд хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдах хугацаанд нь хоол, унааны зардлын хөнгөлөлт үзүүлж, уг зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх;

15.1.2.хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгох;
*/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

15.1.3.ажил олоход хүндрэлтэй иргэн, хувиараа болон өрхийн аж ахуйн хэлбэрээр хөдөлмөр эрхлэх бол түүнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгох;
*/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

15.1.4.хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгох;

15.1.5.хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг

тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах.

15.2.Малгүй болон цөөн малтай иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар туслах малчнаар ажиллуулан, мал маллах арга ажиллагаанд сургаж, малжуулсан малчинд тухайн иргэнд төлсөн хөдөлмөрийн хөлсний хэмжээг нь харгалзан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэг нэг удаа үзүүлж болно.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

15.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж нь ажилд зуучилсан ажил олоход хүндрэлтэй иргэн, түүний ажил олгогчтой гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.
*/Энэ хэсэгт 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ

### 16 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо

16.1.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сүлжээ, түүний программын болон техникийн хангамж, мэдээлэл цуглуулах, түгээх үйлчилгээ, мэдээллийн эх үүсвэрээс бүрдэнэ.

### 17 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

17.1.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь ажиллах хүчний талаарх мэдээ, мэдээлэл, ажлын байрны болон ажил хайгч, ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдсон бүртгэл, мэдээллийг агуулна.

### 18 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээ

18.1.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээ нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, хамгаалах, түүнээс мэдээлэл түгээх, цахим хуудас, түүнд суурилсан программ болон техник хангамж, мэдээллийн бусад арга хэрэгслээс бүрдэнэ.

### 19 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааг хариуцах байгууллага

19.1.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээллийг нэгтгэх, боловсруулах, хадгалах, хамгаалах болон хөдөлмөр

эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, технологийн хувьд хариуцаж, хэвийн ажиллуулах чиг үүргийг энэ хуулийн 29.5-д заасан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

19.2.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны болон аюулгүй байдал, хамгаалалтын журам, стандартыг тогтоох, хяналт тавих, программ болон техник хангамжийг хөгжүүлэх чиг үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.
*/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

**20 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн эх үүсвэр ба бүртгэл**

20.1.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн эх үүсвэр нь иргэн, ажил олгогч, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна.

20.2.Ажил олгогч нь ажиллах хүч болон ажлын байрны холбогдолтой мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирждид гарган өгөх, эсхүл түүний бүртгэл, мэдээллийн сүлжээнд бүртгүүлж, мэдээллээ байршуулах, мэдээлэлд оруулж байгаа өөрчлөлтийг тухай бүрд нь хийж байх үүрэгтэй бөгөөд ажил олгогч нь нийт ажлын байрныхаа талаарх мэдээллийг оны эхэнд нэг удаа, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг улирал тутам, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг тухай бүр нь энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, хөдөлмөрийн биржид гаргаж өгнө.

20.3.Ажил олгогч энэ хуулийн 20.2-т заасан ажлын байрны талаарх мэдээллээ үнэ төлбөргүй өгнө.

20.4.Иргэн өөрөө интернэтийн орчинд болон хөдөлмөрийн биржид очиж мэдээллийн санд бүртгүүлж, мэдээллээ байршуулах ба хэрэгцээт мэдээллээ олж авч болно.

20.5.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын болон ажил олоход хүндрэлтэй иргэний талаарх бүртгэл, мэдээллийг нэгтгэж, хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулна.
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

20.6.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь улсын бүртгэл, статистик, татвар, нийгмийн даатгал, халамжийн асуудал эрхэлсэн холбогдох байгууллагатай тайлан, мэдээ, мэдээлэл, холбогдох баримт бичгийг харилцан үнэ төлбөргүй солилцоно.

20.7.Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн маягтыг статистикийн төв байгууллагын даргын зөвшөөрснөөр хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

**21 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан**

21.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг байгуулна.

21.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно.

**22 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр**

22.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

22.1.4.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр;

22.1.5.гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;

22.1.6.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;

22.1.7.хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;

22.1.8.жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө;
*/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/*

22.1.9.бусад эх үүсвэр.
*/Энэ заалтын дугаарт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

22.2.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэх үйл ажиллагааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

**23 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт**

23.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна:

23.1.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

23.1.2.ажилд зуучлах;

23.1.3.хөдөлмөрт бэлтгэх;

23.1.4.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

23.1.5.ажил олгогчийг дэмжих;

23.1.6.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;

23.1.7.малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
*/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

23.1.8.ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

23.1.9.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;

23.1.10.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтийг хянах, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, сурталчилгаа явуулах, гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэж хэвлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх;

23.1.11.хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх.

23.1.12.сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар сум хөгжүүлэх санд хөрөнгө хуваарилах.
*/Энэ заалтыг 2012 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн ба 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

23.1.13.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих зориулалтаар мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хөрөнгө хуваарилах.
*/Энэ заалтылг 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд үүнийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*

23.2.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу зарцуулна.

23.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

23.4.Энэ хуулийн 23.1.12-т заасан хөрөнгийн хэмжээг Засгийн газар тогтооно.
*/Энэ хэсгийг 2012 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн ба 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

23.5.Энэ хуулийн 22.1.7-д заасан төлбөрийг тухайн орлогыг бүрдүүлсэн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна.
*/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/*

**24 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын төсөв**

24.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилна.

24.2./Энэ хэсгийг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

24.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тухайн жилд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харгалзан Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал батална.

24.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсвийн хуваарийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэнэ.

**25 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлан,тэнцэл гаргах**

25.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргаж ирүүлэх:

25.1.1.улирлын тайланг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор, аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;
*/Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

25.1.2.хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улирлын нэгдсэн тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын төв байгууллагад.
*/Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

**26 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн бүртгэл, тайлангийн маягт**

26.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл, тайлангийн маягтын загварыг санхүү, төсвийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

# ЗУРГАДУГААР БҮЛЭГ
# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 27 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо

27.1.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржээс бүрдэнэ.
*/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

27.2.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл нь нийгмийн зөвшилцлийн байгууллага байна.

27.3.Хөдөлмөрийн бирж нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний байгууллага байх бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээнд холбогдсон төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаас бүрдэнэ.

## 28 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл

28.1.Засгийн газар, ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийг байгуулж, ажиллуулна.

28.2.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн энэ хуулийн 28.1-д заасан гурван талын төлөөлөгчдийн тоо адил байна.

28.3.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрмийг ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагатай зөвшилцөн Засгийн газар, хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/ батална.

28.4.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор Ерөнхий сайд 4 жилийн хугацаагаар батлах бөгөөд Үндэсний зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй байна:

28.4.1.Засгийн газрыг төлөөлж хөдөлмөрийн, санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг хүн;

28.4.2.ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гурван хүн;

28.4.3.ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагаас гурван хүн.

28.5.Үндэсний зөвлөлийн дарга нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

28.6.Үндэсний зөвлөлийн орлогч даргыг энэ хуулийн 28.1-д заасан гурван тал зөвшилцөж, аль нэг талын төлөөлөгчөөс хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар батална.

28.7.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүнээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглоно.

28.8.Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.8.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

28.8.2.төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, стратеги, хөтөлбөрийн талаар санал боловсруулах, хэлэлцэх, энэ хуулийн 6.3.1-6.3.4, 6.3.6-д заасан төсөл, хөтөлбөрийг хэлэлцэн батлах;

28.8.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тайлан, мэдээлэл болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хийсэн хөндлөнгийн байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх;

28.8.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг хуваарилах асуудлыг хэлэлцэж, зөвлөмж гаргах, тус сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих;

28.8.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

28.8.6.хөдөлмөр эрхлэлтийн болон ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн хяналт, шинжилгээний дүнг хэлэлцэх, түүнд үндэслэн хууль тогтоомж, хөтөлбөрийг боловсронгуй болгох талаар зөвлөмж гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

28.8.7.гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөрийн хэмжээг тогтоох, тухайн жилд авах гадаадын мэргэжилтэй ажилчдын хэрэгцээг тодорхойлох асуудлаар зөвлөмж гаргаж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

28.9.Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгож болох бөгөөд уг урамшууллын хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

**29 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага**

29.1./Энэ хэсгийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

29.2./Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

*/Энэ хэсгийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

29.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

*/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

29.4.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтныг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын дарга томилж, чөлөөлнө.
*/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

29.5.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Хөдөлмөрийн төв бирж ажиллана.
*/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*
*/Энэ хэсгийг 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

29.6.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь улсын төсвөөс санхүүжинэ.
*/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

29.7.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын дүрмийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
*/Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

29.8./Энэ хэсгийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

29.9.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

29.9.1.энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил бүр тусгуулах талаар санал боловсруулах;

29.9.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих;

29.9.3.харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийт ажлын байр, шинээр бий болсон, байхгүй болсон болон сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг ажил олгогчоос гаргуулан авах;

29.9.4.ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучлах;

29.9.5.энэ хуулийн 9.2-т заасан санал, дүгнэлт гаргах, хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих;

29.9.6.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийг байгууллага, иргэнд сурталчлах;

29.9.7.аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;

29.9.8.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх;

29.9.9.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;
*/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/*

29.9.10.мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх;
*/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/*

29.9.11.жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх;
*/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/*

29.9.12.хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах, хяналт тавих.
*/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/*

29.9.13.энэ хуулийн 22.1.7-д заасан төлбөрийг төвлөрүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;
*/Энэ заалтыг 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн/*

29.9.14.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.
*/Энэ заалтын дугаарт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хууль, 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

29.10.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

29.10.1.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн урт болон богино хугацааны төлөв байдлыг судлах, хэтийн тооцоо боловсруулах;

29.10.2.хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээллээр иргэн, ажил олгогчийг хангах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах;

29.10.3.хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний талаарх мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, нийтэд үйлчлэх;

29.10.4.энэ хуулийн 9.2-т заасан санал, дүгнэлт гаргах;

29.10.5.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээнд холбогдсон байгууллагыг программ хангамж болон мэргэжил, арга зүй, техникийн удирдлагаар хангаж, мэдээллийн нэгдмэл орчинд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

29.10.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

29.11.Хөдөлмөрийн бирж нь энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

29.11.1.хөдөлмөрийн зах зээлд оролцогчийг бүртгэх, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх;

29.11.2.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох;

29.11.3.ажилд зуучлах;

29.11.4.нийт болон сул чөлөөтэй ажлын байр, шинээр бий болсон, байхгүй болсон ажлын байрны, түүнчлэн ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний зэрэг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулан авч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах;

29.11.5.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

29.11.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

29.12.Хөдөлмөрийн бирж нь нэг цэгийн үйлчилгээний танхим, техник хэрэгслэлээр хангагдаж, хэрэглэгчид мэдээллийн интернэтийн орчинд ажиллах боломжийг хангасан, зохих мэдлэг, ур чадвар эзэмшсэн үйлчилгээний ажилтантай байх нийтлэг шаардлагыг хангасан байна.

29.13.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан /хөдөлмөрийн алба/ нь энэ хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
*/Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хууль, 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

29.13.1.нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажил олоход хүндрэлтэй иргэн, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдах иргэн болон үйлчилгээ үзүүлэгч, ажил олгогчийн бүртгэлийг хөтөлж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах;

29.13.2.нутаг дэвсгэрийн хэмжээнд ажиллах хүчний болон ажлын байрны холбогдолтой мэдээ, мэдээллийг ажил олгогчоос гаргуулан авч, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, эсхүл хөдөлмөрийн биржид хүргүүлэх;
*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

29.13.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах иргэний хэрэгцээг тодорхойлох;

29.13.4.хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээллээр иргэн, ажил олгогчийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийг сурталчлах;

29.13.5.хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг, дунд үйлдвэрийн талаарх хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих.
*/Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/*

29.13.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.
*/Энэ заалтын дугаарт 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

**30 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллага, Хурлын болон Засаг даргын бүрэн эрх**

30.1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.төрийн бодлогын үндэслэл, чиглэлийг боловсруулж, хууль тогтоомж, дүрэм, журам, төсөл хөтөлбөрийн болон бусад шийдвэрийн төсөлд тусгуулах, шийдвэрлүүлэх, бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах;

30.1.2.хууль тогтоомж, дүрэм, журам, төсөл, хөтөлбөрийн болон бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ, салбарын хүрээний болон салбар дундын зохицуулалт хийх;

30.1.3.хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний стандарт, нормативыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

30.1.4.хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, богино, дунд хугацааны болон хэтийн зорилтыг боловсруулах;

30.1.5.хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг бодлогын удирдамж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;

30.1.6.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэр, төсөв, тусгай зориулалтын сан, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх, зарцуулалтад хяналт тавих, үнэлж дүгнэх;

30.1.7.хөдөлмөрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхижуулах сургалт зохион байгуулах;

30.1.8.хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн сургалтын бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах;

30.1.9.Үндэсний зөвлөлийн зөвлөмж, санал, дүгнэлтийг хэлэлцэх, хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

30.1.10.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр уг хөрөнгийг нөхөн төлүүлэх, санхүүжилтийг зогсоох, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

30.1.11.ажилгүйдлийн даатгалын тэтгэмжтэй холбогдсон иргэний санал, гомдлыг судалж шийдвэрлэх;

30.1.12.хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад шаардлагатай мэдээлэл, тооцоо, судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

30.1.13.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнах;
*/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

30.1.14.хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний судалгааг тодорхой давтамжтайгаар хийх, мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хэтийн тооцооллын загвар боловсруулах,
*/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*
*/Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

30.1.15./Энэ заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

30.1.16.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бүрдүүлэх, хөрөнгийн хуваарилалтын төслийг боловсруулах, батлуулах, хөрөнгийг баталсан

хуваарийн дагуу зарцуулах, хяналт тавих, тайлагнах;
*/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

30.1.17.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж, гадаадад ажиллах хүч илгээх болон гадаадаас ажиллах хүч авахад зуучлах байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;
*/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*
*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

30.1.18.хууль тогтоомжид заасан бусад эрх.
*/Энэ заалтын дугаарт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

30.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.2.1.энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил бүр тусган батлах;

30.2.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах;

30.2.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн талаар тайлан, мэдээллийг сонсох, энэ хуулийн 30.3-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй бол Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32.2-т заасан арга хэмжээг авах;

30.2.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

30.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.3.1.энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусгуулах талаар жил бүр санал боловсруулах;

30.3.2.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах, хянах;

30.3.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах;

30.3.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**31 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоо, эрх, үүрэг**

31.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч иргэн энэ хуульд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна:

31.1.1.хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдах хүсэлтээ сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид гаргаж бүртгүүлэх, бүртгүүлсний дараа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтан, хөдөлмөрийн биржтэй холбогдох журмын дагуу идэвхтэй харилцаж, хамтран ажиллах;

31.1.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ хуульд заасны дагуу олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнгийн болон санхүүгийн тайланг сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад заасан хугацаанд ирүүлэх;
**/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/**

31.1.3.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага болон хөдөлмөрийн биржээс санал болгосон ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнээс сонголт хийх.
*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

31.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуульд зааснаас гадна дараах үүрэгтэй байна:
31.2.1.ажил олгогч нь нийт болон сул чөлөөтэй ажлын байр, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу тогтоосон хугацаанд, ажиллагчдынхаа ур чадварыг хөгжүүлэх сургалтын хэрэгцээг тухай бүр аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлэх;
*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

31.2.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 40.5-д заасан нөхцөлөөр ажилтнуудыг бөөнөөр халах, цомхотгох тохиолдолд энэ тухайгаа харьяалах аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад нэг сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэх;
*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

31.2.3.сул чөлөөтэй ажлын байранд аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржээс санал болгосон иргэнийг ажилд авсан бол шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн байгууллагад эргэж мэдэгдэх;
*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

31.2.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүний хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлан, мэдээг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад улирал тутам гаргаж ирүүлэх;
/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.2.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнгийн болон санхүүгийн тайланг сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх;
*/Энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

31.2.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.
31.3.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага болон хөдөлмөрийн биржээс

санал болгосон иргэнийг ажлын байрны шаардлагад нийцүүлэн сонгож ажилд авах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд өөрийн сонголтын дагуу оролцох эрхтэй.
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

31.4.Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэний талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас тухай бүр харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэж, уг байгууллага иргэний хүсэлтийн дагуу бүртгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулна.
*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

***32 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт***

32.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавина:

32.1.1.Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд;

32.1.2.мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллага.

32.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

**33 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

33.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд дараах захиргааны шийтгэлийг хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч ногдуулна:

33.1.1.энэ хуулийн 4.1.1-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-250000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 500000-1000000 төгрөгөөр торгох;

33.1.2.энэ хуулийн 9.2, 9.4.-т заасныг зөрчсөн бол хохирлыг нөхөн төлүүлж, гэм буруутай албан тушаалтныг 100000-250000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 500000-1000000 төгрөгөөр торгох;

33.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, эсхүл хууль бусаар ашигласан бол хохирлыг нөхөн төлүүлж, албан тушаалтныг 500000-1000000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 1000000-2500000 төгрөгөөр торгох;

33.1.4.энэ хуулийн 20.2-т заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг 250000-500000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 1000000-1500000 мянган төгрөгөөр торгох;

33.1.5.энэ хуулийн 31.2.2-д заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-250000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 500000-1500000 төгрөгөөр торгох.

**33 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

33.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

33.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаар заасан бөгөөд үүнийг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*

**34 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

34.1.Энэ хуулийг 2011 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

34.2.Энэ хуулийн 13.2 дахь хэсгийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр** **Улаанбаатар хот**

# ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

### 2 дугаар зүйл.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх, хөгжлийн бодлого төлөвлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэж Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.2.“аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт” гэж бүсчилсэн хөгжлийн бодлогод суурилсан, орон нутгийн онцлогийг харгалзан, байгаль орчны

тогтвортой байдлыг хангасан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилго, зорилтыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.3.“бүсчилсэн хөгжлийн бодлого” гэж Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.4.“дэд хөтөлбөр” гэж Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.5.“Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж бүсчилсэн хөгжлийн бодлого болон аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод суурилсан, орон нутгийн сонгуулиар олонх суудал авсан улс төрийн нам, улс төрийн намуудын эвслийн мөрийн хөтөлбөрийг тусгасан, орон нутгийн хөгжлийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.6.“Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогод суурилсан, Улсын Их Хурлын сонгуулиар олонх суудал авсан улс төрийн нам, улс төрийн намуудын эвслийн мөрийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдсан, хөгжлийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.7.“Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, эдийн засаг, нийгмийн хөгжлийг ахисан түвшинд хүргэх, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангахад чиглэсэн баримт бичгийг;

4.1.8.“төрөөс баримтлах бодлого” гэж Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, түүнд заасан тэргүүлэх чиглэлийн хүрээнд салбарын болон салбар хоорондын хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.9.“улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;

4.1.10.“улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.11.“үндэсний хөтөлбөр” гэж төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.12.“хөгжлийн бодлогын баримт бичиг” гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичгийг.

**5 дугаар зүйл.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчим**

5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
5.1.2.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
5.1.3.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
5.1.5.нөөц бололцоонд үндэслэсэн байх;
5.1.6.ил тод, нээлттэй байх;
5.1.7.олон нийтийн оролцоог хангасан байх.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

### 6 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл

6.1.Хөгжлийн бодлогын баримт бичиг нь дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран дараах төрөлтэй байна:

6.1.1. урт хугацааны;
6.1.2.дунд хугацааны;
6.1.3.богино хугацааны.

6.2.Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.

6.3.Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:

6.3.1.төрөөс баримтлах бодлого;
6.3.2.бүсчилсэн хөгжлийн бодлого;
6.3.3.аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.

6.4.Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:

6.4.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
6.4.2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
6.4.3.үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;
6.4.4.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.

6.5.Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:

6.5.1.улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
6.5.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
6.5.3.Энэ хуулийн 6.5.1-д заасан үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв.

6.6.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг Засгийн газар батална.

### 7 дугаар зүйл.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал

7. 1.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжил, тэгш, хүртээмжтэй өсөлтийг хангахад чиглэсэн зорилго, зорилт, хүрэх үр дүнг нөөц, эх үүсвэртэй нь уялдуулан тооцсон хөгжлийн загварт суурилсан байна.

7.2.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах талаар Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу удирдамж гаргаж, төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна.

7.3.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэдийн оролцоог ханган боловсруулна.

7.4.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

7.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 7.5-д заасан тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

7.7.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

7.8.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулна.

7.9.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна.

7.10.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхийг Үндэсний аудитын газар хянаж, Сонгуулийн ерөнхий хороонд дүгнэлтээ хүргүүлнэ.

**8 дугаар зүйл.Төрөөс баримтлах бодлого**

8.1.Төрөөс баримтлах бодлого нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын тэргүүлэх чиглэлийг дунд хугацаанд салбарын болон салбар хоорондын түвшинд цогц байдлаар хэрэгжүүлэх төрийн бодлогын чиглэл, үйл ажиллагааны зарчим, залгамж чанарыг хадгалсан байна.

8.2.Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

8.3.Төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулахдаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангана.

8.4.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

8.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.

8.6.Төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

**9 дүгээр зүйл.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр**

9.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн болон бодит салбарын өсөлтийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг хангах, нийгмийн хөгжлийн хүртээмжийг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй эдийн засгийн хөгжлийг хангах, хүн амын амьжиргааны түвшинг сайжруулахад чиглэнэ.

9.2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

9.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газар батална.

9.4.Төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

9.5.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, энэ хуулийн 9.4-т заасан тайлан болон хөндлөнгийн үнэлгээний тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

9.6.Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

**10 дугаар зүйл.Үндэсний хөтөлбөр**

10.1.Үндэсний хөтөлбөрт төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг нарийвчлан төлөвлөсөн байна.

10.2.Өмнө батлагдсан ижил төстэй үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилт, агуулгын хүрээнд шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалтыг энэ хуулийн 9.3-т заасан төлөвлөгөөний хамт Засгийн газар батална.

10.3.Энэ хуулийн 10.2-т заасан жагсаалтад орсон үндэсний хөтөлбөрийг төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

10.4.Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

10.5.Үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсөв болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгана.

10.6.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.

10.7.Төрийн захиргааны төв байгууллага жил бүр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газарт танилцуулна.

**11 дүгээр зүйл.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр**

11.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

11.2.Жил бүрийн улсын төсөв, төсвийн тодотголд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт заасан төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийн болон урсгал зардлын санхүүгийн эх үүсвэрийг тусгаж байна.

11.3.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөж, батлахад Төсвийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлийг баримтална.

11.4.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

*/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. /*

**12 дугаар зүйл.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл**

12.1.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэслэн боловсруулна.

12.2.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн холбогдох заалт, зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгасан байна.

12.3.Нутгийн захиргааны байгууллага нь үндэсний хэмжээний бодлогын чанартай арга хэмжээ болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хязгаарыг хангаж байгаа төсөл, арга хэмжээний саналыг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулахаар жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн захиргааны төв байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.4.Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

12.5.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан тухайн салбарын зарлагын дээд хязгаараас хэтрэхгүй байна.

12.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг хүлээн авч нэгтгэн, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газарт хүргүүлнэ.

12.7.Засгийн газар улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хянан хэлэлцэж, жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

12.8.Улсын Их Хурал Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэн батална.

12.9.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.

12.10.Засгийн газар улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

**13 дугаар зүйл.Бүсчилсэн хөгжлийн бодлого**

13.1.Бүсчилсэн хөгжлийн бодлого нь байгалийн баялаг, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглах үндсэн дээр хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулах, төвлөрлийг сааруулах, аймаг, бүс нутаг хоорондын хөгжлийн түвшинг ойртуулах, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэхэд чиглэнэ.

13.2.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.

*/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. /*

13.3.Бүсчилсэн хөгжлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай, Хот байгуулалтын тухай хуультай уялдуулан боловсруулна.

13.4.Бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх ба бүс нутгийн хөгжлийг хангах зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлсон байна.

13.5.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

*/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. /*

13.6.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газарт хүргүүлнэ.

**14 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт**

14.1.Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

14.2.Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж болно.

14.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн, Засаг даргын саналыг үндэслэн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахад энэ хуулийн 21 дүгээр зүйлийг баримтална.

14.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.

14.5.Сум, дүүргийн түвшинд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлоготой байж болно.

14.6.Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

**15 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр**

15.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

15.2.Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

15.3.Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тооцоолохдоо Төсвийн тухай хуулийн 9 дүгээр бүлэгт заасныг мөрдөнө.

15.4.Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.

15.5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засаг даргын бүрэн эрхэд үл хамаарах асуудал болон хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, үндэслэлгүй зорилт, арга хэмжээг тусгахыг хориглоно.

15.6.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг төсөв, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан, дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

15.7.Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

15.8.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

**16 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл**

16.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна.

16.2.Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

16.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.

16.4.Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.

16.5.Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА, САНХҮҮЖИЛТ

**17 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, тавигдах шаардлага**

17.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг доор дурдсан дараалын дагуу боловсруулна:

17.1.1.хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

17.1.2.асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах;

17.1.3.бодлогын хувилбарыг доорх шалгуурын дагуу үнэлж, оновчтой хувилбарыг сонгоно:

17.1.3.а.дэлхий нийтийн болон бүс нутгийн хөгжлийн хандлага, хамтын ажиллагааг харгалзан өөрийн орны хөгжлийн онцлогийг тусгасан эсэх;

17.1.3.б.эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэрт байдалд суурилан тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэх;

17.1.3.в.олон нийтийн эрх, ашиг сонирхолд нийцсэн эсэх;

17.1.3.г.тэгш, хүртээмжтэй байдлыг хангасан эсэх;

17.1.3.д.бодлогын үр ашиг, хэрэгжих үндэслэл бодитой эсэх.

17.1.4.хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна.

17.2.Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх, түүнд тусгагдсан төсөв, санхүүгийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

**18 дугаар зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр**

18.1.Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.

18.2.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилт нь дараах эх үүсвэртэй байна:

18.2.1.улсын болон орон нутгийн төсөв;

18.2.2.гадаадын зээл, тусламж;

18.2.3.гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

18.2.4.Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас;

18.2.5.концессын гэрээ;

18.2.6.бусад эх үүсвэр.

**19 дүгээр зүйл.Олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах**

19.1.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг хэвлэн нийтлэх, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагааг холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр хэлэлцүүлэг зохион байгуулж болно:

19.2.1.хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;

19.2.2.эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд;

19.2.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;

19.2.4.төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.

19.3.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.2-т заасан хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусган боловсруулж, төслийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## БУСАД

**20 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

20.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэгч байгууллага нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвийн багцад тусгаж, батлуулсан байна.

20.2.Энэ хуулийн 7-16 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг Засгийн газар батална.

**21 дүгээр зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

21.1.Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

21.1.1.хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон;

21.1.2.гадаад, дотоод орчны нөлөөлөл, хүчин зүйлээс шалтгаалан улсын эдийн засаг, нийгэм, төсөв, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн;

21.1.3.Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон.

21.2.Дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлнэ.

21.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн үр дүн нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.

21.4.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.

**22 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэвлэн нийтлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, арга зүйн удирдамжаар хангах**

22.1.Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

22.2.Төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.

22.3.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө.

*/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. /*

22.4.Энэ хуулийн 22.2-т заасан эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална.
*/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. /*

22.5.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлнэ.
*/Энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. /*

22.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ Бодлогын судалгааны хүрээлэн ажиллуулж болно.

**23 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

23.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг Төрийн албаны тухай, Төсвийн тухай болон холбогдох бусад хуульд зааснаар зохицуулна.

**24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

24.1.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр** **Улаанбаатар хот**

**Дугаар 19**

## МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030 БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал баталсантай холбогдуулан доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т үүрэг болгосугай:

1/Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2/Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах;

3/Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын бүтэц, тогтолцоог бий болгох;

4/Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж байх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /А.Бакей/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай” Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 26 дугаар тогтоол, “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

*Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт*

# МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030

Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр Монгол Улс 2030 онд:

1.Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17500 америк долларт хүрч, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ.

2.Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна.

3.Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.

4.Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.

5.Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100 хувьд хүргэж, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ.

6.Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэнэ.

7.Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно.

8.Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно.

9.Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно.

10.Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна.

# НЭГ. "МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030"-ЫН ҮР ДҮНГ ИЛЭРХИЙЛЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцыг дараахь 20 үндсэн үзүүлэлтээр тодорхойлж үнэлнэ:

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин (2014 он) | Зорилтот түвшин (2030 он) |
|---|---|---|---|---|
| 1 | Эдийн засгийн жилийн дундаж өсөлт | хувь | 7.8 | 6.6[1] |
| 2 | Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого | ам.доллар | 4166 | 17500 |
| 3 | Хүний хөгжлийн үзүүлэлт | эзлэх байр | 90 | 70 |
| 4 | Дундаж наслалт | жил | 69.57 | 78 |
| 5 | Ядуурлын түвшин | хувь | 21.6 | 0 |
| 6 | Өрсөлдөх чадварын үзүүлэлт | эзлэх байр | 104 | 70 |
| 7 | Бизнес эрхлэлтийн үзүүлэлт | эзлэх байр | 56 | 40 |
| 8 | Байгаль орчны багц үзүүлэлт | эзлэх байр | 111 | 90 |
| 9 | Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал | хувь | 84.4 | 99 |
| 10 | Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт | оноо | 36.5 | 30.0 |
| 11 | 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин | промиль | 15.1 | 8 |
| 12 | 100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин | промиль | 30.6 | 15 |
| 13 | Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж) | хүүхдийн тоо | 27.3 | 20 |
| 14 | Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ | хувь | 0 | 60 |
| 15 | Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ | хувь | 78.2 | 68 |
| 16 | Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ | хувь | 17.4 | 30 |
| 17 | Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо | сая хүн | 0.392 | 2.0 |
| 18 | Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх | хувь | 89 | 100 |
| 19 | Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ | хувь | 17 | 50 |
| 20 | Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь | хувь | 0 | 100 |

[1]2016-2030 оны дундаж

# ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

## 2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-химы, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах макро эдийн засаг, салбарын хөгжлийн бодлого нь дараахь суурь зарчимд тулгуурлана:

**Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим:**

· урт хугацааны эдийн засгийн дундаж өсөлтийг 6.6 хувиас доошгүй байлгах;

· нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах, төсвийн тэнцлийн алдагдалын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ 2020 онд 15 хувь, 2025 онд 10 хувь хүртэл бууруулах;

· төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлах, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн нийт зарлага /улсын нэгдсэн төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтийг бүхэлд нь тооцсоноор/-ыг 2020 онд 35 хувь, 2030 онд 30 хувь хүртэл бууруулах;

· өрийн дээд хязгаарыг чанд сахин мөрдөж, өрийн зохистой түвшинг хангах, гадаад зах зээл дэх Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтмол дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх;

· гадаад зах зээлийн болон түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзлээс сэргийлэх бодлогыг баримталж, хуримтлалын санг бий болгон арвижуулах;

· гадаад валютын нөөцийн зохистой хэмжээг байнга бүрдүүлж байх;

· төлбөрийн тэнцлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийг тогтвортой, нам түвшинд барих;

· банк, санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, эрсдэлгүй, найдвартай байдлыг чанд хангаж, хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх;

·олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн шинжтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлэх;

· урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах.

**Салбарын хөгжлийн зорилтыг хангах зарчим:**

· өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах;

· байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэлийг дэмжих;
· үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг эдийн засаг, нийгмийн бүх салбарт чанд баримтлах.

**2.1.1.Хөдөө аж ахуйн салбар**

**Зорилт 1.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нийт газар нутгийн 10-аас доошгүй хувьд хүргэж, мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчинг бүрдүүлж, үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоог боловсронгуй болгох.

**II үе шат (2021-2025):** Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30-аас доошгүй хувьд хүргэж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний экспортод гаргах боломжийг өргөтгөх, мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчинг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцсэн үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоонд шилжих.

**III үе шат (2026-2030):** Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нийт газар нутгийн 60-аас доошгүй хувьд хүргэж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний экспортод гаргах боломжийг өргөтгөх, олон улсын стандартад нийцсэн үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоотой болох.

**Зорилт 2.Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг гурван хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 100.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд бий болгох.

**II үе шат (2021-2025):** Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг таван хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 150.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд хөгжүүлэх.

**III үе шат (2026-2030):** Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг найман хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 200.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн үндэсний сүлжээг хөгжүүлэх.

**Зорилт 3.Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлтийн технологи нэвтрүүлэх ажлыг 70 хувьд, усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 65.0 мянган га-д, жилд шаардагдах бордооны хангамжийг 50 хувьд, нутагшсан сортын элит үрийн хангамжийг 75 хувьд тус тус хүргэн, тариаланд ашиглагдаж байгаа талбайн хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж, элэгдэл, эвдрэлийг сааруулах.

**II үе шат (2021-2025):** Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлтийн технологи нэвтрүүлэх ажлыг 85 хувьд, усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 100.0 мянган га-д, жилд шаардагдах бордооны хангамжийг 70 хувьд, нутагшсан сортын элит үрийн хангамжийг 90 хувьд тус тус хүргэн, тариаланд ашиглагдаж байгаа талбайн хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж, элэгдэл, эвдрэлийг сааруулах.

**III үе шат (2026-2030):** Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлтийн технологи нэвтрүүлэх ажлыг 90 хувьд, усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 120.0 мянган га-д, жилд шаардагдах бордооны хангамжийг 100 хувьд, нутагшсан сортын элит үрийн хангамжийг 100 хувьд тус тус хүргэн, тариаланд ашиглагдаж байгаа талбайн хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж, элэгдэл, эвдрэлийг сааруулах.

**Зорилт 4.Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Малчин, тариаланчдын 50 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

**II үе шат (2021-2025):** Малчин, тариаланчдын 75 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрх, тариаланчдын бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгох.

**III үе шат (2026-2030):** Малчин, тариаланчид бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болсон байх.

### 2.1.2.Аялал жуулчлалын салбар

**Зорилт 1.Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.**

**I үе шат (2016-2020):** Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэх.

**II үе шат (2021-2025):** Бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах, гадаадын жуулчдын тоог 1.5 саяд хүргэх.

**III үе шат (2026-2030):** Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчлан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэн, гадаадын жуулчдын тоог 2.0 саяд хүргэх.

### 2.1.3.Аж үйлдвэрийн салбар

**Зорилт 1.Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.**

**I үе шат (2016-2020):** Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.

**II үе шат (2021-2025):** Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 25 хувьд хүргэж, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 70 хувьд хүргэх.

**III үе шат (2026-2030):** Бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэх.

**Зорилт 2.Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 30 хувь, сүүний 40 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах.

**II үе шат (2021-2025):** Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр хангах, шинжлэх ухааны өндөр түвшний технологи нэвтрүүлж, олон улсын зах зээлд “Монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүн гаргах, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 50 хувь, сүүний 60 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах.

**III үе шат (2026-2030):** Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр бүрэн хангах, олон улсын зах зээлд “Монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлэх, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 70 хувь, сүүний 80 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах.

**Зорилт 3.Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.**

**I үе шат (2016-2020):** Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.

**II үе шат (2021-2025):** Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээний 70 хувийг Евро 5 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

**III үе шат (2026-2030):** Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр 100 хувь хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

**Зорилт 4.Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.**

**I үе шат (2016-2020):** Жилд 100.0 мянган тонн ган бөмбөлөг, тээрмийн хуяг, бусад эд анги үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулах.

**II үе шат (2021-2025):** Жилд 100.0 мянган тонн ган туйван, барилгын болон төмөр замын металл хийц үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулах.

**III үе шат (2026-2030):** Төмөр, ган, хайлшийн бүтээгдэхүүний экспортын орлогыг нэмэгдүүлэх.

**2.1.4.Эрдэс баялгийн салбар**

**Зорилт 1.Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.**

**I үе шат (2016-2020):** Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулан, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн

зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх.

**II үе шат (2021-2025):** Геомэдээллийн нэгдсэн сан бий болгож, ашигт малтмал хайгуулын салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын хэмжээнд 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 45 хувьд гүйцэтгэх.

**III үе шат (2026-2030):** Ашигт малтмалын эрдсийн хуримтлал бүхий талбайд нарийвчилсан эрлийн ажлыг хийх, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын хэмжээнд 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 50 хувьд гүйцэтгэх.

**Зорилт 2.Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах.

**II үе шат (2021-2025):** Усан хангамжийн найдвартай эх үүсвэрийн төслүүдийг хэрэгжүүлж, уул уурхайн томоохон төслүүдийн үйлдвэрлэлийн бүрэн хүчин чадлыг эзэмших.

**III үе шат (2026-2030):** Уул уурхайн томоохон төслүүдийн шинэ бүтээн байгуулалтыг эхлүүлж, дэд бүтцийг хөгжүүлэх.

**2.1.5.Дэд бүтцийн салбар**

**Зорилт 1.Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.**

**I үе шат (2016-2020):** Эрчим хүчний хэрэгцээнийхээ 85 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.

**II үе шат (2021-2025):** Эрчим хүчний хэрэгцээнийхээ 90 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.

**III үе шат (2026-2030):** Эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүчний экспортлогч орон болох.

**Зорилт 2.Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана.**

**I үе шат (2016-2020):** Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах.

**II үе шат (2021-2025):** Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 25-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг бүрэн хангах.

**III үе шат (2026-2030):** Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглаж эхлэх.

**Зорилт 3.Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр ложистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж, Ухаа

худаг–Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх.

**II үе шат (2021-2025):** Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхайн салбарт түшиглэсэн тээвэр ложистикийн төвүүдийг барьж ашиглалтад оруулах, тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 800 км-ээр нэмэгдүүлж, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж дуусгах, бүсүүдийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх.

**III үе шат (2026-2030):** Тээвэр ложистикийн шинэ төвүүдийг хөгжүүлж, улсын болон олон улсын чанартай авто замын уртыг 470 км-ээр нэмэгдүүлж, бүсүүдийн төмөр замыг барьж дуусгах.

**Зорилт 4.Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, аймаг болон томоохон сумдын нисэх буудлыг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх, Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг барьж дуусгах.

**II үе шат (2021-2025):** Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, үндэсний нисэхийн нөөц буудал байгуулах, агаарын тээвэрт чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх, орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгох.

**III үе шат (2026-2030):** Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, үндэсний агаарын тээврийн сүлжээг хөгжүүлж, бүс нутагт агаарын тээврийн транзит төвийг хөгжүүлэх.

**Зорилт 5.Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.**

**I үе шат (2016-2020):** “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг үе шаттай хэрэгжүүлэх, аймгийн төвүүдийн хөгжлийн болон улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх.

**II үе шат (2021-2025):** Аж үйлдвэрийн хөгжлийн тэргүүлэх бүсийг тогтоож, хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан мөрдүүлэх, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулах, газар нутаг ашиглалтын мастер төлөвлөгөөг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд тус тус боловсруулж, мөрдүүлэх.

**III үе шат (2026-2030):** Хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үргэлжлүүлэн боловсруулж, мөрдүүлэх.

**Зорилт 6.Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй,**

**тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот, суурин дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах.

**II үе шат (2021-2025):** Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг хот, суурин газруудад хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 25 хувиар бууруулах.

**III үе шат (2026-2030):** Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, олон улсын стандартад нийцсэн эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлсэн хот, суурин газруудыг хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 40 хувиар бууруулах.

**Зорилт 7.Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө.**

**I үе шат (2016-2020):** Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээг арав дахин нэмэгдүүлэх.

**II үе шат (2021-2025):** Нийт хүн амын 90 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, хөдөө, орон нутгийн хүн амын 70 хувь нь өргөн зурвасын интернетийн үйлчилгээ ашиглах, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 50-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлэх.

**III үе шат (2026-2030):** Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах.

### 2.1.6.Макро эдийн засгийн бодлого

**Зорилт 1.Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна.**

**I үе шат (2016-2020):** Улсын төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас ихгүй байхаар төлөвлөх.

**II үе шат (2021-2025):** Улсын төсвийг алдагдалгүй төлөвлөж, хэрэгжүүлэх.

**III үе шат (2026-2030):** Улсын төсвийг алдагдалгүй төлөвлөж, хуримтлалын санг үүсгэх.

**Зорилт 2.Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкны бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ.**

**I үе шат (2016-2020):** Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг

10 хувьд хүргэн нэмэгдүүлэх, арилжааны банкны эзлэх хувийг 90 хувьд хүргэн бууруулах, даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөх.

**II үе шат (2021-2025):** Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12 хувьд хүргэн нэмэгдүүлэх, арилжааны банкны эзлэх хувийг 86 хувьд хүргэн бууруулах, даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөх.

**III үе шат (2026-2030):** Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 16 хувьд хүргэн нэмэгдүүлэх, арилжааны банкны эзлэх хувийг 82 хувьд хүргэн бууруулах, даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөх.

**Зорилт 3.Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, гадаад, дотоод өрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон төлөвшүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Хөгжлийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгоно. Тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 58,6 хувиас хэтрүүлэхгүй байж, өрийн зохистой түвшинг хангах.

**II үе шат (2021-2025):** Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлэн бэхжүүлнэ. Өрийн удирдлагын оновчтой тогтолцоог хөгжүүлж, гадаад өрийн ачааллыг зохистойгоор удирдаж, өрийн дээд хязгаарыг чанд баримтлан, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 50 хувиас хэтрүүлэхгүй байх.

**III үе шат (2026-2030):** Өрийн дээд хязгаарыг чанд баримтлан, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 40 хувиас хэтрүүлэхгүй байх.

**2.1.7.Бизнесийн таатай орчин**

**Зорилт 1.Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 25 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах.

**II үе шат (2021-2025):** Тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулан, боловсронгуй болгож, гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 18 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах.

**III үе шат (2026-2030):** Худалдаа, үйлчилгээний дэд бүтэц, ложистик сүлжээг хөгжүүлэн экспортын барааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, импортын барааны тээвэрлэлтийн өртөг, зардлыг бууруулж, гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 10 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах.

## 2.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.

**Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:**

· хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх;
· иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;
· эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байх;
· хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах;
· Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэх;
· нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;
· нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;
· нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх;
· хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх.

### 2.2.1.Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал

**Зорилт 1.Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.**

**I үе шат (2016-2020):** Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах.

**II үе шат (2021-2025):** Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулж, нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх.

**III үе шат (2026-2030):** Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхиүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгон, бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын хүн амд эзлэх хувийг 80 хувьд хүргэх.

**Зорилт 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.**

**I үе шат (2016-2020):** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 100 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

**II үе шат (2021-2025):** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 68 хувьд, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд хүргэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн хэмжээг 200 тэрбумаас доошгүй төгрөгт хүргэх.

**III үе шат (2026-2030):** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 70 хувьд, ажилгүйдлийн түвшинг 3 хувьд хүргэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн хэмжээг 300 тэрбумаас доошгүй төгрөгт хүргэх.

**Зорилт 3.Үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Нийгмийн даатгалын /тэтгэврийн, үйлдвэрлэлийн ослын, ажилгүйдлийн, хөдөлмөр эрхлэлтийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн даатгал/ тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлж, сангуудын бие даасан байдал, удирдлага, засаглалыг сайжруулж, захиран зарцуулалт, санхүүгийн менежментийг ил тод болгох.

**II үе шат (2021-2025):** Нийгмийн даатгалын олон давхаргат тогтолцоог боловсронгуй болгох, хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай, зах зээлийн нөхцөлтэй уялдуулан тогтоох.

**III үе шат (2026-2030):** Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгох.

**2.2.2.Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоо**

**Зорилт 1.Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.**

**I үе шат (2016-2020):** Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 71-д хүргэх.

**II үе шат (2021-2025):** Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, нийт сумдыг хамарсан алсын зайн оношилгооны сүлжээг бий болгож, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, хүн амын дундаж наслалтыг 74-д хүргэх.

**III үе шат (2026-2030):** Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, нийт сумдыг хамарсан алсын зайн үндэсний сүлжээг бий болгож, хүн амын дундаж наслалтыг 78-д хүргэх.

**Зорилт 2.Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.**

**I үе шат (2016-2020):** Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 25, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 13 болгож бууруулах.

**II үе шат (2021-2025):** Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 20, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 11 болгож бууруулах.

**III үе шат (2026-2030):** Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 15, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 9, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах.

**Зорилт 3.Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.**

**I үе шат (2016-2020):** Хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулах.

**II үе шат (2021-2025):** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 16, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 9 хүртэл бууруулах.

**III үе шат (2026-2030):** 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 14, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 8 хүртэл бууруулах.

**Зорилт 4.Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.**

**I үе шат (2016-2020):** Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 98.5, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 3, сүрьеэгийн тохиолдлыг

14.4 болгон бууруулах.

**II үе шат (2021-2025):** Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 2.5, сүрьеэгийн тохиолдлыг 14 болгон бууруулах.

**III үе шат (2026-2030):** Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99.8, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 2, сүрьеэгийн тохиолдлыг 13 болгон бууруулах.

**2.2.3.Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн**

**Зорилт 1.Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.

**II үе шат (2021-2025):** Сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог төгөлдөржүүлж, нэг багшид ногдох хүүхдийн тоог 25 хүртэл бууруулж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 80 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.

**III үе шат (2026-2030):** Сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоог 20 хүртэл бууруулж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 90 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.

**Зорилт 2.Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.**

**I үе шат (2016-2020):** Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх.

**II үе шат (2021-2025):** Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 30 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 25-аас илүүгүй байлгах.

**III үе шат (2026-2030):** Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд эзлэх байрыг 5-аар урагшлуулж, сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх сургуулийг 100 хувь хангах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 50 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 20-оос илүүгүй байлгах.

**Зорилт 3.Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог 60.0 мянгад хүргэх.

**II үе шат (2021-2025):** Мэргэжлийн боловсрол, сургалтын эрэлтэд нийцсэн тогтолцоог төлөвшүүлж, суралцагчдын тоог нэмэгдүүлэх.

**III үе шат (2026-2030):** Үндэсний ажиллах хүчний хэрэгцээг мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнээр бүрэн хангах.

**Зорилт 4.Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно.**

**I үе шат (2016-2020):** Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн түншлэлд түшиглэсэн, олон улсын стандартад нийцсэн дээд боловсрол эзэмших шаталсан тогтолцоог бүрдүүлж, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх.

**II үе шат (2021-2025):** Хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу шинжлэх ухаан, технологийн кластер, парк байгуулж, үндэсний дөрвөөс доошгүй их сургууль Азийн шилдэг их сургуулийн эгнээнд орсон байх.

**III үе шат (2026-2030):** Олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болсон байх.

**Зорилт 5.Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь хүртэлх түвшинд хүргэх.

**II үе шат (2021-2025):** Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2.5 хувь хүртэлх түвшинд хүргэх.

**III үе шат (2026-2030):** Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь хүртэлх түвшинд хүргэх.

## 2.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгаль орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг сайжруулах үндэс болно.

**Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах зарчим:**

· байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах;

· байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах;

· цэвэр технологийг дэмжих, хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх;

· байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлэх;

· байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх.

**2.3.1.Усны нөөцийн нэгдсэн менежмент**

**Зорилт 1.Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.**

**I үе шат (2016-2020):** Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх**.**

**II үе шат (2021-2025):** Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудыг түшиглэн усны нөөцийн цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх, гадаргын усыг хуримтлуулах усан сангуудыг байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 23 хувьд хийх.

**III үе шат (2026-2030):** Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх.

**Зорилт 2.Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

**I үе шат (2016-2020):** Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэж, хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.

**II үе шат (2021-2025):** Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 85 хувьд хүргэж, хүн амын 50 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.

**III үе шат (2026-2030):** Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 90 хувьд хүргэж, хүн амын 60 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.

**2.3.2.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох**

**Зорилт 1.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.**

**I үе шат (2016-2020)**: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгох.

**II үе шат (2021-2025):** Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жишиг төслүүдийг хэрэгжүүлж сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулах.

**III үе шат (2026-2030):** Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг зөөлрүүлж, гамшгийн эрсдэл, түүнээс үүдэлтэй хохирлыг бууруулах.

**Зорилт 2.Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна.**

**I үе шат (2016-2020):** Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, нүүрс, занарыг шингэрүүлэх, хийжүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар

хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 2 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлэх.

**II үе шат (2021-2025):** Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулах арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 7 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 5 дахин нэмэгдүүлэх.

**III үе шат (2026-2030):** Эдийн засгийн бүтцэд өндөр технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 14 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 10 дахин нэмэгдүүлэх.

### 2.3.3.Экосистемийн тэнцвэрт байдал

**Зорилт 1.Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.**

**I үе шат (2016-2020):** Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх.

**II үе шат (2021-2025):** Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 27 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.7 хувьд хүргэх.

**III үе шат** (2026-2030): Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 9.0 хувьд хүргэх.

**Зорилт 2.Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.**

**I үе шат (2016-2020):** Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй болгох.

**II үе шат (2021-2025):** Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх.

**III үе шат (2026-2030):** Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 30 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 40 хувьд хүргэх.

## 2.4.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тогтвортой засаглал мөн. Тогтвортой засаглалыг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын үзэл баримтлал, батлан хамгаалах

номлолын дагуу улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино.

**Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим:**

· төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах;
· хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;
· удирдлагын ил тод байдлыг хангах;
· төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;
· төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авлигыг арилгах.

**Зорилт 1.Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ.**

**Зорилт 2.Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.**

**Зорилт 3.Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.**

**Зорилт 4.Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.**

МОНГОЛ УЛС ҮҮРД ЦЭЦЭГЛЭН ХӨГЖИЖ, МОНГОЛ ХҮН БҮР ЭРҮҮЛ ЭНХ, ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ, АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАХ БОЛТУГАЙ.

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр** **Улаанбаатар хот**

**Дугаар 45**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

**Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:**

1.“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулж байх;

2/Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.

3.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох бусад байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

*Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралт*

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улсын Их Хурлын ээлжит 7 дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд сонгогчдын санал, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд үндэслэн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Монгол Улсад бий болсон эдийн засаг, санхүүгийн хүнд нөхцөлд Засгийн газрын гол зорилт нь улс орныхоо эдийн засгийг богино хугацаанд сэргээж, өсөлтийг бий болгон нийгмийн салбаруудыг дэмжиж, иргэдийнхээ аж амьдралыг эрс сайжруулахад оршино. Мөн төрийн албыг чадавхжуулах, бүх шатанд мэргэшсэн албан хаагчидтай байж, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй үзүүлэх, нийгмийн итгэлцлийг бэхжүүлэн, улс үндэстний аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэсэн тодорхой зорилтуудыг дэвшүүллээ.

## НЭГ.ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО

**Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.**

**1.1.Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах, тогтворжуулах хөтөлбөр боловсруулна.**

1.2.Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.3.Төсвийн нэгдмэл байдлыг хангаж, төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоож, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.4.Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.

1.5.Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, ард иргэдэд нээлттэй, ил тод болгоно.

1.6.Ард иргэд, аж ахуйн нэгж, улс орноо өрийн дарамтаас гаргаж, иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

1.7.Төрөөс захиалгаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсөө авч чадахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг барагдуулна.

1.8.Өр зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, үндсэн төлбөрийн хугацааг хойшлуулах чиглэлээр яриа хэлэлцээ хийж, улсын төсөвт тулгарч буй өрийн дарамтыг үе шаттайгаар бууруулна.

1.9.“Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад үнэлэлт, дүгнэлт өгч, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.10.Хөгжлийн банкны бонд, зээлийн зарцуулалтыг дүгнэж, төсөл, хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлнэ.

1.11.Шинэ төрлийн татвар бий болгохгүй ба үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд тодорхой салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 1.5 тэрбум төгрөгөөс бага жилийн орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулна.

1.12.Аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татварыг орлогын түвшингээс хамаарсан шатлалтай болгоно.

1.13.Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

1.14.Үндэсний хөрөнгө оруулагчдыг бүхий л талаар дэмжиж, эхний хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

1.15.Эрх бүхий байгууллагуудаас үндэсний аж ахуйн нэгжүүдэд тавигдсан татварын актын хүү, торгууль, алданги, үндсэн татварын нөхөн төлбөр төлөх хугацааг сунгах, хаалгасан дансыг нь нээх зэргээр бизнес эрхлэгчдээ дэмжинэ.

1.16.Эдийн засгийн хүндрэлээс улбаалан ажил, орлого нь хумигдан, зээлээ төлж чадахгүйд хүрч, “Найдваргүй зээлдэгчдийн жагсаалт”-д бүртгэгдсэн аж ахуй нэгж, иргэдэд зээлээ эргэн төлж, зээлийн түүхээ сайжруулах боломж олгоно.

1.17.5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.18.Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулна.

1.19.Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана.

1.20.Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эмзэг байдлыг бууруулах, эрсдэлийг багасгах чиглэлээр олон улсын болон бүс нутгийн банк, санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

1.21.Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг сэргээн зохион байгуулна.

1.22.Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээнэ.

1.23.“Үндэсний үйлдвэрлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

1.24.“Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна.

# ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

**Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна.**

**2.1.Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.**

2.2.Монгол Улсад үйлдвэрлэсэн уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүний 50-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа аж ахуйн нэгжийг татварын бодлогоор дэмжинэ.

2.3.“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үнэ цэнэтэй болгоно.

2.4.Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлнэ.

2.5.Томоохон төслийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6.Иргэндээ ээлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ.

2.7.Стандартчилал, хэмжил зүйн талаархи хууль тогтоомжийг олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн шинэчилж, “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

2.8.Бараа бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгахад Стандартчилал, тохирлын үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх, хэрэглэх, ашиглах механизмыг оновчтой болгоно.

2.9.Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгаж, аажмаар бууруулах бодлого баримтална.

2.10.Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

2.11.Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.

2.12.Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна.

2.13.Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжинэ.

2.14.Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлж, чирэгдлийг багасгана.

2.15.“Итгэлийн зээл”-ийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

2.16.Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих “Бүсийн хөнгөлөлт”-ийн бодлого хэрэгжүүлнэ.

2.17.Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор "ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН" үндэсний хөтөлбөр, "ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100" хөтөлбөр, "ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ" хөтөлбөр, "МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН"-ыг шинээр эхлүүлж, "АТРЫН-III АЯН"-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.**

**Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр:**

2.18.Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор "Мах, сүүний анхдугаар аян"-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.

2.19.Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлнэ.

2.20.Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалт, татварын бодлогыг хэрэгжүүлнэ.

2.21.Аймаг, нийслэл, сум, суурин газруудын хэрэгцээнд тохирсон орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын хүнсний боловсруулах жишиг загвар үйлдвэрийг байгуулахыг дэмжинэ.

2.22.Хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно.

2.23.Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.

2.24.Дотоодын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, тахиа, гахай, зөгий, загасны аж ахуй зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**Мал аж ахуйн чиглэлээр:**

2.25.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

2.26."Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", "Монгол малчин", "Малжуулах" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.27.Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистой хослуулснаар мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.28.Мал аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаархи олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх, "Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.29.Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж байгаа хүндрэлийг багасгахад

чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангана.

2.30.Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ.

2.31.Малчдыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх арга хэмжээ авна.

2.32.Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг ханган, мал, амьтны гоц халдварт, халдварт зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, тэмцэх стратегийг хилийн боомтуудыг түшиглэн бүсчлэн хэрэгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.

2.33.Малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, генетикийн нөөцийг хамгаалах, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, шинэ үүлдэр, омгийг бий болгох, орон нутгийн мал үржлийн нэгжүүдийг чадавхжуулна.

2.34.Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.

2.35.Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулан ашиглалт, хяналтыг сайжруулна.

2.36.Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, төлөв байдлыг тогтоох, хянах, сэргээн сайжруулах, доройтол, талхагдал, цөлжилтийг бууруулах, бэлчээрт хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэхэд малчдын оролцоог нэмэгдүүлж, байгаль орчинд халгүй, дэвшилтэт аргыг ашиглана.

2.37.Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн Малын генетик нөөцийн тухай, Бэлчээр хамгаалах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийг тус тус боловсруулан батлуулж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.

2.38.Мал аж ахуй эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах, малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, эрчимжсэн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

**“АТРЫН-III аян”-ыг үргэлжлүүлэх хүрээнд:**

2.39.Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.

2.40.Жимс жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр хانган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.

2.41.Газрын үржил шим, үр өгөөж, таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлж, үрийн сорт чанарыг сайжруулах замаар га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.

2.42.Ургамал хамгааллын цогц арга хэмжээг төлөвшүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулах, тарималын зохистой сэлгээ, тэг элдэншүүлгийн технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

2.43.Усны хайгуул, судалгаанд үндэслэн услалтын систем шинээр барьж, сэргээн засварлах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжиж, усалгаатай талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ.

2.44.Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот суурингийн хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана.

2.45.Газар тариалангийн зориулалттай дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг татварын бодлого, санхүүгийн лизингийн арга хэрэгслээр дэмжинэ.

2.46.Зоорь, агуулах, элеватор, үтрэмийн техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хадгалалт борлуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.47.Тариалангийн даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

**“ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөрийн хүрээнд:**

2.48.Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.

2.49.Хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний үнийн зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.50.Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ.

2.51.Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл тээвэрлэлт, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлж, түүхий эдийн санг бий болгоно.

2.52.Олон улсын худалдааны болон хөрш орнуудын боомтын бүсэд үйлдвэрлэл, худалдаа хөгжүүлэхийг дэмжинэ.

2.53.Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.54.Хөнгөн үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээлэл, сургалт явуулах мэдээллийн болон инкубатор төвийг тухайн салбарын мэргэжлийн холбоодыг түшиглэн байгуулахыг дэмжинэ.

2.55.Гадаад орны өндөр болон дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийг франчайзаар оруулж нутагшуулан, хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн салбарт “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

2.56.Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр дэлхийн тэргүүлэх, дэвшилтэт техник, технологийн үзэсгэлэнг Монгол Улсад тогтмол зохион байгуулж, гадаад оронд зохион байгуулагдаж байгаа үйлдвэрийн тоног төхөөрөмж, бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэнд үйлдвэрлэгчдийг дэмжиж хамруулна.

2.57.Хөнгөн үйлдвэрийн парк байгуулж, салбарын үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлэн бодлогоор дэмжинэ.

2.58.Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

**Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.**

2.59.Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.

2.60.Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.

2.61.Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.

2.62.Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.

2.63.Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.

2.64.“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

2.65.Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.

2.66.Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно.

2.67.Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.

2.68.“Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанктай хамтран шийдвэрлэнэ.

2.69.Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.70.Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.

2.71.Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

2.72.Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.73.Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.

2.74.Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.

2.75.Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.

**Дэд бүтцийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

**Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.**

2.80.Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.81.Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.82.Норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, олон улсын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх орчинг бүрдүүлнэ.

2.83.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна.

2.84.Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

2.85.Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.

2.86.Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.87.Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2.88.Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг 3 дахин нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.89.Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.90.Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.

2.91.Барилга байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн хугацааг уртасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2.92.Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ.

2.93.Нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.

2.94.Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

2.95.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.96.Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.97.Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, номын санд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.98.Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ.

2.99.Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорхи болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ.

2.100.Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг дуусгана.

**Эрчим хүчний салбарын чиглэлээр:**

**Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцөлийг бүрдүүлнэ.**

2.101.Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон суурь салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/

2.102.Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах шинэ эх үүсвэрийг барих, Өмнөд говийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих асуудлуудыг шийдвэрлэнэ.

2.103.Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ.

2.104.Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, Эгийн голын усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлнэ.

2.105.Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

2.106.Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр бүрэн хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.107.Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд бүрэн холбож дуусган сэргээгдэх эрчим хүч болон цэвэр технологид суурилсан төвлөрсөн инженерийн

байгууламж буюу дулаан хангамж, цэвэр бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.108.Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, инновацын түвшний шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.109.Дулаан, цахилгааны үнийг тогтвортой байлгана.

2.110.Метан хийг ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх, хийн хангамжийг хөгжүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчныг бүрдүүлэх, нүүрснээс хийн цэвэр түлш гарган авах үйлдвэр барих төслийг эхлүүлнэ.

**Зам тээврийн салбарын чиглэлээр:**

**Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ.**

2.111.Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлнэ.

2.112.“Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна.

2.113.“Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана.

2.114.“Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.

2.115.Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.116.“Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.117.Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна.

2.118.Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна.

2.119.Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана.

2.220.Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ.

2.221.Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ.

2.222.Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ.

2.223.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан автозамын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг, Сонсголонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина.

2.224.Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ.

2.225.Автозамын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттай нэмэгдүүлнэ.

# ГУРАВ.НИЙГМИЙН БОДЛОГО

**Гэр бүлийг дэмжин тэтгэх, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулна.**

**3.1.Эрүүл мэндийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ: Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх эдийн засгийн тооцооллыг бий болгож, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ.**

**Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагад төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, Халдварт бус өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.**

**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлтөд урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ.**

**Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулна.**

**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно.**

3.1.1.Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр боловсруулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.

3.1.2.Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах, алслагдсан орон нутагт явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.1.3.Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусын голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.1.4.Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үе шаттайгаар 2 дахин нэмэгдүүлнэ.

3.1.5.Эрүүл мэндийг дэмжих санг байгуулна.

3.1.6.Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, хүний дархлал хомсдлын вирүс, дархлалын олдмол хомсдол, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авна.

3.1.7.Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлэн эх, нялхсын эндэгдлийг бууруулна.

3.1.8.Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг сайжруулахад эхний ээлжинд анхаарна.

3.1.9.Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулж, иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

3.1.10.Анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний чанарыг эрс сайжруулж, нэгдсэн эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төрөх, хүүхэд, гэмтэл, мэс заслын тусламж, үйлчилгээг өргөжүүлж чирэгдлийг бууруулна.

3.1.11.Олон улсын жишигт нийцсэн оношилгоо, эмчилгээний төв байгуулж, эрүүл мэндийн салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар гадаадад гарах мөнгөн урсгалыг бууруулна.

3.1.12.Амьсгалын замаар дамжих халдварт өвчин, ялангуяа улаан бурхан, улаанууд зэрэг өвчний дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, өвчлөлийг бууруулна.

3.1.13.Төр, хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн бүх эмнэлэг, лабораториудын шинжилгээ, рентген, томографийн зураг зэргийн хариуг харилцан бие биедээ хүлээн зөвшөөрдөг болгох тогтолцоог бий болгоно.

3.1.14.Эрүүл мэндийн салбарын цахим тогтолцоог хөгжүүлж, өвчний түүхийг цахимжуулан, эмнэлгүүдийн мэдээллийн технологийг боловсронгуй болгох, чирэгдлийг эрс бууруулж, цогц арга хэмжээг авна.

3.1.15.Эрүүл мэндийн салбарт баригдаж байгаа дуусаагүй барилгуудыг үе шаттайгаар ашиглалтад оруулах, ашиглалтад орсон барилгуудын ашиглалтын бүтээмжийг сайжруулна.

3.1.16.Иргэн хувийн эмнэлгээр үйлчлүүлэхэд эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөх зардлын хэмжээг нэмэгдүүлж, иргэнд учрах төлбөрийн дарамтыг бууруулна.

3.1.17.Өндөр өртөгтэй компьютер томограф, MRI зэрэг оношилгоо, зарим мэс заслын төлбөр зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.

3.1.18.Хөдөөгийн суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс хөнгөлөлттэй нөхцөлтэй байр орон сууцаар хангах асуудлыг дэмжинэ.

3.1.19.Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын ажлын ачааллыг тооцож, норм, нормативтай болгон, илүү цагийн хөлсийг тухай бүрд нь тооцож олгодог болно.

3.1.20.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил, боловсролоо тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, ажлын дэмжлэгт орчинг сайжруулах нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.1.21.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн эмнэлэг болон аймаг, дүүрэг бүрээс эмч, сувилагч, мэргэжилтнийг өндөр хөгжилтэй улс оронд сурган, дадлагажуулахын зэрэгцээ өндөр ур чадвартай, мэргэжлийн эмч, мэргэжилтний багийг урилгаар ажиллуулж, тэдний туршлагаас суралцана.

3.1.22.Эрүүл мэндийн санхүүжилтийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах ажлын хүрээнд Эрүүл мэндийн үндэсний тооцооллын тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн нэвтрүүлнэ.

**3.2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Боловсролын чиглэлээр:**

**Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, амьдралд нийцтэй болгоно. Хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт суралцах боломжтой болж, сурагчид гэр сургуулийнхаа хооронд нийтийн тээвэрт үнэгүй зорчиж, сургууль 3 ээлжгүй болно. Хөдөөд малчны хүүхэд 6-8 насандаа сонголттойгоор суралцах боломжтой болж, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулна.**

Сургуулийг хүн хөгжлийн төв болгоно. Сургууль хүүхдэд мэдлэг, боловсрол, чадвар олгодог төдийгүй эрүүл чийрэг, эерэг зан суртахуун, хүмүүжил, төлөвшилтэй, амьдрах ухаантай, эх оронч, үндэсний бахархалтай хүн болоходнь тусалдаг болно. Бүх шатны боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх боломжтой болгож стандартад суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлнэ.

Их, дээд сургууль, коллежийн оюутны суралцах эрхийн баталгааг хангаж, өрхийн боловсролын зардлыг бууруулж, дээд боловсролын сургалтын чанарыг дэмжинэ. Оюутанд үндэсний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно. Оюутан сургалтын төлбөрийн дарамтгүй, эрүүл мэндийн үйлчилгээтэй, суралцах хугацаандаа цагийн ажил эрхлэх, дотуур байранд амьдрах боломжтой болно.

Төрийн өмчийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг хангаж, дээд боловсролд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлнэ.

Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад нийгэм, сэтгэл зүй, дэд бүтцийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, нийгмийн үйлчилгээг бий болгоно.

3.2.1.Малчны хүүхдийг 6-8 насны сонголттойгоор сургуульд элсэн суралцах боломжийг бүрдүүлнэ.

3.2.2.“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно.

3.2.3.Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ.

3.2.4.Нийтийн тээврийн үйлчилгээ нэвтэрсэн хот, суурин газрын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид гэр, сургуулийнхаа хооронд нийтийн тээврээр үнэгүй зорчдог болно.

3.2.5.“Байгууллагын цэцэрлэг”-ийн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, татварын бодлогоор дэмжинэ.

3.2.6.Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгоно.

3.2.7.Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно.

3.2.8.Сурагчдыг эх хэлээрээ алдаагүй зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх хэрэглээний бүрэн ур чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн монгол хэлний сургалтын цогц шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

3.2.9.Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж үйлчилгээний чанар, үр дүнг эцэг, эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломжтой болгоно.

3.2.10.Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ.

3.2.11.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт эх орныхоо түүх, соёлыг судлах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийг оруулна.

3.2.12.Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.

3.2.13.Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлнэ.

3.2.14.Ерөнхий боловсролын сургуульд сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургана.

3.2.15.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, хүмүүжил олгох агуулгыг тусган хэрэгжүүлнэ.

3.2.16.Сурагчдад эх орноо хайрлах, хүрээлэн байгаа орчноо хамгаалах мэдлэг, хүмүүжил олгоно.

3.2.17.Ерөнхий боловсролын сургуулийн сурагч ажил, мэргэжлээ сонгох, суралцах сургуулиа сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар ажил мэргэжлийн зөвлөгөө үзүүлдэг үйлчилгээг бий болгоно.

3.2.18.Төрийн өмчит их, дээд сургууль, коллежийг хувьчлахгүй. Дээд боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, төрийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг нь хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.19.Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд төрөөс зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

3.2.20.“Боловсролын зээлийн сан” шинээр байгуулж, оюутан, суралцагчид үндэсний тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжийн үйлчилгээг үзүүлэх тогтолцоог ил тод, нээлттэй болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.21.Өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа бол санхүүгийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

3.2.22.Үндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг олгоно.

3.2.23.Оюутны дотуур байрны хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ.

3.2.24.Оюутнууд харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээ авдаг болно.

3.2.25.Өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтад элсэгчдийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулж, суралцагчдын тоог 2 дахин нэмэгдүүлнэ.

3.2.26.Оюутанд суралцах хугацаандаа цагийн ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох “Орлоготой оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.2.27.Нээлттэй мэдлэг, боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлж, орчин үеийн мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын тогтолцоог эрчимтэй хөгжүүлнэ.

3.2.28.Дүрслэх урлаг, уламжлалт урлахуйн ухааныг хөгжүүлж, гадаад, дотоодод түгээн сурталчлах бодлогыг хэрэгжүүлнэ.

**Шинжлэх ухаан, мэдээллийн технологи, инновацийн хөгжлийн чиглэлээр:**

**Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.**

3.2.29.Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, Инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулан гаргана.

3.2.30.Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, инноваци, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

3.2.31.Шинжлэх ухааны салбар, эрдэмтэд, хүрээлэнгүүдтэй хамтран шинэ технологи нэвтрүүлсэн хувийн аж ахуйн нэгжүүдийг урамшуулах механизм бий болгоно.

3.2.32.Оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлж, монгол хүний эзэмшиж байгаа зохиогчийн эрх, патентыг хамгаалах асуудлыг олон улсын түвшинд хүргэж, сурталчлах ажлыг идэвхжүүлнэ.

3.2.33.Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.

3.2.34.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд үндэслэн хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан Хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулж, инновацийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх тааламжтай бүтцийг бүрдүүлнэ.

3.2.35.Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого баримтална.

3.2.36.Салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх өндөр технологийн судалгаа ба хөгжил, инновацийн болон зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааны суурь бүтцийг хөгжүүлэх, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.

3.2.37.Нээлттэй лабораторид суурилсан био, нанотехнологийг хөгжүүлж, оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ.

3.2.38.Монгол Улсад Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээ бүхий өгөгдлийн төв (Data center) байгуулах боломж бүрдүүлж, төрийн хамгаалалтад авч, мэдээллийн аюулгүй байдлыг ханган олон улсын компаниуд чөлөөтэй транзит ашиглах боломж бүрдүүлнэ.

3.2.39.“Монгол контент” бүтээгчдийг дэмжих бодлого баримтална.

3.2.40.Сансрын холбооны үндэсний хиймэл дагуул төслийг хэрэгжүүлж, газар сансрыг холбосон үндэсний харилцаа холбооны сүлжээ байгуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаална.

3.2.41.Байгаль, эдийн засаг, нийгэм, хууль, эрх зүй зэрэг салбарын шинжлэх ухааныг хөгжүүлэх, тухайн салбарын эрдэмтдийн болон хүрээлэнгийн үйл ажиллагааг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.

**Соёл урлаг, спортын салбарын чиглэлээр:**

**Соёл урлагийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож соёл урлагийг хөгжүүлэх бодлого, санхүүжилт, удирдлага зохион байгуулалтын шинэчлэлийг хэрэгжүүлнэ.**

Үндэсний болон сонгодог урлаг, нүүдлийн соёл иргэншлийг төрийн ивээлд байлгаж, бүх нийтийн соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёл урлагийн аялал жуулчлал, гадаадад монголын үндэсний соёл урлагийг сурталчлах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, монгол контентийг хөгжүүлнэ. Нийтийн биеийн тамирын нийгмийн орчин, үйлчилгээг боловсронгуй болгох, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх, өвлөн уламжлах, спортын эрдэм шинжилгээ, спортын анагаах ухааныг хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, спортыг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэмцээн, наадмын тогтолцоог боловсронгуй болгох, тамирчин дасгалжуулагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, биеийн тамир, спортын дэд бүтцийг сайжруулан нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.42.Соёлын тухай хуулийг шинэчлэн баталж, киноны тухай, музейн тухай хуулийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.43.Орчин үеийн музейн стандарт шаардлагыг хангасан байгалийн түүхийн музейг шинээр барина.

3.2.44.Үндэсний болон сонгодог урлаг, нүүдлийн соёл иргэншлийг төрийн ивээлд байлгаж, хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, уран бүтээл туурвих, уран бүтээлчдийг урамшуулах санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, монгол хэл, бичгийн соёлыг хадгалах, хамгаалах, судлах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, ном, бүтээл туурвих, соён гэгээрүүлэх монгол өв соёлын дархлааг бий болгох талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.45.Улаанбаатар хотод ажиллаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн зориулалттай театр, соёлын төвүүдийн барилгын нөхцөл байдлыг үнэлж, мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, тоглолт зохион байгуулах боломжийг судалж, хэрэгжүүлнэ.

3.2.46.Жил бүр үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхийн сэдэвтэй кино, тайз дэлгэц, утга зохиолын томоохон хэмжээний мэргэжлийн түвшний 1 бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

3.2.47.Соёл урлагийн аялал жуулчлал хөгжүүлэх, гадаадад монголын үндэсний соёл урлагийг сурталчлах, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох талаар тусгайлсан бодлого хэрэгжүүлнэ.

3.2.48.Музейн хадгалалт, хамгаалалтын шаардлагыг олон улсын стандартад хүргэж, хэрэгжилтийг хангана.

3.2.49.Хөдөө орон нутагт хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чанар, үр дүнтэй уялдуулан соёл урлагийн барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.2.50.Соёл, урлагийг дэмжих сан байгуулна.

3.2.51.Чойжин ламын сүм музейг шинэчлэн засварлаж, Тоньюкукын цогцолборыг хамгаалах, музей байгуулах, Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах, Эзэнт гүрэн музей байгуулах ажлыг зохион байгуулна.

3.2.52.Биеийн тамир, спортын эрх зүйн орчинг боловсронгуй болгож нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх, өвлөн уламжлах бодлого, тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

3.2.53.Спортын төв ордныг шинэчилж, олон улсын стандартад нийцсэн хөнгөн атлетикийн тартанан зам, өвлийн спортын ордон барина.

3.2.54.Спортын эрдэм шинжилгээ, спортын анагаах ухааныг хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.55.“Спортыг дэмжих сан” байгуулна.

3.2.56.Нийтийн биеийн тамир, иог, бясалгал, зохистой хөдөлгөөн /фитнес/-ээр хичээллэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулна.

3.2.57.Үндэсний соёл, урлагийг шинэ шатанд гаргах зорилгоор “Үндэсний байгалийн музей, театр, урлагийн цогцолборууд”-ыг байгуулж, соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

3.2.58.Соёл, шинжлэх ухааны салбарын ажиллагчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ.

3.2.59.Үндэсний урлагийг дэмжих бодлогын хүрээнд Үндэсний урлагийн Их театр барих ажлыг эхлүүлнэ.

**3.3.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулна.**

3.3.1.Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогыг бүх салбарт баримтална.

3.3.2.Өрхийн орлого, зарлага, ядуурлын түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг сайжруулж, бодит амьдралд нийцүүлнэ.

3.3.3.Хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, орон нутгийн санаачилгыг дэмжинэ.

3.3.4.Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэшлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлнэ.

3.3.5.Ажил олгогчийг ажлын байраа хадгалах, өндөр техник, технологи ашигладаг ажлын байраа нэмэгдүүлэхэд төрөөс бодлогоор дэмжинэ.

3.3.6.Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авдаг ажиллагчдын тоог 50-аас дээш хувиар бууруулна.

3.3.7.Өндөр технологийн 2000 энтрепренёр мэргэжилтнийг бэлтгэнэ.

3.3.8.Үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчнийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог хөгжүүлнэ.

3.3.9.Мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.10.Мэргэжлийн боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулна.

3.3.11.Багш, эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн, ажилласан жил зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгоно.

3.3.12.Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрд олгоно.

3.3.13. 3 хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/ болон орлого багатай өрхийг төрөөс дэмжих эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

3.3.14. 3 хүртэл насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь тасрахгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

3.3.15.Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулна.

3.3.16.Малчид, хувиараа аж ахуй эрхлэгчдэд нийгмийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх эрх зүйн орчин бүрдүүлнэ.

3.3.17.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчилнэ.

3.3.18.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн нэр төрлийг багцлан оновчтой тогтоож, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлнэ.

3.3.19.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрх зүйн орчин, санхүүжилтийн механизмыг оновчтой болгоно.

3.3.20.Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний салбарт төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан хамтын ажиллагааг өрнүүлж, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, хэлбэрийг олшруулан дотооддоо өндөр үнэтэй эмчилгээ хийлгэх тохиолдолд даатгалд хамруулдаг болно.

3.3.21.Эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллагыг бүрдүүлж, даатгуулагч төвтэй, орчин үеийн менежмент бүхий стратегийн идэвхтэй худалдан авагч болгон хөгжүүлнэ.

3.3.22.“Төрөөс ахмадын талаар баримтлах бодлого” гаргаж, “Ач санах” хуулийг батлуулж, азай буурлуудад “Насны хишиг” тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

3.3.23.Тэтгэвэр, тэтгэмж, цалинг үе шаттай нэмэгдүүлнэ.

3.3.24.Тэтгэврийн зөрүүг ойртуулах, зээлийн хүүг бууруулах бодлого баримтална.

3.3.25.“Ахмадын зөвлөх үйлчилгээ”-г бий болгож, хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.3.26.Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулахыг дэмжинэ.

3.3.27.Жендерийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.3.28.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална.

3.3.29.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна.

3.3.30.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

3.3.31.Өрх толгойлсон болон бага орлоготой өрхийн гишүүдэд үзүүлэх дэмжлэг, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

3.3.32.Өрх толгойлсон эх /эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг батлан хэрэгжүүлнэ.

3.3.33.Тав хүртэлх насны хүүхдийн эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

3.3.34.Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох эрх зүйн орчин бүрдүүлнэ.

3.3.35.Төрүүлж, өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан хугацааг нэмэгдүүлэн тооцдог болно.

3.3.36.Хүүхдийг хувийн даатгалд хамруулж, боловсрол эзэмших, эмнэлгийн тусламж авах, тэжээгчээ алдсан үед тэтгэмж авах санхүүгийн нэмэлт баталгааг бүрдүүлнэ.

**3.4.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангана.**

3.4.1.Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүтцийг бий болгоно.

3.4.2.Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.

3.4.3.Залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжид орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулдаг арга хэмжээг үе шаттай нэвтрүүлнэ.

3.4.4.Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг чухалчлан үзэж “Хүүхдийн хөгжлийн ордон”, “Хүүхэд хамгааллын төв”-үүдийг дэмжинэ.

3.4.5.Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд үндэсний өв уламжлал, урлаг соёлоор дамжуулан эерэгээр нөлөөлөх бодлого хэрэгжүүлнэ.

3.4.6.Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлж, хүүхдийн осол, эндэгдлийн түвшинг 2 дахин бууруулна.

3.4.7.Хараа хяналтгүй хүүхдийн бүртгэл, хяналтыг сайжруулж, насанд хүртэл нь хамгаалах, амьдралд хөлөө олоход нь туслах бодлого хэрэгжүүлнэ.

3.4.8.Шинээр сургууль төгссөн залуучуудыг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

3.4.9.“Мэргэжилтэй ажилтан” бодлогын хүрээнд жилд 20.000-аас доошгүй залуучуудыг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд сурган мэргэжил, ур чадвар эзэмшүүлнэ.

3.4.10.Залуучуудад бизнесийн гарааны дэмжлэг үзүүлж, их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг тоног төхөөрөмжийн лизинг, жижиг зээлд хамруулах арга хэмжээ авна.

3.4.11.Өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгож, халдварт өвчлөлийн тархалтыг бууруулна.

# ДӨРӨВ.БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно.**

**4.1.Байгаль, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

4.1.1.Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлж, нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулан ашиглах ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

4.1.2.Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, нүүрс боловсруулж ашиглах шинэ технологи нэвтрүүлэн, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үйлдвэрлэл, бизнесийг олон улсын хамтын ажиллагааны хүрээний дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.

4.1.3.Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.

4.1.4.Ой, түүний дагалт баялаг, байгалийн бусад нөөц баялгийн ашиглалтын нөөцийг бий болгож, зохистой ашиглах, эко цэвэр түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

4.1.5.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлэх, байгаль орчин, уур амьсгалын санг байгуулж, үндэсний чадавхыг бэхжүүлнэ.

4.1.6.Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

4.1.7.“Тогтвортой хөгжлийн боловсрол” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, олон нийтэд эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэх мэдлэг олгож, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.

**4.2.Экосистем, унаган байгалийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

4.2.1.Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авна.

4.2.2.Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, байгальд ээлтэй аялал жуулчлал, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлнэ.

4.2.3.Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.

4.2.4.Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулж ус хангамжийг нэмэгдүүлнэ.

4.2.5.Нийслэл, хот суурин газрын ундны эх үүсвэрийг хамгаалах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.6.Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ.

4.2.7.Ойн нөөцийг хамгаалах, үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээх менежментийг сайжруулах ойн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

4.2.8.Байгаль орчинг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, ашиглалтын үр өгөөжийг сайжруулна.

4.2.9.Устах аюулд орсон болон аж ахуйн гоц ашигт амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарьж ургуулах ажлыг хөрөнгө, санхүү, татварын бодлогоор дэмжинэ.

**4.3.Байгаль хамгаалах ажилд бүх нийтийн хамтын оролцоог хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

4.3.1.Байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх ажил эрхэлж байгаа иргэн, нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлж, орон нутагт ажлын байр, орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох ажлыг зохион байгуулна.

4.3.2.Иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага тарьж ургуулсан ой, ургамал, өсгөж үржүүлсэн ан амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар нуур, цөөрөм, усан санг бий болгосон тохиолдолд урамшуулах эрх зүйн орчинг бий болгоно.

4.3.3.Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.

4.3.4.Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийг эмхлэн зохион байгуулж, орчны хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлж, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд хүрэх мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулна.

**4.4.Аялал жуулчлалын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**
**Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.**

4.4.1.Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.

4.4.2.Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

4.4.3.“Бурхан халдун”, “Хорго-Тэрх”, “Хамарын хийд”, “Отгонтэнгэр”, “Хар-Ус”, “Хөвсгөл”, “Хархорин” зэрэг байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц тогтоц бүхий газар нутгийг түшиглэсэн түүхэн болон төрөлжсөн аялал жуучлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжинэ.

4.4.4.Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлж, хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно.

4.4.5.Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ.

4.4.6.Олон улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, туршлага, стандартыг нэвтрүүлэх, нутагшуулах, олон талт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий судалгаа шинжилгээний орон тооны бус зөвлөл, нэгжийг байгуулна.

## ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

**5.1.Тогтвортой, хариуцлагатай, эрх зүйт төрийг төлөвшүүлэх чиглэлээр:**

**Тогтвортой, хариуцлагатай улс төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална.**

5.1.1.Эрх мэдлийн харилцан хяналт, тогтвортой, хариуцлагатай төрийг бий болгохын төлөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан ард түмнээсээ асууж шийдвэрлэнэ.

5.1.2.Парламентын засаглалыг бэхжүүлж, улс төрийн намуудын төлөвшлийг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

5.1.3.Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж байгаа бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ.

5.1.4.Зөвлөлдөх ардчилал, иргэдийн оролцоог дэмжих “Ардын засаглал” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.1.5.Төрийн байгууллагуудын ажил, үүргийн давхардлыг арилгах, нэгтгэх замаар яам, агентлаг, төсвийн байгууллагуудын тоог цөөлж, оновчтой бүтцийг бий болгоно.

5.1.6.Төрийн албан хаагчдыг урт хугацааны цогц даатгалд хамруулах замаар тэдгээрийн нийгмийн хамгааллыг сайжруулна.

5.1.7.Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

5.1.8.Төрийн албан хаагчийн хариуцлагыг нэмэгдүүлж, хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг зөрчин бусдад хохирол учруулсан албан тушаалтан хохирлыг өөрөө хариуцан төлж барагдуулах хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг хангана.

5.1.9.Мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангахгүй, хариуцлага алдаж, ёс зүйн алдаа гаргасан төрийн бүхий л албан тушаалтныг танил тал, нам эвслийн эрх ашгийг харгалзахгүйгээр хуулийн дагуу хариуцлага тооцож, төрийн албаны нэр хүндийг өсгөнө.

5.1.10.Төрийн байгууллагыг удирдаж байгаа хүмүүс ах дүү, хамаатан саднаа ажилд авахыг хориглоно.

5.1.11.Төрийн албаны тогтвортой байдлыг баталгаажуулж, “Төрийн албаны тогтвортой байдлын тухай хууль”-ийг санаачлан батлуулна.

5.1.12.Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж, нөхцөлийг сайжруулах бодлого баримтална.

5.1.13.Төрийн үйлчилгээнд иргэдийн үнэлгээний картын системийг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

5.1.14.Төрөөс олгодог шагналын нэр хүндийг өсгөн, шалгуур үзүүлэлтийн дагуу шагнал олгох тогтолцоог бий болгоно.

5.1.15.Хууль тогтоомжоос үүдэлтэй иргэдийг хохироосон хууль сахиулах байгууллагуудын алдаа гажуудлыг засч, эрх зүйн орчинг нь иргэндээ ойртсон, тогтвортой болгоно.

5.1.16.Төрийн албаны тогтвортой байдлыг баталгаажуулж, төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлж, төрийн албаны мэргэшсэн, чадварлаг байх нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.17.Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүнд сурталгүй хүргэж цахим засгийг бодитой хэрэгжүүлнэ.

5.1.18.Хөдөөгийн иргэдийн аюулгүй орчинд амьдрах, малчдыг мэдээллээр хангах хөтөлбөр хэрэгжүүлж, сум, багийнхаа үйл ажиллагаанд орон зайн тэгш бус байдлаас үл хамааран жигд оролцох боломжоор хангана.

5.1.19.Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлого баримталж, хэрэгжилтийг хангах эрх зүйн орчинг цогцоор бүрдүүлнэ.

5.1.20.Төрийн захиргааны албан тушаалтан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх хугацааг хоёр дахин бууруулж, хөнгөн шуурхай болгоно.

5.1.21.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний

удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

5.1.22.Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

**5.2.Эдийн засаг, бизнес, өмчийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох чиглэлээр:**

**Эдийн засаг, бизнесийн эрх зүйн орчны тогтвортой байдлыг чухалчилж, шаардлагатай өөрчлөлт хийхдээ эрх ашиг нь хөндөгдөх этгээдээс заавал асууж, саналыг нь авах соёлыг хэвшүүлэх зарчмыг баримтална.**

5.2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.

5.2.2.Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ.

5.2.3.Эдийн засаг, бизнес, худалдаа, өмч, санхүүгийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, өмчлөх эрхийн баталгааг алдагдуулсан хууль тогтоомж, шийдвэрийг засч сайжруулна.

5.2.4.Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.5.Иргэн, хуулийн этгээдийн оюуны болон хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийн баталгааг сайжруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

5.2.6.Монгол Улсаас гадаад улстай байгуулсан худалдаа, хөрөнгө оруулалт, давхар татварын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, Монгол Улсын эрх ашигт нийцүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

5.2.7.Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчинг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулна.

5.2.8.Улсын бүртгэлийг ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

5.2.9.Улсын бүртгэлийн архивыг бүхэлд нь цахимжуулж, газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгоно.

5.2.10.“Нэг иргэн, нэг бүртгэл” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн болон цахим бизнес, онлайн банкны үйлчилгээг жигд, тэгш авах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.11.Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах, шинэ хуулийн төсөл боловсруулахад эрх зүйн цахим мэдээллийн нэгдсэн санг ашиглах замаар хууль, эрх зүйн баримт бичгийн агуулга, уялдаа холбоог дээшлүүлнэ.

**5.3.Шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах чиглэлээр:**

**Хууль заавал хэрэгждэг, хүн бүрд эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.**

5.3.1.Үндсэн хуулийн цэцийн болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг боловсронгуй болгож, Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих баталгааг бэхжүүлнэ.

5.3.2.Шүүгчийг сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгож, Шүүхийн захиргааны болон Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн сайжруулна.

5.3.3.Шүүгч бүр дээр хувийн хэрэг нээж, шийдвэрлэсэн хэрэг маргаан нь дээд шатны шүүхээр өөрчлөгдсөн тохиолдол бүрд зөрчлийн оноо тооцон хариуцлагыг дээшлүүлнэ.

5.3.4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай болон Арбитрын тухай хуулийг шинэчлэн, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныг шийдвэрлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

5.3.5.Гэр бүл, хүүхэдтэй холбоотой болон хүрээлэн байгаа орчин, газрын асуудалтай холбоотой хэрэг, маргааныг тухайн чиглэлээр мэргэшсэн шүүгч, прокурор, хууль сахиулах байгууллагын алба хаагч шийдвэрлэх механизмыг бүрдүүлнэ.

5.3.6.Гэрч, хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгож, гэрч, хохирогчийн хамгааллын цогц механизмыг бүрдүүлнэ.

5.3.7.Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.3.8.Хэвлэлийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчинг сайжруулж, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн баталгааг хангана.

5.3.9.Иргэний хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, мэдээллийн нууц, нэр төрөө хамгаалах эрх, эрх чөлөөнд халдахыг хориглосон эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.

5.3.10.Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

5.3.11.Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог сайжруулж, хүний эрхийн стандартыг нэвтрүүлнэ.

5.3.12.Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулна.

5.3.13.Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж, захиргааны байгууллагаас иргэдийн эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх нөхцөлийг хангана.

**5.4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр:**

**Чанд сахилга бат, дэг журамд суурилсан хүнлэг, иргэндээ ээлтэй, улсдаа түшигтэй, хууль хэлбэрэлтгүй мөрдөгдсөн хуулийн байгууллагыг бэхжүүлэх зарчмыг баримтална.**

5.4.1.Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.

5.4.2.Хууль алагчлалгүй үйлчлэх зарчмыг чанд баримтална. Хэн нэгэнд ялгавартай хандах, давуу байдал олгосон хуулийн байгууллагын албан

тушаалтанд оногдуулах сахилгын, захиргааны болон эрүүгийн хариуцлагыг чангатгана.

5.4.3.Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангатгахын зэрэгцээ авлигын хэргээр ял шийтгэгдсэн этгээдийг дахин төрийн албанд томилохгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

5.4.4.Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.4.5.Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн, цагдаагийн байгууллагын дотоод холбоо, мэдээллийн нэгдсэн систем болон бэлэн бус торгуулийн системийг цагдаагийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, цагдаагийн байгууллагын түргэн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.4.6.Монгол цагдааг хөгжүүлэх, цагдаа иргэдтэйгээ хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

5.4.7.Шүүхийн шинжилгээний чанарыг дээшлүүлж, бүртгэл, мэдээлэл, лавлагааны үндэсний нэгдсэн систем, дижитал судлал, инженер техникийн болон гэмт хэрэгтний сэтгэл зүйн шинжилгээний лабораторийг шинээр байгуулна.

5.4.8.Төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогын баримт бичгийг баталж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ.

5.4.9.Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна.

5.4.10.Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон теле хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах, иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ.

5.4.11.Архивын баримт бичгийн 30 хувийг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх замаар төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулна.

5.4.12.Хууль сахиулагч бэлтгэх, давтан сургах тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, хууль сахиулах ажиллагааг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжих нөхцөлийг хангана.

5.4.13.Хууль зүйн салбарын байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмж, дэд бүтцийг шинэчлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

5.4.14.Улсын хил хамгаалалтын холбооны техник хангамжийг шинэчлэх, хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, боомтуудыг холбосон өргөн зурвасын сүлжээнд суурилсан цогц, удирдлага хяналтын систем бий болгох, тал хээрийн бүсийн хил хамгаалалтыг гэрээт хилчний зохион байгуулалтад шилжүүлэх, хилийн ангиудын зэрэглэл, хилчдийн хангамж, нийгмийн баталгааг бүсчлэн зохион байгуулах замаар улсын хилийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, чадавхыг сайжруулна.

5.4.15.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулна.

**5.5.Батлан хамгаалах салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Монгол Улсын батлан хамгаалах эрх зүйн орчинг төгөлдөржүүлж, улс орныг батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, Зэвсэгт хүчний хөгжлийг эрчимжүүлэн батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгоно.**

5.5.1.“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-т нийцүүлэн, батлан хамгаалах тогтолцооны хууль тогтоомжийг шинэчилж, батлан хамгаалах үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлнэ.

5.5.2.Зэвсэгт хүчнийг мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг болгох бодлого, зорилтын хүрээнд түүний бүтэц, зохион байгуулалтыг төгөлдөржүүлэх, хөгжлийн төлөвлөлтийг шинэчлэн тодорхойлох, зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах замаар бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлнэ.

5.5.3.Агаарын цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэлийг эрчимжүүлж, улс орны агаарын хил, орон зайг найдвартай хянах, халхлах чадавх бүхий хамгаалалтын нэгдсэн тогтолцооны суурийг тавина.

5.5.4.Орон нутгийн хамгаалалтын эрх зүйн үндсийг бүрдүүлж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулж, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог төгөлдөржүүлнэ.

5.5.5.НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлнэ.

5.5.6.Батлан хамгаалах зориулалт бүхий материаллаг нөөцийг шинэчлэх, бүрдүүлэх, оновчтой байршуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.5.7.Батлан хамгаалах гадаад харилцаа, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

5.5.8.Цэргийн алба хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулж, аливаа нөхцөлд үүргээ биелүүлэх боломжоор хангах тогтолцоог төлөвшүүлнэ.

5.5.9.Төрийн цэргийн байгууллагуудын нэгдмэл үйл ажиллагааг хангаж, цэргийн захиргааны удирдлагыг төлөвшүүлнэ.

5.5.10.Цэргийн албыг иргэний төлөвшил, эх оронч үзэл, хүмүүжлийн үндэс байх бодлогыг хэрэгжүүлж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн, иргэдэд эх орноо хамгаалахад оролцох, цэргийн боловсрол, бэлтгэл эзэмшүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

**5.6.Гадаад харилцааны салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

**Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, дэлхийн улсуудтай найрсаг харилцаа, улс төр, худалдаа, эдийн засаг, соёлын болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагаанд оновчтой оролцож, хилийн чанадад Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн**

**эрх ашгийг тууштай хамгаалж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг улам сайжруулж, эх орноо гадаадад сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлнэ.**

5.6.1.Монгол Улс, ОХУ-ын стратегийн түншлэл болон Монгол Улс, БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлж, худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, хоёр хөршийн далайн боомтыг ашиглах, тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

5.6.2.Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт хамтын ажиллагааны механизмын хүрээнд Бүс нутгийн хамтын ажиллагааны төлөвлөлтийн төв байгуулж, “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хүрээнд дэд бүтцийн чиглэлээр урьдчилан тохиролцсон төслүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулж, зарим ажлыг эхлүүлнэ.

5.6.3.АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, БНТУ /Турк/ зэрэг гуравдагч хөрш болон бусад улстай уламжлалт харилцаа, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлж, худалдаа, эдийн засгийн харилцааны хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгнө.

5.6.4.НҮБ, түүний системийн болон төрөлжсөн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлнэ.

5.6.5.Худалдааны гол түнш болон бусад улстай худалдааг улам хөнгөвчлөхөд чиглэсэн хэлэлцээр байгуулах чиглэлээр холбогдох судалгааг эхлүүлж, худалдааны тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулна.

5.6.6.Гадаадын хөрөнгө оруулагчдад бодлогын, хамтын ажиллагааны болон хууль, эрх зүйн тогтвортой байдал, тааламжтай орчинг бүрдүүлж, тэдгээрийн эрх ашигт хамаарах олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын болон бусад бүх салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

5.6.7.Гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлэн үр ашгийг нь дээшлүүлж, хил орчмын худалдааг хөнгөвчлөх зорилгоор хилийн боомт, хил орчмын дэд бүтцийг сайжруулж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор иргэд зорчих нөхцөлийг сайжруулж, олон улс, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци болон дэд бүтцийн сүлжээнд хамрагдах үйл явцыг эрчимжүүлж, гадаад худалдааны тааламжтай нөхцөлийг бүрдүүлнэ.

5.6.8.Гадаадын зах зээлд экспортлох боломжтой тэргүүлэх ач холбогдол бүхий бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг төрөөс дэмжих “Монгол экспорт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол-Экспо үзэсгэлэн яармаг арга хэмжээг зохион байгуулан, гадаад зах зээлд гарах нөхцөлийг сайжруулж, үндэсний аж ахуйн нэгж гадаадад хөрөнгө оруулах, дэлхийн санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

5.6.9.Хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийнхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг тууштай хамгаалж, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлж, иргэний бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна. Энэ хүрээнд “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-ийн хөрөнгө, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.6.10.Монгол Улсын түүх, соёлын өв уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилт, хөгжил дэвшил, гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагааг дэлхий нийтэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, Монгол Улсыг сурталчилсан үзэсгэлэн, яармаг, кино, соёл, урлагийн тоглолт, өдрүүд, уулзалт, ярилцлага зэрэг арга хэмжээг хилийн чанадад зохион байгуулна. Монгол судлалын хүрээг тэлэх, тогтвортой хөгжлийг хангах үндсийг бүрдүүлнэ.

5.6.11.Хилийн чанадад байгуулагдсан "Монгол сургууль, цэцэрлэг"-ийн үйл ажиллагааг сурах бичиг, сургалтын арга зүйгээр дэмжинэ. Монгол иргэдийн үүсгэл санаачилгаар байгуулагдсан монголчуудын холбоодод дэмжлэг үзүүлнэ.

5.6.12."Зөгийн үүр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гадаадад сурч, ажиллаж өндөр мэдлэг, боловсрол, технологи, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

5.6.13.Нарийн мэргэжлээр сурч, хилийн чанадад өндөр мэргэжлийн, академик ажил эрхэлж байгаа монголчуудад эх орныхоо хөгжилд алсаас хувь нэмэр оруулах боломж бүрдүүлж, Монгол Улс дахь эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, лабораторитой холбож өгнө.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (САЛБАРААР)

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр) | | | | | | | | Хэрэгжүүлэх байгууллага | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2017 он | | 2018 он | | 2019 он | | 2020 он | | | | |
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Үндсэн | Хамтрагч | Оролцогч |
| ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | | | | | |
| Тэргүүлэх зорилт №3.2.1. Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, амьдралд нийцтэй болгоно. Хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт суралцах боломжтой болж, сурагчид гэр сургуулийнхаа хооронд нийтийн тээвэрт үнэгүй зорчиж, сургууль 3 ээлжгүй болно. Хөдөөд малчны хүүхэд 6-8 насандаа сонголттойгоор суралцах боломжтой болж, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулна. Сургуулийг хүн хөгжлийн төв болгоно. Сургууль хүүхдэд мэдлэг, боловсрол, чадвар олгодог төдийгүй эрүүл чийрэг, зөрэг зан суртахуун, хүмүүжил, төлөвшилтэй, амьдрах ухаантай, эх оронч, үндэсний бахархалтай хүн болоходд нь тусалдаг болно. Бүх шатны боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх боломжтой болгож стандартад суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлнэ. Их, дээд сургууль, коллежийн оюутны суралцах эрхийн баталгааг хангаж, өрхийн боловсролын зардлыг бууруулж, дээд боловсролын сургалтын чанарыг дэмжинэ. Оюутанд үндэсний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно. Оюутан сургалтын төлбөрийн дарамтгүй, эрүүл мэндийн үйлчилгээтэй, суралцах хугацаандаа цагийн ажил эрхлэх, дотуур байранд амьдрах боломжтой болно. Төрийн өмчийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг хангаж, дээд боловсролд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлнэ. Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад нийгэм, сэтгэл зүй, дэд бүтцийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, нийгмийн үйлчилгээг бий болгоно. | | | | | | | | | | | | | | | | |
| 3.2.17. Ерөнхий боловсролын сургуулийн сурагч ажил, мэргэжлээ сонгох, суралцах сургуулиа сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар ажил мэргэжлийн зөвлөгөө үзүүлдэг үйлчилгээг бий болгоно. | 1 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох талаар шийдвэр гаргаж, холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах | 2017-2018 | - | - | Ерөнхий боловсролын сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ бий болох боломж бүрдэх | - | - | - | - | - | - | - | БСШУСЯ | - | - |
| | 2 | Ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээг зохион байгуулах ажлын агуулга, хөтөлбөрийг боловсруулж мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах | 2017-2018 | Гадаад эх үүсвэр | 240.0 | 100 сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ бий болох | 40.0 | 200 сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ бий болох | 80.0 | 200 сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ бий болох | 80.0 | 100 сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ бий болох | 40.0 | БСШУСЯ | - | - |
| | 3 | Ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх онлайн үйлчилгээг бий болгох талаар холбогдох мэргэжлийн болон ТББ-уудтай хамтран ажиллах | 2017-2018 | Гадаад эх үүсвэр | 120.0 | 100 сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэжлийн болон ТББ-уудтай хамтран зохион байгуулах | 30.0 | 200 сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэжлийн болон ТББ-уудтай хамтран зохион байгуулах | 30.0 | 200 сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэжлийн болон ТББ-уудтай хамтран зохион байгуулах | 30.0 | 100 сургуульд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэжлийн болон ТББ-уудтай хамтран зохион байгуулах | 30.0 | БСШУСЯ | - | Мэргэжлийн холбоод, ТББ-ууд |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.18. Төрийн өмчит их, дээд сургууль, коллежийг хувьчлахгүй. Дээд боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, төрийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг нь хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 1 | Төрийн өмчийн их, дээд сургуулийн улс төрөөс хараат бус, бие даасан байдлыг хангах болон бусад чиглэлд дээд боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгох | 2017-2020 | - | - | Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах | - | Холбогдох журмуудад өөрчлөлт оруулах | - | Хэрэгжилтийн түвшинг сайжруулах | - | Төрийн өмчийн их, дээд сургуулиуд улс төрөөс хараат бус, бие даасан байдлаар хөгжих боломж бүрдэх | - | БСШУСЯ | - | МИДСК, МХИДСК |
| | 2 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр батлан хэрэгжүүлэх | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 271.5 | Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны дүгнэлт, гарын авлага , үр дүнд суурилсан сургалтын дэд хөтөлбөр батлуулах | - | Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг шинэчлэх | 100.0 | Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 100.0 | Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, сайжруулах | 71.5 | БСШУСЯ | БМИУЗ | МИДСК, МХИДСК |
| | 3 | "Судалгаанд суурилсан их сургууль" үндэсний хөтөлбөр батлан, хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 6,017.5 | Судалгааны их сургуулийн үзэл баримтлалыг боловсруулах | 17.5 | Судалгаанд суурилсан их сургууль үндэсний хөтөлбөр батлах | 2,000.0 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2,000.0 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2,000.0 | БСШУСЯ | МИДСК, МХИДСК | Их, дээд сургуулиуд |
| | 4 | Дээд боловсролын салбарын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 700.0 | Хүний нөөцийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох | 150.0 | Дээд боловсролын байгууллагын үндсэн багш нарын 8-10 хувийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах | 150.0 | Дээд боловсролын байгууллагын үндсэн багш нарын 8-10 хувийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах | 200.0 | Дээд боловсролын байгууллагын үндсэн багш нарын 8-10 хувийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах | 200.0 | БСШУСЯ, "Дээд боловсролын шинэчлэл" төсөл | БМИУЗ | МИДСК, МХИДСК |
| | 5 | Дээд боловсролын байгууллага, хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд үе шаттайгаар хамруулахад дэмжлэг үзүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 280.0 | Хамтын ажиллагаатай гадаадын магадлан итгэмжлэлийн байгууллагын тоо нэмэгдэх, 3 хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийх | 70.0 | 5 хөтөлбөр олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдэх | 70.0 | 4 хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийх | 70.0 | Олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрийн тоо 8-10 болох | 70.0 | БСШУСЯ | БМИУЗ | МИДСК, МХИДСК |
| 3.2.22. Үндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг олгоно. | 1 | Үндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг сурлагын амжилтыг үндэслэн олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 172,000.0 | Тэтгэлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 43,000.0 | Тэтгэлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 43,000.0 | Тэтгэлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 43,000.0 | Тэтгэлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 43,000.0 | БСШУСЯ | СЯ | СТСан / БЗСан/ |
| | 2 | Жил бүр 40 мянга хүртэлх суралцагчдыг МСҮТ, политехник коллежид суралцуулан, тэтгэлэг олгож, суралцагчийн үр чадварыг үнэлэх журам мөрдүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 84,540.0 | Суралцагчдад тэтгэлэг олгох журам шинэчлэгдэх | 19,770.0 | Тэтгэлэг улсын төсвөөс олгогдохоор төсөвт батлуулах | 19,770.0 | Суралцагчдад тэтгэлэг олгох | 22,500.0 | Суралцагчдад тэтгэлэг олгох | 22,500.0 | ХНХЯ | МБСБ-үүд | ААН-үүд |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.23. Оюутны дотуур байрны хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ. | 1 | Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын оюутны байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх | 2017-2020 | Улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 117,600.0 | Хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүртээмж, орчин сайжрах, амьдран суух оюутан суралцагчдын тоо нэмэгдэх | 39,200.0 | Хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүртээмж, орчин сайжрах, амьдран суух оюутан суралцагчдын тоо нэмэгдэх | 39,200.0 | Хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүртээмж, орчин сайжрах, амьдран суух оюутан суралцагчдын тоо нэмэгдэх | 19,600.0 | Хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүртээмж, орчин сайжрах, амьдран суух оюутан суралцагчдын тоо нэмэгдэх | 19,600.0 | БСШУСЯ | СЯ, БХБЯ | - |
| | 2 | Жилд 5 хүртэлх МСҮТ, политехник коллежийн дотуур байрны хүчин чадлыг нэмэгдүүлэн, засвар үйлчилгээ хийж өргөтгөх | 2016-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 1,200.0 | 15-20 хүртэлх МБСБ-ын оюутны дотуур байрны хүртээмж, орчин сайжрах | 300.0 | 15 хүртэлх МБСБ-ын оюутны дотуур байрны орчин сайжрах | 300.0 | Зарим сургалтын байгууллагын оюутны дотуур байрны орчин сайжрах | 300.0 | Төрийн өмчийн 25 МБСБ-ын оюутны дотуур байрны орчин сайжрах | 300.0 | ХНХЯ | СЯ | - |
| 3.2.24. Оюутнууд харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээ авдаг болно. | 1 | Оюутан залуучуудын эрүүл мэндийг дэмжих сарын аяныг жил бүр зохион байгуулах | 2017-2020 | Улсын төсөв | 310.0 | Их, дээд сургууль, коллежийн оюутны 15 хувь нь хамрагдах | - | Их, дээд сургууль, коллежийн оюутны 20 хувь нь хамрагдах | 100.0 | Их, дээд сургууль, коллежийн оюутны 40 хувь нь хамрагдах | 100.0 | Их, дээд сургууль, коллежийн оюутны 60 хувь нь хамрагдах | 110.0 | БСШУСЯ | ЭМЯ, ХНХЯ | СЯ |
| | 2 | Оюутанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харъяалал харгалзахгүй үзүүлэх зохицуулалт хийх | 2017-2020 | - | - | ЭМСайд, БСШУССайд, ХНХСайдын хамтарсан тушаал батлуулж хэрэгжүүлэх | - | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 50 хувь, эрүүл мэндийн эрт илрүүлэг 50 хувьд хүрэх | - | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 80 хувь, эрүүл мэндийн эрт илрүүлэг 86 хувьд хүрэх | - | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 80 хувь, эрүүл мэндийн эрт илрүүлэг 86 хувьд хүрэх | - | БСШУСЯ, ЭМЯ, ХНХЯ | СЯ | СТСан / БЗСан/ |
| 3.2.26. Оюутанд суралцах хугацаандаа цагийн ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох "Орлоготой оюутан" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1 | "Орлоготой оюутан" хөтөлбөр батлан хэрэгжүүлэх | 2017-2020 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, гадаад эх үүсвэр | 1,960.0 | "Орлоготой оюутан" хөтөлбөр батлагдах | 670.0 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 430.0 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 430.0 | Хөтөлбөрийн дунд оюутан суралцагчид хичээлээс хөндийрөхгүйгээр ажил, хөдөлмөр хийж туршлагажих, орлого олоход нь дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэж, үйл ажиллагаа жигдрэх | 430.0 | БСШУСЯ | ХНХЯ | ААН-үүд |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.27. Нэлттэй мэдлэг, боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлж, орчин үеийн мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын тогтолцоог эрчимтэй хөгжүүлнэ. | 1 | Бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгох үндэсний хөтөлбөр боловсруулан батлаж, хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 1,000.0 | Хөтөлбөрийн төслийг боловсруулах, бүх нийтийн цахим боловсролын түвшний талаарх судалгаа хийх | 586.0 | Хөтөлбөрийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлэх, сургалт зохион байгуулах | 414.0 | Батлагдсан хөтөлбөрийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх | - | Хөтөлбөрийн хүрээнд сургалт судалгаа, арга хэмжээ зохион байгуулах | - | ХХМТГ | БСШУСЯ, МТҮП, их дээд сургуулиуд | - |
| | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насанд хүрээгүй хүүхэд, ахмад настны мэдээлэл, харилцаа холбооны технологийн зөв зохистой хэрэглээ нэмэгдүүлж, интернэтийн орчинд хамгаалах боломжийг бүрдүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 114.0 | Монгол хэлний яриа танилт болон ярианы синтезийн цогц системийг боловсруулах | 58.0 | Өргөн хэрэглээний программ хангамжуудад Монгол хэлний дуу хоолой таних командуудыг байршуулах | 56.0 | - | - | - | - | ХХМТГ, ХНХЯ | БСШУСЯ, МТҮП, их дээд сургуулиуд | - |
| | 3 | Мэргэжлийн боловсрол, сургалт болон хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын сургалтын хамрах хүрээг өргөжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоотой уялдуулах | 2017-2020 | - | - | Хууль, эрх зүйн орчин боловсронгуй болж, хөтөлбөр батлагдах | - | Бүх түвшний насан туршийн боловсролын тогтолцоо боловсронгуй болох | - | Бүх түвшний насан туршийн боловсролын тогтолцоо боловсронгуй болох | - | Насны хязгаар харгалзахгүй мэргэжил эзэмших боломжоор хангагдах | - | ХНХЯ | МБСБ-ууд | БСШУСЯ |
| Тэргүүлэх зорилт №3.2.2. Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | | | | | |
| 3.2.30. Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, инноваци, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ. | 1 | Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлах | 2018-2019 | - | - | - | - | Хөтөлбөрийн төсөл боловсруулах | - | Хөтөлбөрийг батлуулах | - | - | - | БСШУСЯ | СЯ, ҮХГ, ШУА | - |
| | 2 | Инновацийн бүтээгдэхүүн бий болгох, үйлдвэрлэл явуулах таатай орчин бүрдүүлэх | 2016-2020 | - | - | Гарааны компани дэмжсэн журам, жагсаалт батлагдах | - | Жагсаалт батлагдах | - | Жагсаалт батлагдах | - | Жагсаалт батлагдах | - | БСШУСЯ | Холбогдох яамд | ЭШБ-ууд, ААН-үүд |
| | 3 | Инноваци, гарааны бизнесийг дэмжих зорилгоор төсөл хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 19,000.0 | Инновацийн төсөл хэрэгжих | 1,000.0 | Инновацийн төсөл хэрэгжих | 3,000.0 | Инновацийн төсөл хэрэгжих | 5,000.0 | Инновацийн төслүүд хэрэгжиж, экспортэд ээлэх оюуны үйлдвэрлэл нэмэгдэх | 10,000.0 | БСШУСЯ | СЯ | ЭШБ-ууд, ААН-үүд |
| | 4 | МБСБ-ын судлаачид, багш, суралцагчид, төгсөгчдийн инноваци, бүтээлийн оюуны өмчийг хамгаалах, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжих төсөл хэрэгжүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулах | 2017-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 1,200.0 | 200 хүртэлх багш инновацийн сургалт, судалгаанд хамрагдаж, түгээн дэлгэрүүлэлт хийгдэх, оюуны өмч, патент авсан 3 хүртэлх бүтээгдэхүүнийг туршин үйлдвэрлэх | 300.0 | Багш нарын бүтээлийг олон нийтэд танилцуулж, эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлыг эхлүүлэх | 300.0 | Шинэ бүтээгдэхүүн турших ажлыг тогтмолжуулж, сургалтын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үргүй зардлыг тогтоож бууруулах | 300.0 | МБСБ-ын сургалтын материалын зардлын өөрийн эргэлтийг бий болгож, шинээр 5-аас доошгүй бүтээгдэхүүн гаргаж, санхүүгийн эргэлтэд оруулан тогтворжуулах | 300.0 | ХНХЯ | БСШУСЯ, МБСБ-ууд | Их, дээд сургуулиуд |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ. | 1 | Эрдэм шинжилгээний байгууллагуудын лабораторийн орчныг сайжруулж, тоног төхөөрөмжийг орчин үеийн судалгааны шаардлагад нийцүүлэн шинэчлэх | 2017-2020 | - | - | Орчныг шат дараатайгаар шинэчлэх | - | Орчныг шат дараатайгаар шинэчлэх | - | Орчныг шат дараатайгаар шинэчлэх | - | Лабораторийн орчин нөхцөл сайжрах | - | БСШУСЯ | СЯ | - |
| | 2 | Туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, бизнес инкубатор зэрэг инновацийн дэд бүтэц байгуулах ажлыг зохион байгуулах | 2017-2020 | - | - | - | - | Бизнес инкубатор, технологи дамжуулах төв байгуулагдах | - | Туршилтын үйлдвэр байгуулагдах | - | Инновацийн бусад дэд бүтцүүд байгуулагдах | - | БСШУСЯ | СЯ | ЭШБ-ууд |
| | 3 | Телевизийн өргөн нэвтрүүлгийн алсын зайн удирдлага, хяналтын системийг байгуулах | 2017-2020 | Улсын төсөв | 3,750.0 | 40 сайтад алсын зайн хяналтын систем байгуулах | 500.0 | 113 сайтад алсын зайн хяналтын систем байгуулах | 1,080.0 | 113 сайтад алсын зайн хяналтын систем байгуулах | 1,080.0 | 115 сайтад алсын зайн хяналтын систем байгуулах | 1,090.0 | ХХМТГ | "РТҮС" УТҮГ | - |
| | 4 | Өндөр технологийн аж үйлдвэрийн парк байгуулах | 2016-2020 | Гадаад эх үүсвэр | 853.0 | ТЭЗҮ боловсруулж, байгаль орчин, техник технологийн үнэлгээ хийх | 453.0 | Эрчим хүч, дулаан, усны эх үүсвэрт холбох | 400.0 | - | - | - | - | ХХМТГ, ҮХГ | ТББ-ууд | - |
| | 5 | Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ судалгааг цөм технологи, тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөгжүүлэх | 2016-2020 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 25,000.0 | Зам, тээврийн салбарт тэргүүлэх чиглэл, цөм технологийг нэвтрүүлэх хүрээнд судалгааны ажил хийгдэх | 8,000.0 | Судалгааны ажил хийгдэх | 8,000.0 | Судалгааны ажил хийгдэх | 5,000.0 | Судалгааны ажил хийгдэх | 4,000.0 | БСШУСЯ | ЗТХЯ | Их, дээд сургуулиуд, ТББ-ууд |
| | 6 | Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны байгууллагатай болох ажлыг эхлүүлэх | 2017-2019 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 10,000.0 | Судалгааны ажил хийгдэх | 6,000.0 | Эрдэм шинжилгээ судалгааны байгууллагатай болох холбогдох шийдвэр гаргуулах | 4,000.0 | ТЭЗҮ-ийг боловсруулах | - | - | - | ЗТХЯ | БСШУСЯ | ТББ-ууд |
| | 7 | Авто замын салбарт дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, цемент ашиглан цемент бетон хучилттай авто зам барьж, өртөг зардал хямд авто замын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, үндэсний стандартыг бий болгох | 2016-2020 | Гадаад эх үүсвэр | 50,000.0 | Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, цементээр бетон хучилттай авто зам барих, замын өртөг зардлыг бууруулах, ашиглалтын чанарыг сайжруулах техник технологийг боловсруулах | 10,000.0 | Дотоодын бүтээгдэхүүн, цементээр бетон хучилттай авто зам барих технологи бүхий зам барьж турших | 20,000.0 | Дотоодын бүтээгдэхүүн, цементээр бетон хучилттай авто зам барих чиглэлээр Үндэсний стандарт бий болох | 10,000.0 | Цемент бетон хучилттай зам барих эрх зүйн орчин бий болох | 10,000.0 | ЗТХЯ | - | - |
| | 8 | МБСБ-уудад судалгаа-туршилт-үйлдвэрлэл, инноваци лабораторийн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2017-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 2,000.0 | 5 хүртэлх МБСБ-д лабораторийг байгуулах | 500.0 | 5 хүртэлх МБСБ-д лабораторийг байгуулах | 500.0 | 5 хүртэлх МБСБ-д лабораторийг байгуулах | 500.0 | 5 хүртэлх МБСБ-д лабораторийг байгуулах | 500.0 | ХНХЯ | МБСБ-ууд | - |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.35. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого баримтална. | 1 | Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 3,000.0 | - | - | Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр-1-ийг боловсруулах | 1,000.0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 1,000.0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 1,000.0 | БСШУСЯ | СЯ | - |
| | 2 | Нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглах зохистой хэрэглээг бий болгох | 2016-2020 | - | - | Төрийн байгууллагуудад нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглах ерөнхий загвар боловсруулах | - | Төрийн байгууллагуудын хэрэглээнд нийгмийн мэдээллийн сүлжээг зохистой ашиглах загварыг нэвтрүүлэх | - | Нийгмийн мэдээллийн сүлжээний зохистой хэрэглээг дэмжих чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх | - | Нийгмийн мэдээллийн сүлжээний зохистой хэрэглээг дэмжих чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх | - | ХХМТГ | БСШУСЯ, ХНХЯ, ХХЗХ, МТҮП, "ҮДТ" УТҮГ | Их, дээд сургуулиуд |
| | 3 | Багш нарыг үйлдвэр, ААНБ-ын дэвшилтэт тоног төхөөрөмж дээр дадлагажуулах, багш-инженер техникийн ажилтнуудын солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 120.0 | МБСБ-ын багш, удирдах ажилтны ур чадвар сайжрах | 30.0 | Багш нарыг үйлдвэр, ААНБ-уудад дадлагажуулах, багш-инженер техникийн ажилтнуудын солилцооны хөтөлбөрийг боловсруулах | 30.0 | Багш нарыг үйлдвэр, ААНБ-уудад дадлагажуулах, багш-инженер техникийн ажилтнуудын солилцооны хөтөлбөрийг боловсруулах | 30.0 | Багш нарыг үйлдвэр, ААНБ-уудад дадлагажуулах, багш-инженер техникийн ажилтнуудын солилцооны хөтөлбөрийг боловсруулах | 30.0 | ХНХЯ | МБСБ-ууд | БСШУСЯ, ОӨУБЕГ |
| Тэргүүлэх зорилт №3.2.3. Соёл урлагийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож соёл урлагийг хөгжүүлэх бодлого, санхүүжилт, удирдлага зохион байгуулалтын шинэчлэлийг хэрэгжүүлнэ. Үндэсний болон сонгодог урлаг, нүүдлийн соёл иргэншлийг төрийн ивээлд байлгаж, бүх нийтийн соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёл урлагийн аялал жуулчлал, гадаадад монголын үндэсний соёл урлагийг сурталчлах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, монгол контентийг хөгжүүлнэ. Нийтийн биеийн тамирын нийгмийн орчин, үйлчилгээг боловсронгуй болгож, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх, өвлөн уламжлах, спортын эрдэм шинжилгээ, спортын анагаах ухааныг хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, спортыг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэмцээн, наадмын тогтолцоог боловсронгуй болгох, тамирчин дасгалжуулагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, биеийн тамир, спортын дэд бүтцийг сайжруулан нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | | | | | |
| 3.2.56. Нийтийн биеийн тамир, иог, бясалгал, зохистой хөдөлгөөн /фитнес/-ээр хичээллэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаар эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулна. | 1 | Нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйл ажиллагаар магадлан итгэмжлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 2017-2019 | Улсын төсөв | 370.0 | Магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг хангаж эхлүүлэх | 50.0 | Магадлан итгэмжлэлийг эхлүүлж, 30 байгууллагыг хамруулах | 80.0 | Магадлан итгэмжлэлийг эхлүүлж, 40 байгууллагыг хамруулах | 110.0 | Магадлан итгэмжлэлийг эхлүүлж, 50 байгууллагыг хамруулах | 130.0 | БСШУСЯ | БТСГ | Мэргэжлийн холбоод |
| | 2 | Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын үйл ажиллагаар тогтмолжуулж, үзүүлэлтийг сайжруулах | 2017-2020 | Улсын төсөв | 440.0 | Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох үйл ажиллагааг тогтмолжуулж, хамрагдалтыг урьд оноос 3 хувиар, сорилын үзүүлэлтийн түвшинг 0.5 хувиар нэмэгдүүлэх | 80.0 | Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох үйл ажиллагаанд хамрагдалтыг урьд оноос 5 хувиар, сорилын үзүүлэлтийн түвшинг 0.7 хувиар нэмэгдүүлэх | 100.0 | Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох үйл ажиллагаанд хамрагдалтыг урьд оноос 6 хувиар, сорилын үзүүлэлтийн түвшинг 0.9 хувиар нэмэгдүүлэх | 120.0 | Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох үйл ажиллагаанд хамрагдалтыг урьд оноос 7 хувиар, сорилын үзүүлэлтийн түвшинг 1.0 хувиар нэмэгдүүлэх | 140.0 | БСШУСЯ | БТСГ | Бүх шатны ЗДТГ-ууд |
| | 3 | Иргэдэд биеийн тамир, спортоор хичээллэж эрүүл мэндээ хамгаалсны төлөө эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал олгох ажлыг эхлүүлэх | 2017-2018 | Улсын төсөв | 2,700.0 | Холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах | 450.0 | Холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх | 600.0 | Биеийн тамир, спортоор хичээллэж эрүүл мэндээ хамгаалсны төлөө урамшуулал авдаг иргэний тоог нэмэгдүүлэх | 750.0 | Биеийн тамир, спортоор хичээллэж эрүүл мэндээ хамгаалсны төлөө урамшуулал авдаг иргэний тоог нэмэгдүүлэх | 900.0 | БСШУСЯ | ЭМЯ, ХНХЯ, БТСГ | ЭМДСан |
| Тэргүүлэх зорилт №3.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулна. | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.1. Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогыг бүх салбарт баримтална. | 1 | МБСБ-уудын дунд “Монгол ур чадвар” тэмцээнийг зохион байгуулах | 2016-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 1,200.0 | Дэлхийн ур чадварын 44 дэх удаагийн мэргэжлийн тэмцээнд оролцох | 300.0 | Монгол ур чадвар-2018 тэмцээнийг үе шаттайгаар зохион байгуулах | 300.0 | Дэлхийн ур чадварын 45 дахь удаагийн мэргэжлийн тэмцээнд амжилттай оролцох | 300.0 | Монгол хүний ур чадвар, Монголын мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэлхийд сурталчлах | 300.0 | ХНХЯ | МБСБ-ууд, ААН-үүд, мэргэжлийн холбоод | - |
| | 2 | “Дэлхийн ур чадвар” тэмцээнд оролцож ур чадвар эзэмшсэн суралцагч, төгсөгчид, багш нарын талаар олон нийтэд мэдээлж, мэргэжилтэй ажилтны ур чадвар, үнэлэмжийг нэмэгдүүлэх | | | | | | | | | | | | | | |
| 3.3.2. Өрхийн орлого, зарлага, ядуурлын түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг сайжруулж, бодит амьдралд нийцүүлнэ. | 1 | Ядуурлын үндсэн үзүүлэлтийг тооцох болон өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх | 2018-2019 | Улсын төсөв, Орон нутгийн төсөв, гадаад эх үүсвэр | 7,203.5 | 2016 онд шинэчлэн батлагдсан аргачлалын дагуу судалгаа хийгдэх | 3,483.5 | Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалд үнэлгээ хийж, шинэчлэх ажлыг эхлүүлэх | 80.0 | Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлах | 40.0 | Шинэ аргачлалын дагуу судалгаа хийх бэлтгэл ажлыг хангах | 3,600.0 | ҮСХ | ХНХЯ | - |
| | 2 | Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэх | 2016-2017 | - | - | Аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлуулах | - | Аргачлалыг мөрдөж ажиллах | - | Аргачлалыг мөрдөж ажиллах | - | Аргачлалыг мөрдөж ажиллах | - | ХНХЯ | ҮСХ | - |
| 3.3.3. Хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, орон нутгийн санаачилгыг дэмжинэ. | 1 | Орон нутгийн онцлогийг тусган боловсруулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслийг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх | 2016-2020 | Орон нутгийн төсөв, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 24,000.0 | Орон нутгийн байгууллагуудыг татан оролцуулж, саналыг тусгах | 6,000.0 | Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжих | 6,000.0 | Сумдуудад хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх | 6,000.0 | Орон нутгийн засаг захиргааны байгууллагын хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдан ажлын байр нэмэгдэх | 6,000.0 | ХНХЯ | Аймгийн ЗДТГ-ууд, ХХҮГ-ууд | - |
| 3.3.4. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэшлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлнэ. | 1 | Барилгын салбарын эрэлтэд нийцсэн мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтэй ажилчин бэлтгэх тогтолцоог холбогдох байгууллагатай хамтран бүрдүүлэх | 2017-2020 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 20.0 | Эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх | 5.0 | Эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх | 5.0 | Эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх | 5.0 | Эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх | 5.0 | БХБЯ | ХНХЯ | БХТ, ААН-үүд |
| | 2 | Салбарын суурь судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх | 2017-2020 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | 300.0 | Мэдээллийн сан үүсгэх | 300.0 | - | - | - | - | - | - | БХБЯ | БХТ | ТББ-ууд, ААН-үүд |
| | 3 | Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны чадавхийг бэхжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн судалгааны арга зүй, хамрах хүрээ, үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар ажиллах хүчний нийлүүлэлт, хөдөлмөрийн зах зээлийн бодлогын уялдааг хангах | 2017-2019 | - | - | Элсэлтийг бодитой төлөвлөх, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийх чадавхи бэхжих | - | Элсэлтийг бодитой төлөвлөх, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийх чадавхи бэхжих | - | Элсэлтийг бодитой төлөвлөх, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийх чадавхи бэхжих | - | Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэх | - | ХНХЯ | ХЗДХЯ | - |
| 3.3.5. Ажил олгогчийг ажлын байраа хадгалах, өндөр техник, технологи ашигладаг ажлын байраа нэмэгдүүлэхэд төрөөс бодлогоор дэмжинэ. | 1 | Өндөр техник, технологи ашигладаг ажлын байрыг хадгалж нэмэгдүүлсэн ажил олгогчийг татвар болон зээл, санхүүгийн бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бий болгох | 2016-2020 | Улсын төсөв, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 6,000.0 | Судалгааны ажил хийгдэх | - | Төсөл боловсруулагдаж батлагдах | 2,000.0 | Өндөр техник, технологи ашиглаж буй ажлын байр нэмэгдэх | 2,000.0 | Өндөр техник, технологи ашиглаж буй ажлын байр нэмэгдэх | 2,000.0 | ХНХЯ | СЯ | - |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.6. Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авдаг ажиллагчдын тоог 50-аас дээш хувиар бууруулна. | 1 | Гадаадаас ажиллах хүч авахад тавигдах шаардлагыг дотоодын ажиллах хүчний нөөц бололцоо, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, нарийвчлан тогтоох | 2016-2020 | - | - | Хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэх | - | Хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэх | - | Хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэх | - | Хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэх | - | ХНХЯ | - | - |
| | 2 | Дотоодын ажиллах хүчийг гадаадын өндөр ур чадвартай мэргэжилтнийг дагалдуулан сургаж, ажлын байраар хангах | 2016-2020 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 4,000.0 | Гадаадын ажиллагчдын тоо үе шаттай буурах | 1,000.0 | Гадаадын ажиллагчдын тоо үе шаттай буурах | 1,000.0 | Гадаадын ажиллагчдын тоо үе шаттай буурах | 1,000.0 | Гадаадын ажиллагчдын тоо үе шаттай буурах | 1,000.0 | ХНХЯ | Холбогдох яамд, МАОЭНХ | - |
| 3.3.7. Өндөр технологийн 2000 энтрепренёр мэргэжилтнийг бэлтгэнэ. | 1 | Мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлийн энтрепренёр бэлтгэх | 2016-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 1,000.0 | Энтерпренёр бэлтгэх | 517.0 | Энтерпренёр бэлтгэх | 183.0 | Энтерпренёр бэлтгэх | 150.0 | Энтерпренёр бэлтгэх | 150.0 | ХХМТГ | БСШУСЯ, ХХЗХ | МТҮП, их, дээд сургуулиуд |
| | 2 | Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр болон дадлагажигчийн хөтөлбөрийн хүрээнд ажиллах Монгол иргэдийг хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмж өндөртэй, стратегийн ач холбогдол бүхий салбарт ажиллах боломжийг бүрдүүлэх | 2017-2020 | - | - | Хууль, эрх зүйн орчин бүрдэж, хоёр талт гэрээ хэлэлцээрийн зохицуулалт шинэчлэгдэх | - | Өндөр технологи, ур чадвар эзэмшсэн мэргэжилтний тоо үе шаттай нэмэгдэх | - | Өндөр технологи, ур чадвар эзэмшсэн мэргэжилтний тоо үе шаттай нэмэгдэх | - | Өндөр технологи, ур чадвар эзэмшсэн мэргэжилтний тоо үе шаттай нэмэгдэх | - | ХНХЯ | ГХЯ | - |
| | 3 | Их, дээд сургууль, МБСБ-ын төгсөгчдийг гадаад орны өндөр технологи эзэмшүүлэхтэй холбоотой хуул, эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2016-2020 | - | - | Хууль, эрх зүйн төслийг боловсруулах | - | Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдийн нэгжүүдтэй гэрээ хэлцэл байгуулах | - | Өндөр технологи, ур чадвар эзэмшсэн мэргэжилтний тоо үе шаттай нэмэгдэх | - | Өндөр технологи, ур чадвар эзэмшсэн мэргэжилтний тоо үе шаттай нэмэгдэх | - | ХНХЯ | БСШУСЯ | ГХЯ |
| 3.3.8. Үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчнийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог хөгжүүлнэ. | 1 | Барилгын салбарын мэргэжилтэй ажилчдыг үйлдвэрлэлийн баазад түшиглэн давтан сургах тогтолцоог бүрдүүлэх | 2017-2020 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 60.0 | Давтан сургах тогтолцоо бүрдэх | 15.0 | Давтан сургах тогтолцоо бүрдэх | 15.0 | Давтан сургах тогтолцоо бүрдэх | 15.0 | Давтан сургах тогтолцоо бүрдэх | 15.0 | БХБЯ | ХНХЯ | БХТ, ААН-үүд |
| | 2 | Ажил олгогчийн хэрэгцээнд нийцүүлэн МСҮТ, политехник коллежийг түшиглэн салбар дундын ажиллах хүчнийг бэлтгэж, давтан сургаж дадлагажуулах | 2017-2020 | - | - | МБСБ-ыг түшиглэн үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчнийг бэлтгэх, давтан сургах үйл ажиллагааг хөгжүүлэх | - | Эрэлттэй мэргэжлээр бэлтгэх, давтан сургах, ажлын байранд дадлагажуулах нөхцөлийг бүрдүүлэх | - | Ижил төстэй мэргэжил рүү хөрвүүлэн, эрэлттэй мэргэжлээр давтан суралцуулах нөхцөлийг бүрдүүлэх | - | Хууль, эрх зүйн орчин бүрдэх | - | ХНХЯ | МБСБ-ууд | ААН-үүд |
| 3.3.9. Мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | 1 | Мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүд болон барилгын салбарын хувийн хэвшлийн байгууллагууд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх | 2017-2020 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 20.0 | МБСБ-ууд ААН-үүдтэй хамтран ажиллах | 5.0 | МБСБ-ууд ААН-үүдтэй хамтран ажиллах | 5.0 | МБСБ-ууд ААН-үүдтэй хамтран ажиллах | 5.0 | МБСБ-ууд ААН-үүдтэй хамтран ажиллах | 5.0 | БХБЯ | ХНХЯ | БХТ, ААН-үүд |
| | 2 | МБСБ-ын үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан хөгжүүлэх | 2016-2020 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 120.0 | Ажил олгогчдын захиалгат мэргэжилтэй ажилтан бэлтгэгдэх | 30.0 | Сургалтын бүх шатанд хувийн хэвшлийн оролцоог хангах | 30.0 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдсан сургалтын чанар хүртээмж нэмэгдэх | 30.0 | Ажил олгогчийн захиалга давамгайлсан сургалт төлөвлөгддөг болох | 30.0 | ХНХЯ | МБСБ-ууд, ААН-үүд, мэргэжлийн холбоод | - |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.10. Мэргэжлийн боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулна. | 1 | Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын ажилтан, багш, дадлагажуулагч багш нарын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2016-2020 | Улсын төсөв | 240.0 | “МБСБ-ын багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах | 60.0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 60.0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд шатны үнэлгээ хийгдэх | 60.0 | Хөтөлбөрийн дүгнэлт, тайлан гарах | 60.0 | ХНХЯ | - | БСШУСЯ, Удирдлагын академи, МБСБ-ууд |
| 3.3.11. Багш, эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн, ажилласан жил зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгоно. | 1 | Эрүүл мэндийн ажилтны ажлын норм, нормативыг нотолгоонд суурилан тогтоож, цалин хөлстэй уялдуулах | 2017-2020 | - | - | Эрүүл мэндийн голлох мэргэжлийн чиглэлээр ажлын норм, нормативыг шинэчлэн боловсруулж эхлэх | - | Эрүүл мэндийн голлох мэргэжлийн чиглэлээрх ажлын норм, нормативыг нэвтрүүлэх | - | Ажлын норм, нормативыг тогтоох эрүүл мэндийн мэргэжлийн чиглэлүүдийг өргөжүүлэх | - | Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх тогтолцоонд шилжиж, ажлын ачаалалтай уялдсан цалин хөлсний тогтолцоонд шилжих | - | ХНХЯ | ЭМЯ, СЯ | ЭМХТ, ЭМБ-ууд |
| | 2 | Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгох | 2016-2020 | - | - | Судалгаа хийгдэх, үнэлгээ хийгдэх | - | Цалин хөлсний бүтцийг боловсруулах | - | Ангилал, зэрэглэл шинэчлэгдэх | - | Цалингийн сүлжээг шинэчлэх | - | ХНХЯ, ЭМЯ | Салбарын ҮЭХ, ТББ-ууд | - |
| | 3 | Багш нарын ажлын үр дүнг харгалзсан урамшууллын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх | 2017-2020 | - | - | Судалгаа хийгдэх, үнэлгээ хийгдэх | - | Цалин хөлсний бүтцийг боловсруулах | - | Ангилал, зэрэглэл шинэчлэгдэх | - | Цалингийн сүлжээг шинэчлэх | - | СЯ, БСШУСЯ, ХНХЯ | МҮЭХ | ТББ-ууд |
| 3.3.12. Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрд олгоно. | 1 | Хүүхдийн мөнгийг олгох эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 1,116,700.0 | Хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 60 хувьд бэлэн мөнгөөр олгох, нөхөн авах хүүхдийн судалгааг хийх | 161,500.0 | Хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 60 хувьд бэлэн мөнгөөр олгох, нөхөн авах хүүхдийн судалгааг хийх | 158,400.0 | Хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд олгох, 2016, 2017 онд аваагүй хүүхдийн мөнгийг нөхөн олгох | 518,400.0 | Хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд олгох | 278,400.0 | СЯ | ХНХЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| 3.3.13. 3 хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/ болон орлого багатай өрхийг төрөөс дэмжих эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 1 | Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 3 хүртэл настай хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхэд тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэх | 2018-2019 | Улсын төсөв | 44,250.0 | Хуулийн төслийн тооцоо, судалгааг хийх | - | Хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэх | 8,850.0 | Хуулийн төслийг батлуулж, хэрэгжүүлж эхлэх | 17,700.0 | Хуулийг хэрэгжүүлж эхлэх | 17,700.0 | ХНХЯ | СЯ | - |
| 3.3.14. 3 хүртэл насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь тасрахгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 1 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эхчүүдийн НДШ-ийг төлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2017-2018 | Улсын төсөв | 103,680.0 | Хуулийн төслийн тооцоо, судалгааг хийх | - | Хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэх | 20,736.0 | Хуулийн төслийг батлуулж, хэрэгжүүлж эхлэх | 41,472.0 | Хуулийг хэрэгжүүлж эхлэх | 41,472.0 | ХНХЯ | СЯ | - |
| | 2 | Хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эхчүүдэд сар бүр тэтгэмж олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 528,000.0 | Хуулийн төслийн тооцоо, судалгааг хийх | - | Хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэх | 105,600.0 | Хуулийн төслийг батлуулж, хэрэгжүүлж эхлэх | 211,200.0 | Хуулийг хэрэгжүүлж эхлэх | 211,200.0 | ХНХЯ | СЯ | ЭМНДЕГ |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.15. Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулна. | 1 | Малчдын тэтгэврийн насыг эрэгтэй 55, эмэгтэй 50 болгох судалгаа хийж, хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх | 2018 | Улсын төсөв | 208,800.0 | Хуулийн төслийг батлуулах | - | Хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангуулах | - | Малчид эрэгтэй 55, эмэгтэй 50 настай тэтгэвэр тогтоолгож эхлэх | 96,200.0 | Малчид эрэгтэй 55, эмэгтэй 50 настай тэтгэвэр тогтоолгох | 112,600.0 | ХНХЯ | СЯ | ХХААХҮЯ |
| 3.3.16. Малчид, хувиараа аж ахуй эрхлэгчдэд нийгмийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх эрх зүйн орчин бүрдүүлнэ. | 1 | Малчид, хувиараа аж ахуй эрхлэгчдэд НДШ-ээ нэг удаа нөхөн төлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 267,400.0 | Судалгаа хийгдэж, үнэлгээ хийгдэх | 26,800.0 | Хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх | 53,400.0 | Хуулийн төслийг батлуулах | 80,200.0 | Хуулийг хэрэгжүүлж эхлэх | 107,000.0 | ХНХЯ | СЯ | - |
| 3.3.17. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчилнэ. | 1 | Нийгмийн даатгалын тухай багц хуулийг шинэчлэн боловсруулж, батлуулах | 2016-2017 | - | - | Багц хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулах | - | Багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх | - | Хуулийн төслийг батлуулах | - | Хуулийг хэрэгжүүлж эхлэх | - | ХНХЯ | СЯ | ХЗДХЯ |
| | 2 | Тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх | 2016-2017 | - | - | Багц хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулах | - | Багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх | - | Хуулийн төслийг батлуулах | - | Хууль батлагдан, иргэд олон хувилбарт эх үүсвэрээс тэтгэвэр авах боломж бүрдэх | - | ХНХЯ | СЯ | СЗХ |
| 3.3.18. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн нэр төрлийг багцлан оновчтой тогтоож, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлнэ. | 1 | Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг судалж, дүгнэлт гаргах | 2017-2019 | - | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд судалгаа, дүгнэлт хийх | - | Судалгааны хүрээг тогтоох | - | Судалгаа хийгдэж, дүгнэлт гарах | - | Холбогдох хууль тогтоомж шинэчлэгдэх | - | ХНХЯ | СЯ | - |
| | 2 | Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох | 2017-2019 | Улсын төсөв | 30,000.0 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд судалгаа, дүгнэлт хийх | - | Хуулийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагаас санал авах | - | Хуулийн төслийг батлуулах | - | Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | 30,000.0 | ХНХЯ | СЯ | - |
| 3.3.19. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрх зүйн орчин, санхүүжилтийн механизмыг оновчтой болгоно. | 1 | "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний тав дахь хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 200.0 | Хөтөлбөр батлагдан хэрэгжих | 50.0 | Хөтөлбөрийг хэрэгжүүлж, 1 дүгээр үе шатны төлөвлөгөө батлагдах | 50.0 | Хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2 дугаар үе шатны төлөвлөгөө батлагдах | 50.0 | Хөтөлбөр хэрэгжиж, ХАБЭА-н санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгож, төр, төсвийн байгууллагын зардлыг төсөвт тусгадаг болох | 50.0 | ХНХЯ | МҮЭХ, МАОЭНХ, МХЕГ | Холбогдох яамд |
| | 2 | ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжиж, ажил олгогч, даатгуулагчтай хамтран ажиллах, НДС-аас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах | 2017-2020 | - | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, эрх зүйн орчин сайжрах | - | Холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 5 дахь хөтөлбөр хэрэгжиж, 2 дугаар шатны төлөвлөгөө батлагдах, санхүүжилт тодорхой болох | - | Үйлдвэрлэлийн ослын тоо буурах, МШӨ-өөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох, хяналтанд хамруулах үйл ажиллагаа сайжрах | - | ХНХЯ | СЯ, холбогдох яамд | - |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.20. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний салбарт төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан хамтын ажиллагааг өрнүүлж, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, хэлбэрийг олшруулан дотооддоо өндөр үнэтэй эмчилгээ хийлгэх тохиолдолд даатгалд хамруулдаг болно. | 1 | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан бүх төрлийн тусламж, үйлчилгээний төлбөрийн зардлыг санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2016-2020 | - | - | ЭМДС-аас санхүүжих 2-оос доошгүй нэр төрлийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлж эхлэх | - | ЭМДС-аас санхүүжих бүх төрлийн тусламж, үйлчилгээг бүрэн санхүүжүүлэх | - | ЭМДС-аас санхүүжих тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх судалгааны дүн гарах | - | ЭМДС-аас санхүүжих тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдэх | - | ХНХЯ | ЭМЯ, СЯ | ТББ-үүд |
| | 2 | Ховор тохиолдох өвчин эмгэгтэй иргэдийн эмийн зардлыг ЭМДС-аас хөнгөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2018-2020 | - | - | Тооцоо, судалгаа, дүн шинжилгээний дүн гарах | - | ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчин бүрдэх | - | ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж эхлэх | - | Ховор тохиолдох өвчин эмгэгтэй иргэдийн эмчилгээний хүртээмж сайжрах | - | ХНХЯ | ЭМЯ | ТББ-үүд |
| | 3 | Харшлын аллерген эмчилгээний эмийн үнийн хөнгөлөлтийг ЭМДС-аас санхүүжүүлэх | 2017-2020 | - | - | Тооцоо, судалгаа, дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчныг бүрдүүлэх | - | ЭМДС-аас хөнгөлөлт үзүүлж санхүүжүүлэх | - | Харшлын бай эмчилгээний хүртээмж 50 хувьд хүрэх | - | Харшлын бай эмчилгээний хүртээмж 90 хувьд хүрэх | - | ХНХЯ | ЭМЯ | СЯ |
| | 4 | ЭМДС-аас зардлыг нь олгож байгаа өндөр өртөгтэй зарим тусламж үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протезийн нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэх | 2016-2020 | Эрүүл мэндийн даатгалын сан | 112,900.0 | Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо нэмэгдэх | 22,600.0 | Зарим хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн даатгуулагчдыг хамруулах | 26,000.0 | Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо нэмэгдэх | 29,900.0 | Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо нэмэгдэх | 34,400.0 | ХНХЯ | НДҮЗөвлөл | ЭМЯ, ЭМНДЕГ |
| 3.3.21. Эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллагыг бүрдүүлж, даатгуулагч төвтэй, орчин үеийн менежмент бүхий стратегийн идэвхтэй худалдан авагч болгон хөгжүүлнэ. | 1 | Эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллагыг сэргээн байгуулах, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын оролцоог хангах | 2016-2017 | - | - | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | - | Эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллага байгуулагдах | - | Үйл ажиллагаа тогтмолжих | - | Үйл ажиллагаа тогтмолжих | - | ХНХЯ | ЭМЯ, СЯ | - |
| | 2 | Даатгуулагчид чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ худалдан авах, тэдний эрхийг хамгаалах чадавхи бүхий засаглалтай эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллагыг үе шаттайгаар хөгжүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 23,000.0 | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах | - | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх | - | Хууль хэрэгжиж эхлэх | 15,000.0 | Даатгалын үр өгөөж нэмэгдэж, даатгалд хамрагдагсдын тоо нэмэгдэх | 8,000.0 | ХНХЯ | - | ЭМЯ, ЭМНДЕГ |
| 3.3.22. "Төрөөс ахмадын талаар баримтлах бодлого" гаргаж, "Ач санах" хуулийг батлуулж, азай буурлуудад "Насны хишиг" тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 1 | Төрөөс ахмадын талаар баримтлах бодлогыг баталж, хэрэгжүүлэх | 2016-2020 | - | - | Бодлого батлагдаж, хэрэгжиж эхлэх | - | Бодлого батлагдаж, хэрэгжиж эхлэх | - | Ахмадуудад төрийн бодлого, арга хэмжээ хүрэх | - | Ахмадуудад төрийн бодлого, арга хэмжээ хүрэх | - | ХНХЯ | ЭМЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 2 | Ач санах тухай хуулийн төслийг батлуулж, хэрэгжүүлэх | 2017-2018 | Улсын төсөв | 113,500.0 | Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх, батлуулах | 20,500.0 | Хуулийг хэрэгжүүлж эхлэх | 30,000.0 | Хуулийг хэрэгжүүлэх | 31,000.0 | Хуулийг хэрэгжүүлэх | 32,000.0 | ХНХЯ | - | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.23. Тэтгэвэр, тэтгэмж, цалинг үе шаттай нэмэгдүүлнэ. | 1 | Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 881,000.0 | Цалингийн хэмжээг бууруулахгүйгээр 2016 оны түвшинд барих | - | ТАХ-ийн цалин төсвийн орлогын хэмжээнээс хамаарч 2016 оны түвшнээс тодорхой хувиар нэмэгдэх | 190,000.0 | ТАХ-ийн цалин төсвийн орлогын хэмжээнээс хамаарч 2016 оны түвшнээс тодорхой хувиар нэмэгдэх | 211,000.0 | ТАХ-ийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийн хэмжээ 2 дахин нэмэгдэх | 480,000.0 | ХНХЯ | СЯ | - |
| | 2 | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жил тутамд нэмэгдүүлэх замаар иргэдийн орлогын түвшинг дээшлүүлэх | 2018-2020 | Улсын төсөв | 54,000.0 | ХХДХ 2016 оны түвшнээс 25 хувиар нэмэгдэх | 24,000.0 | ХХДХ 2016 оны түвшнээс 25 хувиар нэмэгдэх | - | ХХДХ 2016 оны түвшнээс 50-иас доошгүй хувиар нэмэгдэх | 30,000.0 | ХХДХ 2016 оны түвшнээс 50-иас доошгүй хувиар нэмэгдэх | - | ХНХЯ | СЯ | МАОЭНХ, МҮЭХ |
| 3.3.24. Тэтгэврийн зөрүүг ойртуулах, зээлийн хүүг бууруулах бодлого баримтална. | 1 | Тэтгэврийн зээлийн сарын хүүг үе шаттайгаар бууруулах | 2016-2017 | Бусад эх үүсвэр | 127,600.0 | Тэтгэвэр барьцаалсан зээлийн хүү буурах | 31,900.0 | Тэтгэвэр барьцаалсан зээлийн хүү буурах | 31,900.0 | Тэтгэвэр барьцаалсан зээлийн хүү буурах | 31,900.0 | Тэтгэвэр барьцаалсан зээлийн хүү буурах | 31,900.0 | ХНХЯ | Монголбанк | Арилжааны банкууд |
| 3.3.25. "Ахмадын зөвлөх үйлчилгээ"-г бий болгож, хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулна. | 1 | Хөдөлмөрийн чадамжтай ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднээс мэдлэг, туршлагаа залуу үед өвлүүлэхэд чиглэсэн "Ахмадын зөвлөх үйлчилгээ" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2016-2020 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 4,000.0 | Хөтөлбөрийг боловсруулан батлуулах | 1,000.0 | Хөдөлмөрийн чадамжтай ахмад настны тэтгэврийн бус орлого нэмэгдэх | 1,000.0 | Хөдөлмөрийн чадамжтай ахмад настны тэтгэврийн бус орлого нэмэгдэх | 1,000.0 | Хөдөлмөрийн чадамжтай ахмад настны тэтгэврийн бус орлого нэмэгдэх | 1,000.0 | ХНХЯ | - | - |
| 3.3.26. Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулахыг дэмжинэ. | 1 | Сэргээн засахын болон сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээний өртөг, зардлын судалгаа хийж, бодит өртөгт суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх | 2017-2018 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 10,000.0 | Тогтолцооны эрх зүйн орчин бүрдэх | 2,500.0 | ЭМДС-аас сэргээн засахын болон сувилахуйн дагнасан үйлчилгээний 12 төвийг санхүүжүүлэх | 2,500.0 | ЭМДС-аас сэргээн засахын болон сувилахуйн дагнасан үйлчилгээний 15 төвийг санхүүжүүлэх | 2,500.0 | ЭМДС-аас сэргээн засахын болон сувилахуйн дагнасан үйлчилгээний 18 төвийг санхүүжүүлэх | 2,500.0 | ХНХЯ | ЭМЯ, СЯ | ЭМХТ |
| | 2 | Сэтгэцийн архаг өвчтөнд зориулсан тусгайлсан асрамжийн газар байгуулах | 2017-2020 | Улсын төсөв | 2,000.0 | Эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх | 1,000.0 | Зураг төсөв батлагдаж, барилгын ажлын явц 50 хувьд хүрэх | 1,000.0 | Барилга байгууламжийг улсын комисс хүлээн авч, үйл ажиллагаа эхлэх | - | Үнэлгээний дүн гарах | - | ХНХЯ | ЭМЯ, СЭМҮТ | - |
| | 3 | Сэргээн засах төв, сувилахуйн төв, сувилал, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв байгуулах | 2017-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 15,000.0 | Эрх зүйн орчин бүрдэх | - | 10 аймаг, 2 дүүрэгт хувийн хэвшлийн настны сэргээн засахын болон сувилахуйн дагнасан үйлчилгээний төв байгуулах | 5,000.0 | Настны сэргээн засахын болон сувилахуйн дагнасан үйлчилгээний төв 2 аймаг, 1 дүүрэгт нэмж байгуулах | 5,000.0 | Настны сэргээн засахын болон сувилахуйн дагнасан үйлчилгээний төв 2 аймаг, 1 дүүрэгт нэмж байгуулах | 5,000.0 | ЭМЯ | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд | ААН-үүд |
| | 4 | Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, "Ахмад настны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр"-ийг боловсруулан хэрэгжүүлж, хувийн хэвшлийн төрөлжсөн асрамжийн газруудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллах | 2016-2020 | Улсын төсөв | 2,400.0 | Хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх | - | Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын шинэчлэл хийгдэх | 800.0 | Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын шинэчлэл хийгдэх | 800.0 | Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын шинэчлэл хийгдэх | 800.0 | ХНХЯ | СЯ | ААН-үүд |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.27. Жендерийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 1 | Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх | 2016-2017 | Улсын төсөв | 1,000.0 | Үндэсний хөтөлбөр батлагдаж, хэрэгжиж эхлэх | 200.0 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллага, мэргэжилтнүүдийг чадавхижуулах арга хэмжээнд хамруулах | 300.0 | Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга хэрэгслийг бүх шатны бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээнд нэвтрүүлэх | 300.0 | Улс орны жендэрийн нөхцөл байдлын судалгаа хийж, түншлэл, хамтын ажиллагааны хэлбэрийг зөвшилцөн тодорхойлох | 200.0 | ХНХЯ, ЖҮХороо | СЯ | Холбогдох ТЕЗ-д |
| 3.3.28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална. | 1 | Хот төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах арга хэмжээг тусган боловсронгуй болгох | 2017-2020 | Барилга, байгууламжийн норм, нормативын сан | 150.0 | Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан арга хэмжээг тусгах | 40.0 | Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан арга хэмжээг тусгах | 40.0 | Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан арга хэмжээг тусгах | 40.0 | Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан арга хэмжээг тусгах | 30.0 | БХБЯ | ХНХЯ | ТББ-ууд, ААН-үүд |
| | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах талаар хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төсөл, барилга байгууламжийн зураг төсөлд тусгуулан хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 2017-2020 | - | - | Хэрэгжилтийг зохион байгуулах | - | Хэрэгжилтийг зохион байгуулах | - | Хэрэгжилтийг зохион байгуулах | - | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөл бүрдэх | - | БХБЯ | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд | ТББ-ууд, ААН-үүд |
| | 3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон улсын эрүүл мэнд, үйл ажиллагааны ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх | 2017-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 1,500.0 | Эрх зүйн орчин бүрдэх | - | Хөгжлийн бэрхшээлийг үнэлэх олон улсын эрүүл мэнд, үйл ажиллагааны ангиллыг нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо 40 хувьд хүрэх | 500.0 | Хөгжлийн бэрхшээлийг үнэлэх олон улсын эрүүл мэнд, үйл ажиллагааны ангиллыг нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо 60 хувьд хүрэх | 500.0 | Хөгжлийн бэрхшээлийг үнэлэх олон улсын эрүүл мэнд, үйл ажиллагааны ангиллыг нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо 90 хувьд хүрэх | 500.0 | ХНХЯ | ЭМЯ | ЭМХТ, ЭМБ-ууд |
| | 4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг саадгүй авах эмнэлгийн гадаад, дотоод орчин нөхцөлийг бүрдүүлэх | 2017-2019 | Улсын төсөв | 1,500.0 | Эрх зүйн орчныг шинэчлэн батлах | - | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай үйлчилгээ нэвтрүүлсэн байгууллагын тоо 20 хүртэл хувиар нэмэгдэх | 500.0 | Үнэлгээний дүн гарах | 500.0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай үйлчилгээ нэвтрүүлсэн байгууллагын тоо 60 хүртэл хувиар нэмэгдэх | 500.0 | ЭМЯ | ХНХЯ | БХБЯ, ЗТХЯ, СЯ |
| | 5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 1,300.0 | Үндэсний хөтөлбөр батлагдаж, хэрэгжүүлж эхлэн, олон нийтэд сурталчлах | - | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувьд хүрэх | 500.0 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьд хүрэх | 500.0 | Үндэсний хөтөлбөр бүрэн хэрэгжиж дуусах | 300.0 | ХНХЯ, ЖҮХороо | ЭМЯ, БСШУСЯ, ЗТХЯ, БХБЯ | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6 | Зарим аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийг байгуулах / Дорнод, Дархан-Уул, Хөвсгөл, Ховд, Архангай, Дундговь/ | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 1,800.0 | Төвийг 6 аймагт байгуулах бэлтгэл ажлыг хангах | 600.0 | Төвийг 6 аймагт байгуулах бэлтгэл ажлыг хангах | 600.0 | Төвүүдийн үйл ажиллагаагаа тогтмолжиж эхлэх | 600.0 | Тус төвөөр тухайн аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн 60 гаруй хувь нь үйлчилгээ авах | - | ХНХЯ | Аймгийн ЗДТГ-ууд | БХБЯ, МХЕГ |
| | 7 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх цахим мэдээллийн нэгдсэн сан бий болгох | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 400.0 | Мэдээллийн нэгдсэн сантай болох бэлтгэл ажлыг хангах | 200.0 | Мэдээллийн нэгдсэн сан бий болох | 200.0 | Жил бүр мэдээллийн нэгдсэн сан шинэчлэгдэх | - | Жил бүр мэдээллийн нэгдсэн сан шинэчлэгдэх | - | ҮСХ | ХНХЯ | ЭМЯ |
| | 8 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, дэмжин туслах хөгжлийн төвийг байгуулах | 2016-2020 | Гадаад тусламж | 65,000.0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн барилгын үйл ажиллагаа жигдэрч эхлэх | 40,000.0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн барилгын үйл ажиллагаа жигдэрч эхлэх | 20,000.0 | Төвийг Улсын комисст хүлээлгэн өгч, үйл ажиллагааг эхлүүлэх | 2,000.0 | Төв үйл ажиллагаа явуулж эхлэх | 3,000.0 | ХНХЯ | - | - |
| | 9 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх | 2017-2020 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 10,000.0 | Хөтөлбөр шинэчлэгдэн хэрэгжиж, ажлын байр нэмэгдэх | 2,000.0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх | 2,500.0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, орлого нэмэгдэх | 2,500.0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, орлого нэмэгдэх | 3,000.0 | ХНХЯ | - | - |
| 3.3.29. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна. | 1 | Бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг сайжруулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 20,000.0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энгийн сургуульд хамрагдахад шаардлагатай дэд бүтцийн санхүүжилтийг төсөвт тусгах | 5,000.0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энгийн сургуульд хамрагдах дэд бүтэц бий болох | 5,000.0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энгийн сургуульд хамрагдах дэд бүтэц бий болох | 5,000.0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энгийн сургуульд хамрагдалт нэмэгдэх | 5,000.0 | БХБЯ, СЯ | БСШУСЯ, ХНХЯ, ЗТХЯ | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.30. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ. | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан ААНБ-д үзүүлэх дэмжлэгийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох | 2017-2020 | - | - | Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулах | - | Хуулийн үзэл баримтлалын ЗГ-т хүргүүлэх | - | Хуулийн төслийг УИХ-аар батлуулах | - | Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэх | - | СЯ | ХНХЯ | ХЗДХЯ |
| | 2 | Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, чадварыг илрүүлэх, тодорхойлох, хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төв болон салбар комиссыг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулах | 2016-2020 | Улсын төсөв | 600.0 | Төв болон салбар комиссын үйл ажиллагаа тогтмолжих | 150.0 | Төв болон салбар комиссын үйл ажиллагаа тогтмолжих | 150.0 | Төв болон салбар комиссын үйл ажиллагаа тогтмолжих | 150.0 | Төв болон салбар комиссын үйл ажиллагаа тогтмолжих | 150.0 | ХНХЯ | БСШУСЯ, ЭМЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| 3.3.31. Өрх толгойлсон болон бага орлоготой өрхийн гишүүдэд үзүүлэх дэмжлэг, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална. | 1 | Өрх толгойлсон эх /эцэг/ болон бага орлоготой өрхийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгож, өрхийн мэдээллийн нэгдсэн санг ашиглан тэдэнд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 4,000.0 | Хууль, эрх зүйн орчин бүрдэж, үйлчилгээнд хамрах хүрээ нэмэгдэх | 1,000.0 | Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжих | 1,000.0 | Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжих | 1,000.0 | Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжих | 1,000.0 | ХНХЯ | ЭМЯ, БСШУСЯ, ХХҮЕГ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| 3.3.32. Өрх толгойлсон эх /эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг батлан хэрэгжүүлнэ. | 1 | Өрх толгойлсон эх /эцэг/-ийн нийгмийн хамгааллын тухай хуулийн төслийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх | 2016-2017 | Улсын төсөв | 62,568.0 | Хууль батлагдах | 15,642.0 | Хуулийг хэрэгжүүлж эхлэх | 15,642.0 | Өрх толгойлсон эх /эцэг/-ийн нийгмийн баталгаа хангагдах | 15,642.0 | Өрх толгойлсон эх /эцэг/-ийн нийгмийн баталгаа хангагдах | 15,642.0 | ХНХЯ | СЯ | ХЗДХЯ |
| 3.3.33. Тав хүртэлх насны хүүхдийн эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 1 | 5 хүртэлх насны хүүхдийн эмийн зардлыг ЭМДС-аас хариуцах эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2016-2017 | Эрүүл мэндийн даатгалын сан | 31,800.0 | Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | - | Эрх зүйн орчин бүрдэх | 9,600.0 | Зардал ЭМДС-аас санхүүжигдэх | 10,600.0 | Нийгмийн баталгаа хангагдах | 11,600.0 | ХНХЯ | НДҮЗөвлөл | ЭМЯ, ЭМНДЕГ |
| 3.3.34. Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох эрх зүйн орчин бүрдүүлнэ. | 1 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, сайн дураар даатгуулагч эхэд олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг бодох хувь хэмжээг өөрчлөх | 2017-2020 | Улсын төсөв, Нийгмийн даатгалын сан | 7,600.0 | Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг олгож эхлэх | - | Хуулийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулах | 2,200.0 | Хуулийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулах | 2,500.0 | Хуулийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулах | 2,900.0 | ХНХЯ | - | - |
| 3.3.35. Төрүүлж, өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан хугацааг нэмэгдүүлэн тооцдог болно. | 1 | Эхчүүдийн ажилласан хугацааг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | 2017-2018 | - | - | Хууль батлагдах | - | Хуулийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулах | - | Хуулийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулах | - | Хуулийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулах | - | ХНХЯ | СЯ | - |
| 3.3.36. Хүүхдийг хувийн даатгалд хамруулж, боловсрол эзэмших, эмнэлгийн тусламж авах, тэжээгчээ алдсан үед тэтгэмж авах санхүүгийн нэмэлт баталгаар бүрдүүлнэ. | 1 | Хүүхдэд боловсрол эзэмших, эмнэлгийн тусламж авах, нийгмийн баталгааг хангахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий хувийн даатгалыг хөгжүүлэхэд төрөөс дэмжих | 2018-2020 | - | - | Хүүхдийг хувийн даатгалд хамруулах эрх зүйн орчин бүрдүүлэхэд хамтран ажиллах | - | Эрх зүйн орчин бүрдэж, хэрэгжилтийг хангаан ажиллах | - | Эрх зүйн орчин бүрдэж, хэрэгжилтийг хангаан ажиллах | - | Эрх зүйн орчин бүрдэж, хэрэгжилтийг хангаан ажиллах | - | СЗХ | ХНХЯ | - |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тэргүүлэх зорилт №3.4. Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангана. | | | | | | | | | | | | | | | | |
| 3.4.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүтцийг бий болгоно. | 1 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрыг байгуулах | 2017 | - | - | Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрыг байгуулах | - | Үйл ажиллагаа нь тогтмолжих | - | Үйл ажиллагаа нь тогтмолжих | - | Үйл ажиллагаа нь тогтмолжих | - | ХНХЯ | - | - |
| 3.4.2. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ. | 1 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг батлуулан, хэрэгжүүлэх | 2016-2017 | - | - | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх | - | Дагалдан гарах журмуудыг боловсруулж батлуулах | - | Гэр бүлийн хүчирхийллийн тоо буурах | - | Гэр бүлийн хүчирхийллийн тоо буурах | - | ХЗДХЯ | ХНХЯ | ГБХЗХГ |
| | 2 | Гэр бүлийн боловсрол олгох хичээлийг зааж эхлэх | 2017-2020 | - | - | Сургалтын модуль батлагдаж хэрэгжих | - | Гэр бүлийн боловсролын хөтөлбөрийг албан сургалтын хөтөлбөрт оруулах | - | Гэр бүлийн боловсрол олгох албан болон албан бус сургалт зохион байгуулж хэвших | - | Иргэдийн гэр бүлийн боловсрол дээшлэх | - | ХНХЯ | БСШУСЯ | ГБХЗХГ |
| | 3 | Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 900.0 | Хөтөлбөр батлагдах | - | Хөтөлбөрийн дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх | 300.0 | Гэр бүлийн аж амьдрал, хөгжилд ахиц гарах | 300.0 | Дундаж амьдралтай өрхийн тоо нэмэгдэх | 300.0 | ХНХЯ | ГБХЗХГ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 4 | Аймаг, дүүргийн түвшинд хууль зөрчсөн болон хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын зохицуулалтыг хариуцсан "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо"-г байгуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулах | 2016-2020 | - | - | Аймаг, дүүргүүдэд хороод байгуулагдаж, чадавхи бэхжих | - | Хороодын үйл ажиллагаа тогтмолжих | - | Хороодын үйл ажиллагаа тогтмолжих | - | Хороодын үйл ажиллагаа тогтмолжих | - | ХЗДХЯ | ХНХЯ, ГБХЗХГ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 5 | "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг дэмжиж, хамгааллын тусламж шуурхай үзүүлэх түр хамгаалах байр байгуулах | 2016-2020 | Улсын төсөв | 1,000.0 | Хамтарсан багийн ажиллах журмыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх | 250.0 | Хамтарсан багийн үйлчилгээ тогтмолжих | 250.0 | Хамтарсан багийн үйлчилгээ тогтмолжих | 250.0 | Хамтарсан багийн үйлчилгээ тогтмолжих | 250.0 | ХНХЯ | ЭМЯ, ХЗДХЯ, ГБХЗХГ, НЗДТГ | Нийслэл, аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 6 | Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулан хэрэгжүүлэх | 2017-2020 | - | - | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх | - | Хууль батлагдан, хэрэгжиж эхлэх | - | Гэр бүлийн салалт, хараа хяналтгүй хүүхдийн тоо буурах | - | Гэр бүлийн салалт, хараа хяналтгүй хүүхдийн тоо буурах | - | ХЗДХЯ | ХНХЯ | ХЗДХЯ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.3. Залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжид орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулдаг арга хэмжээг үе шаттай нэвтрүүлнэ. | 1 | Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг батлуулан хэрэгжүүлэх | 2018-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 350.0 | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх | - | Хууль батлагдан, хэрэгжиж эхлэх | 150.0 | Хуулийн хэрэгжилт хангагдах | 100.0 | Хуулийн хэрэгжилт хангагдах | 100.0 | ХНХЯ | ХЗДХЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 2 | Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 900.0 | Хөтөлбөрийг боловсруулан, ЗГ-ын тогтоолоор батлуулах | - | Үндэсний хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхлэх | 350.0 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах | 350.0 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах | 200.0 | ХНХЯ | ХЗДХЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 3 | Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд залуу гэр бүлийг орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулах журам боловсруулан хэрэгжүүлэх | 2017-2018 | Улсын төсөв | 30,000.0 | Журам боловсруулан ЗГ-ын тогтоолоор батлуулах | - | Журам батлагдан хэрэгжиж эхлэх | 10,000.0 | Журмын хэрэгжилт хангагдах | 10,000.0 | Журмын хэрэгжилт хангагдаж, залуучууд, залуу гэр бүлийн 5-аас доошгүй хувийг орон сууцанд хамруулах | 10,000.0 | БХБЯ | ХНХЯ, СЯ | Монголбанк |
| | 4 | "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 20,000 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх | 2017-2020 | Улсын төсөв, Орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 1,119.0 | Хөтөлбөр хэрэгжиж, түрээсийн орон сууцны сангийн бүрдүүлэлтийг 30 хувьд хүргэх | 335.7 | Хөтөлбөр хэрэгжиж, түрээсийн орон сууцны сангийн бүрдүүлэлтийг 60 хувьд хүргэх | 335.7 | Хөтөлбөр хэрэгжиж, түрээсийн орон сууцны сангийн бүрдүүлэлтийг 100 хувьд хүргэх | 223.8 | 20,000 айлын түрээсийн орон сууцны сан бүрдэх | 223.8 | БХБЯ | ТОСК ТӨҮГ, аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд | - |
| 3.4.4. Хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг чухалчлан үзэж "Хүүхдийн хөгжлийн ордон", "Хүүхэд хамгааллын төв"-үүдийг дэмжинэ. | 1 | Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 900.0 | Хөтөлбөрийг боловсруулж, батлуулах | - | Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх | 350.0 | Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаар салбар дундын зохицуулалт сайжрах | 350.0 | Хөтөлбөрт үнэлгээ хийгдэх | 200.0 | ХНХЯ | СЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 2 | Зарим аймаг, дүүрэгт Хүүхдийн хөгжлийн ордон, Хүүхэд хамгааллын үйлчилгээний төвийг үе шаттай байгуулах | 2016-2020 | Гадаад тусламж | 21,000.0 | 1-оос доошгүй аймаг, дүүрэгт хүүхдийн хөгжлийн ордон барих | 3,500.0 | 1-оос доошгүй аймаг, дүүрэгт хүүхдийн хөгжлийн ордон барих | 7,000.0 | 2-оос доошгүй аймаг, дүүрэгт хүүхдийн хөгжлийн ордон барих | 7,000.0 | 4-өөс доошгүй аймаг, дүүрэгт хүүхдийн хөгжлийн ордон барих | 3,500.0 | ХНХЯ | СЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 3 | Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг тасралтгүй ажиллуулах, дуудлагын дагуу хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 3,096.0 | Хүүхдийн тусламжийн утасны төвийг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх | 96.0 | Хүүхдийн эрхийн зөрчил буурах | 1,000.0 | Хүүхдийн эрхийн зөрчил буурах | 1,000.0 | Хүүхдийн эрхийн зөрчил буурах | 1,000.0 | ХНХЯ | СЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| 3.4.5. Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд үндэсний өв уламжлал, урлаг соёлоор дамжуулан эерэгээр нөлөөлөх бодлого хэрэгжүүлнэ. | 1 | Хүүхэд, өсвөр үеийнхэнд үндэсний өв, соёлыг уламжлуулах, тэдний хүмүүжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 200.0 | Хөтөлбөрт жил бүр 5000-аас доошгүй хүүхэд хамрагдах | 50.0 | Хөтөлбөрт жил бүр 5000-аас доошгүй хүүхэд хамрагдах | 50.0 | Хөтөлбөрт жил бүр 5000-аас доошгүй хүүхэд хамрагдах | 50.0 | Хөтөлбөрт жил бүр 5000-аас доошгүй хүүхэд хамрагдах | 50.0 | ХНХЯ | СЯ, ГБХЗХГ | БСШУСЯ, БХЯ, ЭМЯ, ОБЕГ, аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.6. Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлж, хүүхдийн осол, эндэгдлийн түвшинг 2 дахин бууруулна. | 1 | Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэх хөтөлбөр боловсруулах | 2017-2020 | - | - | Хөтөлбөр ЗГ-ын тогтоолоор батлагдах | - | Хөтөлбөрийн 2018 оны шалгуур үзүүлэлтэд хүрэх | - | Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ хийгдэх | - | Хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангах | - | ХНХЯ | ЗТХЯ, ЭМЯ, СЯ | ЭХЭМҮТ, ГССҮТ, ЭМХТ |
| | 2 | "Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх" үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 1,950.0 | Хөтөлбөр ЗГ-ын тогтоолоор батлагдах | - | Хөтөлбөрийн 2018 оны шалгуур үзүүлэлтэд хүрэх | 650.0 | Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ хийгдэх | 650.0 | Хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангах | 650.0 | ЭМЯ | БСШУСЯ, ЗТХЯ, СЯ, ХЗДХЯ, ХНХЯ | ГССҮТ, ЭМХТ |
| | 3 | Бага насны хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгч, олон нийтэд чиглэсэн нөлөөлөл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 2016-2020 | Улсын төсөв | 300.0 | Эцэг эхчүүд, байгууллага, олон нийтийн оролцоо, хариуцлага сайжрах | - | Хүүхдийн осол, эндэгдлийн түвшин 10 хувиар буурах | 100.0 | Хүүхдийн осол, эндэгдлийн түвшин 20 дахин буурах | 100.0 | Хүүхдийн осол, эндэгдлийн түвшин 30 дахин буурах | 100.0 | ХНХЯ | ХНХЯ, ХЗДХЯ, ЭМЯ, БСШУСЯ, ГБХЗХГ, МҮОНТ | ГБХЗХГ, аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| 3.4.7. Хараа хяналтгүй хүүхдийн бүртгэл, хяналтыг сайжруулж, насанд хүртэл нь хамгаалах, амьдралд хөлөө олоход нь туслах бодлого хэрэгжүүлнэ. | 1 | Гэр бүлийн орчноос түр болон урт хугацаагаар хөндийрсөн хүүхэд, тэдгээрийн гэр бүлтэй ажиллах тусгай хөтөлбөр, арга зүйг бий болгож, тэдэнд чиглэсэн тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх | 2016-2020 | Улсын төсөв | 3,800.0 | Хараа хяналтгүй хүүхдэд үйлчилгээ үзүүлэх бүтцийг бий болгож, эдгээр хүүхэд, гэр бүлтэй ажиллах хөтөлбөр, арга зүй боловсруулж, хэрэгжүүлж эхлэх | 1,000.0 | Хараа хяналтгүй хүүхдийн нэгдсэн мэдээллийн сан бий болж, хөтөлбөр, арга зүйн дагуу үйлчилгээ үзүүлэх | 800.0 | Хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйлчилгээ тогтвортой, тасралтгүй явагддаг болох | 1,000.0 | Хараа хяналтгүй хүүхдийн тоо буурах | 1,000.0 | ХНХЯ | СЯ | ГБХЗХГ, аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |
| | 2 | Хараа хяналтгүй хүүхдийн судалгаа, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай болж, түр хамгаалах байрны үйлчилгээний үр дүн, чанарыг сайжруулах | 2017-2020 | Улсын төсөв | 3,000.0 | Мэдээллийн санг бүрдүүлэх | - | Хүүхэд бүрт үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэх | 1,000.0 | Хүүхэд бүрт үйлчилгээ үзүүлэх боломжтой болох | 1,000.0 | Хүүхэд бүрт үйлчилгээ үзүүлэх боломжтой болох | 1,000.0 | ХНХЯ, СЯ | ГБХЗХГ | Аймаг, нийслэлийн ГБХЗХГ-ууд |
| 3.4.8. Шинээр сургууль төгссөн залуучуудыг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ. | 1 | Сургууль төгссөн залуучуудыг байнгын ажлын байраар хангасан ААН-ийг дэмжих зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах асуудлыг судалж шийдвэрлүүлэх | 2016-2020 | - | - | Ажил олгогчдын захиалгаар сургалт явуулах журам боловсруулах | - | Ажил олгогч, суралцагч, сургалтын байгууллагуудын хамтын ажиллагаа уялдах | - | Ажил олгогчийг урамшуулах тогтолцоо бүрдэх | - | Ажил олгогчийг урамшуулах тогтолцоо бүрдэх | - | ХНХЯ | СЯ, ХЗДХЯ | - |
| 3.4.9. "Мэргэжилтэй ажилтан" бодлогын хүрээнд жилд 20.000-аас доошгүй залуучуудыг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд сурган мэргэжил, ур чадвар эзэмшүүлнэ. | 1 | МБСБ-аар дамжуулан жил бүр 20000-аас доошгүй залуучуудад мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 280,000.0 | Жилд 20000-аас доошгүй залуучуудад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх | 70,000.0 | Жилд 20000-аас доошгүй залуучуудад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх | 70,000.0 | Жилд 20000-аас доошгүй залуучуудад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх | 70,000.0 | Жилд 20000-аас доошгүй залуучуудад мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх | 70,000.0 | ХНХЯ | МБСБ-ууд, ААН-үүд, мэргэжлийн холбоод | - |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.10. Залуучуудад бизнесийн гарааны дэмжлэг үзүүлж, их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг тоног төхөөрөмжийн лизинг, жижиг зээлд хамруулах арга хэмжээ авна. | 1 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж, залуучуудад бизнесийн гарааны дэмжлэгийг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр үзүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлэх | 2016-2020 | Улсын төсөв, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 20,000.0 | Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжих | 5,000.0 | Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжих | 5,000.0 | Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжих | 5,000.0 | Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжих | 5,000.0 | ХНХЯ | СЯ | - |
| 3.4.11. Өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгож, халдварт өвчлөлийн тархалтыг бууруулна. | 1 | Оюутан, өсвөр үе, залуучуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, тусламж, үйлчилгээ авах ээлтэй орчин бүрдүүлэх | 2016-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 2,500.0 | Эрх зүйн орчин бүрдэж, тусламж, үйлчилгээнд оюутнуудын 50 хүртэл хувь хамрагдах | 500.0 | Тусламж, үйлчилгээнд оюутнуудын 70 хүртэл хувь хамрагдах | 500.0 | Үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүн гарах | 1,000.0 | Тусламж, үйлчилгээнд оюутнуудын 90 хүртэл хувь хамрагдах | 500.0 | ЭМЯ | БСШУСЯ, ХНХЯ | - |
| | 2 | Өсвөр үе, залуучуудын хөгжлийн цогцолбор, төвүүдийг үе шаттай байгуулж, төвөөр зорилтот бүлгийн өсвөр үе, залуучуудад чиглэсэн амьдрах ухааны боловсрол олгох, эрүүл мэнд, нөхөн үржихүйн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, сургалт, зөвлөгөө, мэдээлэл хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 2,000.0 | Залуучуудын хөгжлийн 16 төвийн үйл ажиллагааг институтчилэх | - | Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтвортой хангаж, эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа, сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өсвөр үе, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн ойлголт хандлагад дүн шинжилгээ хийх | 700.0 | Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан нийт залуучуудын 30 хувьд хүрч ажиллах, шинээр залуучуудын хөгжлийн төв байгуулах | 700.0 | Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан нийт залуучуудын 60 хувьд хүрч ажиллах, залуучуудын зэрэг хандлага, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн ойлголт, хандлага нэмэгдэх | 600.0 | ХНХЯ | ЭМЯ, БСШУСЯ | Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд |

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр** **Улаанбаатар хот**

**Дугаар 71**

## “ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР” БАТЛАХ ТУХАЙ

Эдийн засгийг сэргээх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эдийн засгийг сэргээх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус үүрэг болгосугай:

1/“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

2/энэ тогтоолын хавсралтад заасан банк, санхүү, төсөв, бодит салбарын үйл ажиллагааг дэмжих, тогтворжуулахад шаардагдах хөрөнгийг гадаад, дотоод эх үүсвэрээс нэн даруй босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/эдийн засгийг сэргээхтэй холбоотой тэргүүн ээлжинд боловсруулж батлуулах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож, хугацаандаа хэрэгжээгүй заалт бүрийг хариуцах албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэж, хөтөлбөрийн явцыг хагас жил тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороодод даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2014 оны “Эдийн засгийн идэвхижлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 34 дүгээр тогтоол, 2015 оны “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолыг 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **М.ЭНХБОЛД**

*Монгол Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт*

# ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР

| Зорилт, арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах этгээд |
|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙГ ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | |
| 1.1.Улсын төсвийн алдагдлыг бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлэх:<br><br>1.1.1.Төсвийн сахилга батыг сайжруулах, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, үр дүнгээр санхүүжүүлэх, төсвийн норм, нормативыг баримтлан хэмнэлтийн горимд шилжих;<br><br>1.1.2.“Үндэсний хэмнэлт”-ийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;<br><br>1.1.3.Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад үр ашгийн шинжилгээ хийж, сангийн зарцуулалтыг ард иргэдэд нээлттэй, ил тод болгох;<br><br>1.1.4.Төрөөс захиалгаар гүйцэтгэсэн бараа, ажил үйлчилгээний төлбөрөө авч чадахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг барагдуулах;<br><br>1.1.5.Засгийн газрын үнэт цаасны арилжааг тогтмолжуулах, Хөрөнгийн биржээр дамжуулан борлуулах, үнэт цаасны зуучлагч компаниудын оролцоог нэмэгдүүлэх;<br><br>1.1.6.Дотоодын зах зээлийг тарифын болон тарифын бус аргаар хамгаалах, дотоодын худалдан авалтыг бодлогоор дэмжиж, хууль эрх зүйн орчныг бий болгох;<br><br>1.1.7.Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчныг сайжруулах;<br><br>1.1.8.Байнгын болон түр ажлын байрыг тогтвортой хадгалж байгаа аж ахуйн нэгжийг татвар, зээлийн бодлогоор дэмжих;<br><br>1.1.9.Концессоор хэрэгжсэн, одоо хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд шалгалт хийж, цаашид хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталж, хэрэгжүүлэх механизмыг хөрөнгө оруулагч нарт тодорхой болгох. | Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал | Нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг бууруулж 2017 онд 9.9 хувиас хэтрүүлэхгүй байх | 2017-2018 оны эхний хагас жилд | Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.2.Төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулж, инфляцийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлэх:<br><br>1.2.1.Активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх;<br><br>1.2.2.Эдийн засгийн бодит өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих хүүгийн уян хатан бодлого хэрэгжүүлэх, банкны системийн шалгуур үзүүлэлтүүдийг зохистой түвшинд байлгах;<br><br>1.2.3.Валютын урсгал түр зуур нэмэгдэх үед төгрөгийн нийлүүлэлтийг огцом нэмэгдүүлэхгүй байх, дунд, урт хугацаанд валютын нөөцийг тогтвортой байлгах, хамгаалах зарчим баримтлах;<br><br>1.2.4.Хөгжлийн банк, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад шалгалт хийж, дүгнэлт өгөх;<br><br>1.2.5.Орон сууцны 8.0 хувийн хүүтэй зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлж, ипотекийн зээлийн даатгалыг урт хугацаат даатгалын бүтээгдэхүүний хэлбэрт шилжүүлэх;<br><br>1.2.6.Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн томоохон төслүүдийг урт хугацааны санхүүжилтээр хангах зорилгоор Хөрөнгө оруулалтын сан байгуулах;<br><br>1.2.7.Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, экспортын даатгалын бүтээгдэхүүн бий болгох замаар экспортлогч үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих. | Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал | Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн байх | 2017 онд | Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо |
| 1.3.Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх гадаад өр төлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэх:<br><br>1.3.1.Алт хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх;<br><br>1.3.2.Засгийн газар, Хөгжлийн банкны гадаад бондыг эргүүлэн төлөх, дахин санхүүжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;<br><br>1.3.3.Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банкны болзошгүй өр төлбөрийг судалж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах; | Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал | Гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, хөрөнгө оруулагчид урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | 2017-2018 оны эхний хагас жилд | Засгийн газар, Монголбанк |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.3.4.Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулж, урт хугацаатай, бага хүүтэй санхүүгийн эх үүсвэр татах;<br><br>1.3.5.Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;<br><br>1.3.6.Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулж ажиллах;<br><br>1.3.7.Банк, санхүүгийн системийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, гадаадын банкны салбар нэгж нээн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;<br><br>1.3.8.Техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг бүх талаар дэмжиж, хэрэгжилтийг эрчимжүүлэх;<br><br>1.3.9.Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох; | | | | |
| **СТРАТЕГИ 2. ДУНД ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСАГТ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙЖ, ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ, ӨРИЙН ДАРАМТЫГ БАГАСГАХ** | | | | |
| 2.1.Уул уурхайн бус салбарын экспортын орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх үндэс суурийг тавих:<br><br>2.1.1.Иргэний нисэхийн үйлчилгээнд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж, навигацийн орлогыг өсгөх;<br><br>2.1.2.Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх, хил орчмын төрийн байгууллага хоорондын уялдааг хангаж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг сайжруулах;<br><br>2.1.3.Аялал жуулчлалын гол маршрутын зам дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах;<br><br>2.1.4.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;<br><br>2.1.5.Хурдан морины бооцоот уралдаан зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;<br><br>2.1.6.Импортыг орлох барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих; | Засгийн газрын тогтоол | Уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, экспорт нэмэгдсэн байх | 2017-2018 оны эхний хагас жилд | Засгийн газар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1.7.Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх;<br><br>2.1.8.“Атрын III аян”-ыг үргэлжлүүлж, үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах;<br><br>2.1.9.“Малыг эрүүлжүүлэх” хөтөлбөрийг шинэчлэн эрх зүйн орчныг бий болгох;<br><br>2.1.10.“Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;<br><br>2.1.11.Гадаадын зах зээлд экспортлох боломжтой программ хангамж, техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;<br><br>2.1.12.Иргэдийг гадаад улсад тодорхой хугацаагаар ажиллуулах арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэх;<br><br>2.1.13.Иргэдийг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах зорилгоор дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах;<br><br>2.1.14.Олон улсын байгууллагаас гаргадаг зээлжих зэрэглэл, бизнес эрхлэлт, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг татах чадвар зэрэг индексүүдийг сайжруулах; | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.2.Бодит салбарын өсөлтийг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх:<br><br>2.2.1.Таван толгойн бүлэг ордыг ашиглах, Таван толгойн 450 МВТ-ын цахилгаан станц, Гацууртын алтны орд, Дулааны III цахилгаан станцын 250 МВТ-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВТ-ын өргөтгөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх;<br><br>2.2.2.Таван толгой-Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн, Зүүнбаян-Ханги, Эрдэнэт-Овоот, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж, Богд хан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх;<br><br>2.2.3.Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах хүрээнд цахилгаан станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг шинээр барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх;<br><br>2.2.4.Томоохон үйлдвэрлэл дагасан жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжиж, төрөлжсөн кластерыг бий болгох замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх; | Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол | Дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслийг эрчимжүүлж, эдийн засгийн бодит өсөлтийг 2018 онд 5.1 хувь, 2019 онд 7.1 хувьд хүргэх, шинэ ажлын байр олноор бий болгох замаар ажилгүйдлийг бууруулах | 2017-2018 оны эхний хагас жилд | Засгийн газар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.2.5.Хөшигийн хөндийд баригдаж байгаа Олон Улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, шинэ хотын бүтээн байгуулалтыг эхлүүлэх. | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.3.Эдийн засгийн өсөлтийг дэмжих хариуцлагатай засаглалыг бэхжүүлж, хууль эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх:<br><br>2.3.1.Засгийн газрын өргөн мэдүүлсэн Улсын төсвийн төсөл дэх үндсэн хязгааруудыг / төсвийн алдагдал, орлого, зарлага болон өрийн дээд хэмжээ г.м/ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн явцад нэмэгдүүлэхгүй байхаар хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;<br><br>2.3.2.Төв банкны засаглалын бүтцийг олон улсын жишигт нийцүүлэх, Монголбанкны удирдлагын хараат бус байдлыг бэхжүүлэх, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, Монголбанкны үйл ажиллагааг тодорхой болгох чиглэлээр Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах;<br><br>2.3.3.Валютын урсгалыг зохицуулах харилцааг сайжруулах зорилгоор Валютын зохицуулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, батлуулах;<br><br>2.3.4.Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуурт болгох, болзошгүй эрсдэлийг үнэлэх, хамгаалах, бодлогын уялдааг хангах институт болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах;<br><br>2.3.5.Хөгжлийн банкны улсын төсөвтэй харилцах харилцааг боловсронгуй болгох, болзошгүй эрсдэлийг бууруулах, засаглал, ил тод байдал, тайлагналыг сайжруулах, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, бие даасан байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн батлуулж, бүтцийн өөрчлөлт хийх;<br><br>2.3.6.Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж, батлуулах;<br><br>2.3.7.Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, мэргэжлийн хяналт, татвар, нийгмийн даатгал, хууль хяналтын байгууллагын давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах;<br><br>2.3.8.Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг мэргэшсэн, хариуцлагатай, цомхон, тогтвортой байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;<br><br>2.3.9.Тодорхой эрхэлсэн ажилгүй иргэдийг богино хугацааны цагийн ажилд зуучлах, цалин хөлсийг тухай бүр олгох боломжийг бүрдүүлэх;<br><br>2.3.10.Ажлын байрны эрэлт, хэрэгцээнд үндэслэж богино хугацаанд мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж, ажиллах хүчийг бэлтгэх. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал | “Дэлхийн засаглалын үзүүлэлт”-ээр Монгол Улсын эзлэх байрыг ахиулах | 2017-2018 оны эхний хагас жилд | Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2016 оны 6 дугаар сарын 13-ны өдөр** **Улаанбаатар хот**

**Дугаар 320**

## ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого” батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөрийн сайд Г.Баярсайханд даалгасугай:

2.1. бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, холбогдох арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэх;

2.2. хөдөлмөрийн салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаарх саналаа 2016 онд багтаан Засгийн газарт танилцуулах.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.САЙХАНБИЛЭГ
Хөдөлмөрийн сайд Г.БАЯРСАЙХАН

*Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолын хавсралт*

# ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөр эрхлэлт нь иргэн бүр ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, хувийн аж ахуй эрхлэх эрхийг хангахад чиглэх бөгөөд иргэдийн эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, орлогын түвшин, амьдралын чанараа дээшлүүлэх үндсэн баталгаа, улс орны хөгжлийн үндэс болно.

1.2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн баталсан “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-т тунхагласан 17 зорилго, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болно.

1.3. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого (цаашид “хөдөлмөр эрхлэлтийн бодлого” гэх)-ыг боловсруулах үндэслэл, шаардлага:

1.3.1. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2016 оны 5 дугаар сарын статистик мэдээллээс авч үзэхэд 47.3 мянган ажил хайгч иргэн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй байгаагаас 33.7 мянга нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.7 мянган хүн буюу 5.2 хувиар өссөн байна;

1.3.2. улс орны эдийн засгийн өсөлтийн үр дүнд ажилгүйдэл буурч, ажлын байр нэмэгдэх ёстой боловч манай улсын хувьд эдийн засгийн өсөлтийг бий болгож байгаа уул уурхай, барилга, газар тариалангийн салбар улирлын шинжтэйгээс ажлын байрыг дорвитой нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулахад нөлөө үзүүлэхгүй байна;

1.3.3. хөдөлмөрийн харилцааны зохицуулалт оновчтой бус байгаагаас хөдөлмөр эрхлэлтийн эрэлт, нийлүүлэлт тэнцвэргүй болсон бөгөөд ажиллах хүчний нөөцийг зохистой ашиглаж, ажил олгогчийг дэмжих замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байна;

1.3.4. хөдөлмөр эрхлэлт нь мал аж ахуй, худалдаа, үйлчилгээний уламжлалт салбараас өндөр бүтээмжтэй уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, мэдээлэл технологийн салбарт шилжиж байгаа нь мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчний хэрэгцээ, зохистой хөдөлмөр эрхлэлтийн эрэлтийг нэмэгдүүлэх хандлагатай байна;

1.3.5. хөдөлмөрийн зах зээлд сүүлийн жилүүдэд дээд боловсролтой ажиллах хүчний тоо нэмэгдсэн боловч ажиллах хүчний ур чадвар доогуур байгаа нь ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүйд хүрч, мэргэшсэн ажиллах хүчний дутагдлыг бий болгож байна;

1.3.6. ажилгүйдлийн түвшин хөдөлмөрийн насны залуучуудын дунд ихэсч байгаа тул залуучуудад буюу их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдөд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна;

1.3.7. ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын тогтолцоо бүрдээгүй нь ажилчдын идэвх, санаачилгад сөргөөр нөлөөлж, хөдөлмөрийн бүтээмжийг бууруулж байна.

1.4. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогод хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. **”зохистой хөдөлмөр эрхлэлт”** гэж хөдөлмөрийн таатай нөхцөл, нийгмийн хамгааллын баталгаагаар хангагдсан бөгөөд төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлд тулгуурласан бүтээмжтэй, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг;

1.4.2. **”хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшин”** гэж ажилтны тухайн ажлын байранд үргэлжлэн ажиллах хугацааг.

1.5. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

1.5.1. иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах;

1.5.2. хөдөлмөрийн харилцаанд эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээ хийх эрхийг хангах, хүүхдийн тэвчишгүй болон албадан хөдөлмөрийг устгах, алагчлалыг үл тэвчих;

1.5.3. эдийн засаг, нийгмийн хөгжил, төсөв, хөрөнгө оруулалт, татвар, зээлийн болон бүс, орон нутаг, салбарын хөгжлийн бодлого нь тогтвортой, ногоон хөгжлийг хангасан, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэх;

1.5.4. хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах;

1.5.5. хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ нь хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, эрэлт хэрэгцээ, олон улсын жишигт нийцсэн чанартай, адил тэгш, нээлттэй, ил тод байх;

1.5.6. ажил олгогчид үзүүлэх санхүүгийн дэмжлэг, урамшуулал нь ажиллах хүчний зохистой ашиглалт болон ажилчдын мэргэжлийн ур чадварын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшинтэй уялдсан байх;

1.5.7. нийгмийн түншлэлийг дэмжих.

## Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зорилго, зорилт

2.1. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зорилго нь хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулахад чиглэнэ.

2.2. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

2.2.1. хөдөлмөр эрхлэлтийг хөгжлийн бодлогын үндэс болгох замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулах;

2.2.2. хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;

2.2.3. иргэний мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх замаар боловсролын түвшингээс хамааралтай ажилгүйдлийг бууруулах;

2.2.4. ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг дээшлүүлэх;

2.2.5. хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож олон улсын жишигт нийцүүлэх.

**Гурав. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үе шат**

3.1. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг 2016-2026 онуудад дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

**3.1.1.нэгдүгээр үе шат: 2016-2020 он;**

**3.1.2. хоёрдугаар үе шат: 2021-2025 он.**

**Дөрөв. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг хөгжлийн бодлогын үндэс болгох замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг бууруулах зорилтын хүрээнд:

4.1.1. сургалт, сурталчилгааны олон талт хэлбэрийг ашиглаж, зохистой хөдөлмөр эрхлэлтийн талаарх ойлголт, хандлагыг дээшлүүлэх;

4.1.2. хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгаанд үндэслэн зохистой хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн уялдааг хангасан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх;

4.1.3. хөрөнгө оруулалт болон зээл, зээлийн батлан даалт, санхүүгийн түрээс, дэмжлэгтэй холбогдсон арга хэмжээг бүсчилэн ялгавартай хэрэгжүүлэх замаар алслагдсан болон эдийн засгийн сул хөгжилтэй бүс, орон нутагт зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;

4.1.4. бүс, орон нутаг, эдийн засгийн салбарт ажиллах хүчний төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах;

4.1.5. хөдөлмөрийн хүмүүжлийг бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан олгож, ажил, мэргэжлийн зөв хандлагыг төлөвшүүлэх;

4.1.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.1.7. гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүн амын аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулах.

4.2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

4.2.1. хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэн хүртээмж, чанар, үр ашгийг нь дээшлүүлэх;

4.2.2. ажиллах хүчний шингээлт ихтэй салбарыг татвар, зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;

4.2.3. хүний нөөцийн бодлогын эрх зүйн орчныг сайжруулах замаар ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг нь тасралтгүй хөгжүүлэх;

4.2.4. бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд чиглүүлж, гадаадын зээл, тусламж, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад зохистой ажлын байрыг бий болгох, ажлын байрыг тогтвортой хадгалах нөхцөлийг харгалзах тогтолцоог бүрдүүлэх;

4.2.5. экспортын барааны татварыг буцаан олгох, импортын барааны гаалийн татварыг нэмэгдүүлэх, бараа, ажил, үйлчилгээг нь худалдан авах, мега төслүүдэд туслан гүйцэтгэгчээр ажиллуулах, даатгалд хамруулах зэрэг арга замаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих;

4.2.6. эдийн засгийн хүндрэлийн үед татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийн хуримтлагдсан хугацаа, ажилтны тоог харгалзан хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх замаар ажил олгогчид ажлын байраа тогтвортой хадгалахад нь дэмжлэг үзүүлэх;

4.2.7. хувиараа болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэр эрхлэх иргэдийн санаачилгыг зээл, зээлийн батлан даалт, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлж чадавхжуулах;

4.2.8. хөдөлмөрийн зах зээл дэх ногоон ажлын байрны үнэлэмжийг дээшлүүлж эрэлт, нийлүүлэлтийг дэмжих;

4.2.9. экспортын болон өндөр технологийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулах замаар ногоон ажлын байр олноор бий болгох;

4.2.10. бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг орон нутгийн хөгжил, хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлөхөөр зохион байгуулж, хэрэгжилт, хяналтыг сайжруулах;

4.2.11. ажиллах хүчний бүс, орон нутаг, эдийн засгийн салбар, ажил, мэргэжил хооронд дотоод шилжих хөдөлгөөнийг уян хатан, оновчтой зохицуулах замаар ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй ашиглах.

4.3. Иргэний мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх замаар боловсролын түвшингээс хамааралтай ажилгүйдлыг бууруулах зорилтын хүрээнд:

4.3.1. эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог нэмэгдүүлэх зорилгоор дээд болон техник, мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн агуулгыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтээр тодорхойлж, үр дүнг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшингээр тооцдог болох;

4.3.2. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн гадаад улсад мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах;

4.3.3. оюутан, сурагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх дадлагын бүх хэлбэрийг дэмжих тогтолцоог бий болгох;

4.3.4. төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих;

4.3.5. оюутан, сурагчдад аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлж, ажлын байр бий болгох санаачилгыг дэмжих;

4.3.6. хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан сургалтын байгууллагыг бүсчлэн зохион байгуулж, сургалт, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, дадлагын чанарыг сайжруулах замаар мэргэжлийн боловсрол, сургалтын үйлчилгээг чанаржуулах;

4.3.7. ажилгүй иргэдэд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, давтан сургах, хөгжүүлэх замаар боловсролын түвшингээс хамааралтай ажилгүйдэл, ядуурлыг бууруулах;

4.3.8. цэргийн хугацаат албан хаагчдыг энх цагийн бүтээн байгуулалтад оролцуулж, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, дадлагажуулах замаар хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх;

4.3.9. гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаа монгол иргэдийн эрхийг хамгаалж, гадаадын өндөр хөгжилтэй оронд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх.

4.4. Ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

4.4.1. ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бий болгож, хүн амын хөдөлмөр эрхлэх хүсэл, сонирхлыг идэвхжүүлэх;

4.4.2. ажил, мэргэжлийн үндэсний ангиллыг нэг мөр болгон хөдөлмөрийн хөлс, урамшууллын үнэлгээтэй уялдуулах замаар хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж, ажилтны хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

4.4.3. дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын эзлэх хувийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийн үр шимийг баялаг бүтээгчид тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх;

4.4.4. үйлдвэржилт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, инноваци болон хөдөлмөрийн сахилга бат, ухамсраар дамжуулан хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.

4.5. Хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хүрээнд:

4.5.1. хөдөлмөрийн харилцааны хамрах хүрээг өргөжүүлж, ажилтны хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшин, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

4.5.2. төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлд тулгуурласан хөдөлмөрийн хяналтыг сайжруулах замаар ажил олгогч, ажилтны нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх;

4.5.3. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбогдсон хууль тогтоомж, стандартыг олон улсын жишигт нийцүүлж чадавхийг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх зэргээр үйлдвэрлэлийн осол, гэмтлийн тохиолдлыг бууруулах;

4.5.4. хөдөлмөр эрхлэлтийн даатгалыг шинээр бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тогтолцоог боловсронгуй болгох;

4.5.5. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн чадварт тохирох техник, тоног төхөөрөмж бүхий ажлын байрыг эрх зүйн зохицуулалтаар дэмжих;

4.5.6. хөдөлмөрийн насны иргэдийн бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн нэгдсэн тогтолцоог сайжруулах.

## Тав. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын үр нөлөө, шалгуур үзүүлэлт

5.1. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

5.1.1. хөдөлмөрийн хүмүүжил, ажил, мэргэжлийн зөв хандлага төлөвшиж, эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөр эрхлэлтийн харилцан хамаарал сайжирсан байна;

5.1.2. ажил олгогчийг дэмжих механизм боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшин, ногоон ажлын байр нэмэгдсэн байна;

5.1.3. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү багасч, ажилгүйдлийн түвшин буурсан байна;

5.1.4. хөдөлмөр эрхлэх хүсэл, сонирхлыг идэвхжүүлсэн хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоо бүрдэж, дундаж цалингийн хэмжээ нэмэгдсэн байна;

5.1.5. хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчин олон улсын жишигт хүрч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын хэрэгжилт сайжирсан байна;

5.1.6. ажиллах хүчний нөөцийг зохистой ашиглаж, эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо нэмэгдсэн байх бөгөөд ажилгүйдэл, ядуурлын түвшин буурсан байна.

5.2. Бодлогын үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

| **№** | | **Шалгуур үзүүлэлт** | **2015 он** | **2020 он** | **2025 он** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ажиллах хүчний нөөц ашиглалт | Хүн ам (мян.хүн) | 3057.8 | 3301.9 | 3419.1 |
| | | Хөдөлмөрийн насны хүн ам (мян.хүн) | 2022.9 | 2141.8 | 2344.9 |
| | | Эдийн засгийн идэвхтэй хүн ам (мян.хүн) | 1243.9 | 1335.3 | 1463.0 |
| | | Ажиллах хүчний оролцооны түвшин (хувиар) | 61.5 | 66.0 | 68.0 |
| 2 | Эдийн засгийн өсөлт, хөгжлийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө | ДНБ (тэрбум.төг) | 23166.8 | 35476.4 | 42209.9 |
| | | 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ (мян.төг) | 7653.7 | 10744.4 | 12215.1 |
| | | Ажилгүйдлийн түвшин (хувиар) | 7.5 | 5.6 | 5.0 |
| | | Дундаж цалин (мян.төг) | 808.0 | 1383.9 | 1743.3 |
| | | Ногоон ажлын байрны эзлэх хувь | 6.1 | 10.0 | 30.0 |
| 3 | Зохистой хөдөлмөр эрхлэлт | Ажиллагчдын тоо (мян.хүн) | 1151.2 | 1254.7 | 1355.7 |
| | | Албан хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь | 50.6 | 65.7 | 70.0 |
| | | Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь | 23.0 | 14.1 | 11.7 |
| | | Мал аж ахуй эрхлэгчдийн эзлэх хувь | 26.4 | 20.2 | 18.3 |
| | | Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн тоо (мян.хүн) | 1018.6 | 1129.3 | 1220.1 |

## Зургаа. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, нийгмийн түнш, иргэдийн оролцоотойгоор хариуцан зохион байгуулна.

6.2. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зөвлөлийг эрдэмтэд, судлаачдын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулна.

6.3. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 5 жил тутам тус тус хийж дүнг Засгийн газарт тайлагнана.

6.4. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандивын хөрөнгөөс бүрдэнэ.

6.5. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын үе шат бүрийн хэрэгжилтийг энэхүү бодлогын 5.2-т заасан шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэж, дараагийн шатны үйл ажиллагааг төлөвлөнө.

---o0o---

*Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралт*

# ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн захиргааны төв болон Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага (цаашид “захиргааны байгууллага” гэх) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4.1-6.4.3, 6.5.1, 6.5.2-т заасан урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулахтай холбогдсон нийтлэг харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Энэ журмын 1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулахад хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

3. Улсын төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөнө.

4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад Засгийн газрын 2010 оны 123 дугаар тогтоолоор баталсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”-ыг дагаж мөрдөнө.

5. Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахад Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг дагаж мөрдөнө.

6. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн төслийг боловсруулахад Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг дагаж мөрдөнө.

7. Засгийн газрын гадаад тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн төслийг боловсруулахад Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ыг дагаж мөрдөнө.

8. Энэ журмын 1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5.1-д заасан зарчмыг баримтална.

9. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

9.1. “төсөл” гэж захиргааны байгууллагаас боловсруулж байгаа энэ журмын 1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн эх бичвэрийг;

9.2. ”ерөнхий мэдээлэл” гэж бодлогыг оновчтой тодорхойлох зорилгоор төслийг боловсруулах үеийн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг тодорхойлсныг;

9.3. “нөхцөл байдлын дүн шинжилгээ” гэж асуудлын шалтгаан, үр нөлөөг тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хамрах хүрээний хамт тодорхойлсон бодлогын хувилбар боловсруулахад ашиглах судалгааг;

9.4. ”бодлогын зорилт” гэж асуудлыг хэсэгчлэн болон бүрэн

шийдвэрлэхэд чиглэсэн Засгийн газраас аливаа бодлогын хүрээнд дэвшүүлсэн оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг;

9.6. “бодлогын үр нөлөө” гэж бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны хүрээнд бий болох өөрчлөлтийг;

9.7. “бүтээгдэхүүн” гэж бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас авсан арга хэмжээний хүрээнд холбогдох талуудад нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээг;

9.8. “орц” гэж зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн болон хүний нөөц, эдийн болон эдийн бус хөрөнгийг;

9.9. “шалгуур үзүүлэлт” гэж хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан чанарын болон тоон үзүүлэлтийг;

9.10. “суурь түвшин” гэж төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

9.11. “зорилтот түвшин” гэж бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

9.12. “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” гэж бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчин, аливаа байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг;

9.13. “бодлогын хувилбар” гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын 2-оос дээш сонголтуудыг.

## Хоёр. Төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах

10. Захиргааны байгууллага төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу санаачлан боловсруулах бөгөөд төслийг боловсруулахдаа уг төслийг хэрэгжүүлэх хүний нөөц, чадавхтай уялдуулна.

11. Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг, төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг, төрийн захиргааны төв байгууллага болон Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллага үндэсний хөтөлбөрийн төслийг, Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг тус тус боловсруулна.

12. Захиргааны байгууллага нь дараах төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох хууль тогтоомжид хамтран боловсруулахаар заасан болон бусад захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоод, бодлогын баримт бичиг батлагдсанаар ашиг сонирхол нь хөндөгдөж болохуйц этгээдийн төлөөлийг оролцуулан байгуулж, удирдамжаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавина:

12.1. төрөөс баримтлах бодлого;

12.2. бүсчилсэн хөгжлийн бодлого;

12.3. үндэсний хөтөлбөр.

13. Засаг дарга нь дараах төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, төрийн бус байгууллага, эрдэм

шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан байгуулж, удирдамжаар ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавина:

13.1. аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт;

13.2. дэд хөтөлбөр.

14. Захиргааны байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.2, 6.3-т заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, бодлогын хувилбарыг боловсруулах ажлыг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаар гүйцэтгүүлнэ.

15. Захиргааны байгууллага төсөл боловсруулах ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

16. Хөгжлийн бодлогын баримт бичгийг батлах эрх бүхий этгээд бодлогын хувилбаруудаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17.1.3 дахь заалтыг үндэслэн оновчтой хувилбарыг нь сонгоно.

## Гурав. Төсөл боловсруулах төлөвлөгөө

17. Энэ журмын 12, 13-т заасан Ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

18. Төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрийн хамт тусгана:

18.1. нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх;

18.2. нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлох;

18.3. хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг боловсруулах;

18.4. бодлогын хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх;

18.5. хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах;

18.6. хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах.

19. Ажлын хэсэг төсөл, бодлогын хувилбаруудын төслийг эцэслэн боловсруулж, холбогдох хавсралтын хамт захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх.

## Дөрөв. Нөхцөл байдлын дүн шинжилгээ

20. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхдээ тухайн бодлогын баримт бичигт тусган шийдвэрлэх эдийн засаг, нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх хүндрэл, бэрхшээлийг мэдэрч, асуудлыг судалж тодорхойлно. Энэхүү судалгаанд өмнө нь уг асуудлаар хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, статистик судалгаа, түүвэр судалгаа, олон нийтийн зүгээс давтагдан гарч байгаа санал, шүүмжлэл зэргийг ашиглана.

21. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажилд тухайн асуудлаас хамааруулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, холбогдох бусад талуудыг оролцуулна.

22. Төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх болон төслийг боловсруулах явцад тухайн асуудалтай холбоотой мэдээллийг бусад хүчин төгөлдөр бодлогын баримт бичиг, судалгаа, мэдээллээс иш татсан тохиолдолд бодлогын баримт бичиг болон судалгаа, мэдээллийн эх сурвалжийг заана.

23. Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь тухайн асуудлаар хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, шаардлагыг гаргасан тулгамдсан асуудлыг мэдэрч тодорхойлсон баримт бичиг байна.

## Тав. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

24. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна.

25. Эдийн засаг, нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил, үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө нь их гэж үзсэн тохиолдолд нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

26. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг өмнө хийсэн судалгаа, үнэлгээ, албан ёсны тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хийнэ.

## Зургаа. Олон нийтээр хэлэлцүүлэх

27. Төслийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулна.

28. Хэлэлцүүлэг болохоос 5-аас доошгүй өдрийн өмнө төслийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хэлэлцүүлэгт оролцогчдод хүргүүлнэ.

29. Төслийн талаар хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага, холбогдох байгууллага, мэргэжлийн холбоодоос бичгээр болон цахим хэлбэрээр санал авч болно.

30. Энэ журмын 29-т заасан саналд дүн шинжилгээ хийж, шаардлагатай гэж үзвэл төсөлд тусгана.

## Долоо. Зөвшөөрөл авах

31. Төрийн захиргааны төв байгууллага нь төрөөс баримтлах бодлогын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна. Санал авахаар бодлогын баримт бичгийг хүргүүлэхдээ дараах мэдээллийг хавсаргасан байна:

31.1. нөхцөл байдлын дүн шинжилгээ;

31.2. энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн зорилго, зорилтын уялдаа;

31.3. энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбар бүрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн төсөөлөл тооцоо;

31.4. энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан төслийг нийтээр хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг багцалсан товьёог;

31.5. энэхүү журмын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулсан

нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, түүгээр бодлогын хувилбаруудыг харьцуулан үнэлсэн тухай товч мэдээлэл;

31.6. энэхүү журмын 5 дугаар хавсралтын дагуу боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлт;

31.7. энэхүү журмын 6 дугаар хавсралтад заасан бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.

32. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

33. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

34. Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн төсөл нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5.1-д заасан зарчим, мөн хуулийн 17.2-т заасан шаардлага, энэхүү журамд заасан бүрдэл материал дутуу тохиолдолд уг зарчим, шаардлага болон бүрдлийг хангуулах талаарх зөвлөмжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

## Найм. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах

35. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нэгтгэн боловсруулж, зохих журмын дагуу хэлэлцүүлнэ.

36. Захиргааны байгууллага нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогын зорилго, зорилтуудыг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах өөрийн хариуцсан асуудлын хүрээн дэх бодлогын тэргүүлэх зорилтын талаарх саналыг чиглэл болгосон хугацаанд багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

37. Захиргааны байгууллага нь энэ журмын 35-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хамаарах 3 хүртэлх тооны бодлогын тэргүүлэх зорилтыг тодорхойлсон байна.

38. Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллага Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах бодлогын тэргүүлэх зорилтын талаарх саналыг чиглэл болгосон хугацаанд багтаан Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдад хүргүүлнэ.

39. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг нэгтгэн хянан боловсруулж зохих журмын дагуу Засгийн газраар батлуулна.

40. Захиргааны байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулах саналыг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн нэрсийн жагсаалтын хамт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсанаас хойш 30 хоногийн дотор боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

41. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хамт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний хөтөлбөрийн жагсаалтыг боловсруулна.

42. Захиргааны байгууллага нь үндэсний хөтөлбөрийн жагсаалтыг шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэж ангилан, ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна.

43. Үндэсний хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авахдаа баримт бичгийн төслийг энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

## Ес. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл, дэд хөтөлбөрийн жагсаалтын төслийг боловсруулах

44. Засаг дарга нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулна.

45. Дэд хөтөлбөрийн жагсаалтыг шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэж ангилан, ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна.

46. Шинээр боловсруулах дэд хөтөлбөрийн төслийг Засаг дарга боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

## Арав. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулах

47. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12.3, 12.4, 12.6, 12.7-д заасан цаглабарын дагуу боловсруулна.

48. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг дараах шаардлагын хүрээнд нэгтгэн боловсруулна:

48.1. үндсэн чиглэлийн төсөлд тусгасан арга хэмжээ нь тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай байх;

48.2. энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 1-д заасны дагуу арга хэмжээ бүрт шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр нь үндэслэлтэй, бодитой, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх;

48.3. үндсэн чиглэлийн төсөлд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг өөрчлөх тохиолдолд тухайн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн захиргааны байгууллагатай харилцан зөвшилцөнө.

49. Захиргааны байгууллага нь улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах саналаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон үндэсний хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг үндэслэн боловсруулж Сангийн яаманд заасан хугацаанд хүргүүлнэ.

50. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн захиргааны төв, холбогдох төрийн захиргааны байгууллагаас үндсэн чиглэлийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн саналыг хянаад төсөлд тусгасан, эсхүл тусгаагүй тухай үндэслэл, тайлбарыг энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 2-т заасны дагуу боловсруулж, төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

**Арван нэг. Төслийн бүтэц, агуулга**

51. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төсөл нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.7, 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

52. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4.3-т заасан төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байна:

52.1. нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл;

52.2. хоёрдугаар бүлэг. Бодлогын зорилго, зорилт;

52.3. гуравдугаар бүлэг. Бодлогын хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа;

52.4. дөрөвдүгээр бүлэг. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт;

52.5. тавдугаар бүлэг. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр;

52.6. зургаадугаар бүлэг. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө.

53. Энэхүү журмын 52.1-д заасан “Ерөнхий мэдээлэл” бүлэгт дараах зүйлийг тусгасан байна:

53.1. тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээний гол үр дүн;

53.2. бодлогын төслийг боловсруулах үндэслэл;

53.3. төслийн хамрах хүрээ.

54. Энэхүү журмын 52.2-т заасан “Бодлогын зорилго, зорилт” бүлэгт дараах асуудлыг тусгасан байна:

54.1. бодлогын зорилго, зорилт нь тухайн бодлогыг хэрэгжүүлснээр урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц бодитой байна;

54.2. бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон байна;

54.3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.3-т заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тэргүүлэх болон нэмэлт зорилтуудыг тодорхойлсон байна.

54.4. үндэсний хөтөлбөрийн төсөлд төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн төсөлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тэргүүлэх болон нэмэлт зорилтуудыг тус тус тодорхойлсон байна.

55. Төслийн зорилго, зорилт нь дараах уялдааг хангасан байна:

55.1. төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилго нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилтод үндэслэх;

55.2. аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын зорилго нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилтод үндэслэх;

55.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилтод үндэслэх;

55.4. үндэсний хөтөлбөрийн зорилго нь төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх;

55.5. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

55.6. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх;

55.7. дэд хөтөлбөрийн зорилго нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх.

56. Энэхүү журмын 52.3-т заасан “Бодлогын хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа” бүлэгт бодлогыг хэрэгжүүлэх үе шат бүрт зорилт тус бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон байна.

57. Энэхүү журмын 52.4-т заасан “Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт” бүлэгт бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд бий болох бүтээгдэхүүн, үр нөлөө, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

58. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын баримт бичиг, статистикийн мэдээ, салбарын мэдээлэлд үндэслэн дараах байдлаар тодорхойлно:

58.1. бодлогын зорилго, зорилт бүрийг хэрэгжүүлсний үр дүнд бий болох эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тодорхойлох;

58.2. зорилт тус бүрийн хүрээнд 2-5 хүртэлх тооны эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тодорхойлж, тухайн үр нөлөө бүрт 2-оос доошгүй шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

58.3. бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас бусад этгээдэд хүргэх эцсийн бүтээгдэхүүнийг завсрын бараа, ажил, үйлчилгээ буюу эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход ашиглагдах бүтээгдэхүүнээс ялгаж тодорхойлох;

58.4. бодлогын бүтээгдэхүүн бүрт 1-ээс доошгүй шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

58.5. төсөлд шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, суурь он, зорилтот түвшин болон он, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлсон байх бөгөөд шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар илэрхийлнэ:

58.5.1. бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд гарах өөрчлөлт нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилт, шалгуур үзүүлэлттэй уялдсан байдал;

58.5.2. бодлогын хэрэгжилтийг үнэлэх бусад шалгуур үзүүлэлт.

59. Энэхүү журмын 52.5-д заасан “Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр” бүлэгт дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг бодлогын зорилт тус бүрээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, гадаад өрийн зохистой харьцаа, төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт үндэслэсэн тооцооны хамт тусгасан байна:

60. Энэ журмын 52.6-д заасан “Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө” бүлэгт дараах зүйлийг тусгасан байна:

60.1. хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, нэгтгэн тайлагнах хугацаа;

60.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, санал зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа.

61. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байж болно:

61.1. нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл;

61.2. хоёрдугаар бүлэг. Эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.3. гуравдугаар бүлэг. Нийгмийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.4. дөрөвдүгээр бүлэг. Байгаль орчны бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.5. тавдугаар бүлэг. Засаглалын бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.6. зургадугаар бүлэг. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ.

62. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу боловсруулна.

63. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн салбарын танилцуулга бүлэгт тухайн салбарт дунд, богино хугацаанд тулгарч байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээ, өмнөх оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг тусгасан байна.

64. Үндсэн чиглэлийн төсөлд тусгах арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ болон нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн санал, төсвийн хязгаарт үндэслэн энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 1-д нийцүүлэн боловсруулна.

65. Нутгийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа энэхүү журмын 65, 66-д заасныг баримтална.

## Арван хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний уялдаа

66. Дунд хугацааны бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг эрх бүхий байгууллага гаргана.

67. Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр нөлөөний талаар бодлого боловсруулагчид болон нийтэд мэдээлэхдээ хөндлөнгийн үнэлгээний тайланд үндэслэнэ.

68. Төслийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа өмнө нь хэрэгжүүлсэн хөгжлийн бодлогын баримт бичгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний тайланг харгалзана.

69. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тухайн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хугацааны эхний хагаст шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшний 30 хүртэлх хувийг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд уг бодлогыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэхийг тухайн бодлогын баримт бичгийг баталсан эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.

*Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 1 дүгээр хавсралт*

# ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА
## (бодлогын хувилбар бүрээр)

| № | Боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт | Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал | Төрөөс баримтлах бодлого | Бүсчилсэн хөгжлийн бодлого (Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал) | Бусад бодлогын баримт бичиг |
|---|---|---|---|---|---|
| | | Нийцэж байгаа зорилго, зорилт | Нийцэж байгаа зорилго, зорилт | Нийцэж байгаа зорилго, зорилт | Нийцэж байгаа зорилго, зорилт |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |
| | | | | | |
| ... | | | | | |
| Нийт | | | | | |
| Нийцсэн* (тоо, %) | | | | | |
| Тайлбар танилцуулга:<br>(Энэ хэсэгт хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь бусад бодлогын зорилго, зорилттой хэрхэн уялдаж байгаа талаар товч танилцуулга бичнэ) | | | | | |

*Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 2 дугаар хавсралт*

# ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХУВИЛБАР БҮРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО
## (хувилбар бүрээр)

*(сая төгрөгөөр)*

| № | Бодлогын зорилго, зорилт | Эхлэх/ дуусах огноо | Нийт (1+2+...+k) | Төсвийн жил 1 (1) | | | Төсвийн жил 2 (2) | | | Төсвийн жил к (к) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нийт шаардагдах санхүүжилт | Урсгал зардал | Хөрөнгө оруулалт | Нийт шаардагдах санхүүжилт | Урсгал зардал | Хөрөнгө оруулалт | Нийт шаардагдах санхүүжилт | Урсгал зардал | Хөрөнгө оруулалт |
| 1 | Зорилго 1 | | | | | | | | | | | |
| 1.1. | Зорилт 1 | | | | | | | | | | | |
| 1.2. | Зорилт 2 | | | | | | | | | | | |
| ... | … | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ | | | | | | | | | | | | |
| Санхүүжилтийн эх үүсвэр | | | | | | | | | | | | |
| Улсын төсөв | | | | | | | | | | | | |
| Орон нутгийн төсөв | | | | | | | | | | | | |
| Гадаадын зээл, тусламж | | | | | | | | | | | | |
| Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | | | | | | | | | | | | |
| Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас | | | | | | | | | | | | |
| Концессын гэрээ | | | | | | | | | | | | |
| Бусад эх үүсвэр | | | | | | | | | | | | |

*Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах*
*нийтлэг журмын 3 дугаар хавсралт*

# ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН БАГЦ ТОВЬЁОГ

| № | Бодлогын баримт бичгийн холбогдох зорилго, зорилт | Байгууллага, хувь хүн | Санал гаргасан | | | | Тусгасан эсэх (Тайлбар, үндэслэл) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Нэмэлт оруулах | Хасах | Өөрчлөх | Найруулах | |
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| … | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

*Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 4 дүгээр хавсралт*

# БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН НӨЛӨӨЛЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

| | |
|---|---|
| А. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл | |
| 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлэх зорилтот бүлэг болон бусад бүлэг | Бодлогыг хэрэгжүүлснээр хууль ёсны эрх ашиг, санхүүгийн боломж, өнөөгийн нөхцөл байдалд нь шууд болон шууд бусаар нөлөөлж байгаа нийгмийн зорилтот бүлгийг тодорхойлно. Зорилтот бүлэг гэж бүлэг хувь хүмүүс, нийгмийн бүлэг, хуулийн этгээд (Засгийн газрын болон орон нутгийн удирдлагын байгууллага, түүний ажилчид) зэрэг тухайн бодлогыг хэрэгжүүлснээр эерэг болон сөрөг нөлөө хүртэх бүлгийг хэлнэ. |
| 2. Эдийн засгийн хөгжил болон захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө | 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын шалгуур үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох<br>2. Захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолох:<br>2.1. захиргааны үйл ажиллагааны нөлөө хэвээр үлдэж байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь зорилтот бүлгийн эрх ашиг, хариуцлагыг хөндөхгүй гэдгийг тодорхойлон бичих;<br>2.2. захиргааны үйл ажиллагааны нөлөө буурч байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнээс үр шим хүртэж байгаа нийгмийн бүлэг, байгууллага, аж ахуй, салбарыг тодорхойлон бичих;<br>2.3. захиргааны үйл ажиллагааны нөлөө нэмэгдэж байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь нийгмийн ямар бүлэг, байгууллага, аж ахуй, салбарт үзүүлж байгаа ямар гол өөрчлөлтүүд бий болж байгааг тодорхойлон бичих. |
| 3. Бусад мэдээлэл | Энэхүү нөлөөллийн үнэлгээний “А”-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн талаар энд бичиж болно. |
| Б. Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл | |
| 1. Бодлогын баримт бичгийн төсөл нь хэд хэдэн нийгмийн бүлэгт нөлөө үзүүлэхээр байгаа бол тус бүрээр нь тодорхойлно. Мэдээлэл нь тодорхой бүлэгт үзүүлэх нөлөөллийн хэмжээ, нөлөөлөх магадлал, үр дүнгийн талаар байна. Асуудал болон бодлогын хувилбарууд аль бүлэгт хамааралтай болохыг тодорхойлно. Тухайлбал, орон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газар, жижиг, дунд, том бизнес эрхлэгчид, импортлогчид, экспортлогчид, дотоодын зах зээлд бүтээгдэхүүн ханган нийлүүлэгчид, хэрэглэгчид, газар зүйн бүсүүд, нийгмийн бүлгүүд байна.<br>Нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь шилжилтийн байх, эсхүл урт хугацааны байх гэдгийг тодорхойлно. Түүнчлэн нийгэмд үзүүлэх нөлөөлөлд ямар эрсдэл учирч болох, түүнийг хэрхэн даван туулах талаар мэдээлсэн байна.<br>2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр ямар нөлөө үзүүлэхийг дараах байдлаар тодорхойлсон байна:<br>2.1. хүмүүсийн амьдралын хэв маягт үзүүлэх нөлөөний талаар;<br>2.2. хүмүүсийн соёлд ямар нөлөө үзүүлэх (хамтын итгэл, зан үйл, үнэт зүйл, соёл гэх мэт);<br>2.3. хүмүүсийн амьдардаг суурин болон нийгмийн бүлэгт ямар нөлөө үзүүлэх (уялдаа, тогтвортой байдал, шинж чанар, үйлчилгээ, байгууламж);<br>2.4. хүрээлэн буй орчинд ямар нөлөө үзүүлэх (хүмүүсийн хэрэглэдэг ус, амьсгалдаг агаарын чанар, хүнсний бүтээгдэхүүний чанар, олдоц, аюул, эрсдэлийн түвшин, тоос, дуу чимээний хэмжээ, ариун цэврийн байгууламжийн хангамж, байгууламжийн аюулгүй байдал, нөөцөөс хүртэх боломж, нөөцөд хяналт тавих боломж). | |
| 3. Бусад мэдээлэл | Энэхүү нөлөөллийн үнэлгээний “Б”-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн талаар энд бичиж болно. |

| В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө | |
|---|---|
| 1. Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн акт | Тухайн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай Улсын Их Хурлаар батлагдах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж, дүрэм, журам, тэдгээрийн хэрэгцээ, шаардлага, агуулгын талаар жагсаан бичнэ. |
| 2. Хариуцах байгууллага | Энэхүү нөлөөллийн үнэлгээний “В”-д дурдсан хууль, эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хариуцсан байгууллагын талаарх мэдээллийг энд бичнэ. |
| Г. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлэх нөлөө | |
| 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагууд | Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох эрх бүхий бүх байгууллага, хуулийн этгээдийг тодорхойлж, хэрэгжилтийн аль үе шатанд оролцох талаар бичнэ. |
| 2. Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлэх нөлөө (шинээр бүтэц бий болох, өнөөгийн институцийг татан буулгах, эсхүл бүтцийг өөрчлөн байгуулах) | 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд шинээр байгууллага бий болгох шаардлагатай тохиолдолд одоо байгаа байгууллагын бүтцээр бодлогыг хэрэгжүүлж болохгүй байгаа шалтгааныг бичнэ.<br>2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад аливаа нэгэн байгууллагыг татан буулгах шаардлагатай тохиолдолд цаашид энэхүү байгууллагын чиг үүргийг хэрхэн үргэлжлүүлэх талаар тайлбарлан бичнэ.<br>3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад аливаа нэгэн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх шаардлагатай тохиолдолд тус байгууллагын чиг үүрэг хэрхэн өөрчлөгдөх, тодорхой чиг үүргийг тухайлбал, бүс, орон нутгийн байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болохгүй талаар тайлбарлан бичнэ.<br>4. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судалж бичнэ.<br>5. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлэх боломжийг судалж бичнэ. |
| 3. Хүний нөөцөд үзүүлэх нөлөө | Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, чадавхид өөрчлөлт оруулахгүйгээр бодлогыг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар бичнэ. |

*Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 5 дугаар хавсралт*

# ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ

| № | Бодлогын баримт бичгийн бүлэг/заалт | Зорилт | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | | Мэдээллийн эх сурвалж | Хэрэгжүүлэх байгууллагууд* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Он | Үзүүлэлт | Он | Үзүүлэлт | | |
| 1. | Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилт, шалгуур үзүүлэлт (он/зорилтот түвшин) (энэ хэсэгт зөвхөн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан шалгуур үзүүлэлтүүдийг тусгана) | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | |
| … | | | | | | | | | | |
| | 2. Бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | |
| … | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |

**-хэрэгжүүлэх байгууллагуудыг хэрэгжилтийг хангах хариуцлагын эрэмбээр жагсаана.*

*Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 6 дугаар хавсралт*

# ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

| Зорилго | | Бодлого, хөтөлбөрийн зорилго | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт) | | Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан үр нөлөөг бичнэ. Түүнчлэн хэрэгжилтийн үр дүнг үнэлэхэд ашиглах үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг бичнэ. | | | | |
| 1. Үйл ажиллагааны чиглэл | | Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл | | | | |
| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
| Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 1 | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 2 | | | | | | |
| | | | | | | |
| 2. Үйл ажиллагааны чиглэл | | Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл | | | | |
| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
| Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 1 | | | | | | |
| | | | | | | |

*Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 7 дугаар хавсралт*

## Хүснэгт 1. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮСНЭГТ

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. | | | | | | |
| 1.1 | | | | | | |
| | | | | | | |

## Хүснэгт 2. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛУУДЫН ТАЙЛБАР ТОВЬЁОГ

| № | Төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллага | Арга хэмжээ | Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх | Үндсэн чиглэлд туссан эсэх | Тусгаагүй арга хэмжээний тайлбар | Төлөвлөгдсөн санхүүжилт (төлөвлөсөн/баталсан) | Батлагдсан санхүүжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зам, тээврийн яам | Арга хэмжээ 1 | | | | | |
| 2 | | Арга хэмжээ 2 | | | | | |
| 3 | | Арга хэмжээ 3 | | | | | |
| ... | | | | | | | |

*Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 8 дугаар хавсралт*

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН … ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | | | | | | Хэрэгжүүлэх байгууллага | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2017 он | | 2018 он | | 2019 он | | 2020 он | | | | |
| | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | .Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Үндсэн | Хамтрагч | Оролцогч |
| ХӨГЖЛИЙН САЛБАР №1.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ | | | | | | | | | | | | | | | |
| Зорилго №1.1.1. Бэлчээрийн малын удмын санг хадгалж, сүргийн бүтцийн зохистой харьцааг бүрдүүлж, малын эрүүл мэнд, эрсдэл даах чадварыг сайжруулах, мал амьтны эрүүл мэндийн хяналт, үйлчилгээнд олон улсын стандартыг үе шаттайгаар нэвтрүүлэн, хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэн олон улсын зах зээлд гаргана. | | | | | | | | | | | | | | | |
| Тэргүүлэх зорилт №1.1.1.1. Хангайн бүсийн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны аж ахуйг дэмжиж, тариалангийн бүс нутагт дэвшилтэт технологи бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлэх; | 1. | Арга хэмжээ 1. | | | | | | | | | | | | | |
| | 2. | Арга хэмжээ 2. | | | | | | | | | | | | | |
| | 3. | Арга хэмжээ 3. | | | | | | | | | | | | | |
| | 4. | Арга хэмжээ 4. | | | | | | | | | | | | | |
| | 5. | Арга хэмжээ 5. | | | | | | | | | | | | | |
| Үндсэн зорилтууд №1.1.1.2.1. Малын индексжүүлсэн даатгалыг давхар даатгалд хамруулах замаар олон улсын стандартын дагуу мал сүргийг бүртгэж даатгах; | 1. | Арга хэмжээ 1. | | | | | | | | | | | | | |
| | 2. | Арга хэмжээ 2. | | | | | | | | | | | | | |
| | 3. | Арга хэмжээ 3. | | | | | | | | | | | | | |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хот

**Дугаар 276**

## ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. /Энэ тогтоолын хавсралтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 375 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.САЙХАНБИЛЭГ
Хөдөлмөрийн сайд Г.БАЯРСАЙХАН

*Монгол Улсын Засгийн газрын 2016 оны*
*276 дугаар тогтоолын хавсралт*

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЖИЖИГ ЗЭЭЛ ОЛГОХ, ТҮҮНД БАТЛАН ДААЛТ ГАРГАХ, ХҮҮГ НӨХӨН ТӨЛӨХ, САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2, 12.4, 12.6, 12.8.4, 12.9-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгжид жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, зээлийн хүүг нөхөн төлөх болон бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох, зээлийн хүүгийн төлбөрийг нөхөн төлөх, зээлд батлан даалт гаргах үйл ажиллагаа нь өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэх, хоршоо, нөхөрлөл байгуулах, бичил аж ахуй эрхлэх, өргөтгөх, ажлын байр шинээр бий болгох, хадгалах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

## Хоёр. Жижиг зээл олгох

2.1. Жижиг зээлийг бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид олгоно.

Иргэн бусадтай хамтран нөхөрлөл, хоршоо, 8-10 гишүүнтэй бүлэг байгуулж аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж болно.

2.2. Энэ журмын 2.1-д заасан иргэдийн бүлэг жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах үйл ажиллагаанд бүлгийн гишүүдийн хурлаас томилсон эрх бүхий төлөөлөгчөөр дамжуулан оролцоно.

2.3. Иргэн, аж ахуйн нэгж жижиг зээл хүссэн өргөдлөө холбогдох төслийн хамт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд хүргүүлнэ. Төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1. хүрэх үр дүн, зорилт тодорхой байх;

2.3.2. ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжийн нөөц, боломж болон үйл ажиллагаа явуулах ажлын байр, орчныг сайтар тооцсон байх;

2.3.3. төслийн хүрээнд орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхлэхээр төлөвлөсөн байх;

2.3.4. зээлийн мөнгөн дүнгийн 40 болон түүнээс дээш хувьд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх;

2.3.5. төслийн хүрээнд байнгын ажлын байр бий болгож, цаашид хадгалах боломжтой байх.

2.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан нь иргэн, аж ахуйн нэгжийн зээл хүссэн өргөдлийг судалж, энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд зээл олгох саналаа тодорхойлолтын хамт банкинд хүргүүлнэ.

2.5. Банкнаас жижиг зээл олгох шийдвэр гарсны дараа аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан зээлдэгчтэй ажлын байр бий болгох, өргөтгөх, тогтвортой хадгалах талаар гэрээ байгуулж, зээлдэгчийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, уулзалтыг зохион байгуулах бөгөөд бизнес, аж ахуйн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

2.6. Жижиг зээл олгох банкийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулах бөгөөд шалгарсан банктай гэрээ байгуулж, тухайн жилд төсөвлөсөн зээл, зээлийн батлан даалтын хөрөнгийг дансанд нь байршуулна.

Гэрээнд зээлийн хөрөнгийг банкны дансанд байршуулах болон зээл олгох нөхцөл, зээлийн хөрөнгийн үлдэгдлийг эргүүлэн татах хугацаа, хариуцлагыг тодорхой заана.

2.7. Жижиг зээл олгох банк дараах нөхцөлийг хангасан байна:

2.7.1. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 10 сард хангасан байх бөгөөд энэ талаар Монголбанкны дүгнэлтийг хавсаргасан байна;

2.7.2. зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өмнө хариуцах баталгаа гаргасан байх;

2.7.3. жижиг зээлийн хүүгийн хэмжээ тухайн банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байх бөгөөд гэрээний туршид банкны олгож байгаа хүүгийн доод түвшингээс доогуур байх;

2.7.4. энэ журмын 2.6-д заасан сонгон шалгаруулалтын үеэр тавьсан бусад шаардлагыг хангасан байх.

~~2.8. Банкинд байршуулсан зээлийн хөрөнгөд аливаа хүү, төлбөр төлөхгүй.~~
*/Энэ заалтыг ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/*

2.9. Банк иргэн, аж ахуйн нэгжийн зээл авах болон зээлийн батлан даалтад хамрагдах хүсэлтийг ажлын 5 хоногт багтаан судалж шийдвэрлэнэ.

2.10. Жижиг зээлийг 24 сарын хугацаатай олгох бөгөөд үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа 6 сар хүртэл байна.

2.11. Жижиг зээлийн хэмжээ иргэнд 10.0 сая хүртэл, иргэдийн бүлэгт нэг гишүүнд 2.0 сая хүртэл, аж ахуйн нэгжид 20.0 сая хүртэл төгрөг байна.

2.12. Зээлийг хуваарийн дагуу төлж, зориулалтын дагуу зарцуулсан, үйл ажиллагаа нь тогтворжиж, гэрээнд заасны дагуу ажлын байр шинээр бий болгож тогтвортой хадгалсан, ажилчдаа нийгмийн даатгалд даатгуулсан зээлдэгч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин зээл авах тохиолдолд зээлийн хугацааг 36 сар, үндсэн зээлээс чөлөөлөх хугацааг 12 сар хүртэл болгон нэмэгдүүлж, зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлнэ.

Зээлийн хүүгийн хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жижиг зээл олгох банктай тохирч, энэ журмын 2.6-д заасан гэрээнд тусгана.

2.13. Зээлийн хөрөнгөөр өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхэлж, нэмүү өртгийн сүлжээнд хамрагдсан зээлдэгч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин зээл авах тохиолдолд зээлийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж болно.

2.14. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй бөгөөд зээлээ төлж дуусан болов ч ашиглалтын явцад зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон тохиолдолд тухайн зээлдэгчийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин жижиг зээл авах эрхийг 36 сар хүртэл хугацаагаар хязгаарлана.

**Гурав. Зээлд батлан даалт гаргах**

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2-т заасан малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалтаар олгосон жижиг зээлд батлан даалт гаргана.

3.2. Энэ журмын 3.1-д заасан батлан даалтыг банкны зээл олгох бусад шалгуур үзүүлэлтийг хангасан ч барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуй нэгжийн авч байгаа жижиг зээлд гаргах бөгөөд нэг зээлдэгчид гаргах батлан даалтын хэмжээ олгох зээлийн 60 хүртэлх хувьтай тэнцүү байна.

3.3. Зээлийн батлан даалтын хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

3.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;

3.3.2. гадаад, дотоодын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө;

3.3.3. бусад.

3.4. Зээлд батлан даалт гаргах нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага, батлан даалтын төлбөр төлөх, батлан даалтыг түдгэлзүүлэх, зогсоох, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг “Батлан даалтын гэрээ”-нд тусган хэрэгжүүлнэ. “Батлан даалтын гэрээ”-ний загварыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

**Дөрөв. Зээлийн хүүг нөхөн төлөх**

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.4-т заасан ажил олоход хүндрэлтэй иргэн материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад зориулж жижиг зээл авсан бол хүүгийн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн төлөх бөгөөд ийнхүү төлөхдөө иргэний хүсэлт, зээлийн гэрээ, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг банкинд төлсөн баримт болон санхүүгийн бусад баримтыг үндэслэнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасан иргэний хүсэлтийг мөн журмын 2.9-т заасан хугацаанд судалж шийдвэрлэнэ.

4.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (сан) энэ журмын 4.1-д заасан зээлийн хүүгийн төлбөрийн тухайн жилд ногдох хэсгийг жил бүрийн эхний улиралд багтаан зээлдэгчид нөхөн төлнө.

**Тав. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх**

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7, 28.8.2-т заасны дагуу Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг олгоно.

5.2. Энэ журмын 5.1-д заасан санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээ, нөхцөл, шаардлагыг тухайн төсөл, хөтөлбөрт, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөх хуваарийг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээнд тус тус тусгана.

5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.1-д заасан малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлхэд зориулж үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэг төсөлд 5.0 сая хүртэл төгрөг байх бөгөөд зорилтот бүлгүүдийн онцлогт тохируулж эргэн төлөлтийн хэмжээг 50-иас дээш хувь байхаар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд тогтоон хэрэгжүүлнэ.
*/Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

5.4. Санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх хуваарь санхүүгийн дэмжлэг үзүүлсэн 4 дэх сараас эхлэж 20 хүртэлх сарын хугацаанд сар бүр төлөх нөхцөлтэй байна.
*/Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

5.5. Энэ журмын 5.3-т заасан этгээдийн санхүүгийн дэмжлэгт дахин хамрагдах хугацаа 24 ба түүнээс дээш сарын дараа байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

5.5.1. гэрээний хугацаа бүрэн дууссан байх;

5.5.2. санхүүгийн дэмжлэгийн үр дүнг тооцсон байх;

5.5.3. санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан болон эргэн төлөлтийг төлж барагдуулсан байх.

5.6. Энэ журмын 5.3-т заасан этгээдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтийг мөн журмын 2.9-т заасан хугацаанд судалж шийдвэрлэнэ.

## Зургаа. Хяналт тавих, тайлагнах

6.1. Энэ журамд заасны дагуу жижиг зээл олгосон, батлан даалт гаргасан, хүүг нөхөн төлсөн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн талаарх мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 17.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгүүлж, мэдээллийн сан үүсгэнэ. Бүртгэлийн маягтыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

6.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага энэ журмын 6.1-д заасан мэдээллийн санд тулгуурлан сар бүр тайлан бэлтгэж дараа сарын 3-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн мөн сарын 10-ны дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Тайлангийн маягтыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
*/Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

6.3. Энэ журмын 6.1, 6.2 дахь заалтын хүрээнд банк аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтныг тогтоосон хугацаанд мэдээллээр тогтмол хангаж, хамтарч ажиллана.

6.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан улирал тутам нийт зээлдэгчийг хамруулан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийнэ.

Хяналт, шалгалтын дүнг тухай бүр хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
*/Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

6.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан банкны жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх үйл ажиллагааны гүйцэтгэл болон банкинд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас байршуулсан хөрөнгийн зарцуулалтад улирал тутам хяналт тавьж ажиллана. Хяналтын тайлан, дүгнэлтийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ.
*/Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор өөрчлөлт орсон/*

6.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл болон аймаг, дүүргийн салбар зөвлөл хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд уг үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар хяналт, шалгалт хийлгэж болно.
*/Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 64-р тогтоолоор нэмэлт орсон/*

6.7. Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна.

6.8. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

6.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль бусаар ашигласан гэж буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хот

**Дугаар 64**

## ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 6.6 дахь заалтын “төрийн захиргааны төв” гэсний дараа “болон төрийн захиргааны” гэж нэмсүгэй.

2. Мөн журмын 5.3 дахь заалтын “уг санхүүгийн дэмжлэгийг 30-аас дээш хувийг эргэн төлнө” гэснийг “зорилтот бүлгүүдийн онцлогт тохируулж эргэн төлөлтийн хэмжээг 50-иас дээш хувь байхаар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд тогтоон хэрэгжүүлнэ.” гэж, 6.2 дахь заалтын “хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн мөн сарын 10-ны дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж, 6.4, 6.5 дахь заалтын “хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэснийг “хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгтгэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Журмын 5.4 дэх заалтын “ижил хэмжээгээр” гэснийг хассугай.

4. Мөн журмын 2.8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.ЭРДЭНЭБАТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.НОМТОЙБАЯР

# МОНГОЛ БАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 206 /А/277

Журам шинэчлэн батлах тухай

Монголбанк /Төв банк/-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. «Азийн хөгжлийн банкны Ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд эргэн төлөгдсөн эх үүсвэрээс зээл олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Алимаа/, Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар /Д.Болдбаатар/-т тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2000 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 593, 57 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЗОЛЖАРГАЛ

ХӨДӨЛМӨРИЙН
САЙД С.ЧИНЗОРИГ

*Монгол банкны Ерөнхийлөгч, Хөдөлмөрийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 206/А/277 дугаар тушаалын хавсралт*

# АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ “АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЭРГЭН ТӨЛӨГДСӨН ЭХ ҮҮСВЭРЭЭС ЗЭЭЛ ОЛГОХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1. Азийн хөгжлийн банкнаас Монгол улсад хэрэгжүүлсэн «Ажлын байр нэмэгдүүлэх” төслийн эргэн төлөгдсөн хөрөнгийн эх үүсврийг ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй нөхцөлөөр иргэд, хуулийн этгээдэд зээл олгох, оролцогч байгууллагуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн ажлын уялдаа холбоог хангах, зээлийн хөрөнгийг оновчтой хуваарилж, үр дүнтэй ашиглахад энэхүү журмын зорилго оршино.

2. Оролцогч байгууллага нь Монгол улсын Хөдөлмөрийн яам, аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс, Монголбанк, банкууд байна.

3. Монголбанк болон банкууд хооронд байгууллага дундын Санамж бичиг болон санхүүжилтийн гэрээ, оролцогч банк ба зээлдэгчийн хооронд зээлийн гэрээг байгуулж энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4. Банкууд Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих асуудлыг Хөдөлмөрийн яам, Монголбанк хамтран хэрэгжүүлэх ба төсөлд оролцогч банкуудыг сонгох, цаашид үргэлжлүүлэн оролцуулахгүй байх асуудлыг Монголбанк шийдвэрлэнэ.

5. Журамд хэрэглэгдэж буй нэр томьёоллыг дараах байдлаар ойлгоно:

A. Эргэлтийн сан: Ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд банкуудад олгогдон Монгол банкинд эргэн төвлөрч, цаашид дээрх зорилгын дагуу дамжуулан зээлдүүлэх хөрөнгийн эх үүсвэр.

B. Тусгай хугацаат хадгаламж: Монголбанкнаас энэ журамд заасанзорилгоор оролцогч банкуудад байршуулсан хөрөнгө.

C. Дамжуулах зээл: Тусгай хугацаат хадгаламжаар дамжуулан Монголбанкнаас оролцогч банкинд олгож байгаа зээл.

D. Эцсийн зээлдэгч: оролцогч банкнаас дэд зээл авсан, энэ журмын 2.1- д заасан шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээд.

## Хоёр. Зээлийн ерөнхий нөхцөл

1. Эцсийн зээлдэгч нь Монгол улсын иргэн, хуулийн этгээд байна.

2. Төслийн хүрээнд зээл авахыг хүссэн иргэн, хуулийн этгээдийн зээлийн өргөдөл, төслийн ач холбогдол, хадгалагдаж буй болон шинээр бий болгох ажлын байрны тоо, эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл зэргээс гадна журмын дөрөвдүгээр хэсэгт заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байдлыг харгалзан 30 сая хүртэл төгрөг байна.

3. Оролцогч банкнаас эцсийн зээлдэгчид олгох зээлийн хүү жилийн 10 хувиас хэтрэхгүй байна.

4. Зээлийг 2 жил хүртэлх хугацаатай олгоно.

5. Олгосон зээлийг хуваарийн дагуу төлсөн, үйлдвэрлэл, үйлчилгээ амжилттай эрхлэн явуулж, ажлын байр бий болгоход тодорхой хувь нэмэр оруулсан хуулийн

этгээд дахин зээл авахад зээл олгогч арилжааны банк өөрийн дүрэм, журмын дагуу хөнгөлөлт үзүүлж болно.

6. Зээлийг олгох үед зээлдэгч болон түүний холбогдогч этгээд нь аливаа төрлийн хугацаа хэтэрсэн зээлийн өртэй, эсвэл өмнө нь зээлийн гэрээний үүргийг зөрчиж, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхэд хүрч байсан бол энэ нь тухайн этгээдийг төсөлд оролцуулахаас татгалзах үндэслэл болно.

7. Зээлдэгчийн хэрэгжүүлж буй төсөл, эрхэлж буй үйл ажиллагаа нь хүний биед эсвэл байгаль орчинд хохирол учруулахаар бол энэ нь тухайн этгээдэд зээл олгохоос татгалзах үндэслэл болно.

## Гурав. Зээлийн эх үүсвэрийг олгох, төлүүлэх

1. Монголбанк нь банкуудаас ирүүлсэн материалыг хянан үзсэний үндсэн дээр банкинд байршуулах эх үүсвэрийн хэмжээ, оролцогч банкуудыг сонгон шалгаруулах талаар шийдвэр гаргана.

2. Монгол банк нь банктай санхүүжилтийн гэрээ байгуулж гэрээ байгуулсанаас хойш ажлын 5 хоногийн дотор холбогдох банкинд зээлийн эх үүсвэрийг тусгай хугацаат хадгаламж хэлбэрээр байршуулна.

3. Банкуудад байршуулах Тусгай хугацаат хадгаламжийн хүүг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтоох ба хүүгийн хэмжээ жилийн 7 хувиас хэтрэхгүй байна.

4. Банкуудад байршуулсан Тусгай хугацаат хадгаламжийн хугацаа нь эцсийн зээлдэгчид олгосон зээлийн хугацаанаас сараар илүү байж болох бөгөөд төлөгдөх хугацаа нь болсон эх үүсвэрийг тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас шууд төлүүлнэ.

5. Тусгай хугацаат хадгаламжинд тооцсон хүүний төлбөрийг тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас сар бүр шууд суутгана.

6. Банкууд болон бусад холбогдох оролцогч байгууллагууд зээл авагч хуулийн этгээдүүдийг зээлийн хугацаагаар нь ангилан ангилал тус бүрээр зээлийн маягт хөтөлнө. Банкууд нь тэдгээр маягтыг өөрийн хүсэлтийн хамт Монголбанкинд ирүүлнэ.

7. Үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан шаардлагатай гэж үзвэл тухайн банкинд байрших ТХХ-ийн хэмжээнд Монгол банкнаас өөрийн хөрөнгийн хэмжээнээс нь хамааран хязгаарлалт тогтоож болох бөгөөд үүнийг Санхүүжилтийн гэрээгээр зохицуулна.

8. Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийн аль нэгийг, эсвэл Заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 3 сарын турш дараалан биелүүлээгүй бол тухайн банкийг төсөлд оролцуулахгүй.

## Дөрөв. Зээл олгох үндсэн шалгуур үзүүлэлт

1. Эцсийн зээлдэгч нь дараах шалгуурыг хангасан байх ёстой:

a) Зээл авсанаар ажлын байр шинээр бий болох, цаашид тогвортой хадгалагдах,

b) Банкны хямдруулсан үнэлгээгээр хүссэн зээлийн хэмжээтэй бүрэн тэнцэх хэмжээний барьцаалах эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхтэй байх.

c) Барьцаа хөрөнгийн хэмжээ хангалтгүй байх тохиолдолд Зээлийн батлан даалтын сангаас баталгаа гаргуулж болно.

d) Зээлдэгчийн хэрэгжүүлж буй төсөл, эрхэлж буй үйл ажиллагаа нь хүний биед эсвэл байгаль орчинд хохирол учруулахааргүй байх.

**Тав. Иргэн, хуулийн этгээдээс зээл хүссэн материал хүлээн авах, шалгах, зээлийг олгох**

1.Зээл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж зээлийн хүсэлтээ хэрэгжүүлэх төслийн танилцуулга, холбогдох материалын хамт тухайн аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэст хүргүүлнэ.

2. Аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс нь иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн зээлийн хүсэлтийг хянан үзэж, хөдөлмөрийн үр ашгийг судалж, тодорхойлолт гаргана.

3. Банк зээл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн өргөдөл, боловсруулсан төсөл, бизнес төлөвлөгөөг Хөдөлмөрийн хэлтсийн тодорхойл олтын хамт хүлээн авч, зээл олгох шийдвэрийг гаргана.

4. Банк зээл олгох шийдвэрийг бие даан өөрсдийн журмын дагуу гаргах бөгөөд эцсийн зээлдэгчид олгох зээлийн эрсдэлийг хариуцна.

5. Монголбанкнаас банкинд ТХХ байршуулсан өдрөөс хойш 3 сарын дотор тухайн банк эх үүсвэрийг зориулалтын дагуу эцсийн зээлдэгчид дамжуулан олгоно. Нэг сараас дээш дамжуулан олгоогүй хадгалсан эх үүсвэрт хоног бүрт 1 хувийн торгууль тооцно.

6. Аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс, оролцогч банк зээлийг оновчтой ашиглах, зээлийн эрсдлийг тодорхойлох чиглэлээр болон бизнес төлөвлөгөө зохиох, нягтлан бодох бүртгэл зэрэг холбогдох асуудлаар зээлдэгч болон зээл хүсэгч иргэн, аж ахуйн нэгжид зориулан сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгнө.

7. Аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс нь зээлийн үр дүнд бий болсон ажлын байрны (НДШ, татвар төлсөн) мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

**Зургаа. Хяналт тавих, тайлан мэдээ гаргах**

1. Эцсийн зээлдэгчид зээл олгосны дараа зээлдэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, зээлийг эргүүлэн төлүүлэх үүргийг банк хүлээнэ.

2. Аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс, оролцогч банк нь зээл эргэн төлөгдөж дуустал түүний ашиглалтыг тогтмол хянаж, үнэлгээ өгөх ба зээлийн эрхийн хугацаанд тухайн байгууллагын санхүү, эдийн засгийн бодит байдлыг үнэн зөв тодорхойлоход хөндлөнгийн хяналт тавьж, зээлийн ашиглалт, үр дүнгийн талаар Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар, Хөдөлмөрийн яамны Санхүү, сангийн бодлого, төлөвлөлтийн газарт тус тус хагас жил тутам тайлагнана.

3. Оролцогч банк төслийн хүрээнд олгосон зээлийн эх үүсвэрийн сарын мэдээг энэхүү журмын Хавсралт 1-ийн дагуу гаргаж, дараа сарын 6-ны өдрийн дотор Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газарт ирүүлнэ.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар А/123

## ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ
**/Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох/**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам“-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн төв бирж /Ц.Энхтуяа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Ууганбаатар/-т, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С. Жамъянсүрэн/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2013 оны 05-р сарын 07-ны өдрийн А/92 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Я.САНЖМЯТАВ

*/ХС-ын 2016-05-06-ны А/116 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсныг тусгав./*

*Хөдөлмөрийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн*
*А/123 дугаар тушаалын хавсралт*

# ХӨДӨЛМӨРИЙН ХУВИЙН БИРЖИЙГ БҮРТГЭЖ, САНХҮҮЖИЛТ /ТАРИФААР ТООЦОЖ/ ОЛГОХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Ажилд зуучлах үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх зорилгоор хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгоход Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Хөдөлмөрийн төв бирж /цаашид төв бирж гэх/, хөдөлмөрийн хувийн бирж /цаашид хувийн бирж гэх/ нь ажилд зуучлах үйлчилгээнд Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/154 тоот тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний жишиг дүрэм”-ийг баримтална.

1.3.Төв бирж нь хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгох асуудлыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

## Хоёр. Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх, бүртгэлээс хасах

2.1 Хувийн бирж нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.12 дахь заалтад заасан нийтлэг шаардлагыг хангаж, төв биржид бүртгүүлэхэд дараах бичиг, баримтыг бүрдүүлнэ:

2.1.1. албан хүсэлт;

2.1.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.1.3. удирдах ажилтан /захирал/-ны иргэний үнэмлэхний хуулбар;

2.1.4. үйл ажиллагааны танилцуулга;

2.1.5.хувийн биржийн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх журам, бизнес төлөвлөгөө, үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмж, тавилгын жагсаалт;

2.1.6.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэргэшсэн зөвлөх, хөдөлмөр зуучлал хариуцсан ажилтны анкет, диплом, гэрчилгээний хуулбар;

2.2.Төв бирж нь энэхүү журмын 2.1-д заасан бичиг, баримтыг бүрдүүлсэн хувийн биржийг бүртгэж, гэрчилгээ олгоно.

2.3.Бүртгэлийн гэрчилгээний загварыг төв биржийн даргын тушаалаар батална.

2.4.Хувийн биржийг дараах тохиолдолд бүртгэлээс хасна:

2.4.1.хувийн бирж нь өөрөө хүсэлт гаргасан;

2.4.2.хуулийн этгээд татан буугдсан;

2.4.3.бүртгэл мэдээллийн санд хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд зарласан ажлын байрны болон ажил хайгчийн зарыг дур мэдэн, зөвшөөрөлгүй бүртгэх, бүрэн бус, бодит бус, худал мэдээлэл оруулах, түүнд үндэслэн санхүүжилт хүссэн;

2.4.4.иргэнийг хуулиар хориглосон үйл ажиллагаатай ажилд зуучилсан болон зуучлахыг оролдсон нь нотлогдсон;

2.4.5.төв биржтэй гэрээ байгуулснаас хойш зургаан сарын хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нэг ч ажил хайгчийг ажилд зуучлан оруулсан тухай бүртгэгдээгүй бол;

2.4.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9.4-т заасныг зөрчсөн буюу хувийн бирж нь ажилд зуучлуулсан иргэнээс шууд ба шууд бус байдлаар үйлчилгээний төлбөр авсан.

*/Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/*

2.5. Бүртгэлийн гэрчилгээг 2 жилийн хугацаатай олгоно.

*/Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/*

2.6. Хувийн биржийн албан хүсэлт, төв биржтэй байгуулсан гэрээний биелэлтийн үнэлгээ, дүгнэлтийг тус тус үндэслэн гэрчилгээний хугацааг 2 жилээр сунгана.

*/Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/*

## Гурав. Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа

3.1.Хувийн бирж нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.11 дэх заалтад заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.Хувийн бирж нь энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд ажил хайгч иргэн, ажилгүй иргэн, 40- өөс дээш насны ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна.

3.3.Хувийн бирж нь өөрийн байгууллагын эрхэлж буй хөдөлмөр зуучлалын үйл ажиллагаа болон шууд харьяалах, харьяалагдах аж ахуйн нэгж, байгууллагад ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх зорилгоор ажил хайгчийг ажилд авсан тохиолдолд ажилд зуучлах үйлчилгээнд хамаарахгүй.

3.4 Хувийн биржийн үйл ажиллагаа нь ажил мэргэжил болон эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хүрээнд эсхүл иргэн, ажил хайгч хүн амын тодорхой, онцлог бүлгүүдэд дагнасан байж болно.

3.5. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон их сургууль, дээд сургуулиудад суралцагсдыг суралцаж байх үеэс нь ажил олгогчтой холбох үйл ажиллагааг зохион байгуулна.

*/Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/*

## Дөрөв. Хөдөлмөрийн төв биржийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төв бирж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1.хувийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, санал, дүгнэлт гаргах;

4.1.2.хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй, татгалзсан тухай үндэслэлийг хууль тогтоомжийн дагуу гаргаж, хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагад албан ёсоор хүргүүлэх;

4.1.3.хувийн биржийн үйл ажиллагааг үнэлэх, гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт тогтоох;

4.1.4.хувийн биржтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, гэрээг хагас жил, бүтэн жилээр дүгнэх, санхүүжилт олгох;

4.1.5.хувийн биржийг бүртгэсэн болон бүртгэлээс хассан тухай олон нийтэд ил тод мэдээллэх;

4.1.6.эдгээр болон хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.7. Хувийн биржийн үйл ажиллагаанд жилд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд гэнэтийн шалгалт хийнэ.
*/Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/*

**Тав. Мэдээ, тайлан, санхүүжилт**

5.1. Хувийн бирж нь дараах тайлан, мэдээг гаргаж төв биржид тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

5.1.1.Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/04 дугаар тушаалаар батлагдсан хөдөлмөрийн зах зээлийн анхан шатны ХЗЗ-1, ХЗЗ-2, ХЗЗ-3, ХЗЗ-7а, ХЗЗ-7б маягтын дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, мэдээллийн сүлжээгээр болон албан бичгээр тухайн сарын 30-ны дотор;

5.1.2.Үйл ажиллагааны хагас жилийн тайланг 6 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, төв биржид 6 дугаар сарын 30-ны дотор, жилийн тайланг 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, 12 дугаар сарын 20-ны дотор;

5.2.Төв бирж нь хувийн биржтэй байгуулсан гэрээнд заасан ажил, үйлчилгээний биелэлтийг хянан баталгаажуулж, санхүүжилтийг тогтоосон тарифаар тооцон сар бүр олгоно.

5.3.Төв биржийг хувийн биржийн үйл ажиллагааг үндэслэлгүй дүгнэх, санхүүжилтыг нотлох баримтгүйгээр олгох, хасах, саатуулахыг хориглоно.

5.4.Энэхүү журмын 3.3-т заасан хувийн биржийн үйл ажиллагаанд санхүүжилт олгохгүй.

5.5. Ажил хайгчийг ажилд зуучлагдан орж тогтвортой ажиллах хугацааг харгалзан санхүүжилтийг тарифаар тооцон давхардуулахгүйгээр олгоно.
*/Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/*

5.6. Төв бирж нь хувийн биржийн үйл ажиллагааны мэдээ, тайланг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагад тогтмол мэдээлж, тайлагнана.
*/Энэ хэсгийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар нэмсэн/*

**Зургаа. Бусад**

6.1.Журмын хэрэгжилт, хувийн биржийн үйл ажиллагаанд Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн төв бирж, холбогдох бусад байгууллагаас хяналт тавих бөгөөд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэж болно. Энэхүү журмыг зөрчигчдөд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ. /Энэ хэсэгт Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/116 дугаар тушаалаар өөрчлөлт орсон./

6.2.Хувийн биржийг бүртгэх, санхүүжилт олгох, бүртгэлээс хасахтай холбоотой гомдол, маргааныг Төв биржид гаргах ба маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхэд хандаж болно.

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар А/116

## ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөрийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/123 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам”-д дор дурдсан заалт нэмсүгэй.

1.1/ 2.4.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9.4-т заасныг зөрчсөн буюу хувийн бирж нь ажилд зуучлуулсан иргэнээс шууд ба шууд бус байдлаар үйлчилгээний төлбөр авсан.

1.2/ 2.5. Бүртгэлийн гэрчилгээг 2 жилийн хугацаатай олгоно.

1.3/ 2.6. Хувийн биржийн албан хүсэлт, төв бирж тэй байгуулсан гэрээний биелэлтийн үнэлгээ, дүгнэлтийг тус тус үндэслэн гэрчилгээний хугацааг 2 жилээр сунгана.

1.4/ 3.5. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон их сургууль, дээд сургуулиудад суралцагсдыг суралцаж байх үеэс нь ажил олгогчтой холбох үйл ажиллагааг зохион байгуулна.

1.5/4.1.7. Хувийн биржийн үйл ажиллагаанд жилд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд гэнэтийн шалгалт хийнэ.

1.6/ 5.5. Ажил хайгчийг ажилд зуучлагдан орж тогтвортой ажиллах хугацааг харгалзан санхүүжилтийг тарифаар тооцон давхардуулахгүйгээр олгоно.

1.7/ 5.6. Төв бирж нь хувийн биржийн үйл ажиллагааны мэдээ, тайланг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагад тогтмол мэдээлж, тайлагнана.

2.Хөдөлмөрийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/123 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4.6 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгээс “аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс” гэснийг тус тус хассугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн төв бирж /С.Чойноров/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баянмөнх/-д, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлого зохицуулалтын газар /Г.Сувдаа/-д тус тус даалгасугай.

САЙД Г.БАЯРСАЙХАН

# ХӨДӨЛМӨРИЙН САЙД, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2016 оны 06 дугаар сарын 24-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар № А165/А266

## Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, хөдөлмөр эрхлэх насны залуучуудад мэргэжил сонгох, суралцах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “*Ажил, мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх чиглэл”-ийг нэгдүгээр, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар* хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн яамны төрийн нарийн бичгийн дарга /Ю.Идэрцогт/, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төрийн нарийн бичгийн дарга /Ш.Булга-Эрдэнэ/ нарт тус тус даалгасугай.

3.Чиглэл, төлөвлөгөөний хэрэгжилтийн шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөртэй уялдуулан санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөрийн яамны төрийн нарийн бичгийн дарга /Ю.Идэрцогт/, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төрийн нарийн бичгийн дарга /Ш.Булга-Эрдэнэ/ нарт тус тус даалгасугай.

Хөдөлмөрийн сайд Г.БАЯРСАЙХАН

Боловсрол, соёл,
Шинжлэх ухааны сайд Л.ГАНТӨМӨР

*Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл,*
*шинжлэх ухааны сайдын 2016 оны А165/А266 дугаар*
*тушаалын нэгдүгээр хавсралт*

# АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ /2016-2020 он/

## Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий нийтийн нийгэм, эдийн засаг, техник, технологийн хурдацтай өөрчлөлтийн хирээр хүн насан туршдаа сурч боловсрох, ажил мэргэжлээрээ өсч хөгжих, сонголт хийх хэрэгцээ тулгарч, тэдэнд дэмжлэг үзүүлэх, зөв мэдээллээр хангахад чиглэсэн үйлчилгээ, салбар хоорондын зохицуулалт бүхий ажил, мэргэжлийн чиг баримжааны тогтолцоог хөгжүүлэх шаардлага урган гарч байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна”, “Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна” зорилтын хүрээнд “Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх”, “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-д “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг багасгаж, боловсрол, ур чадвар, ажил мэргэжлийн үл нийцлээс үүдэлтэй ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх” зорилтын хүрээнд “хөдөлмөрийн хүмүүжлийг боловсролын үйлчилгээний бүх шатанд олгож, суурь боловсролын түвшнээс эхлэн ажил, мэргэжлийн зөв хандлагыг төлөвшүүлэх”, Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д “Бүрэн дунд боловсролыг сонголттой, уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий, ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлэхээр тус тус заасан нь ажил, мэргэжлийн чиг баримжааны чиглэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Монгол Улсад 2009 оноос хойш ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Монголын Мянганы сорилтын сан, Швейцарийн хөгжлийн агентлаг, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Азийн хөгжлийн банк зэрэг Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн.

Үүнтэй уялдан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд энэ үйлчилгээг хуульчилж, төрийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүтэц, мэргэжилтний орон тоо бий болсноор хууль эрх зүйн орчин бэхжиж, иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй хүргэх төрийн бодлого хэрэгжих үндэс суурь бий болсон юм.

Сүүлийн жилүүдэд энэ үйлчилгээг хөгжүүлэхэд Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодын үүрэг оролцоо нэмэгдэж, хүний нөөцийг чадавхижуулах, ном, гарын авлага гаргах, төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх зэргээр төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бэхжиж байна.

Гэвч энэ үйлчилгээ нь аль нэг төрийн байгууллага дангаараа хариуцан гүйцэтгэх ажиллагаа биш, оролцогч талуудын хамтын ажиллагаагаа, ялангуяа хөдөлмөрийн болон боловсролын байгууллагын тэргүүлэх оролцоотойгоор илүү үр дүнтэй болдогийг олон улсын туршлага харуулж байна.

Иймд эрх зүйн орныг боловсронгуй болгох, салбар хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоо, удирдлага зохион байгуулалтын механизмыг бий болгож, хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах, үйлчилгээний нэгдсэн стандартыг бий болгох, зорилтот бүлгийн иргэдийн онцлогт тохирсон үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлэх замаар ажил мэргэжлийн чиг баримжааны тогтолцоог бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

1.2. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд дор дурдсан иргэнийг хамруулна. Үүнд:

1.2.1. Хүүхэд, залуучууд;

1.2.1.1. ЕБС-ийн ахлах ангийн суралцагч,

1.2.1.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч

1.2.1.3. их, дээд сургууль, коллежийн оюутан;

1.2.1.4. албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн;

1.2.1.5. эцэг эх, асран хамгаалагчид;

1.2.2. Насанд хүрэгчид;

1.2.2.1. ажил хайгч иргэн;

1.2.2.2. хугацаат цэргийн албан хаагч;

1.2.2.3. хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирж буй иргэн;

1.2.2.4. гадаадад ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэн;

1.2.2.5. тэтгэврийн насны иргэн;

1.2.3. Эмзэг болон эрсдэлтэй бүлгийн иргэн;

1.2.3.1. хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

1.2.3.2. эмзэг, эрсдэлтэй бүлгийн иргэн;

1.2.3.3. хорих ангид хүмүүжигчид болон суллагдсан иргэн;

1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд:

1.3.1. Төрийн байгууллага;

1.3.2. Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо;

1.3.3. Аж ахуйн нэгж байгууллага;

1.3.4. Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр.

## Хоёр. Баримтлах зарчим

2.1. Чиглэлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана. **Үүнд:**

2.1.1.Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон бусад салбарын бодлогуудтай нягт уялдуулан, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;

2.1.2.Төрийн болон Төрийн бус байгууллага, ажил олгогч, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоод, үйлчлүүлэгч зэрэг оролцогч талуудын зохистой түншлэл, оролцоог хангах;

2.1.3.Мэдээллийн нээлттэй байдал, тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээнд суурилсан уян хатан үйл ажиллагааг харилцан уялдаатай авч үзэж, эргэх холбоог сайжруулах.

## Гурав. Зорилго, зорилт

3.1. Иргэн бүрийн насан туршдаа сурч боловсрох, ажил хөдөлмөрийн сонголтоо хийх, ажил мэргэжлийн замаа удирдан хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь туслах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, арга зүйн удирдлагын нэгдмэл тогтолцоо бүрдүүлэхэд оршино.

3.2. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.2.2. ажил, мэргэжлийн чиг баримжааны салбар хоорондын зохицуулалтын механизмыг бий болгох;

3.2.3. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх чиглэлээр хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхижуулах;

3.2.4. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлж, зорилтот бүлгийн иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх;

3.2.5. эмзэг эрсдэлтэй болон нийгмээс тусгаарлагдсан иргэдийг боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд тэгш хамруулах ажлыг уялдуулан зохион байгуулах.

## Дөрөв. Хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

4.1. Чиглэлийг 2016-2020 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат 2016-2018 он
Хоёрдугаар үе шат 2018-2020 он

4.2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

4.2.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг хөгжүүлэх эрэлт хэрэгцээг харгалзан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.2.2.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний нэгдсэн стандарт боловсруулж, хэрэгжүүлэх.

4.3. Ажил, мэргэжлийн чиг баримжааны салбар хоорондын зохицуулалтын механизмыг бий болгох зорилтын хүрээнд:

4.3.1.оролцогч талууд хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, тус санамж бичигт талуудын үүрэг оролцоог нарийвчлан тусгаж өгөх;

4.3.2.боловсролын байгууллагын удирдлага, менежер, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн зах зээлийн талаарх зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргийг тусгах;

4.3.3. боловсрол, мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн цогц бөгөөд уялдаа холбоо бүхий мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

4.3.4. хөдөлмөр эрхлэлт, боловсролын салбарын бодлого төлөвлөлтөд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх;

4.3.5.хоёр жилд нэг удаа холбогдох яамд, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагууд хамтран дэд чуулга уулзалт зохион байгуулах.

4.4. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх чиглэлээр хүний нөөцийг үе шаттай чадавхижуулах зорилтын хүрээнд:

4.4.1.багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох агуулгыг тусгах;

4.4.2.ЕБС-ийн ахлах анги удирдсан багш, Насан туршийн боловсролын төвийг багш нарыг суралцах чиглэл, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох арга зүйд сургах;

4.4.3.хөдөлмөр эрхлэлтийн албаны мэргэжилтнүүд, боловсролын бүх шатны байгууллагын нийгмийн ажилтан, нийгмийн түншлэл хариуцсан ажилтан, иргэний нийгмийн байгууллагын холбогдох ажилтнуудыг үе шаттай сургалтад хамруулж мэргэшүүлэх;

4.4.4.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургагч багш нарт зориулсан цахим мэдээллийг хөгжүүлж, арга зүйн гарын авлагаар хангах;

4.4.5.ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох мэргэжилтнүүдийг дотоод, гадаадад туршлага судлах, танилцах аялал хийх замаар мэдлэг, ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

4.5Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлж, зорилтот бүлгийн иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд:

4.5.1.зорилтот бүлгийн иргэнд ажил, мэргэжлээ сонгох, ажил хайх, ажил мэргэжлээрээ өсч хөгжих, хувь хүний хөгжил, төлөвшил болон сэтгэл зүйн сургалтыг тогтмол, үе шаттай, нэгдсэн зохион байгуулалттайгаар хүргэх;

4.5.2.оюутан, сурагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, дадлагажих нөхцлийг бүрдүүлэх замаар ажил мэргэжилтэй бодитой танилцах боломжийг нэмэгдүүлэх;

4.5.3.Албан бус-Насан туршийн боловсролын төв, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын дэргэдэх иргэн, оюутанд үйлчлэх төвүүд зэрэг хөдөлмөр эрхлэлт, боловсролын үйлчилгээг дэмжих бүтцийг оновчтой ашиглаж, ажил мэргэжлийн чиг баримжааны хүртээмжийг өргөжүүлэх;

4.5.4.ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээний загвар төвийг байгуулахыг дэмжиж, тухайн орон нутгийн иргэн ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийн зах зээлд идэвхитэй оролцоход туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

4.5.5.техник технологийн дэвшилтэт шинэлэг хэлбэрүүдийг ашиглан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг цахим хэлбэрээр иргэнд хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлэх;

4.5.6.зорилтот бүлэгт зориулсан ном, гарын авлага боловсруулах;

4.5.7.ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, иргэдийг мэргэшсэн зөвлөх/мэргэжилтнээс үйлчилгээ авах соёлд сургах.

4.6. Эмзэг эрсдэлтэй болон нийгмээс тусгаарлагдсан иргэдийг боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд тэгш хамруулах ажлыг уялдуулан зохион байгуулах зорилтын хүрээнд:

4.6.1.хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан байгууллагаар дамжуулан мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үзүүлэх;

4.6.2.нийгмийн халамж, туслалцаа зайлшгүй шаардлагатай гэр бүл, гэр бүлийн гишүүнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

4.6.3.хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хорих ангид хүмүүжигч, хорих ангиас суллагдсан иргэдийн онцлогт тохирсон ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх;

4.6.4.тусгай хэрэгцээт боловсролын байгууллагын сурагчдыг ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамруулах.

**Тав. Үр дүн**

5.1. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд хүрэх үр дүн:

5.1.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.

5.1.2.ажил, мэргэжлийн баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний нэгдсэн стандарт бий болсон байна.

5.2. Ажил, мэргэжлийн чиг баримжааны салбар хоорондын зохицуулалтын механизмыг бий болгох зорилтын хүрээнд хүрэх үр дүн:

5.2.1.хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан байна.

5.2.2.холбогдох талууд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлдэг болсон байна.

5.2.3.мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байна.

5.2.4.дэд чуулга уулзалт зохион байгуулагдсан байна.

5.2.5.боловсрол, ур чадвар, ажил мэргэжлийн үл нийцлээс үүдэлтэй ажилгүйдэл буурна.

5.3. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх чиглэлээр хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхижуулах зорилтын хүрээнд хүрэх үр дүн:

5.3.1.багш бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох агуулгыг тусгасан байна.

5.3.2.ЕБС-ийн дунд болон ахлах анги удирдсан багш нарыг суралцах чиглэл, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох арга зүйд сургасан байна.

5.3.3. ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ цар хүрээ өргөжиж, хүртээмж нэмэгдсэн байна.

5.3.4.ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажилтны мэргэшил, мэргэжил, ур чадвар дээшилсэн байна.

5.3.5.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх мэргэжилтнийг бакалавр ба дээш түвшинд бэлтгэж эхэлсэн байна.

5.3.6.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх, сургагч багш нарт зориулсан цахим болон хэвлэмэл гарын авлагатай болсон байна.

5.3.7.холбогдох мэргэжилтнүүд мэдлэг, ур чадвараа хөгжүүлсэн байна.

5.4. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний төрөл хэлбэрийг өргөжүүлж, зорилтот бүлгийн иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд хүрэх үр дүн:

5.4.1.зорилтот бүлгийн иргэд сургалтад хамрагдсан байна.

5.4.2.сурагчид, оюутнууд суралцах болон ажиллах сонголт хийхээсээ өмнө тэдгээрийг судлах, турших, танилцах боломж бүрдсэн байна.

5.4.3.албан бус-Насан туршийн боловсролын төв, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын дэргэдэх оюутанд үйлчлэх төвүүд дэх мэргэшсэн зөвлөхөөс ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ авах хүртээмж нэмэгдэнэ.

5.4.4.ажил, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний загвар төвүүдийн тоо нэмэгдсэн байна.

5.4.5.иргэд техник технологийн дэвшилтэт шинэлэг хэлбэрүүдийг ашиглан орон зай, цаг хугацаа харгалзахгүй хэрэгцээтэй мэдээллээ авна.

5.4.6.зорилтот бүлэгт зориулсан ном, гарын авлага гарсан байна.

5.4.7.иргэд ажил, мэргэжлийн чиг баримжааны мэргэшсэн зөвлөхөөс мэдээлэл, зөвлөгөө авах соёлд суралцсан байна.

5.5. Эмзэг эрсдэлтэй болон ниймгээс тусгаарлагдсан иргэдийг боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд тэгш хамруулах ажлыг уялдуулан зохион байгуулах зорилтын хүрээнд хүрэх үр дүн:

5.5.1. нийгмийн хамгааллын байгууллагын холбогдох ажилтан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлдэг болсон байна.

5.5.2. холбогдох орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, эмзэг эрсдэлтэй болон нийгмээс тусгаарлагдсан иргэдэд хүрэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.

5.5.3. эмзэг эрсдэлтэй болон нийгмээс тусгаарлагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

## Зургаа. Санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

6.1.1. Улсын төсөв;

6.1.2. Орон нутгийн төсөв;

6.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжлийн боловсрол, сургалтын сан, бусад сангаас хуваарилагдсан хөрөнгө;

6.1.4. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, зээл, төслийн санхүүжилт;

6.1.5. Бусад эх үүсвэр.

6.2. Шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөв болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган батлуулж, санхүүжүүлнэ.

## Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, нэгтгэн тайлагнах хугацаа

7.1.1. 2016-2020 онд холбогдох бусад төсөл хөтөлбөртэй уядлуулан зохион байгуулах бөгөөд ерөнхий удирлага, зохицуулалт, хяналтыг хөдөлмөр болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

7.1.2.аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтэс нь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөх үйлчилгээний мэдээг улирлаар гаргаж, дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн дэд төвд хүргүүлнэ.

7.1.3.аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтэс нь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөх үйлчилгээний мэдээг улирлаар гаргаж, дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн дэд төвд хүргүүлнэ.

7.1.4.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн газар газар, хэлтэс нь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөх үйлчилгээний мэдээг улирлаар гаргаж, дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор эрхлэлтийн

үйлчилгээ, судалгаа, мэдээллийн дэд төвд хүргүүлнэ.

7.1.5. хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн дэд төв нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирлаар гаргаж, дараа улирлын 15-ны өдрийн дотор хөдөлмөр болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүргүүлнэ.

7.1.6. тухайн жилд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтэд жил бүр үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, тайланг Засгийн газарт танилцуулна.

7.1.7. хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаархи мэдээ, тайланг холбогдох байгууллагууд цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

7.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, санал зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа

7.2.1. үр дүнд суурилсан 1 дүгээр үе шатны үнэлгээг 2018 оны 4 дүгээр улиралд багтааж, дунд хугацаанд зорилтот түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргана.

7.2.2. үр дүнд суурилсан нэгтгэн дүгнэх үнэлгээг 2020 оны 4 дүгээр улиралд багтааж, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг эцсийн байдлаар үнэлж, үр дүн, үр нөлөөг тодорхойлон, цаашдын бодлого боловсруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргана.

---oOo---

# ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар А/216/А/104

## Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйл, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Мэргэжлийн сургалтын байгууллагын гэрчилгээний загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, биелэлтэд хяналт тавьж ажилллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөрийн сайдын 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/136, А/271 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Н.НОМТОЙБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД Ж.БАТСУУРЬ

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд*
*2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 3668 дугаарт бүртгэв.*

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны А/216/А/104 тушаалын нэгдүгээр хавсралт*

# "МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БҮРТГЭХ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ"

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.2.Энэхүү журмаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардагдах нэгж буюу бүлэг ажилбарыг гүйцэтгэх арга барил, техник, технологийн анхан шатны мэдлэг, чадвар, дадлыг тодорхой ажил мэргэжлийн чадамжийн хүрээнд эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох богино хугацааны мэргэжлийн сургалтын /цаашид "сургалт" гэх/ үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэхүү журмын хүрээнд мэргэжлийн чадамж эзэмшүүлэх, хөдөлмөрийн болон бизнес эрхлэх үндсэн мэдлэг, чадвар олгох сургалтууд эрхлэх байгууллагуудын үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

1.3.1.иргэнд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтын төрөлд мэргэжлийн болон техник, технологийн суурь мэдлэг эзэмшүүлэх сургалтууд хамаарна.

1.3.2.иргэнд хөдөлмөрийн болон бизнес эрхлэх үндсэн мэдлэг, чадвар, эзэмшүүлэх сургалтад хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох, аж ахуй, бизнес эрхлэх чадамж олгоход чиглэгдсэн сургалтууд хамаарна.

1.4.Энэ журмын 3.1-т заасан шаардлагыг хангаан бүртгүүлсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж зохион байгуулна.

1.5.Шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэж, улсын хэмжээнд нэгдсэн загвартай, бүртгэлийн дугаар бүхий бүртгэлийн гэрчилгээ олгоно.

1.6.Энэ журмын хэрэгжилтийг хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "Агентлаг" гэх/ эрхлэн зохион байгуулна.

1.7.Агентлаг нь мэргэжлийн сургалтын байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг бий болгон баяжуулж, мэдээллийг түгээнэ.

## Хоёр. Мэргэжлийн сургалтын зорилго, хамрах хүрээ

2.1.Мэргэжлийн сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, чадамж эзэмшүүлэхэд оршино.

2.2.Сургуулиас гадуурх мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагааны чиглэлээр барилга, уул уурхай, зам

тээвэр, эрчим хүч, хөдөө аж ахуй, үйлдвэр, үйлчилгээний салбар, хэл, компьютер, урлаг, эдийн засаг, санхүү, бариа заслын төрлөөр тусгай хөтөлбөрийн дагуу мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэх чадамжид суурилсан сургалтыг явуулна.

2.3.Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу зохион байгуулагдах шашны сургалт болон шашинтай холбоотой зан заншил, холбогдох сургалт, үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулахгүй.

## Гурав. Мэргэжлийн сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага

3.1.Мэргэжлийн сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: /Нотолсон баримт бичгийн хамт/

3.1.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан хуулбар /;

3.1.2.хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, ажил олгогчийн хэрэгцээнд үндэслэн боловсруулж, үйл ажиллагаа эрхлэх байршил дахь мэргэжлийн боловсролын бүсийн арга зүйн төвөөр эсхүл мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал эрхэлсэн байгууллагаар мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг батлуулсан байх;

3.1.3.мэргэжлийн сургалтын төвийн багш нь мэргэжлийн зэрэгтэй, тухайн чиглэлээр 3-аас доошгүй жилийн ажлын дадлага, туршлагатай, мэргэжлийн боловсрол, сургалтын заах арга зүйн сургалтад хамрагдаж, багшлах эрх авсан байх;

3.1.4.мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрт заагдсан, мэргэшлийн түвшний шаардлагад нийцсэн сургалтын орчин, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан байх;

3.1.5.өөрийн байранд дадлага хийлгэх боломжгүй тохиолдолд байгууллага аж ахуйн нэгж, үйлдвэрийн газартай гэрээ байгуулж, дадлагын сургалт зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн байх;

3.1.6. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх;

3.1.7.суралцагчидтай байгуулах гэрээний загварыг баталгаажуулсан байх;

3.1.8.мэргэжлийн сургалтын байгууллага нь сургалтын төлбөр тогтоосон шийдвэрээ албажуулсан байх ба хэт өндөр төлбөр тогтоохгүй байх;

3.1.9.шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, харьяа дүүргийн нийгмийн даатгал, татварын алба болон харилцагч банкнаас санхүүгийн болон байгууллагын чадамжаа илэрхийлсэн тодорхойлолт тус тус авсан байх.

3.2.Мэргэжлийн сургалтын байгууллага нь суралцагчдын ирц, багшийн журнал, холбогдох бүртгэл хөтөлнө.

3.3.Мэргэжлийн сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа болон төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар, чадамжийг мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал эрхэлсэн байгууллагаар хийлгэх хүсэлт гарган, үнэлгээ хийлгэж, эзэмшсэн ур чадвар, чадамжийг баталгаажуулсны үндсэн дээр төгсөгчдөд чадамжийн гэрчилгээ олгоно.

## Дөрөв. Мэргэжлийн сургалтын агуулга, хөтөлбөр

4.1.Мэргэжлийн сургалтын агуулга нь нэгж буюу бүлэг ажилбарт хуваагдсан тодорхой түвшний ур чадвар эзэмшүүлэх, чадамжийн нэгжээс бүрдсэн, суралцагч сонгон суралцах боломжийг хангасан байна.

4.2.Мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд болон аж ахуй, бизнес эрхлэхэд шаардагдах мэргэжлийн суурь мэдлэг, ур чадвар, чадамж, дадал эзэмшүүлэхэд чиглэсэн байна.

4.3.Мэргэжлийн сургалтын байгууллага нь суралцагчдад үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, технологийн чиглэлээр шинэ техник эзэмших, өөрчлөлтөд зохицож хөгжих, тодорхой мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай техникийн суурь мэдлэг, чадвар эзэмшүүлнэ.

4.4.Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн боловсролын бүсийн арга зүйн төв болон мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал эрхэлсэн байгууллага 30 хоногийн дотор хянан дүгнэлт гаргаж батална.

## Тав. Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, гэрчилгээ олгох

5.1.Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлэх хүсэлт гаргаж буй хуулийн этгээд нь энэхүү журмын 3.1-т заасан шаардлагын дагуу материал бүрдүүлж, агентлагт албан бичгээр хандана.

5.2.Агентлаг нь ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгээр хэлэлцүүлэн, шаардлага хангасан эсэх талаарх дүгнэлтийг 30 хоногийн дотор гаргаж, хариу мэдэгдэнэ.

5.3.Шаардлага хангасан тухай дүгнэлт хүлээн авсан байгууллага нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хураамжийг харьяалах татварын албанд байршуулсны дараа бүртгэлийн гэрчилгээг олгоно.

## Зургаа. Мэргэжлийн сургалтын байгууллагын гэрчилгээний хүчинтэй хугацаа, эрх сунгах, хасах

6.1.Мэргэжлийн сургалтын байгууллагад олгох гэрчилгээ нь улсын хэмжээнд нэгдсэн загвартай байх, бүртгэлийн он, сар, өдөр, дугаар болон хүчинтэй хугацааг заасан байна.

6.2.Мэргэжлийн сургалтын байгууллагад олгох гэрчилгээний дугаар давхцахгүй байна.

6.3.Бүртгэлийн гэрчилгээг 2 жил хүртэл хугацаагаар олгох ба мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх тухай агентлагийн даргын тушаалын хамт хүчин төгөлдөр болно.

6.4.Мэргэжлийн сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлтээ гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө гаргана.

6.5.Мэргэжлийн сургалтын байгууллага бүртгэлийн гэрчилгээг сунгуулах хүсэлтэд энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа явуулсан тайлан, төгсөгчдийн ур чадварыг үнэлүүлсэн дүнгийн хавсралтын хамт агентлагт ирүүлнэ.

6.6.Агентлаг нь гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах талаарх шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, хариу мэдэгдэнэ.

6.7.Агентлаг нь мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангаагүй, бүртгэлийн гэрчилгээний хугацаа дууссан, сунгалт хийгдээгүй байхад сургалтын үйл ажиллагаа явуулсан болон мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал эрхэлсэн байгууллагаар хийгдсэн суралцагчдын чадамжийн үнэлгээний үр дүн шаардлага хангахгүй байгаа тохиолдолд зөрчлийг арилгуулах, шаардлага хүргүүлэх, бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авна.

## Долоо. Удирдлага, зохион байгуулалт

7.1.Агентлаг нь мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг чиг үүргийн дагуу томилон ажиллуулна.

7.2.Мэргэжлийн сургалтын байгууллагуудын мэдээллийн санг бүрдүүлэх, хяналт тавих, тайлан гаргах үүргийг агентлаг хариуцна.

7.3.Агентлаг, мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал эрхэлсэн байгууллага болон мэргэжлийн боловсролын бүсийн арга зүйн төв нь сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган, дэмжиж ажиллана.

## Найм. Хяналт, тайлан мэдээ

8.1.Агентлаг нь гэрчилгээ олгосон мэргэжлийн сургалтын байгууллагуудын мэдээллийн санг үүсгэн тухай бүр баяжилт хийнэ.

8.2.Агентлаг нь гэрчилгээ олгосон сургалтын байгууллагуудын бүртгэлийн талаарх мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.

8.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

8.4.Мэргэжлийн сургалтын байгууллага нь үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээг хагас жилээр жил бүрийн 6 дугаар сарын 30-ны дотор, жилийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 30-ны дотор гарган аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

8.5.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн сургалтын байгууллагуудын тайланг нэгтгэн хагас жилээр жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 5-ны дотор агентлагт хүргүүлнэ.

8.6.Агентлаг нь мэргэжлийн сургалтын байгууллагуудын жилийн эцсийн тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

---oOo---

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны А/216/А/104 тушаалын хоёрдугаар хавсралт*

## Мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн **ГЭРЧИЛГЭЭ**

..........оны......сарын......өдөр Дугаар........ Улаанбаатар хот

Шийдвэрийн дугаар............ Огноо ................

*Шаардлага хангасан мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгов.*

Аймаг, хот: ..........................................................................................................................

Сургалтын байгууллагын нэр: ...........................................................................................

Сургалтын төрөл: ...............................................................................................................

Байгууллагын хаяг, удирдлагын нэр: ................................................................................

Хүчинтэй байх хугацаа: .... оны.... сарын ....... өдөр

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний
ерөнхий газрын дарга : /............................./ /......................./
/Нэр/ /Гарын үсэг/

Сунгалтын хугацаа: .... оны .... сарын ....... өдөр

Шийдвэрийн дугаар.............. Огноо................................

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний
ерөнхий газрын дарга : /............................./ /......................./
/Нэр/ /Гарын үсэг/

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар сарын 19-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 22

## Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хanган ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Мэндбаяр)-т даалгасугай.

3. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Үндэсний зөвлөлийн ажлын алба (Б.Болормаа)-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны 21, 2016 оны 03 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА С.ЭРДЭНЭ

*Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн*
*2016 оны 22 дугаар тогтоолын хавсралт*

# АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль”-ийн дагуу ажилгүйдлийн даатгалын сан (цаашид “сан” гэх)-гаас тэтгэмж олгохтой холбоотой асуудлаар нийгмийн даатгалын байгууллага, даатгуулагч (иргэн), хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага нь даатгуулагч (иргэн)-ийн ажилгүйдлийн тэтгэмж хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцож олгох, тэтгэмж авч буй иргэн ажилд орсон эсэхэд хяналт тавих, ажилгүйдлийн тэтгэмж авагч мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдсан тохиолдолд уг сангаас сургалтын зардлыг санхүүжүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

1.3. Ажилгүйдлийн тэтгэмж авагчийн тэтгэмжийн бодолт, олголт, мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдсан эсэхэд Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага хяналт тавина.

1.4. Хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага (ажилтан) (цаашид “Хөдөлмөрийн байгууллага” гэх) нь ажилгүй болсон даатгуулагчийг бүртгэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, төсөл, хөтөлбөрт хамрагдах боломж, хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдээллээр хангаж, зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах, ажилгүйдлийн тэтгэмж авагчийг түр болон байнгын ажилд зуучлан оруулсан бол мэдээллийг тухай бүрт уг иргэний харьяалах нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэн хамтран ажиллана.

1.5. Хөдөлмөрийн байгууллага нь шинээр мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдах хүсэлт гаргасан ажилгүйдлийн тэтгэмж авагчийг ажилгүй болсноос хойш 6 сарын дотор эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамруулна. Хөдөлмөрийн байгууллага нь эрх бүхий сургалтын байгууллагатай гэрээ байгуулж, сургалтад хамрагдсан ажилгүйдлийн тэтгэмж авагчийн тоо, сургалтын зардлын гүйцэтгэлийн сар, улирлын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хугацаанд харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

## Хоёр. Хамрах хүрээ

2.1.”Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль”-ийн 2 дугаар зүйлд заасан нөхцөл, болзлыг хангасан, “ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа, хөдөлмөрийн насны иргэн”-д ажилгүйдлийн тэтгэмж олгоно.

2.2. Энэ журмын 2.1-д заасан “ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны иргэн” гэж Хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй, уг байгууллагаас санал болгосон ажилд ороход бэлэн, ажилгүй байгаа хүнийг хэлнэ.

## Гурав.Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх

3.1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан нөхцөл, болзлыг хангасан даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй.

3.2. Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсан, цалингүй чөлөө авсны улмаас тухайн сард бүтэн ажиллаагүй боловч ажилласан хугацаанд ногдох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д заасан хувиар тооцож, нийгмийн даатгалын санд шимтгэл төлсөн бол тухайн сард ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох ба энэ журмын 3.1-д заасан хуулийн нөхцөл, болзлыг хангасан бол тэтгэмж авах эрх үүснэ.

Жишээ №1: Даатгуулагч нийт 3 жил нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан, үүнээс 2015 оны 11 дүгээр сарын 01-ээс 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл ажиллаж, 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс ажлаас чөлөөлөгдсөн. Тухайн даатгуулагч 2016 оны 03 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 10-ныг дуустал хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авч, 03 дугаар сарын 11-ний өдрөөс ажиллан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн гэвэл түүний шимтгэл төлж ажилласан 10 хоног (ажлын)-ийг тухайн сард нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлснөөр тооцох тул, түүнд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ.

3.3. Даатгуулагч ажлаас халагдсан тухайн сардаа бүтэн ажиллаагүй бол түүний ажлаас халагдсан тушаал, шийдвэр, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон сарын өмнөх саруудад Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-д заасан ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг хангаж байвал ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ.

Жишээ №2: Даатгуулагч нийтдээ 3 жил ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлж, ажиллаж байгаад 2016 оны 06 дугаар сарын 18-ны өдөр ажлаасаа халагдсан гэвэл уг даатгуулагч 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө 9 сард нь тасралтгүй шимтгэл төлсөн байх тул түүнд ажилгүйдлийн тэтгэмж тогтоож олгоно.

Жишээ №3: Даатгуулагч 2009-2013 он хүртэл 4 жил ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлж, ажиллаад хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон. (тухайн үед ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсээгүй) Харин "С" нь 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ажилд орж, 2016 оны 08 дугаар сарын 15-ны өдөр ажлаасаа халагдсан гэвэл "сүүлийн 9 сард нь тасралтгүй шимтгэл төлөөгүй" *(халагдсан тухайн сард нь бүтэн ажилласан гэж тооцохгүй)* гэсэн үндэслэлээр ажилгүйдлийн тэтгэмж тогтоож, олгохгүй.

3.4. Даатгуулагчийн хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд нь ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан, дампуурсан бол тухайн даатгуулагчид хүүхдээ асрах чөлөө олгосон тушаал, шийдвэр гарсан сарын өмнөх шимтгэл төлсөн хугацаа нь энэ журмын 3.1-д заасан хуулийн нөхцөл, болзлыг хангаж байвал ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй.

Жишээ №4: Даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг тасралтгүй 8 жил төлсөн, 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс хүүхдээ асрах 2 жилийн хугацаатай чөлөө авсан бөгөөд түүний ажиллаж байсан байгууллага нь 2016 оны 07 дугаар сарын 18-ны өдөр татан буугдаж, уг даатгуулагчийг мөн өдөр (18/VII)-өөс ажлаас нь чөлөөлсөн гэвэл хүүхдээ асрах чөлөө авсан 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн өмнө буюу 2014 оны 12 дугаар сар ба түүнээс өмнө 9 сард нь ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлсөн тохиолдолд даатгуулагч нь ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй.

3.5. Хүүхдээ асрах чөлөөтэй байсан даатгуулагч ажилдаа буцаж орсны дараа байгууллага нь татан буугдсан, дампуурсан бол ажилдаа буцаж орсноос хойшхи шимтгэл төлсөн хугацаа дээр хүүхдээ асрах чөлөө олгосон тушаал, шийдвэр гарсан сарын өмнөх шимтгэл төлсөн хугацааг нэмэхэд энэ журмын 3.1-д заасан хуулийн нөхцөл, болзлыг хангаж байвал ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй.

3.6. Үндсэн ажлаас гадуур байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу давхар ажил эрхэлж байгаа даатгуулагч зөвхөн үндсэн ажлаасаа халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгоно.

3.7. Даатгуулагч (иргэн) үндсэн ажлаас халагдсаны дараагийн өдрөөс эхлэн давхар ажиллаж буй аль нэг байгууллагын үндсэн даатгуулагчаар шилжин Нийгмийн даатгалын тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилласан тохиолдолд түүнд ажилгүйдлийн тэтгэмж олгохгүй.

## Дөрөв. Ажилгүйдлийн тэтгэмжийг тооцож олгох

4.1. Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр тооцож олгоно.

4.2. Даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг дор дурдсан аргачлалаар тооцож тодорхойлно:

4.2.1.Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг тооцох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджийг тодорхойлохдоо энэ журмын 4.1-т заасан 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг “3”-д хуваах;

4.2.2.“Нэг сард ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ”-г тооцохдоо энэ журмын 4.2.1-д заасан сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджийг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д заасан шимтгэл төлж ажилласан хугацаа (жил)-нд харгалзах хувь хэмжээгээр үржүүлж 100-д хуваах;

4.2.3.“Ажлын нэг өдөрт ногдох тэтгэмжийн хэмжээ“-г тооцохдоо энэ журмын 4.2.2-д заасан нэг сард ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг сарын ажлын өдрийн дундаж тоо (21.2 өдөр)-нд хуваах;

4.2.4.”Тухайн даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ”-г тогтоохдоо энэ журмын 4.2.3-д заасан ажлын нэг өдөрт ногдох тэтгэмжийн хэмжээг ажлын 76 өдрөөр үржүүлж тодорхойлно.

Жишээ №5: Даатгуулагч 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 16 жил ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн, 2016 оны 03 дугаар сард 400 000

төгрөг, 04 дүгээр сард 380 300 төгрөг, 05 дугаар сард 390 000 төгрөгийн хөдөлмөрийн хөлс авч байсан бөгөөд тэрээр 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажлаас халагдсан гэвэл түүнд олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг энэ журмын 4.2-т заасны дагуу дараах байдлаар тооцно:

а/Даатгуулагч 16 жил шимтгэл төлж ажилласан тул ажилгүйдлийн тэтгэмжийг сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 70 хувиар бодно.

б/Сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дундаж хэмжээ:

(400 000 төг + 380 300 төг + 390 000): 3 = 390 100 төгрөг.

в/Нэг сард ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

390 100 төг х 70% : 100% = 273 070 төгрөг.

г/Ажлын нэг өдөрт ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

273 070 төг : 21.2 өдөр = 12 880.66 төгрөг

д/Даатгуулагч “Ц”-д олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

12 880.66 төг х 76 өдөр = 978 930.16 төгрөг.

4.3. Тухайн иргэн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон боловч анх тэтгэмж олгохоор тогтоосон хугацаа дуусахаас өмнө ажлаас халагдсан тохиолдолд түүнд үлдэх хугацаанд ногдох тэтгэмжийг урьд авч байсан хэмжээгээр нь үргэлжлүүлэн ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно.

Жишээ №6: Ажилгүйдлийн тэтгэмж авагч “Б” нь ажлын 15 өдрийн тэтгэмж авсны дараа түр ажилд ороод ажлын 20 өдрийн дараа халагдсан гэвэл түүнд ажлын 61= (76-15) өдрийн тэтгэмж олгоно.

Тайлбар[1]: Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-д “Даатгуулагч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар болон бусад хэлбэрээр түр ажил, хөдөлмөр эрхэлсэн бол түүний тэтгэмжийг түдгэлзүүлэн зогсоож тэтгэмж олгох хугацааг уг ажил, хөдөлмөр гүйцэтгэсэн хоногоор сунгана.” гэж заасан.

Жишээ №7: Ажилгүйдлийн тэтгэмж авагч “Г” нь ажлын 5 өдрийн ажилгүйдлийн тэтгэмж авсны дараа түр ажилд ороод ажлын 85 өдрийн дараа халагдсан бол түүнд ажлын 71 өдрийн тэтгэмж олгоно. {71=(76-5)}

Жишээ №8. Ажилгүйдлийн тэтгэмж авагч ажлын 10 өдрийн ажилгүйдлийн тэтгэмж авч байгаад ажилд орж ажлын 107 өдрийн дараа халагдсан гэвэл ажилгүйдлийн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгохгүй.

Тайлбар[2]: Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д ”Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрийн хугацаанд олгоно.” гэж, мөн Үндэсний статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 01-68/94 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ын 2.12.1.2-д “түр ажилтан”-д хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах татвар, нийгмийн даатгалын

шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг хамруулна.” гэж тус тус заасныг үндэслэн ажлын 106 (5 сар*21.2 өдөр) өдрөөс дээш хугацаагаар ажил хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгохгүй гэж ойлгоно.

4.5. Энэ журмын 3.2, 3.3-т заасан тохиолдолд болон ажил олгогч нь Хөдөлмөрийн хуулийн 56.2 дахь заалтад заасны дагуу ажилтандаа сул зогсолтын олговор олгосон тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж бодох цалин хөлс, орлогын дунджийг тодорхойлохдоо тухайн даатгуулагчийн сүүлийн 3 сард бүтэн ажиллаж авсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг үндэслэн тооцно. Хэрэв тухайн сард бүтэн ажиллаагүй боловч ажилласан хугацаанд ногдох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол энэ орлогыг ажилгүйдлийн тэтгэмж бодох дундаж цалин хөлс, орлогод оруулан тооцохгүй.

4.6. Энэ журмын 3.5-д заасан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж бодох цалин хөлс, орлогын дунджийг тодорхойлохдоо тухайн даатгуулагчийн сүүлийн 3 сард бүтэн ажиллаж авсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг үндэслэн тооцох ба ажилдаа буцаж орсноос хойш цалин авсан сар 3 сард хүрэхгүй бол хүүхдээ асрах чөлөө олгосон тушаал, шийдвэр гарсан сарын өмнөх шимтгэл төлсөн хугацааны цалинг оруулан тооцно.

4.7. Даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсаныг шүүхээс тогтоож, түүний ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгож, ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож зохих санд төлсөн тохиолдолд тухайн даатгуулагчийн ажилгүй байх хугацаанд авсан ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлүүлж, тооцоо хийнэ.

Тайлбар[3]: Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн дагуу ажилгүйдлийн тэтгэмж авагч ажилд орсон тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олголтыг зогсоодог тул нэг талаас цалин хөлс, орлогыг ажилгүйдлийн тэтгэмжтэй давхардуулан олгохгүй байх, нөгөө талаас шүүхээс уг ажилд нь буцаан томилохоор шийдвэрлэсэн нь хөдөлмөрийн гэрээ хэвээр үргэлжилнэ гэсэн үг юм.

4.8.Тухайн даатгуулагчид олговол зохих нэг өдөрт ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон 1 өдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас бага бол тэтгэмжийг дараах байдлаар тооцно.

Жишээ №9: Даатгуулагч “Б”-ийн шимтгэл төлж ажилласан сүүлийн 3 сарын цалингийн дундаж 192 000 төгрөг, шимтгэл төлж ажилласан хугацаа 4 жил гэвэл, даатгуулагч “Б”-д ажлын 76 өдрийн хугацаанд олгох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар тооцно:

а/ Нэг сард ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

192 000 төгрөг х 45% = 86 400 төгрөг

б/ Ажлын нэг өдөрт өдөрт ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

86 400 төгрөг : 21.2 өдөр = 4 075.47 төгрөг

в/ Даатгуулагч “Б”-д олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

4 075.47 х 76 өдөр = 309 735.85 төгрөг байна.

Энэ нь тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас бодсон дүнгээс бага байгаа тул даатгуулагч “Б”-д 516 226.42 (192 000 төгрөг х 75% :21.2 х 76 өдөр) төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тооцож олгоно.

## Тав. Даатгуулагчийн эрх, үүрэг

5.1. Ажлаас халагдсан даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасан хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй.

5.2. Ажлаас халагдсан (чөлөөлөгдсөн) даатгуулагч ажил олгогчтойгоо тооцоо хийж дуусcанаас хойш 14 хоногийн дотор оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ Нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлж, ажилгүйдлийн тэтгэмж тогтооход шаардлагатай дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд:

5.2.1.Өргөдөл /баталсан маягтын дагуу/

5.2.2.Нийгмийн даатгалын дэвтэр;

5.2.3.Ажлаас халсан тухай шийдвэр;

5.2.4. Иргэний үнэмлэх, түүний хуулбар;

5.2.5.Ажилгүй болсноо Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн тухай мэдэгдэх хуудас.

5.3. Даатгуулагч нь энэ журмын 5.2.2.-5.2.4-д заасан баримт бичгийг бүрдүүлэн оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяалах Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлж, мэдэгдэх хуудас авах;

5.4. Ажилгүйдлийн тэтгэмж авагч энэ журмын 6.1-д заасны дагуу нийгмийн даатгалын байгууллагаас нээсэн тэтгэмжийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох баримт бичиг, тэтгэмж тогтоолттой танилцан гарын үсэг зурж, баталгаажуулах бөгөөд тэтгэмжээ банкаар эсхүл банк дахь өөрийн харилцах, хадгаламж, төлбөрийн картаар авах эсэхээ сонгох;

5.5. Тэтгэмж авагч өөрийн сурах сонирхолтой мэргэжлийн чиглэлээ тодорхойлж, хөдөлмөрийн байгууллагатай гэрээ байгуулсан эрх бүхий сургалтын байгууллагыг сонгон суралцах;

5.6. Тэтгэмж авагч нь ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон, тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон бол энэ тухайгаа нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэн, тэтгэмж олголтыг зогсоож, тооцоо хийж, нийгмийн даатгалын дэвтрээ буцаан авна. Түр ажилд орж, дахин ажлаас халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж авах өмнө тогтоосон хугацаа дуусаагүй бол энэ журмын 5.2.2, 5.2.3-т заасан бичиг баримтыг бүрдүүлэн Нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлж, ажилгүйдлийн тэтгэмжээ үргэлжлүүлэн авах, эсэх асуудлыг шийдвэрлүүлэх;

5.7. Ажилгүй болсон даатгуулагч хүндэтгэн үзэх шалтгаан (даатгуулагч хүндээр өвчилж асруулж байсан, мөн өвчтэй хүн асарсан, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон, ажилтнаас хамаарахгүй шалтгаанаар ажил олгогчтой тооцоо хийх хугацаа хойшилсон, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллагын буруугаас шимтгэл төлөлттэй холбоотой мэдээллийн лавлагааг хугацаанд бүрдүүлээгүй, гадаад улсад зорчсон)-ны улмаас энэ журмын 6.2-д заасан хугацаанд Нийгмийн даатгалын байгууллагад өргөдөл гаргаагүй тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ 3 сарын дотор гарган Нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх;

5.8. Ажлаас халагдсан даатгуулагч (иргэн) өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу нийгмийн даатгалын дэвтэртээ шилжилт хөдөлгөөн хийлгүүлсэн байх;

5.9. Зөвхөн нэг байгууллагад ажиллаж байгаад ажлаасаа халагдсан даатгуулагч (иргэн) ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа Нийгмийн

даатгалын тухай хуульд заасан болзол журмын дагуу нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр даатгуулж болох;

5.10. Тэтгэмж авагч нь ажилгүйдлийн тэтгэмжийн олголтыг нь зогсоосон, хэмжээг нь бууруулсан тохиолдолд энэ талаар нийгмийн даатгалын байгууллагаас тайлбар авах, уг тайлбарыг хүлээн зөвшөөрөхгүй бол нийгмийн даатгалын дээд шатны байгууллага, шүүхэд гомдол гаргах эрхтэй.

**Зургаа. Нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүрэг**

6.1. Нийгмийн даатгалын байгууллага ажилгүй болсон даатгуулагчийн өргөдлийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авч шалгаж, тэтгэмжийн хувийн хэрэг нээж, олгох тэтгэмжийн хэмжээг энэ журмын 4.2, 4.3-т заасан аргачлалын дагуу тооцсон талаар тэтгэмж авагчид танилцуулах;

6.2. Тэтгэмж авагчид олгосон тэтгэмжийн хэмжээг сар бүр тэтгэмж олгох тухай мэдэгдэл, ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах дансны баримттай тулган шалган, баталгаажуулж, тэтгэмжийн олголтыг түүний хувийн хэрэгт тэмдэглэх;

6.3. Хөдөлмөрийн байгууллагатай гэрээтэй, сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий сургалтын байгууллагаас ажилгүйдлийн тэтгэмж авагчийг мэргэжил олгох буюу давтан сургалтад хамруулан сургаж байгаа хичээл, сургалтын явцад хяналт тавих;

6.4. Нийгмийн даатгалын төв байгууллага нь ажилгүйдлийн тэтгэмж авагчийн мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлж, ажилгүйдлийн тэтгэмж авагчийн ажилд орсон эсэхэд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх;

6.5. Нийгмийн даатгалын төв байгууллага нь ажилгүйдлийн тэтгэмж авагчийн тэтгэмж зогсоогдсон мэдээллийг Хөдөлмөрийн байгууллагад тухай бүр цахимаар мэдэгдэх;

6.6. Ажилгүйдлийн тэтгэмж авагчийн тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон тохиолдолд тэтгэмжийн олголтыг зогсоож, тооцоо хийж, цахим мэдээллийн санд бүртгэн баталгаажуулж, тухайн иргэнд нийгмийн даатгалын дэвтрийг буцаан олгож, холбогдох бусад баримт бичгийг хавсарган тэтгэмжийн хувийн хэргийг хааж, архивт шилжүүлэх;

6.7. Ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулах сургалтын зардлын нэг хүнд ногдох дээд хэмжээг сургалт зохион байгуулж буй мэргэжлийн сургалтын байгууллагаас тогтоосон сургалтын төлбөрийн жишгийг баримтлан санал боловсруулж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

6.8. Сургалтад хамрагдах хүсэлт гаргасан даатгуулагч сургалтын зардлын төлбөрийн зөрүү (нийт сургалтын төлбөрөөс ажилгүйдлийн даатгалын сангаас олгох хэмжээг хассан дүн)-г төлсөн нөхцөлд сургалтын төлбөл зохих төлбөр (тогтоосон хэмжээгээр)-ийг нэхэмжлэл, холбогдох баримтыг үндэслэн мэргэжлийн сургалтын байгууллагын дансанд бэлэн бусаар шилжүүлж, тооцоо хийх;

6.9. Тэтгэмж авч байх хугацаандаа сургалтад хамрагдсан иргэний ажилгүйдлийн тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон эсэхээс үл хамааран энэ журмын 6.8-д заасны дагуу шилжүүлсэн сургалтын зардлыг бууруулахгүй байх;

Жишээ №10. Иргэн “Ц” 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс ажилгүйдлийн тэтгэмжийг авч эхэлсэн бөгөөд 10 дугаар сарын 15-нд тэтгэмж авах хугацаа дуусгавар болно. Тэрээр 10 дугаар сарын 05-ны өдрөөс 3 сарын хугацаатай

сургалтад хамрагдахаар хүсэлт гаргасан ба сургалтын нийт зардлын хэмжээ 150 000 төгрөг, уг төлбөрийн 100 000 төгрөгийг уг иргэн өөрөө төлж, даатгалын байгууллага үлдэх 50 000 төгрөгийг хариуцсан гэвэл ажилгүйдлин тэтгэмж авах хугацаа 10 дугаар сарын 15-ны өдөр дууссанаас үл хамааран нийгмийн даатгалын байгууллагаас шилжүүлсэн өмнөх төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орохгүй.

6.10. Даатгуулагчаас гаргасан гомдлыг хүлээн авч зохих хууль, журмын дагуу хянан шийдвэрлэх.

## Долоо. Ажил олгогчийн эрх, үүрэг

7.1. Ажил олгогч нь ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хугацаанд төлж, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэл ногдуулалт, төлөлтийн тооцоог нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-аар баталгаажуулсан байх;

7.2. Ажлаас халагдаж, ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх даатгуулагчтай холбогдох тооцоог хийж дууссан тухай албан ёсны тодорхойлолт гарган өгөх;

7.3. Ажил олгогч нь ажлаас халагдсан даатгуулагч (иргэн)-д ажилгүйдлийн тэтгэмж авахаар холбогдох байгууллагад бүртгүүлэх болон тэтгэмж олгох нөхцөл, журмын талаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлэх.

--- оОо ---

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 01

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 28 дугаар зүйлийн 28.8.2, Засгийн газрын 2011 оны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.6, 4.7-д заасныг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг хоёрдугаар, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг гуравдугаар, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг дөрөвдүгээр, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг тавдугаар, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг зургаадугаар хавсралтаар баталж, 2017-2018 онд хэрэгжүүлсүгэй.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т тус тус даалгасугай.

3. “Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийн санхүүжилт”-ээр хэрэгжүүлэх төслүүдийн тэргүүлэх чиглэлийг батлуулахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т, батлагдсан чиглэлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгохоор төрийн болон төрийн бус байгууллагуудын санаачилсан төслүүдийг сонгон шалгаруулж, шийдвэрлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

Үндэсний зөвлөлийн дарга,<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын<br>сайд Н.НОМТОЙБАЯР

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн<br>дарга Д.ХАДХҮҮ

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын нэгдүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт*

# ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН УР ЧАДВАР ОЛГОХ ХӨТӨЛБӨР

## Нэг. Зорилго

Иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад хамруулж хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

## Хоёр. Хамрах хүрээ

2.1. Ажилгүй иргэн;
2.2. Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн[1];
2.3. Ажил олоход хүндрэлтэй иргэн;
2.4. Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд;
2.5. 15-34 насны залуучууд.

## Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:
3.1.1. Хөдөлмөрт бэлтгэх;
3.1.2. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалт[2].

## Дөрөв. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах

4.1. Тухайн иргэн[3]ий онцлог, хэрэгцээг тодорхойлж, хөдөлмөрт бэлтгэх дараах арга хэмжээнд хамруулна. Үүнд:

4.1.1. Зөвлөгөө, мэдээлэл /Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох болон нийгэмшүүлэх зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан зохицоход нь туслах, мэдээллээр хангах/;

4.1.2. Сургалт /харьцааны ур чадвар, сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, хөдөлмөрийн харилцаа аюулгүй ажиллагааны сургалтууд/.

---

1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт заасны дагуу “Ажилгүйдэлд өртөж болзошгүй гэж –Хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, эрүүл мэндийн шалтгаанаар ажлаа өөрчлөх шаардлагатай болсон, эрхэлж байсан хувийн аж ахуй нь эрсдэлд орсны улмаас сэргэх боломжгүй болсон тухайгаа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид мэдэгдэж, бүртгүүлсэн иргэнийг хэлнэ” гэж ойлгоно.

2 Иргэний суралцах мэргэжлийн чиглэл, хэлбэр, боломжийн талаарх хүсэлтийг үндэслэн ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулна.

3 Сургууль завсардсан хөдөлмөрийн насны хүүхэд, асрамжаас гарсан иргэн; хорих ангиас суллагдсан иргэн; 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн; хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн; 15-34 насны ажилгүй залуучуудыг хамруулна.

## Тав. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт[4]-д хамруулах арга хэмжээг зохион байгуулах

5.1. Хөдөлмөр, халамжийн үйлчичлгээний газар, хэлтэс нь иргэний суралцах мэргэжлийн чиглэл, хэлбэр, боломжийн талаарх хүсэлтийг үндэслэн ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулна.

5.2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

5.2.1. Үйлдвэрлэл дээрх сургалт;

5.2.2. Мэргэжлийн болон давтан сургалт.

5.3. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах

5.3.1. “Үйлдвэрлэл дээрх сургалт” гэж ажил олгогчийн үйлдвэрлэл, ажлын байранд тухайн иргэнд шинэ мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх зорилгоор дагалдуулан сургаж, ажиллуулах арга хэмжээг ойлгоно.

5.3.2. Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг хүнд ногдох зардлын хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд[5] батална.

5.3.3. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн обьектийн байршлаар Улаанбаатар хотод Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүсэлтээ гаргах ба Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар жилд 2 удаа зохих журмын дагуу нэгтгэн сонгон шалгаруулж, гэрээ байгуулан сургалтыг зохион байгуулна.

5.3.4. Орон нутагт аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь аж ахуйн нэгжийн хүсэлтийг хугацаа харгалзахгүйгээр хүлээн авч, шаардлага хангаж байгаа эсэхэд ажлын 10-15 хоногийн дотор дүгнэлт хийн, гэрээ байгуулж, хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.

5.3.5. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулж байгаа аж ахуйн нэгжид 10.0 сая хүртэл төгрөгийн сургалтын зардлыг нөхөн олгож болно. Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах ажлын байр, цахилгаан, багаж, тоног төхөөрөмж зэрэг материаллаг болон материаллаг бус зардлыг аж ахуйн нэгж өөрөө хариуцна.

5.3.6. Үйлдвэрлэл дээрх сургалтын онолын хичээлийг аж ахуйн нэгж нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай, эсхүл эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах бөгөөд дадлагын хичээлийг онолын багшийн эсхүл үйлдвэрлэлийн дадлагажуулагч багшийн арга зүйн удирдлагын дор өөрийн үйлдвэрлэл дээр зохион байгуулна.

5.3.7. Үйлдвэрлэл дээрх сургалтын онол, дадлагын хичээлийн харьцаа 20/80, сургалтын хугацааг хувь хүний эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох чадамжийн нэгжийн хөтөлбөрт үндэслэн уян хатан тогтоож болох бөгөөд 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй, сургалтын нийт үргэлжлэх хугацаа нь 3-6 долоо хоног байна.

5.3.8. Ажлын шинэ байр олноор бий болгох үйлдвэрлэл, бүтээн байгуулалтад шаардлагатай байгаа мэргэжилтэй ажилтны захиалга, эрэлтийг үндэслэн мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, дадлагажуулан ажиллуулах арга хэмжээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нэгтгэн зохион

4 “Хөдөлмөр эрхлэлтийн сургалт” гэж ажилд зуучлагдах, хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэхэд шаардагдах мэргэжлийн зохих ур чадвар, чадамж эзэмшүүлэх, хөгжүүлэх арга хэмжээг ойлгоно.

5 Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ

байгуулж, холбогдох зардлыг батлагдсан жишиг, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр санхүүжүүлж болно.

5.4. Мэргэжлийн[6] болон давтан сургалт[7] зохион байгуулах

5.4.1. Хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчдын эрэлт, ажлын байр, ур чадварын судалгаа, ажилгүй иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн болон давтан сургалтыг зохион байгуулна.

5.4.2. Мэргэжлийн болон давтан сургалтыг Улаанбаатар хот[8]-д Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, орон нутаг[9]-т Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд болон эрх бүхий мэргэжлийн сургалт[10]ын байгууллагуудтай гэрээ байгуулж, зохион байгуулах зохих журмын дагуу санхүүжилт[11]ийг олгоно.

5.4.3. Мэргэжлийн болон давтан сургалтыг Улаанбаатар хотод эрхийн бичгээр болон эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллагаар хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах удирдамж”[12]-ийн дагуу хэрэгжүүлнэ.

5.4.4. Эрхийн бичгийн сургалтад орон нутгийн иргэн хамрагдаж болох бөгөөд энэ тохиолдолд өөрийн харьяа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт тавьж, тодорхойлолт гаргуулна. Сургалтын үйл ажиллагаанаас бусад зардлыг иргэн өөрөө хариуцна.

5.4.5. Мэргэжлийн болон давтан сургалтын онол, дадлагын хичээлийн харьцаа 30/70, 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.

5.4.6. Мэргэжлийн болон давтан сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулах бөгөөд үргэлжлэх хугацаа нь сонгосон хөтөлбөрөөс хамааран 1-6 долоо хоног байх бөгөөд хамрагдах иргэдийн 40 хүртэл хувь нь ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн байна.

5.4.7. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авч байгаа иргэний хэрэгцээнд үндэслэн мэргэжлийн сургалтад тодорхой чиглэл[13]ийн дагуу хамруулж, холбогдох зардлыг тухайн сангаас батлагдсан жишиг[14]ээс хэтрүүлэхгүй санхүүжүүлж болно.

5.4.8. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэнд “Мэргэжлийн сургалтаар чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэдийн мэргэшлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу ур чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв зохион байгуулж, Чадамжийн гэрчилгээ олгох ба иргэн өөрөө хүсвэл мэргэжлийн зэрэг олгох шалгалтад хамруулж болно.

---

6 “Мэргэжлийн сургалт” гэж мэргэжилгүй иргэнд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи ашиглан мэргэжлийн ажил, ажилбар гүйцэтгэх ур чадвар эзэмшүүлж, чадамжийн гэрчилгээ олгохыг ойлгоно.

7 “Давтан сургалт” гэж ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнд мэргэжлийн шинэ ур чадвар, чадамж эзэмшүүлж, чадамжийн гэрчилгээ олгохыг ойлгоно.

8 Төвийн 6 дүүрэгт хамаарна.

9 21 аймаг болон алслагдсан 3 дүүрэгт хамаарна.

10 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь мэргэжлийн болон давтан сургалтын эрх бүхий байгууллагуудын жагсаалтыг гаргана.

11 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Мэргэжлийн болон давтан, явуулын сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй байна.

12 “Эрхийн бичгээр болон магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах удирдамж”-ийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар баталж, мөрдүүлнэ.

13 Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайд сургалтын чиглэлийг батална.

14 Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг баримтална.

## Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

6.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6.1.1. Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө;

6.1.2. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдсан ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй хүний тоо, мэргэжлийн чиглэлээр;

6.1.3. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдаж ажлын байртай болсон иргэний тоо, бүлэг, төрлөөр;

6.1.4. Мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдсан ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй хүний тоо;

6.1.5. Мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдаж ажлын байртай болсон ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний тоо, хугацаагаар;

6.1.6. ”Чадамжийн гэрчилгээ” авсан хөдөлмөр эрхлэлтийн ур чадвартай болсон хүний тоо.

6.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

6.2.1. Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээний үр дүн сайжирсан байна;

6.2.2.Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан байна;

6.2.3. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдсан иргэд ажлын байраар хангагдсан байна;

6.2.4. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн, ажилгүй байх хугацаа богиноссон байна.

-----o0o-----

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын нэгдүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

# АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

## Нэг. Зорилго

Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй, бичил бизнес эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

## Хоёр. Хамрах хүрээ

2.1. Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн;

2.2. Ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч;

2.3. Ажилгүй иргэн, орон нутгийн иргэдийн бүлэг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж;

2.4. Ажил хайгч иргэд, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын оюутан, суралцагч;

2.5. Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хүнсний ногоо тариалах хүсэлт гаргасан иргэн, иргэдийн бүлэг.

## Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

3.1.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох;

3.1.2. Аж ахуй эрхлэлтийн сургалт;

3.1.3. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх;

3.1.4. Ажил олгогчид дэмжлэг олгох;

3.1.5. Нийтийг хамарсан ажил зохион байгуулж, түр ажлын байраар хангах;

3.1.6. Ажил хайгч иргэд, оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучилж орлого нэмэгдүүлэх;

3.1.7. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулж орлогын дэмжлэг үзүүлэх.

## Дөрөв. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах

4.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олон нийтэд зарлан мэдээлэх, төсөл өгч хүсэлт гаргасан иргэдийг бүртгэх, төсөл боловсруулах болон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах, төслүүдийг шалгаруулах, төслүүдэд борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх, төслийн үр дүнд хяналт-шинжилгээ хийх гэсэн үе шатттайгаар зохион байгуулна.

4.2. Төсөл шалгаруулах үе шат бүрийг ил тод, нээлттэй зарчмаар зохион байгуулах ба 3 долоо хоногоос доошгүй хугацааны өмнөөс тухайн нутаг дэвсгэрийн иргэд, олон нийтэд зар мэдээлэл, сурталчилгаа хийнэ.

4.3. Аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 35 ба түүнээс дээш насны хөдөлмөрийн насны иргэний төсөлд хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж, 3.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгоно.

4.4. Гадаадад ажиллаж, амьдарч байгаад ирсэн иргэн[15] өөрийн эзэмшсэн мэргэжил, ур чадварын дагуу гарааны бизнес эрхлэх хүсэлт гаргасан бол төслийн хэрэгжих үндэслэлийг үнэлэн шалгаруулж, 5.0 хүртэл сая төгрөгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр нэг удаа олгоно.

4.5. Санхүүгийн дэмжлэг нь 24 сарын дотор 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг иргэний саналыг үндэслэн тогтооно.

4.6. Хүсэлт ирүүлсэн иргэн нь хийхээр төлөвлөсөн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байх нь төслийн шалгаруулалтад давуу тал болно.

4.7. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь жил бүрийн 4, 9 дүгээр сард төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах[16] ба шалгарсан төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, санхүүгийн дэмжлэгийг олгон хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

## Тав. Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах

5.1. Аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэн болон жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар төсөл өгсөн, төсөл нь шалгарсан иргэнийг хүсэлтэд нь үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалтад[17] хамруулна.

5.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай бол тухайн ажилтан сургалтыг зохион байгуулж болно.

5.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт, зөвлөгөө өгөх, үйлдвэрлэлийн байр түрээслүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, орон нутагт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь эрх бүхий байгууллагуудтай[18] гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж болно.

5.4. Иргэн нь бизнес эхлэх, хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төлөвлөгөө, төсөл боловсруулах, бизнесийн санааг хөгжүүлж гарааны бизнесийг хөгжүүлэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулж үйл ажиллагаа эрхлэх, борлуулалтын сүлжээ, маркетингийн болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээрх сургалтын хөтөлбөрөөс сонгон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдана.

5.5. Аж ахуй эрхлэлтийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 болон 5 хоног байх бөгөөд 3 хоногийн сургалт нь 21-ээс, 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.

---

15 Гадаадаас сүүлийн 2 жилийн дотор ирсэн иргэнийг хүсэлтэд үндэслэн хамруулна.

16 Сум, хорооны иргэдийн төслийг Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн шалгаруулж, шийдвэрлэж болно.

17 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Аж ахуй эрхлэлтийн сургалтын зардлын дээд хэмжээ”-г мөрдөнө.

18 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь бизнес инкубатор төв, мэргэшсэн сургалтын байгууллагуудын жагсаалт гаргана.

5.6. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийн явцад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах ба хяналт тавих, хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах зорилгоор иргэд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг жилд 2 удаа зохион байгуулна.

## Зургаа. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

6.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн болон бусад дэмжлэг, жижиг зээл авсан иргэний бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь иргэний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах цэгийг ажиллуулна[19].

6.3. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 12 болон түүнээс дээш сарын хугацаагаар байнгын ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа, ХЭДС-ийн жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч, нөхөрлөл, хоршоодод түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, нөхцөл байдлыг газар дээр нь үнэлсэн үнэлгээнд үндэслэн ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг[20] төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.

6.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг зарж борлуулахад чиглэсэн үзэсгэлэн, яармагийг зохион байгуулна.

6.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь үндэсний бүтээгдэхүүнийг гадаад орнуудад гаргаж, борлуулалт хийдэг байгууллагуудаар дамжуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадаад орнуудад борлуулахад дэмжлэг үзүүлнэ.

6.6. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын www.hudulmur-halamj.mn цахим хуудсанд санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах тусгайлсан цэс ажиллуулж, борлуулалтад дэмжлэг үзүүлж, тус цэсийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

6.7. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь тусгайлсан цэсэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн бараа, бүтээгдэхүүний мэдээллийг сар бүр шинэчлэн оруулна.

6.8. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэн болон тухайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг 36 сарын хугацаанд энэхүү хөнгөлөлтөд дахин хамруулахгүй.

19 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан ”Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй байна.

20 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй байна.

## Долоо. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

7.1. “Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ” гэж ажил олгогчоос ажил олоход хүндрэлтэй иргэнийг авч ажиллуулахтай холбоотой гарсан зардлын тодорхой хэсгийг нөхөн төлөх, тухайн иргэнийг ажлын байранд нь тогтвортой ажиллуулахыг урамшуулах зорилго бүхий үйл ажиллагааг ойлгоно.

7.2. “Ажил олгогч” нь улсын бүртгэлийн болон татвар, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр авч байнга ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, нөхөрлөл, хоршооны удирдлага[21] байна.

7.3. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэн, ажил идэвхтэй хайж байгаа боловч 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг бий болгосон байнгын ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгоно.

7.4. Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажилд авч, 12 сараас дээш хугацаагаар үргэлжлүүлэн байнгын ажлын байраар хангасан бол нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний[22] санхүүгийн дэмжлэгийг бий болгосон байнгын ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгоно.

7.5. Ажил олгогч энэхүү хөтөлбөрийн 7.3, 7.4-т заасан иргэнийг ажлын байраар хангах тухайгаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст мэдэгдэн гэрээ байгуулна.

7.6. Ажил олгогч нь ажлын байраар хангасан иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, цалин, хөлсийг олгон, баримт бүрдүүлнэ.

## Найм. Нийтийг хамарсан ажил зохион байгуулж, түр ажлын байраар хангах арга хэмжээ

8.1. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах төслийн хүрээнд байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, мод тарих, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, усны нөөц сан байгуулах, засварлах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэж болно.

8.2. Орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага нь орон нутгийн ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах төсөл, төлөвлөгөөг боловсруулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ирүүлнэ.

8.3. Ирүүлсэн төслийг хүлээн авч, бий болгох түр ажлын байрны тоо, гүйцэтгэх ажлын зардал, санхүүгийн тооцоо зэргийг хянан үзээд дэмжигдсэн төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах шийдвэр гаргаж, гэрээ байгуулна.

---

21 Энэхүү арга хэмжээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр болон төсвөөс санхүүжилт авдаггүй төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад төсвийн байгууллага, төрийн бус байгууллага, нөхөрлөл, хоршооны гишүүд хамаарахгүй.

22 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Дээд хэмжээгээр тооцох нэг сарын цалингийн хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй байна.

8.4. Нийтийг хамарсан ажилд хамрагдах иргэдийг сард ажлын 10 хүртэл хоногоор, өдөрт 8 хүртэл цагаар ажиллуулах ба ажилласан иргэдийн цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг[23] ажилласан цагаар тооцож өдрөөр болон ажил хийгдэж дууссаны дараа олгоно.

8.5. Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн ажлын хөлс, зардлыг аймаг, нийслэл, дүүргийн газар, хэлтэс тухайн иргэний банкин дахь нэрийн дансанд шилжүүлнэ.

8.6. Нийтийг хамарсан ажлыг гэрээлэн гүйцэтгэх нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж нь хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн үүрэгт ажил[24]-ыг нийтийг хамарсан ажлаар гүйцэтгүүлэхийг хориглоно.

8.7. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын эрэлт, хэрэгцээг судалж нийтийн ашгийн төлөө ажил зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх талаарх мэдээллийг ажил олгогч, олон нийтэд болон иргэнд өгч оролцох боломжийн талаар танилцуулна.

8.8. Арга хэмжээний хүрээнд талуудын хамтран ажиллах гэрээний загвар, тайлангийн маягтыг Хөдөлмөр, халамжийн ерөнхий газрын дарга баталж мөрдүүлнэ.

8.9. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан иргэдэд олгосон цалин хөлснөөс Нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож авахгүй[25].

## Ес. Ажил хайгч иргэн, оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучилж орлого нэмэгдүүлэх арга хэмжээ

9.1. Ажил хайгч иргэд, их, дээд сургуулийн оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын өдрийн ангид суралцагчийг орлого олоход дэмжлэг үзүүлэх зорилгоор цагийн ажилд зуучилна.

9.2. Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дэргэдэх “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-үүдээр дамжуулан, аймагт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар ажил хайгч иргэд, оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучлах арга хэмжээг зохион байгуулна.

9.3. Цагийн ажлын цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зардлыг ажил олгогч хариуцах бөгөөд хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангаж аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж өгч ажиллана.

9.4. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь цагийн ажлын зуучлалд зориулсан бүртгэл, зуучлалын мэдээллийн сан бий болгон хөгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны анхан шатны зааварчилгаа өгөх, цагийн ажилд зуучлах хөдөлмөрийн яармаг, өдөрлөг, явуулын, хөдөлмөрийн бирж ажиллуулж, батлагдсан зардлын жишгийн дагуу санхүүжүүлнэ.

---

23 Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын баталсан “Нийтийг хамарсан ажлын хөлс, зардлын хэмжээ”-ний дагуу олгоно.

24 Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогчийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1125 дугаар захирамжийн 2 дугаар зүйл, заалт болон түүнтэй адилтгах хууль тогтоомж, орон нутгийн шийдвэрийн дагуу хүлээсэн үүрэгт ажлыг болон бусад хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүрэгт ажлыг ойлгоно.

25 Засгийн газрын 2015 оны 380 дугаар тогтоол, Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны 47 дугаар тогтоолын 1.8 дахь заалтыг баримтлан ажиллана.

9.5. Оюутнуудад цагийн ажлын үргэлжлэх хугацаа нь өдөрт 4 цагаас, долоо хоногт 20 цагаас илүүгүй байна. Хичээлийн жилийн завсарлага буюу зуны амралтын хугацаанд энэхүү хязгаарлалт хамаарахгүй.

## Арав. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулж орлогын дэмжлэг үзүүлэх

10.1. Иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамруулан сургаж, орлогоор дэмжинэ.

10.2. Хүнсний ногоо тариалах арга хэмжээг Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, аймгууд болон Улаанбаатар хотын алслагдсан 3 дүүргийн хэмжээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулах ба хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.

10.3. Арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй иргэдэд зохих мэдээллийг нийтэд мэдээлэн, шалгаруулж, тодорхой төлөвлөгөөний дагуу хүнсний ногоо тариалах арга барилд сурган иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар ажиллуулна.

10.4. Арга хэмжээний хүрээнд иргэдийн хураасан ургацыг хамрагдсан иргэдэд олгох бөгөөд зарж, борлуулахад чиглэсэн нэгдсэн арга зохион байгуулж болно.

## Арван нэг. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

11.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

11.1.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан хүний тоо, зарцуулсан болон эргэн төлөгдсөн хөрөнгийн хэмжээ;

11.1.2. Бий болсон байнгын ажлын байрны тоо;

11.1.3. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэний тоо;

11.1.4. Бараа, бүтээгдэхүүн борлуулах цэг болон хамрагдсан иргэн, нөхөрлөл, хоршооны тоо;

11.1.5. Дотоод, гадаадын үзэсгэлэн яармагт оролцсон иргэн, нөхөрлөл, хоршооны тоо;

11.1.6. Ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэн, нөхөрлөл, хоршооны тоо;

11.1.7. Нийтийг хамарсан ажлын төрөл, чиглэл тус бүрт хамрагдсан хүний тоо;

11.1.8. Цагийн ажилд зуучлагдсан хүний тоо, хүйсээр, мэргэжлийн төрлөөр, бүртгэлд хамрагдсан оюутан, ажил хайгчийн тоо;

11.1.9. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамрагдсан иргэний тоо.

11.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

11.2.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдаж ажлын байр бий болсон байна;

11.2.2. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдан үйл ажиллагаа тогтворжсон байна;

11.2.3. Ажил олоход хүндрэлтэй иргэд байнгын ажлын байраар хангагдаж, орлого нь нэмэгдсэн байна;

11.2.4. Иргэд түр ажлын байраар хангагдаж, орлого нэмэгдсэн байна.

-----o0o-----

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын нэгдүгээр тогтоолын гуравдугаар хавсралт*

# ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

## Нэг. Зорилго

Залуучууд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны болон санхүүгийн дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байртай болгох замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

## Хоёр. Хамрах хүрээ

2.1. Хөтөлбөрт залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид хэрэгжүүлэх арга хэмжээний шаардлагын дагуу хамрагдана.

## Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

3.1.1. Гарааны бизнесийг дэмжих;

3.1.2. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох;

3.1.3. Борлуулалтын болон үйлдвэрлэлийн ажлын байрны түрээсийн хөнгөлөлт олгох.

## Дөрөв. Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг туршилтаар[26] зохион байгуулах

4.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс[27] нь гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

4.1.1. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих ажлын хэсгийг[28] аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, Төсөл хэрэгжүүлэх нэгж \ТХН\ болон холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.1.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон сум, хорооны хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь гарааны бизнес эхлүүлэх хүсэлтэй залуусыг[29] бүртгэж, бүлэг байгуулна.

26 ШХА-ийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн хүрээнд Төсөл хэрэгжүүлэх нэгж хамтран зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжүүлж буй: Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Завхан, Өмнөговь, Увс, Ховд аймгууд ба нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүрэг хамаарна.

27 Туршилтаар хэрэгжүүлэх арга хэмжээг 2017 онд төсөл хэрэгжиж буй аймаг, дүүрэгт зохион байгуулж туршлага, сургамжид тулгуурлан зохистой загварыг бий болгон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ.

28 Ажлын хэсгийн ажлын нийтлэг удирдамжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

29 15-34 насны залуучууд байна.

4.1.3. Уг бүлгийн гишүүдэд гарааны бизнесийн таатай орчин бүрдүүлэх талаар сургалт, дараагийн шатанд аж ахуй эрхлэлт, бизнес загвар боловсруулах сэтгэлгээний сургалт[30] зохион байгуулна.

4.1.4. Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах 54 цагийн арга хэмжээг Ажлын хэсэг, сум, хорооны гарааны бизнесийг дэмжих бүлгийн гишүүд бизнесийн зөвлөхүүдтэй хамтран зохион байгуулна.

4.1.5. Залуучуудад аж ахуй эрхлэлт, загвар бүтээх сэтгэлгээний сургалт, гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх зөвлөгөөг бүлгүүдийн хэрэгцээ, хүсэлтэд үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дэргэдэх бизнес инкубатор төв, эсвэл мэргэшсэн, эрх бүхий байгууллага[31]ын туслалцаатайгаар зохион байгуулж, холбогдох зардлыг санхүүжүүлж[32] болно. Шалгарсан нэг төсөлд 10,0 сая төгрөгийн гарааны дэмжлэгийг 24 сарын хугацаатайгаар олгоно.

4.1.6. Гарааны бизнесийг сонгон шалгаруулахад эхний байранд шалгарсан багтай Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс гарааны дэмжлэг олгох тухай гэрээ байгуулж, хамтран ажиллах ба төсөл хэрэгжүүлэх эхний 6 сард гарааны дэмжлэгийн эргэн төлөлт хийхгүй байж болох ба эргэн төлөлт[33]ийн хуваарийг бүлгийн саналд үндэслэн тогтооно.

4.1.7. Санхүүгийн дэмжлэгийг гарааны бизнес эрхлэх хүний цалин хөлсөнд болон шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эргэлтийн хөрөнгө гэх мэт гэрээнд заасан зориулалтаар зарцуулна.

4.2. Туршилтаар хэрэгжүүлэх арга хэмжээг 2017 онд төсөл хэрэгжиж буй аймаг, дүүрэгт зохион байгуулж туршлага, сургамжид тулгуурлан зохистой загварыг бий болгон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ.

4.3. Энэхүү арга хэмжээг төсөл хэрэгжээгүй[34] аймаг, нийслэлийн дүүргүүд хэрэгжүүлэх бол гарааны бизнесийг дэмжих үйл ажиллагааг зохих дараалал, зарчмын дагуу зохион байгуулах ба ТХН-тэй хамтран сургагч багш, зөвлөхүүдийг бэлтгэсний дараа хэрэгжүүлж болно. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь уг арга хэмжээг аймаг, дүүрэгт хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн гэж үзвэл нэмэлт санхүүжилтийг хуваарилна.

## Тав. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт санхүүгийн дэмжлэг олгох

5.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч[35]-ийг хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилгоор тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад нь зориулж, нэг төгсөгчид 3 сая төгрөг, бүлэгт 10 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгоно. Төгсөгчид бүлэг

30 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй.

31 Гарааны бизнесийг дэмжих мэргэшсэн байгууллага, бизнес инкубатор болон бизнесийг дэмжих төвүүдийн жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар гаргана.

32 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээнээс хэтрүүлэхгүй.

33 Гарааны дэмжлэгийн эргэн төлөлтийг аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж зохих журмын дагуу хяналт тавьж ажиллана.

34 Нийслэлийн Хан-уул, Баянгол дүүргээс бусад дүүрэгт хамаарна.

35 15-24 насны залуучууд байна.

болсон тохиолдолд 5-аас ихгүй гишүүнтэй байна.

5.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэг нь бизнес, аж ахуй эрхлэх талаарх төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт, холбогдох мэдээллийг боловсруулж, төгсөгчийн болон бүлгийн ахлагчийн байнга оршин суух хаягийн бүртгэлээр харьяалах Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт гаргана.

5.3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь 3, 8 дугаар саруудад төгсөгчдийн төслийг зарлах, төслүүдийн хэрэгжих үндэслэлийг тооцон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллана.

5.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авах ажилд төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.

5.5. Төгсөгч болон бүлэг нь гэрээ байгуулснаас хойш 24 сарын дотор санхүүгийн дэмжлэгийг эргүүлэн төлөх ба эргэн төлөлтийн хуваарийг төгсөгч, бүлгийн саналыг харгалзан тогтооно.

5.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч, төгсөгч нь үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил, мэргэжлийн уралдаан, тэмцээнд амжилт гарган шилдгээр шалгарсан тохиолдолд мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дэмжих багаж, тоног төхөөрөмж авахад зориулан олгох урамшууллыг батламж, гэрчилгээнд үндэслэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас санхүүжүүлж болно.

5.7. Төслийн шалгаруулалтын дүн шийдвэрийн талаар олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, шалгаруулалттай холбоотой гарсан маргааны асуудлыг бүрэн хариуцан хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

5.8. Төгсөгч болон төгсөгчдийн бүлэг нь бизнес, аж ахуй эрхлэх зориулалтаар авсан дэмжлэгийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон нөхцөлд уг дэмжлэгийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нэн даруй эргэн төлүүлнэ.

## Зургаа. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

6.1.Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх санхүүгийн болон гарааны дэмжлэг авсан залуучууд, залуучуудын бүлгийг бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь бараа, бүтээгдэхүүнийг борлуулах төвлөрсөн цэгийг ажиллуулна[36].

6.3.Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар байнгын ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа бол түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, нөхцөл байдлыг газар дээр нь үнэлсэн үнэлгээнд үндэслэн ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг[37] төлбөр

36 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ"-нээс хэтрүүлэхгүй байна.

37 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ"-нээс хэтрүүлэхгүй байна.

төлсөн баримтаар нөхөн олгоно.

6.4.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг зарж борлуулахад чиглэсэн үзэсгэлэн, яармагийг зохион байгуулна.

6.5.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь үндэсний бүтээгдэхүүнийг гадаад орнуудад гаргаж, борлуулалт хийдэг байгууллагуудаар дамжуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадаад орнуудад борлуулахад дэмжлэг үзүүлнэ.

6.6.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын www.hudulmur-halamj.mn цахим хуудсанд энэхүү хөтөлбөрт хамрагдсан залуучуудын бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах тусгайлсан нэмэлт цэс ажиллуулж, борлуулалтад дэмжлэг үзүүлж, тус цэсийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

6.7.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь тусгайлсан нэмэлт цэсэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн бараа, бүтээгдэхүүний мэдээллийг сар бүр шинэчлэн оруулна.

6.8.Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан бол 24 сарын хугацаанд энэхүү хөнгөлөлтөд дахин хамруулахгүй.

6.9.Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдаж буй төгсөгч болон төгсөгчдийн бүлгийн хэрэгцээ, хүсэлтэд үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалт, зөвлөгөө өгөх, үйлдвэрлэлийн байр түрээслүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, орон нутагт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь эрх бүхий байгууллагуудтай[38] гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж болно.

6.10.Бизнес эхлэх, хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төлөвлөгөө, төсөл боловсруулах, гарааны бизнесийг хөгжүүлэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулж үйл ажиллагаа эрхлэх, борлуулалтын сүлжээ, маркетингийн болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээрх сургалтын хөтөлбөрөөс сонгон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдана.

6.11.Аж ахуй эрхлэлтийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 болон 5 хоног байх бөгөөд 3 хоногийн сургалт нь 21-ээс, 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.

6.12.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрт хамрагдсан залуучуудын үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийн явцад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах ба хяналт тавих, хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах зорилгоор залуучууд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг жилд 2 удаа зохион байгуулж болно.

## Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

7.1.Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

7.1.1. Гарааны бизнесийг дэмжих бүлгийн гишүүдийн тоо, үйл ажиллагааны салбараар, нас, хүйсээр;

7.1.2. Гарааны бизнесийг дэмжих бэлтгэгдсэн сургагч багшийн тоо, нас, хүйсээр;

38 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь эрх бүхий бизнес инкубатор төв, мэргэшсэн сургалтын байгууллагуудын жагсаалт гаргана.

7.1.3. Санхүүгийн дэмжлэг авсан баг, төгсөгчдийн тоо, үйл ажиллагааны салбараар, нас, хүйсээр;

7.1.4. Борлуулалтын болон түрээсийн төлбөрийн хөнгөлөлт, сургалтад хамрагдсан баг, хүмүүсийн тоо, үйлчилгээний чиглэл тус бүрээр, нас, хүйсээр;

7.1.5. Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, бизнесийн бүлгийн тоо, шинээр бий болсон ажлын байрны тоо.

7.2.Хөтөлбөрийн хүрэх үр дүн

7.2.1.Залуучуудын аж ахуй, бизнес, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна;

7.2.2.Залуучуудын гарааны бизнес, санхүүгийн дэмжлэгийн үр ашиг дээшилсэн байна.

-----o0o----

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын нэгдүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт*

# МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

## Нэг. Зорилго

Залуу малчин, цөөн малтай иргэдэд мал маллагааны арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх ур чадвар олгох, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

## Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1.Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

2.1.1. Малчин өрхийг малжуулах;

2.1.2. Мал маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах.

2.2.Малчин өрхийг малжуулах арга хэмжээг зохион байгуулах

2.2.1.Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хөдөлмөрийн чадвартай, 15-39 насны 2-оос доошгүй гишүүнтэй, бог малд шилжүүлснээр 200 хүртэл толгой мал[39]тай “малчин[40]” өрхийг хамруулна.

2.2.2. Арга хэмжээнд хамрагдах малчин өрх нь 150 хүртэл толгой малтай бол 5.0 сая төгрөг, 150-200 хүртэл толгой малтай бол 4.0 сая төгрөгийн мал худалдан авах арга хэмжээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс[41] зохион байгуулна.

2.2.3. Санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авч өгснөөс хойш 24 сарын дотор хуваарийн дагуу 100 хувь эргүүлэн төлнө.

2.2.4. Арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс сонгож, гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоосон байна. Хамрагдах малчин өрх нь төлөвлөгөө, төсөлтэй байна.

2.2.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь мал худалдан авч өгөх үйл ажиллагааг хуулийн дагуу нээлттэй, ил тод зохион байгуулна. Худалдан авч байгаа малын үнэ нь зах зээлийн дундаж үнээс илүүгүй байна.

2.2.6. Хэрэв 50 хүртэл толгой малтай малчин өрх малжуулах арга хэмжээнд хамрагдах бол мал аж ахуй эрхлэх дадлага, туршлагатай дадлагажуулагч малчинтай байна.

2.2.7. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор тухайн иргэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон сумын Засаг дарга нар гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэж ажиллана.

39 Мал тооллогын “А” дансанд бог малд шилжүүлснээр бүртгэгдсэнийг үндэслэнэ.

40 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасны дагуу “мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэн”-ийг хэлнэ.

41 Алслагдсан 3 дүүргийг хамруулна.

2.3. Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах

2.3.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд аж ахуй эрхлэлтийн[42] болон малын эрүүл мэнд, мал маллах арга ажиллагааны болон малын ашиг шимийг боловсруулах сургалт /мах, сүү цагаан идээ, ноос, арьс шир боловсруулах г.м/, туршлага солилцох уулзалт зохион байгуулах, малын хашаа, хороо барих, хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг дэмжлэг, туслалцаа үзүүлэх бөгөөд энэхүү арга хэмжээний нийт зардал нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэхүү хөтөлбөрт хуваарилсан нийт хөрөнгийн 5 хувиас ихгүй байна.

2.3.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь сургалт зохион байгуулах эрх бүхий мэргэшсэн сургалтын байгууллагыг[43] сонгож, гэрээ байгуулан ажиллана. Мөн мал маллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн эрх бүхий сургагч багшаар сургалтыг зохион байгуулж болно.

2.3.3. Туршлагатай сайн малчдаас суралцах, туршлага солилцох, дэлгэрүүлэх зорилготой уулзалт, хэлэлцүүлгийг жилд тухайн жилд хуваарилагдсан төсөвт багтаан тухайн аймаг, дүүргийн жилийн төлөвлөгөөг Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр батлуулан зохион байгуулж болно.

Малчин өрх нь малжуулах арга хэмжээнд зөвхөн нэг удаа хамрагдана.

## Гурав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

3.1.Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

3.1.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүд, олгосон малын тоо, төрлөөр, арга хэмжээнд хамрагдсанаас хойш 24 сарын дараах малын тоо, орлогын дүнгээр;

3.1.2. Шавь сургалтад хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүдийн тоо, хүйсээр, шавь сургалт хийсэн дадлагажуулагч малчны тоо;

3.1.3. Мал аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалтад хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүдийн тоо, хүйсээр;

3.1.4. Туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдсан малчин өрхийн тоо, гишүүдийн тоо.

3.2.Хөтөлбөрийн хүрэх үр дүн

3.2.1. Малжуулах арга хэмжээнд залуу малчид хамрагдаж, амьжиргаа нь дээшилсэн байна.

3.2.2. Туршлага солилцох уулзалт болон сургалтуудыг зохион байгуулснаар ахмад, туршлагатай малчдаас суралцаж, мал маллах арга ажиллагааны чадвар, мэдлэг, дээшилсэн байна.

-----o0o----

42 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Аж ахуй эрхлэлтийн сургалтын зардлын дээд хэмжээ”-нээс хэтрүүлэхгүй байна.

43 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагуудыг шалгаруулж, жагсаалт гаргана.

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын нэгдүгээр тогтоолын тавдугаар хавсралт*

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

## Нэг. Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

## Хоёр. Хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1.Хөтөлбөрт доорх иргэдийг хамруулна. Үүнд:

2.1.1. "Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан[44]", эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хүчин төгөлдөр шийдвэртэй, бичгээр хандсан хөгжлийн бэрхшээлтэй хүн;

2.1.2. Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх;

2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч.

2.2.Хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний аж ахуй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

2.2.2. Ажил олгогчийг дэмжих.

## Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

3.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

3.1.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ;

3.1.2. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ;

3.1.3. Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.4. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх;

3.1.5. Аж ахуй эрхлэлтийн болон хөдөлмөр эрхлэлтийн сургалт явуулах.

3.2.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах

3.2.1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох болон нийгэмшүүлэх, ажлын байр, үйлдвэрлэлийн орчинтой танилцуулах, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны анхан шатны мэдлэг олгох, зөвлөгөө

44 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.

өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах багц үйлчилгээг “Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ” гэж ойлгоно.

3.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, нийгэм, хамт олны дунд биеэ авч явах тухай сургалт, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хүнтэй харилцах, өөрийгөө ойлгуулах чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны анхан шатны зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны мэдлэг олгоно.

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ганцаарчилсан болон бүлгийн зохион байгуулалттайгаар арга хэмжээнд хамруулна. Үргэлжлэх хугацаа нь хөгжлийн бэрхшээлийн төрлөөс шалтгаалан ажлын 5-10 хоног хүртэл байна.

3.2.4. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн жилд нэг удаа хамрагдана.

3.2.5. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг эрх бүхий[45] хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

3.2.6. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний үйлчилгээ, сургалтын хөтөлбөр, агуулгыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батлах ба Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ажилтнуудыг арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана.

3.2.7. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулсны дараа ажилд зуучлах үйлчилгээ үзүүлнэ.

3.3. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээг зохион байгуулах

3.3.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлэн, ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд үндэслэн ажилд зуучлах үйлчилгээг ганцаарчлан болон хэсэг, бүлгээр зохион байгуулна.

3.3.2. Шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан ажлын, ярилцлагад ороход туслах, ажлын байр, ажил олгогчтой танилцуулах зорилгоор хөтөч, дохионы хэлмэрч ажиллуулж болох бөгөөд хөтөч[46], дохионы хэлмэрч[47] нь сургалтад хамрагдсан байна.

3.3.3. Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгчийг цагийн ажлын хэлбэрээр ажиллах хугацаа нь ажлын 5 өдрөөс хэтрэхгүй байна. Урамшууллыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан зардлын жишиг хэмжээг үндэслэн олгоно.

3.3.4. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгчийн үйлчилгээг тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

3.4.Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах

3.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл шалгаруулах тухай зар мэдээллийг 3 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө тухайн нутаг дэвсгэрийн иргэд, олон нийтэд сурталчилж, жил бүрийн эхний болон гуравдугаар улиралд тус тус багтаан аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн

45 Тухайн салбар, мэргэжлээр сургалт явуулахаар бүртгэгдсэн эрх бүхий мэргэшсэн байгууллага
46 “Хөтөч” гэж хараагүй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах хүнийг,
47 “Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг хэлнэ.

үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулна.

3.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эх нь хувиараа болон бүлэг, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнес, газар тариалан, фермерийн аж ахуй эрхлэх төслөө Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлнэ.

3.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төслийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 5.0 хүртэл сая төгрөг байх ба дэмжлэгийг 4 хүртэл жилийн хугацаанд 100 хувь эргэн төлнө. Иргэний саналыг үндэслэн эргэн төлөлтийн хуваарийг гэрээнд хавсарган баталгаалжуулна.

3.4.4. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах төслийн урьдчилсан үнэлгээ хийх, сонгон шалгаруулах ажлын хэсгийг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулах бөгөөд тэдгээрийн гучаас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

3.4.5. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төслийн сонгон шалгаруулалтын дүн, шийдвэрийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх бөгөөд сонгон шалгаруулалттай холбоотой гарсан маргааныг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

3.5.Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

3.5.1. Бичил бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтэд үндэслэн боловсруулсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамруулах ба Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулна.

3.5.2. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 12 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг, мөн нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг нөхөрлөл, хоршоо, бизнес инкубатор төвийн бойжигчийг хамруулна.

3.5.3. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь холбогдох баримт бичиг, түрээсийн гэрээг үндэслэн нөхцөл байдлыг газар дээр нь тодорхойлсны үндсэн дээр ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг[48] нөхөн олгоно. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг нөхөн олгохдоо тухайн төлбөрийг төлсөн баримтыг үндэслэнэ.

3.5.4. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэн, нөхөрлөл, хоршоо, бизнес инкубаторын бойжигч нь 24 сарын хугацаанд энэхүү хөнгөлөлтөд дахин хамрагдахгүй.

3.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн, яармагийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулах бөгөөд шаардлагатай бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

---

48 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ"-нээс хэтрүүлэхгүй байна.

3.6.Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах

3.6.1. Аж ахуй эрхлэлтийн сургалтад энэхүү хөтөлбөрийн 3.4-т заасан санхүүгийн дэмжлэгт хамрагдсан болон бичил бизнес эрхэлдэг, цаашид эрхлэх хүсэл сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хүсэлтийн дагуу хамруулна.

3.6.2. Эрх бүхий мэргэшсэн, боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн эрх бүхий байгууллага[49], иргэнтэй гэрээ байгуулан 3-5 хоногийн хугацаанд зохион байгуулна. Аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс тухайн ажилтнаар сургалтыг зохион байгуулж болно.

3.7.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

3.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн ур чадвар, чадамжийг 1-10 сарын хугацаанд багтаан эрх бүхий мэргэшсэн, боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн байгууллага, иргэнтэй гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд уг сургалт нь модуль хэлбэртэй тусгайлсан сургалтын хөтөлбөрт суурилсан байна.

3.7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн чадамж эзэмшүүлэх, үйлдвэрлэл дээрх ажлын байрны болон шавь сургалт зэрэг тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон төрөл хэлбэрийг сонгон зохион байгуулна. Энэхүү арга хэмжээний хүрээнд хөтөч, дохионы хэлмэрчийг бэлтгэх, хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжаа олгох сургалт болон хөгжлийн бэрхшээлийн бусад төрөл хэлбэрийн онцлогт тохирсон нэмэлт сургалтыг хийж болно.

3.7.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон мэргэжлээр мэргэжлийн ур чадварын тусгайлсан сургалтыг Улаанбаатар хотод Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн сургалт зохион байгуулах дадлага, туршлага бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

3.7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтад ногдох зардлын дээд хязгаарыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд тогтооно.

3.7.5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд “Мэргэжлийн сургалтын чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэдийн мэргэшлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу ур чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв зохих журмын дагуу зохион байгуулж, “Чадамжийн гэрчилгээ” олгоно.

**Дөрөв. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах**

4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих дараах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

4.1.1. Урамшуулал олгох;

4.1.2. Санхүүгийн дэмжлэг олгох.

49 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах мэргэшсэн байгууллагуудын нэгдсэн жагсаалт гаргана.

4.2.Урамшуулал олгох арга хэмжээг зохион байгуулах

4.2.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тусгайлсан байнгын ажлын байраар хангасан дор дурдсан нөхцөл, шаардлагыг хангасан ажил олгогчид[50] хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно. Үүнд:

А.Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх заалтад зааснаас цөөн буюу 25 хүртэл ажилтантай ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол байнгын ажлын байраар хангасан хүний тоогоор;

Б.25 болон түүнээс дээш тооны ажилтантай ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар тогтоосон хувиас давсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас давсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор тус тус урамшууллыг олгоно.

4.2.2.Ажил олгогч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авах тухай шийдвэр, хүсэлтийг урьдчилан гаргаж, холбогдох гэрээг байгуулна.

4.3.Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах

4.3.1. Тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлсэн тохируулгатай, байнгын ажлын байр бий болгох зорилгоор боловсруулсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын төслийг шалгаруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэг ажлын байранд 5 хүртэл сая төгрөгөөр тооцож, 50 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

4.3.2. Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын боловсруулсан төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт холбогдох хууль, тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах бөгөөд шалгарсан төслийг хэрэгжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулж, ажиллана.

4.3.3. Төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа ил тод, нээлттэй, тэгш ажиллах зарчмыг хангах ба холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг зөвшилцөн оролцуулна.

## Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

5.1.Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

5.1.1. Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо хүйсээр, байгууллагын тоо, сургалтын төрлөөр;

5.1.2. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, ажилд зуучлагдсан хүний тоо хүйсээр, ажил олгогчийн өмчийн хэлбэрээр, хөтөч ашигласан хүний тоо, хүйсээр, хөтөч, дохионы хэлмэрчээр ажилласан хүний тоо, хүйсээр, давтамж цагаар;

5.1.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт, Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүний тоо, хүйсээр, сургалтын төрлөөр, мэргэжлээр;

---

50 Ажил олгогч гэж эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээсээ олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хамруулна.
Энэхүү арга хэмжээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр болон төсвөөс санхүүждэггүй төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад төсвийн байгууллага, ажил олгогч малчин, төрийн бус байгууллага хамаарахгүй.

5.1.4. Иргэн болон бүлэг нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан төсөл, хамрагдсан хүний тоо, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйсээр, салбараар;

5.1.5. Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, үзэсгэлэн, яармагт хамрагдсан бүлэг, нөхөрлөл, хоршоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо;

5.1.6. Санхүүгийн дэмжлэг, урамшуулалд хамрагдсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, шинээр бий болгосон тохируулгатай ажлын байрны тоо, байнгын ажлын байраар хангагдсан хүний тоо мэргэжлээр, салбараар.

5.2.Хөтөлбөрийн үр дүн

5.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр нэмэгдсэн байна;

5.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуй, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна;

5.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн аж ахуй эрхлэлт, өрхийн орлого өссөн байна.

----- o0o-----

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын нэгдүгээр тогтоолын зургаадугаар хавсралт*

# АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

## Нэг. Зорилго

Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж орлогын дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

## Хоёр. Хөтөлбөрийн хамрах хүрээ

2.1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт гарган мэдээллийн санд бүртгүүлсэн тэтгэврийн насны ахмад мэргэжилтнүүд;

2.2.Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, холбоод.

## Гурав. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1.Аймаг, дүүрэгт ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах[51];

3.2.Үндэсний хэмжээнд ахмадын төрийн бус байгууллагуудаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах,

3.3.Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

## Дөрөв. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах

4.1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийн тавигдах шаардлагыг холбогдох мэдээллийн хамт нийтэд ил тод зарлан мэдээлж, зохион байгуулах ба аймаг, нийслэл, дүүргүүд тус бүрт 15 хүртэлх төслийг сонгон шалгаруулна.

4.2.Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйл ажиллагаа шаардлагатай байгаа боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон төрийн захиргааны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нь хэрэгцээ, шаардлага, ажлын цар хүрээг тодорхойлсон төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ирүүлнэ.

4.3.Төсөлд хамрагдан ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ахмадад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишиг хэмжээгээр[52] ажилласан цагийн урамшууллыг тооцож, төсөлд хамрагдсан байгууллагын ирүүлсэн тайлан, ажлын цагийн бүртгэлд үндэслэн урамшууллыг

51 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан"-г үүсгэж, хяналт тавьж ажиллана.

52 Нийтийг хамарсан ажлын цагийн хөлс болон журмын дагуу тооцож олгоно.

ахмад мэргэжилтэнд шууд олгох ба нийтийг хамарсан ажил зохион байгуулах журмын дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй.

4.4.Зөвлөх мэргэжилтний төслийн хүрээнд олгох урамшууллыг тооцохдоо нэг жил хүртэлх хугацаанд ажлын 30 өдөр буюу нийт 240 цагаас хэтрэхгүй байхаар төсөл, холбогдох гэрээнд тусган ажиллана.

4.5.Тухайн төсөлд хамрагдаж буй ахмад мэргэжилтний гүйцэтгэх ажил үүрэг, салбар нь давхцахгүй байхад Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд хяналт тавьж ажиллана.

4.6.Төсөл хэрэгжүүлэгч ахмад мэргэжилтэнд аймаг, сум орон нутгийн захиргаа, бусад байгууллагаас үйл ажиллагаа явуулах байр, техник хэрэгсэл, ажиллах нөхцөл, шаардагдах материал түүхий эд, санхүүгийн болон дэмжлэг үзүүлэх ба гүйцэтгэж буй ажил, үүрэгтэй нь уялдуулан нэмэлт цалин хөлсийг зохих хууль тогтоомжийн дагуу олгож болно.

## Тав. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ

5.1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь бүтээн байгуулалт болон бусад салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадын багийг улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг ахмадын эрх ашгийг хамгаалсан холбоодтой хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

5.2.Зөвлөх үйлчилгээний төслийг хэрэгжүүлэх ахмад настны эрх ашгийг хамгаалах холбоо нь тухайн зөвлөх үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж үзүүлэх мэргэжлийн өндөр ур чадвартай баг, бүрэлдэхүүнтэй байна.

5.3.Ахмад мэргэжилтний багийн зөвлөх үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх ахмадын төрийн бус байгууллага нь төсөлд хамрагдах хүний тоо, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах төр хувийн хэвшлийн байгууллагын хүсэлт, ажиллах байршил, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төслийн холбогдох баримт бичгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлнэ.

5.4.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь зөвлөх үйлчилгээний захиалгад үндэслэн ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж, төсөлд хамрагдах ахмад мэргэшсэн зөвлөх мэргэжилтнүүд “Ахмад мэргэшсэн зөвлөхүүдийн нэгдсэн мэдээллийн сан”-д бүртгүүлнэ. Төслийн зориулалтаар хуваарилагдсан хөрөнгө, түүний зарцуулалт олон нийтэд ил тод, нээлттэй байна.

5.5.Төслийн үйл ажиллагаа эхлэхэд санхүүжилтийн 70 хувийг, төслийн явц, үр дүнг үндэслэн үлдэгдэл 30 хувийг санхүүжүүлнэ.

5.6.Төслийн үйл ажиллагаанд ахмадын баг, бүлгийг ажиллуулах ажил олгогч, төрийн захиргаа үйлчилгээний байгууллага нь ажиллах нөхцөл, байр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах болон ажлын нэмэгдэл хөлс, цалинг олгож болно. Энэхүү арга хэмжээнд хамрагдаж буй ахмад мэргэжилтнүүд нь аймаг, орон нутагт хэрэгжүүлэх ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөлд давхардан хамрагдахгүй.

## Зургаа. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх

6.1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь ахмадуудын төслийн тавигдах шаардлагыг холбогдох мэдээллийн хамт нийтэд ил тод зарлан мэдээлж, 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах ба аймаг, нийслэл, дүүргүүд тус бүрт 10 хүртэлх төслийг сонгон шалгаруулна.

6.2.Ахмад нь боловсруулсан төслөө харьяа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ирүүлэх ба төсөлд олгох эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг[53] нь 3.0 сая хүртэл төгрөг байна.

6.3.Санхүүгийн дэмжлэг нь 24 сарын дотор 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг иргэний саналыг үндэслэн тогтооно.

## Долоо. Төслийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

7.1.Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно. Үүнд:

7.1.1.Төсөл, зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад мэргэжилтнүүдийн тоо, нас, хүйс, салбар, мэргэжлээр;

7.1.2. Бүтээн байгуулалтад ажилласан ахмад мэргэжилтний зөвлөх багийн тоо, салбар, мэргэжлээр;

7.1.3. Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад настны төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, салбар, мэргэжлээр;

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо.

7.2.Хөтөлбөрийн хүрэх үр дүн

7.2.1. Ахмад мэргэжилтэн нь ажлын байраар хангагдаж, орлого нэмэгдсэн байна.

7.2.2. Ахмад мэргэжилтний мэдээллийн сан бий болсон байна.

7.2.3. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.

-----о0о-----

53 Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт нэг удаа хамрагдана.

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 02

## Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.1-28.3 дахь заалтыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1 . “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд, тогтоолын хэрэгжилтийг хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн Ажлын алба /Ц.Амартөгс/-д даалгасугай.

Үндэсний зөвлөлийн дарга,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайд Н.НОМТОЙБАЯР

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн
дарга Д.ХАДХҮҮ

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын хоёрдугаар тогтоолын хавсралт*

# АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн эрх, үүрэг, түүний удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах зөвшилцлийн байгууллага байна.

1.3. Аймгийн зөвлөл нь сум, багийн, нийслэлийн зөвлөл нь дүүрэг, хорооны хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

## Хоёр. Зөвлөлийн эрх үүрэг

2.1.Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.1.1. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрхэн биелүүлж байгаа талаарх тайлан, мэдээлэл авах, хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;

2.1.2. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн орон нутагт зохион байгуулах, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар санал боловсруулж Иргэдийн төлөөлөгчдийн хурал, холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

2.1.3. хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн газар, хэлтэс болон Засаг даргын тамгын газар бусад нэгжүүдийн ажлыг уялдуулан зохицуулах;

2.1.4. хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүд болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах, биелэлтэд нь хяналт тавих;

2.1.5. тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах;

2.1.6. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлан, мэдээлэл авах, хэлэлцэх, зөвлөмж гаргах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн төсөвт хуваарилуулах санал оруулах;

2.1.7. хөдөлмөр эрхлэлт дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдах сум,

хорооны хуваарийг тухайн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, орон нутгийн хүн ам, ажилгүйдлийн түвшин зэргийг харгалзан батлах, бодлого, чиглэл гаргах;

2.1.8. аймаг, нийслэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг дүүрэг, хороо, сум, баг, иргэнд үр өгөөжтэй хүргэхэд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ эрхэлдэг төр, хувийн хэвшлийн байгууллагын ажил үүргийг чиглүүлж удирдлагаар хангах.

**2.2. Зөвлөл дор дурьдсан үүрэгтэй байна:**

2.2.1. Төсвийн тухай хуулийн 58.1.58, 58.2.5 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.2 дахь заалтын дагуу орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар зарцуулагдах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил бүр тусган батлуулах;

2.2.2. аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, холбогдох хөтөлбөрүүд, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг боловсруулан батлуулах ажлыг санаачлан зохион байгуулах;

2.2.3. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлого, зарлагын явц, байдал, үүний дотор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих;

2.2.4. тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах;

2.2.5. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд нийгмийн болон төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмуудыг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын үүсгэл санаачлагыг дэмжих, иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах;

2.2.6. орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийг зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр хангах;

2.2.7. хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар төрийн захиргааны үйлчилгээний байгуулага, ялангуяа мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг дунд үйлдвэр, хөдөө аж ахуй, гэр бүл, залуучууд хөгжлийн болон бусад холбогдох асуудал эрхэлсэн байгууллага, бусад хороо зөвлөлүүдтэй үйл ажиллагаа уялдуулах;

2.2.8. тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүрийн 1 дугаар сард ирүүлж байх;

2.2.9. үндэсний зөвлөлийн ажлын албанаас гаргасан аргачилсан удирдамж, зөвлөмжийг үндэслэн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, томилсон байгууллагадаа ажлаа тайлагнах болон удирдан зохицуулах, хяналт үнэлгээ хийхдээ ашиглах шалгуур үзүүлэлтүүд зэргийг үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж хэрэгжүүлэх.

## Гурав. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

3.1.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга 4 жилийн хугацаагаар батална. Зөвлөлийн дарга нь тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга байх бөгөөд гурван талын төлөөлөгчдийн тоо адил бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

3.1.1. төрийг төлөөлж Засаг дарга болон аймаг, нийслэл, дүүргийн боловсрол болон нийгмийн хөгжил, төсөв санхүүгийн байгууллагаас нийт гурван хүн;

3.1.2. ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах орон нутгийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гурван хүн;

3.1.3. ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах орон нутгийн ажил олгогчдын байгууллагаас гурван хүн.

3.2. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга түр эзгүй байх тохиолдолд зөвлөлийн даргын үүргийг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч гүйцэтгэнэ.

3.3. Орон нутгийн үйлдвэрчний эвлэлийн болон ажил олгогчдын байгууллагууд энэхүү дүрмийн 3.1.2 болон 3.1.3-т заасан төлөөллийг бүрдүүлэхдээ тухайн орон нутгийн тэргүүлэх салбарын ажил олгогч болон ажилтны байгууллагаас оролцуулах бөгөөд түүнчлэн харилцан зөвшилцсөнөөр мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөгчийг бүрэлдэхүүндээ оруулж болно.

3.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд хуралдааныг гурван тал тус бүрээс 2 гишүүн, нийт 6-гаас доошгүй гишүүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

3.5. Зөвлөл нь хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн хуралдаанаас эрх, үүргийнхээ хүрээнд санал дүгнэлт, зөвлөмж, тогтоол гаргах бөгөөд хуралдааны тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулна. Зөвлөл нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

3.6. Зөвлөлийн хуралдаанаас гаргасан тэмдэглэл, санал дүгнэлт, зөвлөмж, тогтоолыг гишүүдэд танилцуулан, зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

3.7. Зөвлөлийн гишүүдэд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээгээр гишүүний оролцоог харгалзан зөвлөлийн нарийн бичгийг даргыг хамруулан урамшуулал олгоно. Урамшуулал болон зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын төсөвт тусган Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

3.8. Зөвлөлийн ажлын албаны үүргийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга байна.

3.9. Зөвлөлийн шийдвэрийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.10. Зөвлөлд төрийг төлөөлж буй гишүүд нь Засаг даргад, Засаг дарга нь үр дүнгийн гэрээний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад, ажилтны төлөөллийн гишүүд нь орон нутгийн болон үйлдвэрчний эвлэлийн үндэсний хэмжээний байгууллагад, ажил олгогчийн төлөөллийн гишүүд нь орон нутгийн болон ажил олгогчдын үндэсний хэмжээний байгууллагад хийсэн ажлаа тайлагнана.

-----o0o-----

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хот

Дугаар 03

## Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, Засгийн газрын 2011 оны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 4.6, 4.7-дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд "Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг 2017 онд хэрэгжүүлэх чиглэл"-ийг нэгдүгээр, төслийн шалгаруулалт зохион байгуулах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Батлагдсан чиглэлийн хүрээнд нэгж төслийн төсөвт өртгийг 200.0 хүртэл сая төгрөгт багтаан хууль тогтоомжийн дагуу нээлттэй зарлан 15-аас доошгүй төслийг удирдамжийн дагуу шалгаруулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийн гэрээ байгуулан санхүүжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга /Б.Нямдаваа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-т даалгасугай.

Үндэсний зөвлөлийн дарга,<br>хөдөлмөр, нийгмийн<br>хамгааллын сайд Н.НОМТОЙБАЯР

Үндэсний зөвлөлийн<br>нарийн бичгийн дарга Д.ХАДХҮҮ

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн*
*2017 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн*
*хурлын 3 дугаар тогтоолын*
*нэгдүгээр хавсралт*

# Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн тэргүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлт

<table>
<tr><th>№</th><th>Хөтөлбөр, төслийн тэргүүлэх чиглэл</th><th>Ерөнхий шаардлага</th><th>Шалгуур үзүүлэлт</th></tr>
<tr><td></td><td colspan="3">Орон нутаг, нийслэлийн үндсэн үзүүлэлт:<br>- Хүн ам /мян.хүн/,<br>- Хөдөлмөрийн насны хүн ам,<br>- Ажиллах хүчний оролцооны түвшин,<br>- Ажилгүйдлийн түвшин,<br>- Ажиллагчдын тоо,<br>- Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь,<br>- Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн тоо,<br>- Мал аж ахуй эрхлэгчдийн тоо гэх мэт.</td></tr>
<tr><td>1.</td><td>Салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүд</td><td rowspan="7">- Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээг судалгаанд үндэслэн тодорхойлсон байх;<br><br>- Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тооцсон байх;<br><br>- Хөтөлбөр, төсөл хэрэгжиж эхлэх үеийн суурь үзүүлэлтүүдийг тооцсон байх;<br><br>- Төсөвт өртөгийг бодитойгоор тооцсон байх;<br><br>- Төслийн баримт бичгийн стандарт, шаардлагыг хангасан байх;<br><br>- Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс хэлэлцэн дэмжсэн байх;</td><td rowspan="7">- Төслийн үндэслэл, тооцоолол, үр ашиг, нийгмийн үр нөлөө;<br><br>- Ажлын байр шинээр бий болгох, хадгалах, ажлын байрны бүтээмж, орлогыг дээшлүүлэх;<br><br>- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хэмжээ;<br><br>- Татвар, нийгмийн даатгал болон зээлийн өр, төлбөргүй байх;<br><br>- Төсөл хэрэгжүүлэгч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн дэмжлэг, зээлд хамрагдаагүй байх;</td></tr>
<tr><td>2.</td><td>Өндөр технологид суурилсан гарааны бизнесийг дэмжиж, интерпрёнер мэргэжилтэн бэлтгэх, цахим ажлын байр бий болгох</td></tr>
<tr><td>3.</td><td>Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээрх үйлдвэрлэл, үйлчилгээ болон ногоон ажлын байрыг дэмжих</td></tr>
<tr><td>4.</td><td>Малын гаралтай түүхий эд, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, малын үүлдэр угсаа, ашиг шимийг дээшлүүлэх үйлдвэрлэлийг дэмжих, хөдөө аж ахуйн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх</td></tr>
<tr><td>5.</td><td>Жимс, хүнсний ногоо боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих</td></tr>
<tr><td>6.</td><td>Нийтийн ахуйн үйлчилгээний жишиг үйлчилгээг сайжруулахыг дэмжих</td></tr>
<tr><td>7.</td><td>Хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай мэргэшсэн ажилтан дадлагажуулан, сургаж, ажлын байранд зуучлах</td></tr>
</table>

*Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2017 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн
хурлын 3 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт*

# Зорилтот төслийн шалгаруулалт зохион байгуулах удирдамж

## Нэг. Зорилго

Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын уялдаа холбоог зохицуулахад энэхүү удирдамжийн зорилго оршино.

## Хоёр. Хамрах хүрээ

Төслүүдийн хамрах хүрээ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуульд заасан зорилтот бүлэг, иргэд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид, бичил аж ахуй эрхлэгч, ажил олгогч аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага байна.

## Гурав. Зохион байгуулалт, санхүүжилт, хяналт-үнэлгээ, тайлагналт

3.1.Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн шалгаруулалтыг олон нийтэд зарлан мэдээлэх, бүртгэх, шалгаруулах, санхүүжүүлэх, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, эргэн төлөлтөд хяналт тавих гэсэн үе шаттайгаар жилд нэг удаа зохион байгуулна.

3.2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан 30 хоногийн турш олон нийтэд зарлан мэдээлж, сурталчилна.

3.3.Орон нутаг, нийслэлийнхээ онцлог, хэрэгцээ, хүн амын тоо, нийгэм, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын болон амьжиргааны түвшин зэрэг холбогдох үзүүлэлтүүдэд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилтот төслийг “тэргүүлэх чиглэл, төсөлд тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлт”[54]-д нийцүүлэн боловсруулсан байна.

3.4.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан, аймаг, нийслэл, дүүргээс ирүүлсэн төслүүдийг хүлээн авч, зохих хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын шийдвэрээр баталгаажуулна.

3.5.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь батлагдсан төслүүдийг хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, санхүүжүүлэн, хэрэгжилт, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

3.6.Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн төсөвт өртөг нь 200,0 хүртэл сая төгрөг байх ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ. Тухайн аймаг орон нутгийн хөгжлийн сан[55] болон

54 Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэл
55 Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл

бусад эх үүсвэрээс нэмэлт хөрөнгө гаргаж болно.

3.7.Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг 2 жил хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

3.8.Төслийг сонгон шалгаруулахтай холбоотой гарах үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн онд батлагдсан төсвийн хуваарийн “Засгийн газрын шийдвэрийн дагуу аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс баталсан бусад хөтөлбөр, төслийн санхүүжилт”-д заасан хөрөнгөөс Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын шийдвэрээр зарцуулж болно.

3.9.Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулан жилд 2 удаа хийнэ.

3.10.Төслийн хэрэгжилт, үр дүнгийн тайлан, мэдээг улирал бүрийн эхний сарын 5-ны дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлж, тус газар нь ажлын 3 хоногт багтаан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.

3.11.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн хэрэгжилтийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр “Сайн төсөл”-ийг шалгаруулна.

3.12.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх тайлан, мэдээллийг Засгийн газарт тайлагнаж ажиллана.

---oOo---

# МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар А/18

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны .... дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. ”Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-г нэгдүгээр, “Мэргэжлийн болон давтан, явуулын сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-г хоёрдугаар, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээ”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг үндэслэл болгож, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны .... дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга /Б.Нямдаваа/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг тогтоох тухай” Хөдөлмөрийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/06 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Н.НОМТОЙБАЯР

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/18 тоот тушаалын нэгдүгээр хавсралт*

# Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ

| Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал | Мэргэжлийн чиглэл | Ажилгүй иргэний сургалт | | Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний сургалт | |
|---|---|---|---|---|---|
| | | 5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ /мян.төг/ | Нийт зардлын дээд хэмжээ /мян.төг/ | 5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ /мян.төг/ | Нийт зардлын дээд хэмжээ /мян.төг/ |
| А. Хөдөө аж ахуй, ойн аж ахуи, ан агнуур | 1. Газартариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа | 75,0 | 600,0 | 52,5 | 420,0 |
| | 2. Ойн аж ахуй, мод бэлтгэх | 62,5 | 500,0 | 43,8 | 350,0 |
| | 3. Бусад | 56,3 | 450,0 | 39,4 | 315,0 |
| Б.Уул уурхай, олборлолт | 1. Машин механизм, төхөөрөмжийн оператор | 97,5 | 780,0 | 68,3 | 546,0 |
| | 2. Машин механизм, төхөөрөмжийн засварчин | 97,5 | 780,0 | 68,3 | 546,0 |
| | 3. Зүтгүүрийн машинч /төмөр замын ажилтан/ | 90,0 | 720,0 | 63,0 | 504,0 |
| | 4. Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан | 97,5 | 780,0 | 68,3 | 546,0 |
| | 5. Далд ба ил уурхайчин | 90,0 | 720,0 | 63,0 | 504,0 |
| | 6. Баяжуулагч | 90,0 | 720,0 | 63,0 | 504,0 |
| | 7. Зам, засвар үйлчилгээний ажилтан | 77,5 | 620,0 | 54,3 | 434,0 |
| | 8. Хүнд даацын тээврийн хэрэгслийн жолооч | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 9. Бусад | 75,0 | 600,0 | 52,5 | 420,0 |
| В.Боловсруул- ах үйлдвэр | 1. Хүнсний бүтээгдэ-хүүний үйлдвэрлэл | 60,0 | 480,0 | 42,0 | 336,0 |
| | 2.Нэхмэл оёдол болон хувцас үйлдвэрлэл | 60,0 | 480,0 | 42,0 | 336,0 |
| | 3. Арьс, арьсан бүтээг- дэхүүн үйлдвэрлэл | 60,0 | 480,0 | 42,0 | 336,0 |
| | 4.Хэвлэх, дахин үйлдвэрлэх ажиллагаа | 52,5 | 420,0 | 36,8 | 294,0 |
| | 5.Бусад | 45,0 | 360,0 | 31,5 | 252,0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Г.Барилга болон техникийн үйлчилгээ | 1.Кран өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины оператор | 90,0 | 720,0 | 63,0 | 504,0 |
| | 2.Барилгын засал, чимэглэл | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 3.Барилгын өрөг угсрагч | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 4.Барилгын бетон арматур | 90,0 | 720,0 | 63,0 | 504,0 |
| | 5.Барилгын цахилгаанчин | 90,0 | 720,0 | 63,0 | 504,0 |
| | 6.Барилгын гагнуурчин | 90,0 | 720,0 | 63,0 | 504,0 |
| | 7.Барилгын сатехникч | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 8.Барилгын мужаан | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 9.Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн оператор | 90,0 | 720,0 | 63,0 | 504,0 |
| | 10.Шилчин | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 11.Дээвэрчин | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 12.Металл хийц бэлтгэгч, нимгэн төмөрчин | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 13.Цахилгаан төхөөрөмжийн механикч /тохируулагч/ | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 14.Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |
| | 15.Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин | 82,5 | 660,0 | 57,8 | 462,0 |

Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээ тус бүрийн 20 хувийг онолын хичээлд, 80 хувийг дадлагын хичээлд зарцуулна.

Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээг «Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар огох хөтөлбөр”-т заасан үйлдвэрлэл дээрх сургалтын зардалд жишиг болгоно.

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/18 тоот тушаалын хоёрдугаар хавсралт*

## Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ

| Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал | Мэргэжлийн чиглэл | Ажилгүй иргэний сургалт | | Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний сургалт | |
|---|---|---|---|---|---|
| | | 5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ /мян.төг/ | Нийт зардлын дээд хэмжээ /мян. төг/ | 5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ /мян.төг/ | Нийт зардлын дээд хэмжээ /мян.төг/ |
| А. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур | 1.Үр тариа, тэжээлийн ургамал тариалах | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 2.Фермерийн аж ахуй | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 3.Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах / ногоочин/ | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 4.Ойн аж ахуй, мод бэлтгэх | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 5.Малчин | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 6.Бусад | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| Б.Уул уурхай, олборлолт | 1.Машин механизм, төхөөрөмжийн оператор | 46,7 | 280,0 | 37,3 | 224,0 |
| | 2.Машин механизм, төхөөрөмжийн засварчин | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 3.Зүтгүүрийн машинч /төмөр замын ажилтан/ | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 4.Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан | 36,7 | 220,0 | 29,3 | 176,0 |
| | 5.Далд ба ил уурхайчин | 36,7 | 220,0 | 29,3 | 176,0 |
| | 6.Баяжуулагч | 33,3 | 200,0 | 26,7 | 160,0 |
| | 7.Зам, засвар үйлчилгээний ажилтан | 36,7 | 220,0 | 29,3 | 176,0 |
| | 8. Бусад | 33,3 | 200,0 | 26,7 | 160,0 |
| В.Боловсруул- ах үйлдвэр | 1.Хөнгөн үйлдвэрлэлийн оёдол, эсгүүр | 30,0 | 180,0 | 24,0 | 144,0 |
| | 2.Хөнгөн үйлдвэрлэлийн сүлжигч, нэхэгч, кительчин | 30,0 | 180,0 | 24,0 | 144,0 |
| | 3.Хатгамал, эсгий, даавуу урлал | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 4.Арьс ширэн урлал | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 5.Гутал үйлдвэрлэл /монгол буриад гутал эсгэх оёх / | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 6.Гар урлал бэлэг дурсгал | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 7.Модон эдлэл буюу гэр ахуйн мужаан | 30,0 | 180,0 | 24,0 | 144,0 |
| | 8.Жижиг эдлэл үйлдвэрлэл /чөдөр, ногт г.м/ | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 9.Хүнсний боловсруулах үйлдвэрлэл /мах, сүү/ | 30,0 | 180,0 | 24,0 | 144,0 |
| | 10.Хоол үйлдвэрлэл, тогооч | 30,0 | 180,0 | 24,0 | 144,0 |
| | 11.Талх нарийн боов | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 12.Сүү цагаан идээ боловсруулах | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 13.Бусад | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| Г.Барилга болон техникийн үйлчилгээ | 1.Кран өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины оператор | 36,7 | 220,0 | 29,3 | 176,0 |
| | 2.Засал, чимэглэл | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 3.Өрөг угсрагч | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 4.Бетон арматур | 43,3 | 260,0 | 34,7 | 208,0 |
| | 5.Цахилгаанчин | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 6.Гагнуурчин | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 7.Сатехникч | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 8.Барилгын мужаан | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 9.Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн оператор | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 10.Шилчин | 33,3 | 200,0 | 26,7 | 160,0 |
| | 11.Дээвэрчин | 33,3 | 200,0 | 26,7 | 160,0 |
| | 12.Металл хийц бэлтгэгч, нимгэн төмөрчин | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 13.Цахилгаан төхөөрөмжийн механикч /тохируулагч/ | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 14.Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч | 36,7 | 220,0 | 29,3 | 176,0 |
| | 15.Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин | 33,3 | 200,0 | 26,7 | 160,0 |
| | 16.Хөдөө аж ахуйн машин механизм, тоног төхөөрөмжийн механикч, засварчин | 40,0 | 240,0 | 32,0 | 192,0 |
| | 17.Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин | 36,7 | 220,0 | 29,3 | 176,0 |
| | 18.Бусад | 33,3 | 200,0 | 26,7 | 160,0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Д. Бөөний болон жижиглэн худалдаа, ахуйн болон засвар үйлчилгээ | 1.Автомашины засвар | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 2.Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 3.Дархан, мужаан, сийлбэр | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 4.Телевизор, гар утасны засварчин | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 5.Гутал засвар | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 6.Жижиг эдлэлийн засварчин /цүнх, цаг г.м/ | 20,0 | 120,0 | 16,0 | 96,0 |
| | 7.Үсчин | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 8.Гоо засал | 26,7 | 160,0 | 21,3 | 128,0 |
| | 9.Зочид буудлын үйлчлэгч, үйлчилгээний ажилтан | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 10.Гэрийн үйлчлэгч, асрагч | 20,0 | 120,0 | 16,0 | 96,0 |
| | 11.Цэцэрлэгийн багшийн туслах ажилтан | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 12.Аялал жуулчлалын хөтөч,тайлбарлагч | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 13.Худалдагч касс, нярав | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 14.Зөөгч Бармен | 23,3 | 140,0 | 18,7 | 112,0 |
| | 15.Бусад | 20,0 | 120,0 | 16,0 | 96,0 |

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн (суралцагч)-д ногдох сургалтын зардлын хэмжээ нь тухайн мэргэжлийн болон давтан сургалтын зардлын хэмжээг 30 хувиар нэмэгдүүлэн тооцсонтой тэнцүү байна.

Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээ тус бүрийн 30 хувийг онолын хичээлд, 70 хувийг дадлагын хичээлд тус тус зарцуулна.

Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээг «Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн”-ийн мэргэжлийн болон давтан сургалт, «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хөдөлмөр эрхлэлтийн сургалтын зардалд жишиг болгоно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны *01* дүгээр сарын
*27-ны өдрийн А/18 тоот тушаалын* гуравдугаар хавсралт

# Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээ

| № | Зардлын хэмжээг жишиг болгох арга хэмжээнүүд | Зардлын төрөл, хэмжээ | | |
|---|---|---|---|---|
| 1. | “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг арга хэмжээ | Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ /мян.төг/ | | |
| | | Улаанбаатар хот | Аймгийн төв | Сумын төв |
| | | 700.0 | 600.0 | 400.0 |
| | | Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт[56] үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ /мян.төг/ | | |
| | | Улаанбаатар хот | Аймгийн төв | Сумын төв |
| | | 250.0 | 200.0 | 150.0 |
| | | | | |
| 2. | “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтын арга хэмжээ | Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтын зардлын дээд хэмжээ /мян.төг/ | | |
| | | 3 хоног = 15.0 | 15 хоног = 30.0 | |
| | | | | |
| 3. | “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн ажил олгогчийн урамшуулал арга хэмжээ | Дээд хэмжээгээр тооцох нэг сарын цалингийн хэмжээ /мян. төг/ | | |
| | | 500.0 | | |
| | | | | |
| 4. | “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн дэмжлэгтэйгээр ажилд зуучлах арга хэмжээ | Нийтийг хамарсан ажил, түр ажлын хөлс, зардлын жишиг хэмжээ /мян.төг/ | | |
| | | Нэг цагийн ажлын хөлс | Нэг цагийн ажлын ХАБЭА-н зардал | |
| | | 3.5 | 0.5 | |
| | | | | |
| 5. | Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ | Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян. төг/ | | |
| | | Ганцаарчилсан | Бүлгээр | |
| | | 12.0 | 6.0 | |
| | | | | |
| 6. | Ажилд зуучлах үйлчилгээ | Ажилд зуучлах үйлчилгээний [57] нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/ | | |
| | | 7.0 | | |
| | | | | |
| 7. | “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ | Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/ | | |
| | | 45.0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн | |
| | | | 70.0 | |

56 Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлэхдээ тухайн зорилтот бүлгийн иргэний ажлын байрны түрээсийн төлбөрийн 40 хүртэл хувийг 6 сарын хугацаатай сар бүр нөхөн олгоно.

57 Ажилд зуучлах үйлчилгээ, ажлын байрны мэдээлэл авах, солилцохтой холбоотой гарах бичиг хэрэг, харилцаа холбоо, мэдээлэл, сурталчилгааны болон явуулын бирж ажиллуулахад зарцуулна.

# МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хот

№ А/26

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хууийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 1 тоот тогтоолоор батлагдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, мөн нэгдсэн удирдамжийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд оролцогч талуудын хооронд байгуулах гэрээний загвар, шаардлагатай тайлангийн маягтуудыг боловсруулан баталж, мөрдүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус даалгасугай.

САЙД Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
*2017 оны 2 дугаар сарын16-ны өдрийн*
А/26 тоот тушаалын хавсралт

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН УДИРДАМЖ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2017-2018 онд хэрэгжүүлэхээр баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулан ажиллах Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд, сум, хорооны хөдөлмөрийн асуудал хариуцсан ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн удирлага, арга зүйгээр хангаж, хөтөлбөрийг нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэхэд удирдамжийн зорилго оршино.

## Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам мэргэжлийн удирдлагаар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар зохицуулалт, арга зүйгээр хангаж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллана.

1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл болон сум, дүүрэг/хорооны Засаг дарга, иргэдийн төлөөллийн байгууллага байнгын хяналт тавина.

1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж, хамтран ажиллана.

1.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналт-үнэлгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар жилд 2 удаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам жилд 1 удаа хийнэ.

1.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийн сарын тайлан, мэдээг дараа сарын 3-ны дотор, улирлын тайлан, мэдээг дараа улирлын эхний сарын 3-ны дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт, тус газар нь тайлан, мэдээг ажлын 3 хоногт багтаан нэгтгэн дүгнэж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлнэ.

1.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний болон хамрагдаж буй иргэдийн мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (LMIS)-д маягтын дагуу тогтмол бүртгэж, шинэчилнэ.

1.7. Хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, бичиг баримт хуурамчаар үйлдсэн болон бусад зөрчил, дутагдал гаргасан нь холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтаар тогтоогдвол олгосон санхүүжилтийг буцаан төлүүлэх арга хэмжээ авч, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

## Хоёрдугаар бүлэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зохицуулалт

2.1.Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.1.1.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ:

2.1.1.1.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулах сургалтыг эрх бүхий байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ба сургалт зохион байгуулах байгууллагын жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас гаргана.

2.1.2.Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах

2.1.2.1.Үйлдвэрлэл дээрх сургалтыг 3 долоо хоног буюу ажлын 15 хоногоос 6 долоо хоног буюу ажлын 30 хоногт ажил олгогчийн хүссэн, боломжтой хугацаагаар зохион байгуулна. Ажил олгогчийн хэрэгцээ, суралцагчийн хүсэлтийг харгалзан сургалтын хугацаа уян хатан байх бөгөөд сургалтын хугацаанд ногдох санхүүжилтийг олгоно.

2.1.2.2.Үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулж, ажиллах хүчин авах хүсэлтэй аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан тухай холбогдох баримт бичиг, материалыг бүрдүүлж, холбогдох байгууллагад хандана. Үүнд:

А. Тухайн салбарт үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгааг нотолсон аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй, Монгол Улсын хуулийн этгээд байх;

Б. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажилтнуудтай, улмаар үйл ажиллагаа нь өргөжиж, шинээр ажилтан авах эрэлт хэрэгцээ бий болсон байх;

В. Суралцагч үйлдвэрлэл дээр дадлага эзэмших боломжоор хангагдсан байх / дадлагын тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн цех, талбайтай, дагалдуулан сургах ур чадвар бүхий дадлагажуулагч багштай, мастер, мэргэшсэн мэргэжилтэн, инженер, сургагчийн нөөцтэй г.м/;

Г. Дадлагын сургалтын хөтөлбөр, агуулга нь чадамжийн нэгж бүрээр тодорхойлогдсон байх бөгөөд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байх;

Д. Сургалтын хугацаанд үйлдвэрлэлийн горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, дүрэм журмыг мөрдүүлэх боломжтой байх;

Е. Суралцагчдад сургалтын дадлагын хугацаанд нь ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг зохих журмын дагуу олгох боломжтой байх;

Ё. Үйлдвэрлэл дээрх сургалтын суралцагчдын 80-аас доошгүй хувийг ажлын байраар хангаж, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулах боломжтой байх;

Ж. Бусад.

2.1.2.3.Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах аж ахуйн нэгж нь өөрийн үндсэн ажилтны тоо /Нийгмийн даатгалын шимтгэл төлдөг/ 5 хүртэл байвал 3 хүртэл хүнийг, 6 буюу түүнээс их байвал шинээр бий болох ажлын байрны тоогоор буюу 4-өөс дээш хүнийг үйлдвэрлэл дээр сургах тухай хүсэлтээ ирүүлж болно.

2.1.2.4.Үйлдвэрлэл дээрх сургалтын онол, дадлагын хичээлийн зардлыг ажил олгогчид шилжүүлэн олгох бөгөөд онолын хичээлийн 20 хувьд зориулсан сургалтын зардлыг онолын хичээлийг явуулахаар тухайн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан эрх бүхий сургалтын байгууллагын дансанд шилжүүлж, баримт бүрдүүлнэ.

2.1.2.5.Үйлдвэрлэл дээрх сургалтын үйл ажиллагаанд зарцуулах нийт зардлыг сургалт эхлэхэд 70 хувь, сургалтын үйл ажиллагаа дуусч, суралцагч мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалт өгсний дараа шалгалтанд тэнцсэн болон ажлын байраар хангагдсан суралцагчийн тоог үндэслэн үлдсэн 30 хувийг тус тус олгоно.

2.1.2.6.Үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулах тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь монгол иргэдийг гадаад ажилтан, ажилчдыг дагалдуулан ажиллуулж байгаа бол төслийн шалгаруулалтад давуу тал болно.

2.1.3.<u>Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах</u>

2.1.3.1.”Мэргэжлийн сургалт”-нд ажилгүй болон ажлын байранд зуучлагдах болох хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэнийг, ”Давтан сургалт”-нд ажил олгогчийн хүсэлтийг үндэслэн ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг тус тус сургана.

2.1.3.2. Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

А. Холбогдох журмын дагуу бүртгүүлсэн, мэргэжлийн сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллага байх бөгөөд сургалт зохион байгуулах гэрчилгээтэй байх;

Б. Сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад нийцсэн, ажил олгогчийн эрэлт, хэрэгцээг хангахуйц байх;

В. Насанд хүрэгчдийн сургалт заах арга зүй, ур чадвар бүхий үндсэн багштай байх;

Г. Сургалтын стандарт нөхцлийг хангасан онолын болон дадлагын байр, танхимтай байх;

Д. Сургалт нь онол, дадлага буюу лабораторийн ажил, үйлдвэрлэлийн дадлагын хэсгүүдээс бүрдэх бөгөөд онолын сургалт нь нийт сургалтын 30 хувиас ихгүй байх;

Е. Бусад

2.2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.2.1.<u>Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох:</u>

2.2.1.1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авахыг хүссэн иргэн бусадтай хамтран аж ахуй эрхлэх нь нээлттэй бөгөөд энэ тохиолдолд үйл ажиллагаа эрхлэх төсөл, төлөвлөгөөндөө хамтран ажиллах иргэдийн оролцоог тусгана.

2.2.1.2. Санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн өөрийн харьяалах аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж хандана. Үүнд:

А. Санхүүгийн дэмжлэг хүссэн тухай өргөдөл;

Б. Иргэний өөрийн болон хамтран ажиллах бусад иргэдийн иргэний үнэмлэхний хуулбар;

В.Аж ахуй, бичил бизнес эрхлэх үйл ажиллагааны төсөл, төлөвлөгөө;

Г. Гадаадад ажиллаж, амьдарч байгаад ирсэн бол гадаад паспорт, шаардлагатай бол эзэмшсэн мэргэжил, ур чадварыг тодорхойлох баримт бичиг.

2.2.1.3. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой чиглэл харгалзахгүйгээр зохион байгуулна. Хэрэв аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь орон нутгийн онцлогт чиглэсэн тодорхой чиглэлээр эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах бол Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

2.2.1.4. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд зарцуулах нийт хөрөнгийн 70 хүртэл хувийг 4 дүгээр сард, үлдсэн хувийг 9 дүгээр сард тус тус зарцуулахаар төлөвлөж, холбогдох арга хэмжээг зохион байгуулна.

2.2.1.5. 4 дүгээр сард зохион байгуулахдаа иргэдийг бүртгэх тухай зарлал, мэдээллийг жил бүрийн 2 дугаар сарын сүүлийн 7 хоногт нийтэд мэдээлэх бөгөөд 3 дугаар сарын 3 дахь 7 хоногт иргэдийн бүртгэлийн ажлыг зогсооно. Иргэдийн ирүүлсэн материал болон нөхцөл, байдалтай газар дээр нь танилцаж, санхүүгийн дэмжлэг авах шаардлага хангасан иргэдийг 4 дүгээр сарын 2 дахь 7 хоногт багтаан шалгаруулж дууссан байна.

2.2.1.6. 9 дүгээр сард зохион байгуулах санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг 7 дугаар сараас эхлэн энэхүү удирдамжийн 2.2.1.5-д заасан үйл ажиллагааг тухайн заагдсан хугацаанд багтаан зохион байгуулна.

2.2.1.7. Иргэдээс ирүүлсэн төслийг шалгаруулахдаа хэрэв өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу буюу хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хүрээнд эзэмшсэн мэргэжлийн дагуу үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт ирүүлсэн бол давуу тал болно. Энэ тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн сургалтын чадамжийн гэрчилгээг үндэслэл болгоно.

2.2.1.8. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн төлөлтийг гэрээний дагуу иргэнээр төлүүлж, хяналт тавих ба эргэн төлөлтийг аймаг, дүүрэг тус бүр өөрийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлнэ.

2.2.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр, хөтөлбөрүүдийн хүрээнд олгогдсон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг улирал бүрийн сүүлийн сарын 4 дэх долоо хоногт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлнэ.

2.2.1.10. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг иргэнд олгохдоо хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад хөтөлбөр, төслийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан хүнд давхардуулан[58] олгохгүй.

2.2.2.<u>Аж ахуй эрхлэлтийн сургалт явуулах арга хэмжээг зохион байгуулах</u>

2.2.2.1. Жижиг зээл болон энэхүү хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг авах төсөл ирүүлсэн болон шийдвэрлэгдсэн иргэд түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдаагүй аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг өөрсдийн хүсэлтэд нь үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулна.

2.2.2.2. Аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд сургалтын үйл ажиллагаанд хуваарилсан төсвийг тухайн багшийн замын зардал болон томилолтын зардалд зарцуулж болно. Төсвийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ажилтан багшийн урамшуулал болон цалинд зарцуулахгүй.

2.2.2.3. Жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжих, хяналт тавих <u>зорилгоор иргэ</u>д, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил

58 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдүгээр тогтоолоор баталсан хөтөлбөрүүдийн хүрээнд санхүүгийн дэмжлэгийг нэг иргэнд давхардуулан олгохгүй.

олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг аж ахуй эрхлэлтийн сургалтын зардалд хуваарилсан төсвийн 5 хүртэл хувиар зохион байгуулж болно.

2.2.2.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалтыг гаргахдаа Бизнес инкубатор төвүүдийн нэгдсэн холбооны саналыг харгалзан тогтооно.

2.2.3.<u>Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах</u>

2.2.3.1. Борлуулалтын цэгийг ажиллуулах зардлыг зөвхөн түрээсийн төлбөр болон урсгал зардал /цахилгаан, дулаан, интернет гэх мэт/-д зарцуулна. Борлуулалтын цэг дээр ажиллах борлуулагчид цалин, урамшуулал олгохгүйгээр буюу борлуулалтын цэгт хамрагдаж байгаа зорилтот бүлгийн иргэдийг тодорхой хуваарийн дагуу ажиллуулах, эсхүл зорилтот бүлгийн иргэдтэй харилцан тохиролцож, борлуулалтын орлогын тодорхой хувиар цалин, урамшууллыг олгох байдлаар зохион байгуулна.

2.2.3.2. Борлуулалтын цэгийг бизнес инкубатор төвөөр гэрээлэн ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд санхүүжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ"-нээс хэтрүүлэхгүйгээр олгоно.

2.2.3.3. Борлуулалтын цэг нь бараа, бүтээгдэхүүн борлуулахад дэмжлэг үзүүлж, борлуулалтын захиалга хүлээн авах, сурталчлах, худалдан авагчидтай холбох зэрэг арга хэмжээг зохион байгуулна.

2.2.3.4. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ажлын байр түрээсэлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдах шийдвэр гарсан иргэдэд үзүүлнэ.

2.2.3.5. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг тухайн ондоо багтааж дээд тал нь 6 сарын хугацаатай үзүүлэх ба хөнгөлөлтийг сар сараар нөхөн олгоно.

2.2.3.6. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт эдлэх хүсэлтэй зорилтот бүлгийн дараах шаардлагыг хангасан иргэдийг шалгаруулж, хамруулна. Үүнд:

А. Энэхүү хөтөлбөрийн зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй, бичил бизнес эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байх;

Б. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаагаа тасралтгүй 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар явуулсан байх;

В. Хүчин төгөлдөр хугацаа бүхий түрээсийн гэрээтэй байх;

Г. Бусад.

2.2.3.7. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх иргэдийг сонгон шалгаруулахад тухайн ажлын байранд ажиллаж байгаа ажилтнуудын тоо нь давуу тал болно.

2.2.3.8. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулахад чиглэсэн нэгдсэн үзэсгэлэн, яармагийг жилд 5 сая хүртэл төгрөгт багтаан зохион байгуулах ба холбогдох зардлыг батлагдсан төсвийн "Борлуулалтын дэмжлэг"-т хуваарилсан

хөрөнгөөс санхүүжүүлнэ.

2.2.3.9. Иргэн нь түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд үйлдвэрлэлийн, эсхүл үйлчилгээний аль нэг чиглэлээр хамрагдана. Үйлчилгээний төрөлд хүнсний болон бэлэн бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа хамрахгүй болно.

2.2.3.10. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрт хамрагдаж буй иргэний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадаад оронд зарж борлуулах тухай саналаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж болно.

2.2.3.11. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа Бизнес инкубатор төв нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, борлуулалтын цэг ажиллуулах зэрэг үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах гэрээ байгуулж, зардлын жишгийг баримтлан санхүүжүүлж болно.

2.2.4.<u>Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах</u>

2.2.4.1. Ажил олгогчид урамшуулал, санхүүгийн дэмжлэг олгох тухай гэрээг ажил олгогч болон ажлын байраар хангагдаж байгаа иргэний оршин суугаа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс байгуулж, санхүүжилтийг хариуцна.

2.2.4.2. Ажил олгогчийн урамшуулал, санхүүгийн дэмжлэгийг авахаар гэрээ байгуулсан ажил олгогч урамшууллаа авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж холбогдох байгууллагад хандана. Үүнд:

А. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
Б. Ажил олгогч, ажилтны хүсэлт;
В. Ажилтны иргэний үнэмлэхний хуулбар;
Г. Ажилтан зорилтот бүлгийн иргэн мөн болохыг нотолсон баримт бичиг, тодорхойлолт;
Д. Хөдөлмөрийн болон бусад гэрээний хуулбар;
Е. Ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
Ё. Ажил олгогчийн хүн амын орлогын болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай болон татвар шимтгэлийн өргүй талаарх Татварын болон Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;
Ж. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэстэй байгуулсан гэрээ;
З. Ажилтны цалингийн картны хуулга;
И. Бусад.

2.2.4.3. Ажил олгогчийн дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэнийг ажлын байраар хангаж, тасралтгүй 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллуулсан, цаашид үргэлжүүлэн ажиллуулах ажил олгогчид олгоно. (тасралтгүй 12 сар ажилласан боловч ажлаасаа гарсан иргэний тухайд ажил олгогчид дэмжлэг олгохгүй)

2.2.5. <u>Ажил хайгч иргэн, оюутан, суралцагчийг цагийн ажилд зуучилж, орлого нэмэгдүүлэх арга хэмжээ</u>

2.2.5.1. Арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь “Ажил хайгч иргэн, оюутан, суралцагчдийг цагийн ажилд зуучлах зөвлөмж”-ийг хөтөлбөрийн зүйл, заалтад нийцүүлэн баталж,

зохицуулалтаар хангаж ажиллана.

2.2.5.2. Хөтөлбөрийн 9.4-т заасан арга хэмжээний хүрээнд Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь явуулын болон хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг хөдөлмөрийн зуучлалын байгууллага, салбарын ажил олгогчдыг оролцуулж тухай бүр зохион байгуулна.

2.2.6.Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулах

2.2.6.1.Арга хэмжээг орон нутгийн захиргааны эрх бүхий байгууллагаас нэгдсэн зохион байгуулалттайгаар газар дээр иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хамруулж, хэрэгжүүлнэ.

2.2.6.2.Иргэдийг сонгохдоо Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс зарлал мэдээлэл, сурталчилгааг явуулж, бүртгэнэ. Бүртгэгдсэн иргэдэд арга хэмжээний талаар танилцуулга хийж, өөрийнх нь хүсэлтэд тулгуурлан арга хэмжээнд хамруулна. Хэрэв арга хэмжээнд хамрагдахаар бүртгүүлсэн иргэдийн тоо Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн төлөвлөсөн тооноос давбал бүлгээр ажиллах иргэдийн саналыг харгалзан шалгаруулна.

2.2.6.3.Арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг иргэдийн цалин, урамшуулал, хоолны зардалд бус хүнсний ногоо тариалахтай холбоотой үр бордоо, бага оврын багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, хашаа, хайс, хүлэмж барих, худаг гаргах, амралтын гэр, байр барих зэрэг болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, бусад холбогдох үйл ажиллагааны зардалд зарцуулна.

2.2.6.4.Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэнийг нэн тэргүүнд хамруулах чиглэл баримтлана.

2.3.Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.3.1.Гарааны бизнесийг дэмжих

2.3.1.1.Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг туршилтаар хэрэгжүүлж буй аймаг, дүүргүүдэд зохион байгуулж буй арга хэмжээнд бусад аймаг, дүүргүүд нь ажиглагчаар оролцож, туршлага судална.

2.3.1.2. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь дүүргүүдэд гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, ажлын хэсэг болон холбогдох төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, хамтран гүйцэтгэнэ.

2.3.1.3. Хөтөлбөрийн 4.3-т зааснаар зохион байгуулах арга хэмжээнд зарцуулах төсвийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хуваарилсан "Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ"-нд төсөвлөсөн хөрөнгөнөөс санхүүжүүлж, хяналт тавьж ажиллана.

2.3.2.Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох

2.3.2.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэг нь өөрийн эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нь энэхүү арга хэмжээнд сонгогдон хамрагдах давуу тал болно.

2.3.2.2.Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг зөвхөн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад зарцуулахаас гадна шаардлагатай

бараа материал, түүхий эд худалдан авахад зориулж болно. Бараа материал, түүхий эд худалдан авах зардал нь санхүүгийн дэмжлэгийн 30 хувиас ихгүй байна.

2.3.2.3.Шалгарсан төслийн санхүүжилтыг тухайн төгсөгчийн болон төгсөгчдийн бүлгийн ахлагчийн нэрийн дансанд шилжүүлэх бөгөөд зориулалтын дагуу зарцуулахад нь аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн холбогдох ажилтан /ажлын хэсэг/ хяналт тавьж ажиллана.

2.3.2.4.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон бүлгийг 3 дугаар сард эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамруулах арга хэмжээнд хуваарилагдсан хөрөнгийн 70 хүртэл хувийг зарцуулах ба арга хэмжээний талаарх мэдээллийг жил бүрийн 2 дугаар сарын эхний долоо хоногоос эхлэн төгсөгчдөд сурталчлан мэдээлэх бөгөөд 3 дугаар сарын 1 дэх долоо хоногт төгсөгчдийг бүртгэж дуусгасан байна.

2.3.2.5.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс төгсөгчийн ирүүлсэн төсөл, мөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх ажлын байртай[59] танилцан, санхүүгийн дэмжлэг авах шаардлага хангасан төгсөгч болон бүлгийг мөн сарын 3 дахь 7 хоногт багтаан шалгаруулж дууссан байна.

2.3.2.6.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон бүлгийг 8 дугаар сард эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамруулах арга хэмжээг жил бүрийн 7 дугаар сараас эхлэн энэхүү удирдамжийн 2.3.2.4, 2.3.2.5-д заасан тухайн хугацаануудад багтаан зохион байгуулна.

2.3.2.7.Төгсөгч болон төгсөгчийн бүлэг нь үйлдвэрлэл, аж ахуй эрхлэн арга хэмжээнд хамрагдахаар хөтөлбөрийн 5.2-т заасан хүсэлтийг дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

А. Төгсөгч болон бүлгийн гишүүдийн хүсэлт; иргэний үнэмлэхний хуулбар;

Б. Мэргэжлийн диплом, гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар;

В. Үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх болон хэрэгжих үндэслэлтэй бизнесийн төсөл, үр ашиг, орлого нэмэгдүүлэх тооцоо судалгаа, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх;

Г. Төслийг нөхөрлөл, хоршоо, бүлгийн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх бол гишүүд, оролцогчдын үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг бичгээр тодорхойлсон байх;

Д. Бусад

2.3.2.8.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төслийн шалгаруулалтын дүн шийдвэрийн талаар төсөл хэрэгжүүлэх хүсэлтээ ирүүлсэн бусад төгсөгч болон бүлэгт нээлттэй, ил тод мэдээлнэ. Төслийн шалгаруулалттай холбоотой гарсан маргааны асуудлыг бүрэн хариуцан хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

2.3.3.<u>Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ</u>

2.3.3.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь бизнес инкубацийн үйлчилгээг зохион байгуулах эрх бүхий бизнес инкубатор төвүүдийн жагсаалтыг гаргахдаа бизнес инкубатор төвүүдийн нэгдсэн холбооны саналыг харгалзан үзнэ.

2.3.3.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь тус арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг эрх бүхий бизнес инкубатор төвд хуваарилахдаа, хөтөлбөрт

59 Өөрийн эзэмшлийн эсвэл шинээр түрээслэн үйл ажиллагаа явуулах ажлын байр байж болно.

хамрагдсан төгсөгч болон төгсөгчдийн бүлгийн тоог харгалзан холбогдох хууль, журмын хүрээнд хуваарилж, гэрээ байгуулж ажиллана.

2.3.3.3. Гарааны дэмжлэгт хамрагдсан залуучууд, МБСБ-ын төгсөгч болон төгсөгчдийн бүлгийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг энэхүү хөтөлбөрийн хүрээнд болон www.hudulmur-halamj.mn цахим цэс, гадаад борлуулалт, аймаг, дүүрэг бүрт байгуулсан борлуулалтын цэгүүд болон нэгдсэн үзэсгэлэн, яармаг, арга хэмжээний хүрээнд холбогдох байгууллагууд хариуцан зохион байгуулна.

2.3.3.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь түрээсийн хөнгөлөлтийг үзүүлэхдээ "Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ"-гээр тооцож олгоно.

2.4.Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.4.1.Малчин өрхийг малжуулах арга хэмжээ

2.4.1.1.Сумын амьжиргааг дэмжих зөвлөл нь арга хэмжээнд хамрагдах малчин өрхийн нэрсийн жагсаалт, холбогдох мэдээлэл бүхий саналыг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэн аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ирүүлэх бөгөөд газар нь малчин өрхийг арга хэмжээнд хамруулах тухай эцсийн шийдвэрийг гаргана.

2.4.1.2. Арга хэмжээнд дараах шаардлагыг хангасан малчин өрхийг хамруулна. Үүнд:

А. Арга хэмжээнд хамруулах хүсэлт гаргасан байх;

Б. 15-39 насны 2-доошгүй гишүүнтэй /бусад насны гишүүдийн тоо хамаарахгүй бөгөөд тайлангийн маягтад бусад гишүүдийн тоог тусгана./ малчин өрх байх;

В. Хөтөлбөрийн 2.2.1-д заасан толгой малтай байх;

Г. Хөтөлбөрт хамрагдах малчин өрх нь малжуулах арга хэмжээнд хамрагдахдаа боловсруулсан төлөвлөгөө, төсөлтэй байх;

Д. Эргэн төлөлтийг хийх хуваарийг тусгасан төлөвлөгөө гаргасан байх.

2.4.1.3. Сонгогдсон малчин өрх малжуулах дэмжлэгийн эргэн төлөлтийг мал худалдан авч өгсөн өдрөөс хойш 24 сарын дотор мөнгөн хэлбэрээр хийх ба малчин өрхийн өөрийн боломжид тулгуурлан боловсруулсан "Эргэн төлөлт хийх төлөвлөгөө"-г малчин өрх, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон сумын Засаг дарга нарын гурвалсан гэрээнд хавсаргана.

2.4.1.4. Эргэн төлөлтийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлнэ.

2.4.1.5. Бог малд шилжүүлснээр 50 хүртэл толгой малтай малчин өрхийг дадлагажуулагчийг сонгохдоо арга хэмжээнд хамрагдах малчин өрхийн ойр дотны хамаатан садан, айл саахалтын хүмүүс болон найз нөхдийг нь сонгохыг удирдамжийн хүрээнд зөвлөж байна.

2.4.1.6. Малчин өрхийг малжуулах арга хэмжээг Улаанбаатар хотын алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд хэрэгжүүлж, хөрөнгийг хуваарилах бөгөөд тухайн дүүргүүд хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу арга хэмжээг зохион байгуулна.

2.4.2.Аж ахуй эрхлэлтийн, мал маллагааны болон малын ашиг шим боловсруулах сургалт, туршлага солилцох уулзалт, бусад арга хэмжээг зохион

байгуулах

2.4.2.1.Аж ахуй эрхлэлтийн сургалт, мал маллагааны болон малын ашиг шим боловсруулах сургалт, туршлага солилцох уулзалтыг зөвхөн малжуулах арга хэмжээнд хамрагдаж байгаа малчин өрхөд зориулан зохион байгуулна.

2.4.2.2.Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн аж ахуйг аймаг, дүүрэгт байгуулсан Борлуулалтын цэгээр дамжуулан дэмжинэ.

2.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

2.5.1.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ

2.5.1.1.Хөтөлбөрийн 3.2.2-т заасан арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэйн улмаас нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг түлхүү хамруулна.

2.5.1.2. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулах сургалтыг эрх бүхий байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ба сургалт зохион байгуулах байгууллагын жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас гаргана.

2.5.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжлэгтэйгээр ажилд зуучлах

2.5.2.1.Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах арга хэмжээнд хамрагдахаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ажил хөдөлмөр эрхлэх хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг Хөдөлмөрийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 08 ны А/04 тушаалаар батлагдсан “Ажил хайгч иргэний бүртгэл”-д, ажил олгогчоос ирүүлсэн захиалгыг “Ажлын байрны захиалгын мэдээлэл”-д хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломжтой эсэх лавлагааг тодорхой асууж, бүртгэнэ.

2.5.2.2. Дээрх бүртгэлд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажил, мэргэжлийн чиг баримжаа, сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, хөдөлмөрийн харилцааны суурь мэдлэг олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх болон ажлын байранд зуучилна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлагдсан “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ”-ний зардлын жишгийн дагуу санхүүжүүлнэ.

2.5.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломжит ажлын байрны нөхцөл, тоноглол, тохируулгын талаар ажил олгогчид зөвлөгөө өгөх, хамт олонд түшиглэн нийгэмшүүлэх, харьцааны ур чадвар, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн горимд дасан зохицох ярилцлагад ороход нь туслах үйлчилгээг ажлын 5 өдөр хүртэлх хугацаанд хөтөч, дохионы хэлмэрчийн оролцоотой зохион байгуулна. Дээрх үйлчилгээг үзүүлэхэд ажилласан хөтөч, дохионы хэлмэрчийн урамшууллыг ажилласан цаг, давтамж, ажил олгогчийн тодорхойлолтыг үндэслэн хөтөлбөрийн 3.3.3-т заасны дагуу олгоно.

2.5.3.Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ

2.5.3.1.Уг арга хэмжээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй иргэн дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

А. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хугацаа нь хүчинтэй, тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх болон хөгжлийн бэрхшээлтэй

иргэний биеийн байдал нь төслөө хэрэгжүүлэх боломжтой байх;
Б. Албан ёсоор оршин суугаа харьяаллын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлж, санхүүгийн дэмжлэгт хамрагдах өөрийн хүсэлтээ бичгээр илэрхийлсэн байх;
В. Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хэрэгжих үндэслэлтэй бизнесийн санаа, сонирхол, үр ашиг, орлого нэмэгдүүлэх тооцоо судалгаатай төсөл, үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн саналыг боловсруулсан байх;
Г. Төслийг нөхөрлөл, хоршоо, бүлгийн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх бол гишүүд, оролцогчдын үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг бичгээр тодорхойлсон байх.

2.5.3.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрийн 3.4.1.-т заасан зар мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг тодорхой төлөвлөгөө хуваарийн дагуу орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулж, байнгын ажлын байр бий болгох төсөл сонгон шалгаруулалтыг нийтэд зарлана.

2.5.3.3. Хөтөлбөрийн 3.4.4.-т заасан арга хэмжээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг сонгон шалгаруулалтын удирдамжийн дагуу зохион байгуулна. Ажлын хэсгийн гуравны нэгээс доошгүй бүрэлдэхүүнд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалсан тухайн орон нутгийн төрийн бус байгууллага, холбоодын хоорондоо зөвшилцсөн төлөөллийг оролцуулна.

2.5.3.4. Санхүүгийн дэмжлэгт хамруулах төслүүдийг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс тухайн оны эхний болон 3 дугаар улиралд багтаан сонгон шалгаруулна. Сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор сонгон шалгаруулалтын дүн шийдвэрийн талаар төсөл хэрэгжүүлэх саналаа ирүүлсэн иргэд болон нийтэд ил тод мэдээлнэ.

2.5.3.5.Сонгон шалгаруулалтанд тэнцсэн төсөл хэрэгжүүлэгчтэй “Аж ахуй, бичил бизнес эрхлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн гэрээ”-ний загварын дагуу гэрээ байгуулж, талууд баталгаажуулна.

2.5.3.6. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь төсөл хэрэгжүүлж буй иргэний мэдээллийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн иргэний бүртгэл”-д буюу батлагдсан маягтын дагуу бүртгэнэ.

2.5.4.<u>Борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх арга хэмжээ</u>

2.5.4.1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ба “Борлуулалтын цэг”-т байршуулан борлуулах дэмжлэг үзүүлнэ.

2.5.4.2.Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ажлын байр түрээсэлж байгаа хөтөлбөрийн 3.5.2.-т заасан иргэнийг хамруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар шинэчлэн батлагдсан зардлын хэмжээгээр тооцон, тухайн жилдээ багтаан дээд тал нь 6 сарын хугацаатай үзүүлэх ба хөнгөлөлтийг сар бүр нөхөн олгоно.

2.5.5.Аж ахуй эрхлэлтийн болон хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

2.5.5.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан хөтөлбөрийн 3.7.2-т заасан сургалтын аль нэг төрлийг сонгон хамруулна.

2.5.5.2.Аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хүрээнд хөтөч, дохионы хэлмэрчийг бэлтгэх, хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжааны сургалт болон хөгжлийн бэрхшээлийн бусад төрөл хэлбэрт хамаарах нэмэлт сургалтыг хөдөлмөр эрхлэлтийн болон аж ахуй эрхлэлтийн сургалтын зардлаас зохион байгуулж болно.

2.5.5.3.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь сургалтыг “Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-нд дурдсан мэргэжлийн дагуу сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага хангасан гэрчилгээтэй, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусаагүй, эрх бүхий сургалтын байгууллага, иргэнтэй гэрээлэн гүйцэтгүүлнэ.

2.5.5.4.“Мэргэжлийн болон давтан сургалтад нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-ний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн сургалтын зардлын хэмжээг 30 хувиар нэмэгдүүлэн тооцох нь зөвхөн мэргэжлийн ур чадварын сургалтанд хамаарна.

2.5.5.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэл дээрх сургалтыг “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн 5.3.1-5.3.2, 5.3.5-5.3.7 дахь заалтуудад нийцүүлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулна.

2.5.5.6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний шавь сургалтыг зөвхөн мэргэжлийн ур чадвар олгох чиглэлээр өндөр ур чадвар бүхий иргэнтэй хамтран зохион байгуулах бөгөөд шавь сургалтын үргэлжлэх хугацаа нь 1-6 долоо хоног байна. Шавь сургалтын нэг хүнд ногдох зардлын хэмжээг “Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-ний “Мэргэжлийн сургалтын зардлын хэмжээ”-тэй дүйцүүлж, санхүүжүүлнэ. Шавь сургалтын зардалд хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн сургалтын 30 хувийн нэмэгдлийг тооцохгүй болно.

2.5.5.7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орон зайн чиг баримжааны сургалт болон хөтөч, дохионы хэлмэрчийг бэлтгэх анхан шатны нэг удаагийн сургалтын үргэлжлэх хугацаа нь 5 хоног байх бөгөөд сургалтыг эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага болон иргэнтэй хамтран зохион байгуулна. Сургалтын зардлыг “Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-ний “Мэргэжлийн сургалтын зардлын хэмжээ”-нд заасан хамгийн өндөр “5 ажлын өдөрт ногдох зардлын хэмжээ”-гээр буюу 46700 төгрөгөөр дүйцүүлж, санхүүжүүлнэ. Эдгээр сургалтын зардалд хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн сургалтын 30 хувийн нэмэгдлийг тооцохгүй болно.

2.5.6.Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

2.5.6.1.Хөтөлбөрийн 4.2.1-д заасан урамшуулалд хамрагдах хүсэлтэй ажил олгогч нь хөтөлбөрийн 2.1-д тодорхойлсон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авах тухай шийдвэр, хүсэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст гаргаж, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид урамшуулал олгох гэрээ”-ний загварын дагуу гэрээ байгуулж, талууд баталгаажуулна.

2.5.6.2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь дээрх гэрээний хэрэгжилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллаж байгаа байнгын ажлын байрны тогтвортой байдалд тогтмол хяналт тавина.

2.5.6.3.Хөтөлбөрийн 4.2.1-д заасан урамшууллыг дараах баримт бичгийг үндэслэн аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс олгоно. Үүнд:

А. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
Б. Ажил олгогч, ажилтны хүсэлт;
В. Ажилтны иргэний үнэмлэхний хуулбар;
Г. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссийн хүчинтэй шийдвэр;
Д. Хөдөлмөрийн гэрээний хуулбар;
Е. Ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
Ё. Ажил олгогчийн хүн амын орлогын болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай болон татвар шимтгэлийн өргүй талаарх Татварын болон Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;
Ж. Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй байгуулсан гэрээ;
З. Ажилтны цалингийн картны хуулга;
И. Бусад.

2.5.6.4.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь байнгын ажлын байртай болж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон урамшуулалд хамрагдсан ажил олгогчийн талаарх мэдээллийг "Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-д бүртгэнэ.

2.5.7.<u>Тохируулгатай ажлын байрны санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ Үүнд:</u>

2.5.7.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тохируулгатай байнгын ажлын байрыг бий болгоход олгох санхүүгийн дэмжлэгийн сонгон шалгаруулалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу тухайн оны 3-4 сард багтаан зохион байгуулна.

2.5.7.2.Санхүүгийн дэмжлэгийн 70 хувийг төсөл эхлүүлэхээр гэрээ байгуулсны дараа, үлдсэн хувийг төслийн хэрэгжилтийн явцын болон үр дүнгийн тайлан мэдээг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг олгоно.

2.5.7.3.Уг арга хэмжээнд хамрагдах байгууллагуудыг өргөжүүлэх, үр дүнг сайжруулах, тохируулгатай ажлын байр нэмэгдүүлсэн байх зарчмыг баримтлан ажиллана.

2.6.Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

Хөтөлбөрийн хамрах хүрээг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

-"ахмад мэргэжилтэн" гэж зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэхээр аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлсэн, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд тус тус заасан тэтгэвэр авагч /хүчин төгөлдөр тэтгэврийн дэвтэртэй/ ахмад настанг;

-"Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, төрийн бус байгууллага" гэж Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4

дүгээр зүйлд заасан хуулийн этгээдийг;

-"Ахмад мэргэжилтний зөвлөх баг" гэж нийгэм, эдийн засгийн тодорхой салбар, мэргэжлийн чиглэлээр ахмад настны эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын 3 ба түүнээс дээш гишүүнтэй тэтгэвэр авагч ахмад мэргэжилтнүүдийн баг, бүлгийг;

-"Мэргэжлийн өндөр ур чадвартай" гэж хувь хүний гоц буюу ховор авьяас, мэргэжил, өндөр ур чадвар, нарийн мэргэшил, мэдлэгийн эрх /диплом, сертификат, гэрчилгээ гэх мэт/ эзэмшсэн хүнийг тус тус ойлгоно.

2.6.1. <u>Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах</u>

2.6.1.1."Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ"-нд хамрагдах боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон төрийн захиргааны салбарт зөвлөгөө үзүүлэх ахмад мэргэжилтэнг тухайн сум, дүүрэг, хорооны онцлогийг харгалзан аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс тодорхойлж, хэрэгжүүлнэ.

2.6.1.2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь тухайн салбарт мэдлэг туршлагатай, тэтгэврийн насны ахмад иргэдэд сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

2.6.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бусад хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд зөвлөгөө өгөх, хяналт тавих ажлыг хамтран гүйцэтгэж болно.

2.6.1.4.Мэдээлэл сурталчилгааны үр дүнд төсөлд хамрагдах хүсэлтэй ахмад мэргэжилтэн оршин суух харьяаллын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

А. Төслийг хэрэгжүүлэх тухайн сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

Б. Төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлт;

В. Иргэний үнэмлэхний хуулбар, түүний танилцуулга;

Г. Зөвлөгөө өгөх ажил үйлчилгээний төрөл, арга хэлбэр, хугацаа, гарах үр дүн, санхүүжилтийн тооцоо болон бусад шаардлагатай зүйлийг тусгасан төсөл, төлөвлөгөө;

Д. бусад шаардлагатай лавлагаа.

2.6.1.5.Төслийн сонгон шалгаруулалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ахмадын төрийн бус байгууллагын төлөөллийг зөвшилцөн оролцуулна.

2.6.1.6.Сонгон шалгаруулалтанд тэнцсэн төсөл хэрэгжүүлэгчтэй Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар баталсан гэрээний загварын дагуу "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулж, баталгаажуулна.

2.6.1.7.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст нь шаардлагатай тохиолодолд ахмад мэргэжилтний зөвлөгөө өгөх зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулах байр, техник хэрэгсэл, хамрагдах иргэдийн оролцоог хангах талаар сум, хороо, нутгийн захиргааны байгууллагатай хамтран дэмжлэг үзүүлнэ.

2.6.2.<u>Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх</u>

2.6.2.1.Хөтөлбөрийн 5.1.-д заасан ахмад мэргэжилтний

багийн зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд Засгийн газрын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “олон нийтийн байгууллагаас улс орныг хөгжүүлэх, төр, нийгмийн байгууллыг бэхжүүлэх, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангахад тус дөхөм үзүүлэх талаар гаргасан санал, санаачилгыг дэмжих шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тэдгээр байгууллагатай харилцан ажиллана.”, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Төрийн байгууллага төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болно”, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө” зэрэг холбогдох заалтуудыг үндэслэл болгоно.

2.6.2.2.Төсөлд хамрагдах ахмад мэргэжилтний зөвлөх баг нь төсөл хэрэгжүүлэх тухайн салбарт мэргэшсэн, 3-аас доошгүй гишүүнтэй байна. Төсөл хэрэгжүүлэх баг нь өөрийн үйл ажиллагааны талаарх асуудлаар удирдах дээд, төв байгууллагаараа уламжлан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай гэрээ байгуулан ажиллана.

2.6.2.3.Төсөл хэрэгжүүлэхээр шалгарсан байгууллага, зөвлөх баг нь тухайн салбарт хэрэгцээтэй байгаа ахмад мэргэжилтний туршлага, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, нарийн мэргэжлийн гарын авлага, арга зүйн зөвлөмж, ном товхимлыг төслийн өртөгтөө багтаан боловсруулж, хэвлэх зардалд зарцуулж болно. Төслийн нийт өртөгийн 10 хувиас хэтрэхгүй байна.

2.6.2.4.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь тухайн аймаг, сум, дүүрэг, хороонд төсөл хэрэгжүүлэгч ахмад мэргэжилтнүүдийн зөвлөх багтай байнгын харилцаатай байж, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, үнэлгээ хийнэ.

2.6.3.<u>Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх</u>

2.6.3.1.Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх ахмад настан нь өөрийн амьдралын явцад олж авсан, мэдлэг, туршлагадаа тулгуурлан өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлнэ.

2.6.3.2.Мэдээлэл сурталчилгааны үр дүнд төсөлд хамрагдах хүсэлтэй ахмад настан оршин суух харьяаллын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

А. Төслийг хэрэгжүүлэх тухайн сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
Б. Төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлт;
В. Иргэний үнэмлэхний хуулбар;
Г. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх хугацаа, гарах үр дүн, санхүүжилтийн тооцоо болон бусад шаардлагатай зүйлийг тусгасан төсөл, төлөвлөгөөтэй байх;
Д. Бусад шаардлагатай лавлагаа.

## Гуравдугаар бүлэг. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах

3.1.<u>Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.</u>

3.1.1.Хөдөлмөрийн зах зээлд оролцогчдыг нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;

3.1.2.Ажил,мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

3.1.3.Ажилд зуучлах.

3.2.Хөдөлмөрийн зах зээлд оролцогчдыг нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах

3.2.1. Нэгдсэн бүртгэл мэдээллийн үйлчилгээ нь ажил хайгч иргэнийг ажлын байр, түүнд тавигдах шаардлага, ажил мэргэжлийн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санд иргэний мэдээллийг ХЗЗ-2 маягтын дагуу оруулж бүртгэх цогц арга хэмжээ, үйлчилгээнээс бүрдэнэ.

3.2.2.Мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг нь хөдөмөр зах зээлд оролцогч ажил олгогч байгууллага, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын мэдээллийг ХЗЗ-1 маягтын дагуу хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хангахад чиглэнэ.

3.2.3.Мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд ажил хайх, ажил олоход туслалцаа үзүүлэхэд чиглэсэн тодорхой ажил мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ажил мэргэжлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, нэгдсэн мэдээллийн сангийн боловсруулсан мэдээллийг ажил хайгч иргэдэд хүргэх, олон нийтэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах нөхцлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах суурь үйлчилгээ хамаарна.

3.3.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах

3.3.1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд Ерөнхий боловсролын сургуулийн /ЕБС/ сурагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилгүй иргэдэд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцлийн талаар зөвлөгөө өгөх хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ хамаарна.

3.3.2.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулж, батлагдсан зардлын жишгийн дагуу санхүүжүүлнэ.

3.3.3.Мэргэжлийн мэдээллийн жишиг үйлчилгээ үзүүлэх журам, уг үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр, агуулгыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батлах бөгөөд жишиг үйлчилгээ нь онлайн хэлбэрээр хэрэгжих ба үйлчилгээнд ажил хайгч иргэд, хүүхэд, залуучуудыг хамруулна.

3.3.4.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулах бөгөөд үргэлжлэх хугацаа нь ажлын 3 өдрөөс хэтрэхгүй байна.

3.3.5.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн болон сум, хороо, тосгоны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, мөн эрх бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

3.4.Ажилд зуучлах үйлчилгээ

3.4.1. Ажилд зуучлах үйлчилгээ нь ажлын байрыг судлах, ажил

олгогчийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, ажил хайгчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажлын байранд тохирох эсэх, хувь хүний болон ур чадварын үзүүлэлтийг шинжлэх, хоёр талын хэрэгцээнд нийцсэн туслалцаа үзүүлэх үйлчилгээ хамаарна.

3.4.2.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байгууллагад тавих шаардлага стандартыг хангасан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх байгууллага нь харьяалах орон нутгийн болон салбарын онцлог, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогод нийцүүлэн ажилд зуучлах үйлчилгээний байгууллагын стандарт, журмуудыг боловсруулан мөрдөж, үйлчилгээний гүйцэтгэлийг хэмжих шинэ арга хэрэгсэл боловсруулж хэрэгжүүлнэ.

3.4.3.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандартын дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлж буй орчныг үйлчлүүлэгчдэд ээлтэй, илүү үр дүнтэй, үр ашигтай үйлчилгээ үзүүлэх боломжтой болгон шинэчлэн зохион байгуулна. Үүнд:

-Үйлчлүүлэгчдийг хүлээж авах хэсэгт компьютерууд байрлуулах,

-Үйлчлүүлэгчид өөрсдийгөө бүртгэх, ажил хайх боломж бүрдүүлэх,

-Ганцаарчилсан зөвлөгөө өгөх, ажил хайх сургалт семинар, бүлгээр зөвлөгөө хийх боломж бүрдүүлэх,

-Ажил хайгч иргэдийг тохирсон ажлын байранд зуучлах /жоб матчинг хийх/,

-Нэгдсэн болон төрөлжсөн бирж ажиллуулах /цагийн ажилд зуучлах болон хувийн зуучлалын байгууллагын үйлчилгээ/,

-Ажлын байрны нэгдсэн зар мэдээ,сүлжээ, сайт бий болгох,

-Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, үйлчилгээний талаарх сурталчилгаа, өдөрлөг зохион байгуулах.

3.4.4.Ажил олгогч нарт зориулсан үйлчилгээг сайжруулах, ажлын байранд зуучлах үйлчилгээнд доорх арга хэмжээг хамруулна .Үүнд:

-Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сан дахь ажлын байрны захиалгын тоо, чанарыг сайжруулах, шинэчлэх үйл явцыг тодорхой болгох,

-Ажлын байрны захиалгыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд холбогдох боломжтой болгох,

-Ажил олгогчдод шаардлагатай ажилтныг холбож өгөх, мэдээллийн үйлчилгээ /онлайн зуучлалын үйлчилгээ/

-Ажил олгогчид ажлын байрны захилгаа бүртгүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сан болон бусад хувийн хэвшлийн ажлын байрны мэдээллийн санг ашиглах нөхцлийг бүрдүүлэх,

-Ажил олгогчийн ажлын байрны шилжилт хөдөлгөөний мэдээллийг тогтмол хугацаанд авч хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санг баяжуулах.

3.4.5.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахад чиглэсэн ажилд зуучлалын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх гарын авлага, зөвлөмжийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газраас боловсруулна.

3.4.6.Аймаг, нийслэлийн хэмжээнд хөдөлмөрийн нэгдсэн болон төрөлжсөн бирж ажиллуулах /цагийн ажилд зуучлах болон хувийн хөдөлмөр зуучлалын байгууллагын үйлчилгээ/ нэгдсэн зар мэдээ, сүлжээ, цахим хуудас бий болгох, сурталчилгаа, өдөрлөг зохион байгуулна.

3.4.7.Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржүүдийн

үйл ажиллагаанд тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага, стандартын дагуу тодорхойлж, стандартын шаардлага хангасан дүгнэлтийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар гаргах ба бүргэж, гэрчилгээ олгоно.

-----o0o-----

# ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 дугаар сарын 24-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар А/63

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн холбогдох бичиг баримтыг батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/26 дугаар тушаалын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд арга хэмжээ, үйл ажиллагааны төрөл тус бүрээр талуудын байгуулах гэрээний загварыг нэгдүгээр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн тайлангийн маягтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн гэрээний загвар, тайлангийн маягтыг мөрдөж ажиллахыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газарт, хэрэгжилтийг арга зүйгээр хангаж зохион байгуулахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар /Ч.Саналбаяр/-т даалгасугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт, мониторингийн газар /Ч.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА Б.НЯМДАВАА

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-1*

# АЖИЛ ОЛГОГЧИД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

................. хот/аймаг №  20 ... оны ... сарын ... өдөр

Энэхүү гэрээг .................... аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ хэлтэс /(цаашид А тал гэх) ............... аж ахуйн нэгж, байгууллагын эзэн/удирдлага (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 7.4-т заасан ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгоход үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... сарын ... өдрөөс 20 ... оны ... сарын ... өдөр хүртэл байгуулав.

## Нэг.Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажилд авч ажиллуулахтай холбоотой гарсан зардлын тодорхой хэсгийг нөхөн төлөх, ажлын байранд тухайн иргэнийг тогтвортой ажиллуулахыг урамшуулах, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, бизнесээ хөгжүүлэхэд дэмжихэд оршино.
1.2 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талууд гэрээ байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.
1.3 Зорилтот бүлгийн иргэн ......... регистрийн дугаар бүхий ...................... овогтой ............ ийг Б тал 20 … оны ..... сарын ......-ны өдөр ажилд авч, тогтвортой ажиллуулах бөгөөд ажилд орсон өдрөөс хойш 12 сарын дараа тухайн ажилтанд нэг жилийн хугацаанд олгосон цалин хөлстэй тэнцэх хэмжээний/сар бүр олгосон үндсэн цалингаар тооцож/ санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/18 тоот тушаалаар баталсан “Дээд хэмжээгээр тооцох нэг сарын цалингийн хэмжээ”-ний хүрээнд А тал Б талд олгохоор харилцан тохиролцов.
1.4 Энэхүү санхүүгийн дэмжлэгийг холбогдох бичиг баримтыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлж олгоно.

## Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Гэрээнд заасан үүргээ биелүүлсэн ажил олгогчийн холбогдох материалыг хянан үзэж, санхүүгийн дэмжлэгийг ажил олгогчийн ................. банкин дахь .................... тоот дансанд хүсэлт гаргасан өдрөөс хойш ажлын ......... хоногт багтаан шилжүүлнэ.
2.2 Хөтөлбөрт хамрагдсан иргэний хөдөлмөр эрхлэлтийн байдал, зохистой хөдөлмөр эрхлэлтийн явц, Б талын ажлын байранд хяналт тавина.
2.3 Ажил олгогч болон ажлын байраар хангагдсан иргэний талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулна.
2.4 Ажил олгогч болон ажлын байраар хангагдсан иргэнийг холбогдох мэдээ, мэдээллээр хангана.
2.5 Ажлын байраар хангагдсан иргэний хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаарх

мэдээ тайланг тогтоосон хугацаанд Б талаас авна.
2.6 Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авна.

**Гурав. Б талын эрх, үүрэг**

3.1 Иргэн ................ овогтой ............ ийг үндсэн ажилтнаар авч 12 сараас дээш хугацаагаар ажиллуулсан буюу цаашид тогтвортой ажиллуулсан байна.
3.2 Дээрх иргэнийг ажиллуулахдаа тухайн иргэний Нийгмийн даатгалын шимтгэл болон хууль, тогтоомжид заасан бусад татвар, шимтгэлийг тухай бүр төлсөн байна.
3.3 Хөтөлбөрт хамрагдсан иргэн өөрийн хүсэлтээр ажлын байраа орхиж явсан, ажлаас чөлөөгдсөн, Б талын санаачлагаар Хөдөлмөрийн гэрээг цуцалсан тохиолдолд А талд даруй мэдэгдэнэ.
3.4 Ажлын байраар хангагдсан иргэний хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаарх мэдээ тайланг тогтоосон хугацаанд А талд ирүүлнэ.
3.5 Ажлын байраар хангагдсан иргэнд тухайн ажлын байранд шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөгөө мэдээллийг өгнө.
3.6 Байгууллагын байршлын шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд А талд мэдэгдэнэ.
3.7 Гэрээний дагуу олгох санхүүгийн дэмжлэгийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.

**Дөрөв. Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
| --- | --- |
| ............ аймаг/дүүргийн | ..................................... |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн дарга | Аж ахуйн нэгж, байгууллагын захирал |
| ................................. | ...................................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ |
| Хаяг ______________ | Хаяг ______________ |
| Утас ______________ | Утас_______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-2*

# АЖ АХУЙ, БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧИД ЭРГЭН ТӨЛӨЛТТЭЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

……………хот/аймаг №  20… оны .... сарын ... өдөр

Энэхүү гэрээг …………. аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс (цаашид А тал гэх) аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч ............овогтой ....................(цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 4.0-т заасан эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгоход үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... сарын ...-ны өдрөөс 20.. оны ... сарын ...-ны өдөр хүртэл байгуулав.

## Нэг Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэнд эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийг олгож, ажлын байр бий болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талуудын гэрээ байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.

1.3 А тал Б талын аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг дэмжих зорилгоор ....... /…….. төгрөг/ төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Б талын ..... банкны ...... тоот дансанд шилжүүлэх бөгөөд тухайн санхүүгийн дэмжлэгийг 100 хувь .... /.... төгрөг/ төгрөгийг хөрөнгө дансанд шилжиж орсноос хойш 24 сарын дотор Б тал хавсралтанд тусгасан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу төлж барагдуулахаар харилцан тохиролцов.

1.4 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа нь гэрээ байгуулснаас хойш 24 сарын дараах энэ өдөр буюу Б тал үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж, эргэн төлөлтийг төлж барагдуулснаар дуусгавар болно.

## Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээллээр Б талыг хангаж, өөрийнх нь хүсэлтийн дагуу “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 5.0-д заасан аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулж, дэмжин ажиллана.

2.2 Гэрээнд талууд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш .... хоногийн дотор төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Б талын дансанд 100 хувь шилжүүлнэ.

2.3 Төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, хавсралтанд тусгагдсан Б талын боловсруулсан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

2.4 Б талаас “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу эргэн төлөлт хийхийг шаардах эрхтэй.

2.5 Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл гарсан тухай Б талаас мэдэгдсэн бол уг асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.6 Б талаас төслийн хэрэгжилтийн талаарх үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд гаргуулж авна.
2.7 Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй болон удаа дараагийн зөвлөгөө шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
2.8 Төсөлд хамрагдсан иргэдийн талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

**Гурав. Б талын эрх, үүрэг**

3.1 Энэхүү гэрээний дагуу олгох санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.
3.2 Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг А талд цаг тухайд нь мэдэгдэж, харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
3.3 Төслөө хэрэгжүүлэх хугацаанд бусад иргэнийг тогтвортой ажлын байраар хангаж, хуулийн дагуу сайн дурын нийгмийн даатгал эсвэл заавал даатгалд хамруулна.
3.4 Төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сар бүр тогтоосон хугацаанд гаргах/санхүүгийн баримтуудыг хавсарган/ ба төслийн үйл ажиллагаа дуусахад нэгдсэн тайланг гаргаж А талд ирүүлнэ.
3.5 Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтанд тусгагдсан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө. Санхүүгийн дэмжлэгийн зардлын төсвийн тооцоог гэрээний хавсралтаар гаргана.
3.6 Санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдвол санхүүгийн дэмжлэгийн нийт хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлж барагдуулна.
3.7 Оршин суух хаяг, төслийн байршлын шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд А талд мэдэгдэнэ.

**Дөрөв. Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд**

| | |
|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
| ............ аймаг/дүүргийн | Иргэн |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн дарга | ............ овогтой ................ |
| ................................. | ...................................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ |
| Хаяг ______________ | Хаяг ______________ |
| Утас ______________ | Утас______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-3*

# АЖ АХУЙ, БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧИД АЖ АХУЙ ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ ЗОХИОНЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

…………… хот/аймаг № 20… оны … сарын ... өдөр

Энэхүү гэрээг ................... аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар(цаашид “А” тал гэх) “ ............................. “ сургалтын байгууллага/бизнес инкубатор төв (цаашид “Б” тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 5.0–д заасан аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... сарын ...-ны өдрөөс 20.. оны ... сарын ...-ны өдөр хүртэл байгуулав.

## Нэг. Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь зорилтод бүлгийн иргэдийн эрхлэх үйл ажиллагааны онцлогт нийцсэн аж ахуй эрхлэлтийн сургалтыг эрх бүхий байгууллагаар зохион байгуулах, түүнд зарцуулах сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөс олгох харилцааг зохицуулахад оршино.
1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талуудын гэрээг байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.
1.3 Б тал нь 20 … оны ... сарын ... өдрөөс эхлэн ... ажлын хоногт нийт ... аж ахуй, бичил бизнес эрхлэгч, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид аж ахуй эрхлэх сургалтыг зохион байгуулах ба А тал нь сургалтын зардал ... / ... төгрөг /төгрөгийг Б талын ... банкны ... тоот дансанд шилжүүлэхээр харилцан тохиролцов.

## Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Сургалтанд хамрагдаж байгаа суралцагчдын болон Б талын талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.
2.2 Сургалт эхлэхэд буюу гэрээ байгуулснаас хойш ... хоногийн дотор сургалтын нийт зардлын 70 хувийг, сургалтын үйл ажиллагаа дууссаны дараа сургалтын тайлан, үр дүнг үндэслэн 30 хувийг Б талын дансанд тус тус шилжүүлнэ.
2.3 Сургалтанд хамрагдах суралцагчдыг зохион байгуулж, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
2.4 Сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай бол сургалтын үйл ажиллагааг зогсоож, энэхүү гэрээний 4.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.
2.5 Сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд Б талаас авна.

## Гурав. Б талын эрх, үүрэг

3.1 Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтыг чанарын өндөр

түвшинд үр дүнтэй зохион байгуулна.
3.2 Сургалт явуулахад зайлшгүй шаардагдах өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, сургалтын материалыг үнэ төлбөргүй ашиглуулна.
3.3 Сургалтын үйл ажиллагааг суралцагчдын боловсруулсан төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглүүлж зохион байгуулна.
3.4 “Суралцагчийн бүртгэлийн дэвтэр” нээж, сургалтын явц, ирцийг тэмдэглэн баталгаажуулна.
3.5 Гэрээний дагуу олгох санхүүжилтийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.
3.6 Сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд А талд ирүүлнэ.

**Дөрөв. Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол сургалтын үйл ажиллагааг зогсоож, зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

А талыг төлөөлж:
..........................
аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/
Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга
.................................
/гарын үсэг, тамга/
Хаяг ______________
Утас ______________

Б талыг төлөөлж:
..........................
Сургалтын байгууллага/
Бизнес инкубатор төвийн захирал
.....................................
/гарын үсэг, тамга/
Хаяг ______________
Утас______________

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-4*

# АЖ АХУЙ, БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧ, НӨХӨРЛӨЛ, ХОРШООНД ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

............ хот/ аймаг №  20 … оны ... сарын ... өдөр

Энэхүү гэрээг ............. аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс (цаашид А тал гэх) хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч/нөхөрлөл/хоршооны удирдлага ............... овогтой ................ (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27–ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 6.3-т заасан ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг нөхөн олгоход үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... сарын ...-ны өдрөөс 20.. оны ... сарын ...-ны өдөр хүртэл байгуулав.

## Нэг. Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч/нөхөрлөл/хоршоонд ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлж, үйл ажиллагааг нь дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талуудын гэрээг байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.
1.3 А тал нь Б талын үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг ажлын байрны түрээсийн төлбөрийн ... /40 хүртэл/ хувь болох ... /... төгрөг/ төгрөгийг хөнгөлөлт хэлбэрээр нийт ... /6 хүртэл/ сарын хугацаанд үзүүлж, Б талын ... банкны ... тоот дансанд гэрээнд заасан хугацаанд шилжүүлж байхаар тохиролцов.
1.4 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа нь А тал нь Б талын дансанд сүүлийн сарын түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг шилжүүлснээр дуусгавар болгоно.

## Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтыг үндэслэн сар бүрийн хоёр дахь долоо хоногт Б талын дансанд шилжүүлнэ.
2.2 Б талын ажлын байрны түрээсийн төлбөртэй холбоотой мэдээллийг түрээслүүлэгч талаас тодруулах, энэ тухай лавлагаа авах эрхтэй байна.
2.3 Б тал болон түрээсүүлэгч тал хоорондын түрээсийн гэрээтэй холбоотой аливаа асуудалд оролцохгүй бөгөөд итгэмжлэгч, батлан даагчийн үүргийг хүлээхгүй.
2.4 Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

## Гурав.Б талын эрх, үүрэг

3.1 Түрээсийн төлбөр төлсөн баримтын хуулбарыг сар бүрийн эхний 7 хоногт

багтаан А талд ирүүлнэ. /Цахим хэлбэрээр байж болно./
3.2 Түрээсийн төлбөртэй холбоотой аливаа маргааныг өөрөө хариуцаж түрээслүүлэгчтэй байгуулсан гэрээнийхээ хүрээнд шийдвэрлэнэ.

**Дөрөв.Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд**

| | |
|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
| ............ аймаг/дүүргийн | Иргэн/нөхөрлөл/ |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний | хоршооны удирдлага |
| газар/хэлтсийн дарга | ............ овогтой ............... |
| .................................. | ...................................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ |
| Хаяг _______________ | Хаяг _______________ |
| Утас _______________ | Утас_______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-5*

## НИЙТИЙГ ХАМАРСАН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

.......... хот/аймаг № 20 ... оны .... сарын ... өдөр

Энэхүү гэрээг ..............аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс (цаашид А тал гэх), ......................... аж ахуйн нэгж/нутгийн захиргааны байгууллагыг төлөөлж ................ овогтой ............. (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 8.0-д заасан нийтийг хамарсан ажил зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулахаар харилцаж тохиролцож 20... оны .... сарын .... өдрөөс 20... оны ... сарын .... өдөр хүртэл байгуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж, ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах харилцааг зохицуулахад оршино.
1.2 Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэний цалин хөлсийг ажилласан цагаар тооцож, ажиллагчдын банкин дах нэрийн дансанд шилжүүлж, олгоно. Нийтийг хамарсан ажлын нэг цагийн ажлын хөлс нь 3500 төгрөг байна.
1.3 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа нь гэрээг байгуулснаас хойш 10 хүртэл хоногийн хугацаанд Б тал ажлыг амжилттай хийж гүйцэтгэснээр дуусгавар болно.

### Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Төсөлд хамрагдах иргэдийг зохион байгуулж, мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллана.
2.2 Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах цалин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлнэ.
2.3 Төслийн явц, хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцно.
2.4 Б талаас төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааны тайлан мэдээг тогтоосон хугацаанд авна.
2.5 Б талын ирүүлсэн төслийн үйл ажиллагааны тайланд үндэслэн нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн цалин хөлсийг ажиллагчдын банкин дах нэрийн дансанд шилжүүлж, олгоно.
2.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Б талаас шаардах эрхтэй.

### Гурав.Б талын эрх, үүрэг

3.1 Нийтийг хамарсан ажил зохион байгуулах төсөлд хамтран оролцож буй нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж нь тухайн нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах төсөлд шаардлагатай ажиллах хүчний цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлаас бусад зардлыг хариуцан гаргана.

3.2 Төсөлд хамрагдаж байгаа иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг хангаж, зориулалтын хамгаалалтын хэрэгсэл /ажлын хувцас, хэрэгсэл, малгай, бээлий/-ээр бүрэн хангасан байна.
3.3 Төсөлд хамрагдаж буй иргэдтэй Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу холбогдох гэрээ байгуулж ажиллана.
3.4 Төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааны тайланг А талд тогтоосон хугацаанд гаргаж өгнө.
3.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг А талаас шаардах эрхтэй.

**Дөрөв. Бусад**

4.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ А тал авна.
4.2 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.3 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд**

| | |
|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
| ............ аймаг/дүүргийн | ……………………. |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний | Сум/дүүрэг/ын Засаг дарга/ |
| газар/хэлтсийн дарга | ААНБайгууллагын захирал |
| ................................. | ...................................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ |
| Хаяг ______________ | Хаяг ______________ |
| Утас ______________ | Утас_______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-6*

# ҮЙЛДВЭРЛЭЛ ДЭЭРХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

...............хот/аймаг №  20 ... оны ... сарын ... өдөр

Энэхүү гэрээгээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар/......... аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (цаашид А тал гэх) .............................. аж ахуйн нэгж буюу ажил олгогч (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн 5.3-т заасан үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... сарын .... өдрөөс 20 ... оны ... сарын ... өдөр хүртэл байгуулав.

## Нэг.Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь ажил олгогчийн хөдөлмөрийн эрэлт, ажлын байранд шаардлагатай ур чадварыг бий болгох хүрээнд тухайн ажил олгогчийн үйлдвэрлэл, ажлын байранд иргэнийг дагалдуулан сургаж бэлтгэх, нийлүүлэх, түүнд зарцуулах сургалтын зардлыг олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талууд гэрээг байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.

1.3 Б тал нь 20 … оны .... сарын ... өдрөөс эхлэн .... ажлын хоногт суралцагчдыг үйлдвэрлэл дээр сургаж, ажлын байраар хангах ба А тал нь сургалтын зардал ....../..............төгрөг/төгрөгийг Б талын ........ банкны ....... тоот дансанд шилжүүлэхээр харилцан тохиролцов.

1.4 Үйлдвэрлэл дээрх сургалтанд .... мэргэжлээр ... суралцагч хамрагдана

## Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Сургалт эхлэхэд буюу гэрээ байгуулснаас хойш ...... хоногийн дотор сургалтын нийт зардлын 70 хувийг, сургалтын үйл ажиллагаа дуусч, суралцагчид мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалт өгч тэнцсэн болон ажлын байраар хангагдсан суралцагчийн тоо, сургалтын тайлан мэдээг үндэслэн үлдсэн 30 хувийг Б талын дансанд тус тус шилжүүлнэ.

2.2 Онолын сургалтыг зохион байгуулах эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын талаарх мэдээллээр Б талыг хангана.

2.3 Төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх арга хэмжээг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулж, Чадамжийн гэрчилгээ олгоно.

2.4 Үйлдвэрлэл дээрх сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж шаардлагатай

бол сургалтын үйл ажиллагааг зогсоож, энэхүү гэрээний 4.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.
2.5 Б талыг арга зүйгээр ханган, сургалтын тайлан мэдээг тогтоосон хугацаанд авна.

**Гурав.Б талын эрх, үүрэг**

3.1 Суралцагчдыг үйлдвэрлэл дээр дадлага эзэмших боломж, бололцоогоор хангаж, дадлагын тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн цех, талбайг ашиглуулах, дагалдуулан сургах ур чадвар бүхий дадлагажуулагч багш, мастер, мэргэшсэн мэргэжилтэн, инженер, сургагчийн нөөцийг бүрдүүлнэ.
3.2 Дадлагын сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах ажлын байр, цахилгаан, багаж, тоног төхөөрөмж зэрэг материаллаг болон материаллаг бус зардлыг хариуцна.
3.3 Онолын сургалтыг зохион байгуулах эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон санхүүжилтын онолын сургалтанд зарцуулах хэсгийг буюу нийт сургалтын зардлын 20 хувийг сургалтын байгууллагын дансанд шилжүүлнэ.
3.4 “Суралцагчийн бүртгэлийн дэвтэр”-ийг нээж, сургалтын явц, ирцийг тэмдэглэн баталгаажуулна.
3.5 Сургалтын хугацаанд үйлдвэрлэлийн горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, дүрэм журмыг мөрдүүлж, үүнтэй холбоотойгоор гарах бүхий л хариуцлагыг хүлээнэ.
3.6 Суралцагчид сургалтын дадлагын хугацаанд нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгоно.
3.7 Суралцагчдыг ажлын байраар хангана.
3.8 Сургалтын тайлан мэдээг А талд тогтоосон хугацаанд ирүүлнэ.
3.9 Гэрээний дагуу олгох сургалтын санхүүжилтийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.
3.10 Сургалтыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, сургалтанд хамрагдах суралцагч бүртэй дараах чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалтын тусгайлсан гэрээ байгуулж, баримтжуулна. Үүнд:
3.10.1 Сургалтын арга хэмжээнд өөрийн хүсэл сонирхлын дагуу хамрагдсан байна.
3.10.2 Сургалтын явцад сургалтын болон үйлдвэрлэлийн дотоод дүрэм, журмыг мөрдөж, идэвхи санаачлагатай суралцана.
3.10.3 Дадлага хийх хугацаанд Б талын нууцад хамаарагдах технологийн шийдэл, нууц мэдээ, баримт бичиг, тоног төхөөрөмжийн мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.
3.10.4 Мэргэжлийн тодорхой ур чадвар, чадамж эзэмшиж, мэргэжлийн ур чадварын шалгалтанд орж, Чадамжийн гэрчилгээ авна.

**Дөрөв. Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол сургалтын үйл ажиллагааг зогсоож, зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.

4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

А талыг төлөөлж:
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар/
.................... аймгийн
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
.................................
/гарын үсэг, тамга/
Хаяг ______________
Утас ______________

Б талыг төлөөлж:
.............................
Аж ахуйн нэгжийн захирал
.......................
/гарын үсэг, тамга/
Хаяг ______________
Утас ______________

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-7*

# МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

...............хот/аймаг №  20 ... оны ....... сарын ...... өдөр

Энэхүү гэрээг .............. аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс/Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар (цаашид А тал гэх) болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага/эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн 5.4-т заасан мэргэжлийн сургалтыг ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнд зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... сарын ... өдрөөс 20... оны ... сарын ... өдөр хүртэл байгуулав.

### Нэг.Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь иргэнд тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн чадамж бүхий харилцан уялдаатай нэгж ажилбаруудыг эзэмшүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талуудын гэрээг байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.

1.3 Б тал нь 20 … оны .... сарын ....өдрөөс эхлэн ..... ажлын хоногт нийт ...... ажилгүй иргэн/ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнд мэргэжлийн сургалтыг зохион байгуулах ба А тал нь сургалтын зардал ........./...............төгрөг/төгрөгийг Б талын ....... банкны ....... тоот дансанд шилжүүлэхээр харилцан тохиролцов.

### Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Сургалтын арга хэмжээнд хамрагдаж байгаа суралцагчдын болон Б талын талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.2 Сургалт эхлэхэд буюу гэрээ байгуулснаас хойш .... хоногийн дотор сургалтын нийт зардлын 70 хувийг, сургалтын үйл ажиллагаа дуусч суралцагч мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтанд орсны дараа сургалтын тайланг үндэслэн 30 хувийг Б талын дансанд тус тус шилжүүлнэ.

2.3 Төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх арга хэмжээг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулж, “Чадамжийн гэрчилгээ” олгоно.

2.4 Сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж шаардлагатай бол сургалтын үйл ажиллагааг зогсоож, энэхүү гэрээний 4.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.5 Б талыг арга зүйгээр ханган, сургалтын тайлан мэдээг тогтоосон хугацаанд авна.

2.6 Б талын зохион байгуулах сургалтанд хамрагдахыг хүссэн суралцагч иргэдтэй дараах чиглэлээр тусгайлсан гэрээ байгуулж, баримтжуулна. Үүнд:
2.6.1 Сургалтын арга хэмжээнд өөрийн хүсэл сонирхлын дагуу хамрагдсан байна.
2.6.2 Сургалтын явцад сургалтын болон дадлагын дотоод дүрэм, журмыг мөрдөж, идэвх санаачлагатай суралцана.
2.6.3 Мэргэжлийн тодорхой ур чадвар эзэмшиж, мэргэжлийн ур чадварын шалгалтанд орж, Чадамжийн гэрчилгээ авна.

**Гурав. Б талын эрх, үүрэг**

3.1 Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтыг чанарын өндөр түвшинд үр дүнтэй зохион байгуулна.
3.2 Сургалт явуулахад зайлшгүй шаардагдах өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, сургалтын материалыг үнэ төлбөргүй ашиглуулна.
3.3 “Суралцагчийн бүртгэлийн дэвтэр”-ийг нээж, сургалтын явц, ирцийг тэмдэглэн баталгаажуулна.
3.4 Төгссөн суралцагчдыг ажлын байранд зуучлахад дэмжлэг өгч ажиллана.
3.5 Сургалтын тайлан  мэдээг А талд тогтоосон хугацаанд ирүүлнэ.
3.6 Гэрээний дагуу олгох сургалтын санхүүжилтийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.

**Дөрөв. Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол сургалтын үйл ажиллагааг зогсоож, зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
|---|---|
| .............. аймаг/дүүргийн | ................................ |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний | Сургалтын байгууллага/ |
| газар/хэлтэс/Нийслэлийн | Мэргэжлийн боловсрол, сургалтын |
| хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга | байгууллагын захирал |
| ................................. | ...................................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ |
| Хаяг ______________ | Хаяг ______________ |
| Утас ______________ | Утас______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-8*

# МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧ, ТӨГСӨГЧДИЙН БҮЛЭГТ ЭРГЭН ТӨЛӨЛТТЭЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

............ хот/аймаг №  20... оны ... сарын ... өдөр

Энэхүү гэрээг ………….. аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс (цаашид А тал гэх) Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч/төгсөгчдийн бүлэг .............. овогтой ................ (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 5.0-д заасан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, төгсөгчдийн бүлэгт эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20 ... оны ... сарын ... өдрөөс 20 ... оны .... сарын .... өдөр хүртэл байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Гэрээний зорилго нь Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгоход хэрэгцээтэй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад нь зориулсан эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох харилцааг зохицуулна.

1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талуудын гэрээг байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.

1.3 А тал Б талын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авч ажлын байр бий болгохыг дэмжих зорилгоор ....... /…….. төгрөг/ төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Б талын ..... банкны ...... тоот дансанд шилжүүлэх бөгөөд тухайн санхүүгийн дэмжлэгийг 100 хувь буюу .... /.... төгрөг/ төгрөгийг хөрөнгө дансанд шилжиж орсон хойш 24 сарын дотор Б тал хавсралтанд тусгасан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу төлж барагдуулахаар тохиролцов.

1.4 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа нь гэрээ байгуулснаас хойш 24 сарын дараах энэ өдөр буюу Б тал үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж, эргэн төлөлтийг төлж барагдуулснаар дуусгавар болно.

**Хоёр. А талын эрх, үүрэг**

2.1 Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээллээр Б талыг хангаж, хөтөлбөрийн 6.9-т заасан аж ахуй эрхлэлтийн сургалт, зөвлөгөө өгөх арга хэмжээнд хамруулан дэмжин ажиллана.

2.2 Гэрээнд талууд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш .... хоногийн дотор төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Б талын дансанд 100 хувь шилжүүлнэ.

2.3 Төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж

байгаа эсэх, хавсралтанд тусгагдсан Б талын боловсруулсан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн биелэлтэд тус тус хяналт тавьж ажиллана.
2.4 Б талаас “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу эргэн төлөлт хийхийг шаардах эрхтэй.
2.5 Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарсан тухай Б талаас мэдэгдсэн бол уг асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
2.6 Б талаас төслийн хэрэгжилтийн талаарх үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд авна.
2.7 Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй болон удаа дараагийн зөвлөгөө шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
2.8 Төсөлд хамрагдсан иргэдийн талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.
2.9 Төгсөгчид бүлэг болсон тохиолдолд бүлгийн гишүүн нэг бүртэй гэрээ байгуулан ажиллана.

## Гурав.Б талын эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний дагуу олгох санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдол нэхэмжлэх эрхтэй.
3.2 Төсөлд тусгагдсан үйлдвэрлэл, аж ахуйн чиглэлийн үйл ажиллагааг эрхэлж, төсөлд заасан тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийг худалдан авах ба санхүүгийн дэмжлэгийн 30 хувиас ихгүй хувийг шаардлагатай бараа материал, түүхий эд худалдан авахад зарцуулж болно.
3.3 Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг А талд цаг тухайд нь мэдэгдэж, харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
3.4 Төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сар бүр тогтоосон хугацаанд гаргах/санхүүгийн баримтуудыг хавсаргах/ ба төслийн үйл ажиллагаа дуусахад нэгдсэн тайланг гаргаж А талд ирүүлнэ.
3.5 Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтанд тусгагдсан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх ба санхүүгийн дэмжлэгийн зардлын төсвийн тооцоог гэрээний хавсралтаар гаргана.
3.6 Санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдвол санхүүгийн дэмжлэгийн нийт хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлж барагдуулна.
3.7 Төслийн үр дүнд байнгын ажлын шинэ байртай болж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн байна.
3.8 Оршин суух хаяг, төслийн байршлын шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд А талд мэдэгдэнэ
3.9 Нийгмийн даатгалын сайн дурын эсвэл заавал даатгалд хамрагдсан байна.

## Дөрөв. Бусад

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

| | |
|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
| ………… аймаг/дүүргийн | МБСБ-ын төгсөгч |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ хэлтсийн дарга | ............ овогтой ................ |
| ................................. | ...................................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг/ |
| Хаяг ______________ | Хаяг ______________ |
| Утас ______________ | Утас_______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-9*

# МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧ, ТӨГСӨГЧДИЙН БҮЛЭГТ АЖ АХУЙ ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

…………….. хот/аймаг № 20 ... оны ... сарын ...өдөр

Энэхүү гэрээг ........... аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар(цаашид А тал гэх), ................. бизнес инкубатор төв/сургалтын байгууллага (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 6.9-т заасан аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20 ... оны ... сарын ... өдрийн 20 ... оны ... сарын ... өдөр хүртэл байгуулав.

**Нэг.Ерөнхий зүйл**

1.1 Гэрээний зорилго нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгч болон төгсөгчдийн бүлгийн гишүүдэд аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах, түүнд зарцуулах зардлыг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хөрөнгөөс олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол улсын хууль, талуудын гэрээг байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулна, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.

1.3 Б тал нь 20 … оны ... сарын ... өдрөөс эхлэн ... ажлын хоногт нийт ..... төгсөгчид аж ахуй эрхлэх сургалтыг зохион байгуулах ба А тал нь сургалтын зардал ......./.......... төгрөг/ төгрөгийг Б талын ..... банкны............. тоот дансанд шилжүүлэхээр харилцан тохиролцов.

**Хоёр. А талын эрх, үүрэг**

2.1 Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдаж байгаа суралцагчдын болон Б талын талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.2 Гэрээ байгуулсанаас хойш ........ хоногийн дотор аж ахуй эрхлэлтийн сургалтын нийт зардлын 70 хувийг, сургалтын үйл ажиллагаа дууссаны дараа сургалтын тайлан, үр дүнг үндэслэн 30 хувийг Б талын дансанд тус тус шилжүүлнэ.

2.3 Сургалтын үйл ажиллагаанд хамрагдах төгсөгчдийг зохион байгуулж, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.4 Сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай бол сургалтын үйл ажиллагааг зогсоож, энэхүү гэрээний 4.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.5 Сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд Б талаас авна.

**Гурав.Б талын хүлээх эрх, үүрэг**

3.1 Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтыг чанарын өндөр түвшинд үр дүнтэй зохион байгуулна.

3.2 Сургалт явуулахад зайлшгүй шаардагдах өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, сургалтын материалыг үнэ төлбөргүй ашиглуулна.

3.3 Сургалтын үйл ажиллагааг МБСБ-ын төгсөгч/ төгсөгчдийн бүлгийн боловсруулсан төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглүүлж зохион байгуулна.

3.4 “Суралцагчийн бүртгэлийн дэвтэр” нээж, сургалтын явц, ирцийг тэмдэглэн баталгаажуулна.

3.5 Гэрээний дагуу олгох санхүүжилтийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.

3.6 Сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тотоосон хугацаанд А талд ирүүлнэ.

**Дөрөв.Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол сургалтын үйл ажиллагааг зогсоож, зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.

4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
| --- | --- |
| ......... аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга | ………………….. Бизнес инкубатор төв/ Сургалтын байгууллагын захирал |
| ................................. /гарын үсэг, тамга/ | ..................................... /гарын үсэг, тамга/ |
| Хаяг ______________ | Хаяг ______________ |
| Утас ______________ | Утас______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-10*

# МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧ, ТӨГСӨГЧДИЙН БҮЛЭГ, ЗАЛУУЧУУДЫН БҮЛЭГТ ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

............... хот/аймаг №     20 ... оны ... сарын ... өдөр

Энэхүү гэрээг ................ аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс(цаашид А тал гэх) ................. МБСБ-ын төгсөгч/төгсөгчдийн бүлэг/залуучуудыг бүлэг(цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр сарын тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 6.3-д заасан түрээсийн хөнгөлөлт үзүүлэхэд үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20 ... оны ... сарын ... өдрөөс 20 ... оны .... сарын ... өдөр хүртэл байгуулав.

## Нэг.Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь санхүүгийн дэмжлэг/гарааны дэмжлэгт хамрагдсан төгсөгч болон төгсөгчдийн бүлэг/залуучуудын бүлэгт ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлж, үйл ажиллагааг нь дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол улсын хууль, талуудын гэрээг байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зарцуулна.

1.3 А тал нь Б талд үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг төгсөгч/төгсөгчийн бүлэг/залуучуудын бүлгийн ажлын байрны түрээсийн төлбөрийн ........ /40 хүртэл/ хувь болох....... /..... төгрөг/ төгрөгийг хөнгөлөлт хэлбэрээр нийт .... /6 хүртэл / сарын хугацаанд үзүүлж, Б талын ... банкны ... тоот дансанд гэрээнд заасан хугацаанд шилжүүүлж байхаар харилцан тохиролцов.

1.4 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа нь А тал нь Б талын дансанд сүүлийн сарын түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг шилжүүлсэнээр дуусгавар болно.

## Хоёр. А талын хүлээх эрх, үүрэг

2.1 Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтыг үндэслэн сар бүрийн хоёр дахь долоо хоногт багтаан Б талын дансанд шилжүүлнэ.

2.2 Ажлын байрны түрээсийн төлбөртэй холбоотой мэдээллийг түрээслүүлэгч талаас тодруулах, энэ тухай лавлагаа авах эрхтэй байна.

2.3 Б тал болон түрээслүүлэгч тал хоорондын түрээсийн гэрээтэй холбоотой аливаа асуудалд оролцохгүй бөгөөд итгэмжлэгч, батлан даагчийн үүргийг хүлээхгүй.

2.4 Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн талаарх мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

**Гурав. Б талын хүлээх эрх, үүрэг**

3.1 Түрээсийн төлбөр төлсөн баримтын хуулбарыг сар бүрийн эхний 7 хоногт багтаан А талд ирүүлнэ. / Цахим хэлбэрээр байж болно/
3.2 Түрээсийн төлбөртэй холбоотой аливаа маргааныг өөрөө хариуцаж түрээслүүлэгчтэй байгуулсан гэрээнийхээ хүрээнд шийдвэрлэнэ.

**Дөрөв.Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

| | |
|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
| .................. аймаг/дүүргийн | Иргэн |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний | ............ овогтой .............. |
| газар/хэлтсийн дарга | |
| .................................. | ...................................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг/ |
| Хаяг _______________ | Хаяг _______________ |
| Утас _______________ | Утас_______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-11*

# АЖ АХУЙ, БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ЭРГЭН ТӨЛӨЛТЭЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

………... хот/аймаг №  20 ... оны ... сарын ... өдөр

Энэхүү гэрээг ........... аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс(цаашид А тал гэх), хөгжлийн бэрхшээлтэй иргэн/байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эх ...................... регистрийн дугаартай ................. овогтой ............. (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 3.4-т заасан эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгоход үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... сарын ... өдрөөс 20 ... оны ... сарын ... өдөр хүртэл байгуулав.

## Нэг.Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн/байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг нь ажлын байр бий болгохоор хувиараа болон бүлэг, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнес, газар тариалан, фермерийн аж ахуй эрхлэхэд эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талуудын гэрээ байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.

1.3 А тал Б талын өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнес, газар тариалан, фермерийн аж ахуй эрхлэхийг дэмжих зорилгоор ....... /…….. төгрөг/ төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Б талын ..... банкны ...... тоот дансанд шилжүүлэх бөгөөд тухайн санхүүгийн дэмжлэгийг 100 хувь буюу .... /.... төгрөг/ төгрөгийг хөрөнгө дансанд шилжиж орсон хойш 48 сарын дотор Б тал хавсралтанд тусгасан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу төлж барагдуулахаар тохиролцов.

1.4 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа нь гэрээ байгуулснаас хойш 48 сарын дараах энэ өдөр буюу Б тал үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж, эргэн төлөлтийг төлж барагдуулснаар дуусгавар болно.

## Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээллээр Б талыг хангаж, өөрийнх нь хүсэлтийн дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 3.6-д заасан аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулж, дэмжин ажиллана.

2.2 Гэрээнд талууд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш .... хоногийн дотор төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Б талын дансанд 100 хувь шилжүүлнэ.
2.3 Төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, хавсралтад тусгагдсан Б талын боловсруулсан "Эргэн төлөлт хийх хуваарь"-ийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.
2.4 Б талаас "Эргэн төлөлт хийх хуваарь"-ийн дагуу эргэн төлөлт хийхийг шаардах эрхтэй.
2.5 Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарсан тухай Б талаас мэдэгдсэн
бол уг асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
2.6 Б талаас төслийн хэрэгжилтийн талаарх үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сар бүр тогтоосон хугацаанд авна.
2.7 Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй болон удаа дараагийн зөвлөгөө шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
2.8 Б талын мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

## Гурав. Б талын эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний дагуу олгох санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.
3.2 Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг А талд цаг тухайд нь мэдэгдэж, харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
3.3 Төслөө хэрэгжүүлэх хугацаанд бусад иргэнийг тогтвортой ажлын байраар хангаж, хуулийн дагуу сайн дурын даатгал эсвэл заавал даатгалд хамруулна.
3.4 Төслийн үйл ажиллагааны тайланг сар бүр тогтоосон хугацаанд гаргах/санхүүгийн баримтуудыг хавсарган/ба төслийн үйл ажиллагаа дуусахад нэгдсэн тайланг гаргаж А талд ирүүлнэ.
3.5 Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан "Эргэн төлөлт хийх хуваарь"-ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө.
3.6 Санхүүгийн дэмжлэгийн 70-аас доошгүй хувийг тоног төхөөрөмж, бараа материалын зардалд зарцуулна. Санхүүгийн дэмжлэгийн зардлын төсвийн тооцоог хавсралтаар гаргана.
3.7 Санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдвол санхүүгийн дэмжлэгийн нийт хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлж барагдуулна.
3.8 Оршин суух хаяг, төслийн байршлын шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд А талд мэдэгдэнэ.

## Дөрөв. Бусад

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.

4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан талууд:

А талыг төлөөлж:
………… аймаг/дүүргийн
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн дарга
.................................
/гарын үсэг, тамга/
Хаяг ______________
Утас ______________

Б талыг төлөөлж:
Иргэн
............ овогтой ................
......................................
/гарын үсэг/
Хаяг ______________
Утас______________

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-12*

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАСАН АЖИЛ ОЛГОГЧИД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

................. хот/аймаг № 20 ... оны .... сарын ... өдөр

Энэхүү гэрээг .................... аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ хэлтэс /(цаашид А тал гэх) .............. аж ахуйн нэгж, байгууллагын эзэн/удирдлага (цаашид Б тал гэх), иргэн ......... регистрийн дугаар бүхий ...................... овогтой ............ (цаашид В тал гэх)нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн” 4.2-т заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид урамшуулал олгоход үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... сарын ... өдрөөс 20... оны ... сарын ... өдөр хүртэл байгуулав.

## Нэг.Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч ажиллуулахтай холбоотой гарсан зардлын тодорхой хэсгийг нөхөн төлөх, ажлын байранд тухайн иргэнийг тогтвортой ажиллуулахыг урамшуулах, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, бизнесээ хөгжүүлэхэд дэмжихэд оршино.
1.2 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талууд гэрээ байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.
1.3 В талыг Б тал 20 … оны ..... сарын ......-ны өдөр ажилд авч, тогтвортой ажиллуулах бөгөөд ажилд орсон өдрөөс хойш 12 сарын дараа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг А тал Б талд олгохоор харилцан тохиролцов.
1.4 Энэхүү урамшууллыг холбогдох бичиг баримтыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлж олгоно.

## Хоёр. А талын хүлээх эрх, үүрэг

2.1 Гэрээнд заасан үүргээ биелүүлсэн ажил олгогчийн холбогдох материалыг хянан үзэж, урамшууллыг ажил олгогчийн ................. банкин дахь .................... тоот дансанд хүсэлт гаргасан өдрөөс хойш ажлын ......... хоногт багтаан шилжүүлнэ.
2.2 В талын хөдөлмөр эрхлэлтийн байдал, зохистой хөдөлмөр эрхлэлтийн явц, Б талын ажлын байранд хяналт тавина.
2.3 Ажил олгогч болон ажлын байраар хангагдсан иргэний талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулна.
2.4 Ажил олгогч болон ажлын байраар хангагдсан иргэнийг холбогдох мэдээ, мэдээллээр хангана.

2.5 Ажлын байраар хангагдсан иргэний хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаарх мэдээ тайланг Б талаас тогтоосон хугацаанд авна.
2.6 Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авна.

**Гурав. Б талын эрх, үүрэг**

3.1 Иргэн ................ овогтой ............ ийг үндсэн ажилтнаар авч, 12 сараас дээш хугацаагаар ажиллуулсан буюу цаашид тогтвортой ажиллуулсан байна.
3.2 В талын Нийгмийн даатгалын шимтгэл болон хууль, тогтоомжид заасан бусад татвар, шимтгэлийг тухай бүр төлсөн байна.
3.3 В тал өөрийн хүсэлтээр ажлын байраа орхиж явсан, ажлаас чөлөөгдсөн, Б талын санаачлагаар Хөдөлмөрийн гэрээг цуцалсан тохиолдолд А талд даруй мэдэгдэнэ.
3.4 Ажлын байраар хангагдсан иргэний хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаарх мэдээ тайланг тогтоосон хугацаанд А талд ирүүлнэ.
3.5 Ажлын байраар хангагдсан иргэнд тухайн ажлын байранд шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөгөө мэдээллийг өгнө.
3.6 Байгууллагын байршлын шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд А талд мэдэгдэнэ.
3.7 Гэрээний дагуу олгох урамшууллыг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.

**Дөрөв. В талын эрх, үүрэг**

4.1 Хөдөлмөрийн дотоод дүрэм, журмыг мөрдөж, ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангаж, идэвхи санаачлагатай байж, ажлын байран дээрээ дадлагажиж мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байна.
4.2 Б талын технологийн шийдэл, нууц мэдээ, баримт бичиг, тоног төхөөрөмжийн мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээж, хэрэв задруулбал холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ

**Тав. Бусад**

5.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
5.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
5.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
5.4 Энэхүү гэрээг талууд гурван хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

| | | |
|---|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: | В талыг төлөөлж: |
| ............ аймаг/дүүргийн | ..................... | |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний | Аж ахуйн нэгж, | Иргэн |
| газар/хэлтсийн дарга | байгууллагын захирал | ......... овогтой ............. |
| ............................. | ............................. | ............................. |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг/ |
| Хаяг ________________ | Хаяг ________________ | Хаяг ____________ |
| Утас ________________ | Утас________________ | Утас____________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-13*

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ТОХИРУУЛГАТАЙ АЖЛЫН БАЙРНЫСАНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

................. хот № 20 ... оны .... сарын ... өдөр

Энэхүү гэрээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (цаашид А тал гэх) ............... аж ахуйн нэгж, ТББ-ын эзэн/удирдлага (цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 4.2-т заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тохируулгатай ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгоход үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20... оны ... дугаар сарын ... ны өдрөөс 20.. оны ... дугаар сарын ... өдөр хүртэл байгуулав.

**Нэг.Ерөнхий зүйл**

1.1 Гэрээний зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлсэн тохируулгатай ажлын байр бий болгох аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох, үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.
1.2 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талууд гэрээ байгуулах болсон үндэслэл, гэрээний агуулга, А талын зааварчилгаа зэргийг үндэслэн харилцан тохиролцож зохицуулна.
1.3 А тал Б талын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохируулгатай ажлын байр бий болгох үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг дэмжих зорилгоор ....... /…….. төгрөг/ төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Б талын ..... банкны ...... тоот дансанд шилжүүлнэ.
1.4 Б тал................ хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангана.

**Хоёр. А талын эрх, үүрэг**

2.1 Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээллээр Б талыг хангаж ажиллана.
2.2 Гэрээнд талууд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш .... хоногийн дотор төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардлын 70 хувийг, төслийг хэрэгжүүлж дууссаны дараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан, төслийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан мэдээ, үйл ажиллагааны бодит байдлыг үндэслэн үлдэгдэл 30 хувийг Б талын дансанд тус тус шилжүүлнэ.
2.3 Ажил олгогч болон ажлын байраар хангагдсан иргэний талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулна.
2.4 Төслийн үйл ажиллагааны явц, үр дүнд, санхүүгийн дэмжлэгийн зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.
2.5 Б талаас төслийн хэрэгжилтийн талаарх үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд гаргуулж авна.

2.6 Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй болон удаа дараагийн зөвлөгөө, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна

**Гурав. Б талын эрх, үүрэг**

3.1 Төслийн хүрээнд байгууллагын чадавхийг нэмэгдүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тохируулгатай байнгын ........ ажлын байр бий болгоно.
3.2 Ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, тухайн иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл болон хууль, тогтоомжид заасан бусад татвар, шимтгэлийг тухай бүр төлсөн байна.
3.3 Ажлын байраар хангагдсан иргэдэд тухайн ажлын байранд шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.
3.4 А талд төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сар бүр тогтоосон хугацаанд гаргаж өгнө.
3.5 Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах ба санхүүгийн дэмжлэгийн 70-аас доошгүй хувийг ажлын байрны зориулалтын тоноглол, тохируулга, хэрэгцээт тоног төхөөрөмжийн зардалд зарцуулна. Санхүүгийн дэмжлэгийн зардлын төсвийн тооцоог гэрээний хавсралтаар гаргана.
3.6 Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдвол санхүүгийн дэмжлэгийн нийт хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлж барагдуулна.
3.7 Энэхүү гэрээний дагуу олгох санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг гэрээний 2.2-т заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэх эрхтэй.
3.8 Оршин суух хаяг, төслийн байршлын шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдолд А талд мэдэгдэнэ.

**Дөрөв. Бусад**

4.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх ба хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
4.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
4.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.4 Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

| | |
|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: : |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний | Аж ахуйн нэгж, |
| ерөнхий газрын дарга | ТББ-ын захирал |
| ................................. | ...................................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ |
| Хаяг ______________ | Хаяг ______________ |
| Утас ______________ | Утас______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-14*

# МАЛЧИН ӨРХИЙГ МАЛЖУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

......... аймаг/дүүрэг №  20 ... он ... сарын ... өдөр

Энэхүү гэрээг ........... аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ хэлтэс(цаашид А тал гэх), ....... сум/дүүргийн Засаг дарга (цаашид Б тал гэх), хөтөлбөрт хамрагдах малчин өрхийг төлөөлж (цаашид В тал гэх) ............. овогтой .............. нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны оны 1 дүгээр сарын 27–ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2.2-т заасан малчин өрхийг малжуулахад үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20 ... оны ... сарын ... өдрөөс 20 ... оны ... сарын ... өдөр хүртэл байгуулав.

## Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь залуу малчин өрхийг малжуулах, малчин өрхийн гишүүдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулахад оршино.
1.2 А тал нь В талыг малжуулах, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор ... / ... төгрөг/ төгрөгийн мал худалдан авч өгөх эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийг В талд мал нийлүүлэх иргэний .... банкны .... тоот дансанд шилжүүлэх бөгөөд тухайн хөрөнгийг 100 хувь буюу ..... /…..... төгрөг/ төгрөгийг хөрөнгө дансанд шилжиж орсноос хойш 24 сарын дотор В тал хавсралтанд тусгасан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу төлж барагдуулахаар харилцан тохиролцов.
1.3 В талын мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг Б тал хуулийн хүрээнд бүх талаар дэмжиж ажиллахаар талууд харилцан тохиролцсон болно.
1.4 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа нь гэрээг байгуулснаас хойш 24 сарын дараах энэ өдөр буюу В тал үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, эргэн төлөлтийг төлж барагдуулснаар дуусгавар болно.

## Хоёр.А талын эрх, үүрэг

2.1 Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээллээр В талыг хангаж, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2.3-т заасан мал маллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт зохион байгуулж дэмжиж ажиллана.
2.2 Гэрээнд талууд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ... хоногийн дотор төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг В талд мал нийлүүлэх иргэний дансанд 100 хувь шилжүүлнэ.
2.3 Хөтөлбөр хэрэгжих хугацаанд В талд худалдан авч өгсөн талын тоо толгой, мал маллагаанд анхаарал тавьж, төсөл үр дүнтэй хэрэгжихэд хяналт тавьж ажиллана.
2.4 В тал нь мал аж ахуй эрхлэх явцад гарсан хүндрэл бэрхшээлийн талаар

мэдэгдсэн бол Б талтай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.
2.5 В талаас төслийн хэрэгжилтийн талаарх үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргуулж авна.
2.6 Хавсралтад тусгагдсан В талын боловсруулсан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн биелэлтэд хяналт тавьж, төлөвлөгөөний дагуу эргэн төлөлт хийхийг шаардах эрхтэй.
2.7 Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй болон удаа дараагийн зөвлөгөө, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
2.8 Төсөлд хамрагдсан иргэдийн талаарх мэдээллийн хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

**Гурав. Б талын эрх, үүрэг**

3.1 В талыг мал аж ахуй эрхлэхтэй холбоотой мэдээлэл, зөвлөгөөгөөр хангаж ажиллана.
3.2 В тал нь байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр гарч буй хүндрэл бэрхшээлийг мэдэгдсэн тохиолдолд шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллана.
3.3 Дадлагажуулагч туршлагатай малчинг сонгоход В талд зөвлөгөө өгнө.
3.4 В талын малаа маллаж өсгөн үржүүлж байгаа мал аж ахуйн арга ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
3.5 Хадлан бэлчээрийн талбайг зохион байгуулж хангах, малын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, малжуулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

**Дөрөв. В талын эрх, үүрэг**

4.1 Хөтөлбөрт хамрагдснаар В тал дараах малыг авна. Үүнд: үхэр ....., адуу ...., тэмээ ...., хонь ...., ямаа .... /малын тоо толгойг бичнэ/
4.2 Хашаа хороо, саравч зэрэг мал аж ахуй эрхлэх материаллаг баазтай байна.
4.3 Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг А болон Б талд цаг тухайд нь мэдэгдэж, харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
4.4 Төслийн үйл ажиллагааны тайланг сар бүр гаргаж, тогтоосон хугацаанд А талд ирүүлнэ.
4.5 Туршлагатай дадлагажуулагч малчныг дагалдан мал маллах арга ажиллагаанд суралцаж, хөтөлбөрийн хүрээнд авсан малыг худалдаж борлуулахгүй, өөр бусад малаар солихгүй өсгөн үржүүлж ажиллана.
4.6 Байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр бий болж болзошгүй эрсдлийг тооцон, үүнд байнгын бэлтгэлтэй байна. Хөтөлбөрийн хүрээнд олгогдсон малаа өөрийн буруугаас болж эрсдэлд оруулсан тохиолдолд хохирлыг биетээр болон тухайн үеийн зах зээлийн ханшаар төлж барагдуулна.

**Тав.Бусад зүйл**

5.1 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд талууд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх бөгөөд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
5.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд гэрээний заалтыг зөрчсөн нь нотлогдвол зарцуулсан зардлыг буруутай талаар нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээг А тал авна.
5.3 Маргааныг шийдвэрлэх боломжгүй үед шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.4 Энэхүү гэрээг талууд гурван хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба энэ нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан талууд:**

| | | |
|---|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: | В талыг төлөөлж |
| ............. аймаг/ дүүргийн | ....... аймаг/дүүргийн | Иргэн |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ хэлтсийн дарга | .......сум/хороо/-ын Засаг дарга | .....овогтой ... |
| ................................. | ........................ | ...................... |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг/ |
| Хаяг _______________ | Хаяг _______________ | Хаяг_______________ |
| Утас _______________ | Утас _______________ | Утас_______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-15*

# АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

............. хот/аймаг № 20 ... оны .... сарын ... өдөр

Энэхүү гэрээгээр ...............аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ хэлтэс(цаашид А тал гэх) ...............аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлж........... овогтой ............... (цаашид Б тал гэх)Ахмад мэргэжилтэн ........ овогтой …..... (цаашид В тал гэх)нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 4.0-т заасан ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20 .... оны .... сарын .... өдрөөс 20 ... оны ... сарын .... өдөр хүртэл байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Мэргэжлийн өндөр мэдлэг, туршлагатай ахмад мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэн ажлын байраар хангаж, тэдгээрийн орлогыг нэмэгдүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад мэргэжилтний урамшууллыг ажилласан цагаар тооцож олгоно. Зөвлөх үйлчилгээний нэг цагийн хөлс нь нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлстэй адил 3500 төгрөг байна.

1.3 Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хугацаа нь нэг жил хүртэлх хугацаанд ажлын 30 өдөр буюу нийт 240 цагаас хэтрэхгүй байна.

**Хоёр. А талын эрх, үүрэг**

2.1 Б талын төсөлд заасан ....... чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмад мэргэжилтнийг арга зүйгээр хангаж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллана.

2.2 Ахмад мэргэжилтний Б талд зөвлөх үйлчилгээ үзүүлэх хугацаа, ажлын цагийн хуваарийг тодорхойлно.

2.3 Б талын төслийн дагуу зөвлөгөө, мэдээлэлд хамрагдах зорилтот бүлгийн иргэдийг тодорхойлж хамруулахад дэмжлэг үзүүлнэ.

2.4 Шаардлагатай тохиолдолд В талын зөвлөх үйлчилгээ явуулах байр, техник хэрэгсэл, ажиллах нөхцөл, шаардагдах материал, түүхий эд, санхүүгийн болон бусад дэмжлэгийг үзүүлэхэд сум, хороо, орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.

2.5 Б тал болон ахмад мэргэжилтний талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.6 В талын зөвлөх үйлчилгээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд авна.

2.7 Б талаас ирүүлсэн ахмад мэргэжилтний үзүүлсэн зөвлөх үйлчилгээний тайлан мэдээ, цагийн бүртгэлд үндэслэн ахмад мэргэжилтний ........... банкин дах ...........

дансанд урамшууллыг шилжүүлж олгоно.

**Гурав. Б талын эрх, үүрэг**

3.1 В талаар гэрээний 2.1-т заасан чиглэлээр зөвлөх үйлчилгээ өгөх ажлыг зохион байгуулж ажиллана.
3.2 В талын үзүүлж буй зөвлөх үйлчилгээний явц, үр дүнд хяналт тавьж, зөвлөгөө мэдээллээр хангана.
3.3 В талын үзүүлсэн зөвлөх үйлчилгээний тайлан мэдээ, цагийн бүртгэлийг тогтоосон хугацаанд А талд ирүүлнэ.

**Дөрөв.В талын эрх, үүрэг**

4.1 А талаас тодорхойлсон зөвлөх үйлчилгээний төсөлд хамрагдах хүсэлтээ бичгээр өгсөн байна.
4.2 Б талын төсөлд нийцүүлэн иргэдэд/Б тал/ аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн баталсан ажлын цаг, хуваарийн дагуу зөвлөгөө өгнө.
4.3 Чанарын шаардлага хангасан зөвлөх үйлчилгээг иргэдэд/Б тал/ үзүүлнэ.
4.4 Зөвлөх үйлчилгээний тайлан, мэдээг тогтоосон хугацаанд А талд гаргаж өгнө.

**Тав. Бусад**

5.1 Энэхүү гэрээг гурван хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
5.2 Гэрээнд оролцогч талууд энэхүү гэрээтэй холбоотой гарсан аливаа асуудлыг харилцан тохиролцож шийднэ, эс тохиролцвол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
5.3 Шаардлагатай тохиолдолд гэрээнд оролцогч талууд энэхүү гэрээтэй холбоотой асуудлаар уулзалт зохион байгуулж болно.

**Гэрээ байгуулсан талууд:**

| | | |
|---|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж | Б талыг төлөөлж: |
| .........аймаг/дүүргийн | ........................ | |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/ хэлтсийн дарга | ААНБ-ын захирал | Ахмад мэргэжилтэн ......... овогтой ......... |
| .................................. | ........................... | ........................ |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг/ |
| Хаяг _______________ | Хаяг _______________ | Хаяг__________ |
| Утас _______________ | Утас _______________ | Утас__________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

*ХЭДХ-гэрээний загвар-16*

# АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ БАГИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

............. хот №  20 ... оны .... сарын ... өдөр

Энэхүү гэрээгээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар(цаашид А тал гэх) ................... ахмадын ТББ(цаашид Б тал гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 5.0-д заасан ахмадын төрийн бус байгууллагаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож 20 ... оны ... сарын .... өдрөөс 20 ... оны ... сарын ... өдөр хүртэл байгуулав.

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Мэргэжлийн өндөр мэдлэг туршлагатай ахмад мэргэжилтнүүдийн баг ажиллуулж, тэдгээрийн орлогыг нэмэгдүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 А тал Б талын бүтээн байгуулалт болон бусад салбарын үйл ажиллагаанд оролцож буй аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэхийг дэмжих зорилгоор ....... /…….. төгрөг/ төгрөгийн санхүүжилтийг Б талын ..... банкны ...... тоот дансанд шилжүүлнэ.

## Хоёр. А талын эрх, үүрэг

2.1 Б талыг арга зүйгээр ханган, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд, төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

2.2 Б талаас төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээ тайланг тогтоосон хугацаанд авна.

2.3 Б талын тухайн жилд аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх зөвлөгөө, мэдээллийн төрлийг тодорхойлж гаргана.

2.4 Б талын зөвлөх үйлчилгээг эхлүүлэхэд 70 хувийг, үлдсэн 30 хувийг төслийн явц, үр дүнг үндэслэн төслийг хэрэгжүүлсний дараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилнэ.

2.5 Б тал нь зөвлөх үйлчилгээнд хамрагдаж буй аж ахуйн нэгжид шаардлага хангахгүй үйлчилгээ үзүүлсэн буюу гэрээний үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд санхүүжилтийг буцаан татах буюу гэрээг цуцлах эрхтэй.

## Гурав. Б талын эрх, үүрэг

3.1 Бүтээн байгуулалт болон бусад салбарын үйл ажиллагаанд оролцож буй аж ахуйн нэгж, байгууллагад ..... сараас доошгүй хугацаанд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллана.

3.2 Чанарын шаардлага хангасан зөвлөх үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагад хүргэнэ.

3.3 Зөвлөх үйлчилгээний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээг сар

бүр тогтоосон хугацаанд гаргаж А талд ирүүлнэ.
3.4 Төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулна. Төслийн санхүүжилтийн 10-с ихгүй хувийг ахмад мэргэжилтний туршлага, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, нарийн мэргэжлийн гарын авлага, арга зүйн зөвлөмж, ном товхимлыг боловсруулж хэвлүүлэхэд зарцуулж болно.
3.5 Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжид шаардлага хангасан үйлчилгээ үзүүлээгүй, гэрээний биелэлтээ зөрчих, төслийн санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулсан, тайлан мэдээгээ хуурамчаар гаргаж өгсөн, төслөө хэрэгжүүлээгүй нь тогтоогдсон бол санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд буцаан төлнө.
3.6 Б талын гишүүдийн дунд аливаа маргаан үүсч төслийн хэрэгжилтэнд саад учирсан тохиолдолд мөн гэрээг цуцалж, санхүүжилтийг буцаан төлнө.
3.7 Байгууллагын байршлын шилжилт хөдөлгөөний хийгдсэн тохиолдолд А талд мэдэгдэнэ.
3.8 Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад мэргэжилтний урамшууллыг ажилласан цагаар тооцож олгоно .

**Дөрөв. Бусад**

4.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
4.2 Гэрээнд оролцогч талууд энэхүү гэрээтэй холбоотой гарсан аливаа асуудлыг харилцан тохиролцож шийднэ, эс тохиролцвол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
4.3 Шаардлагатай тохиолдолд гэрээнд оролцогч талууд энэхүү гэрээтэй холбоотой асуудлаар уулзалт зохион байгуулж болно.

**Гэрээ байгуулсан талууд:**

| | |
|---|---|
| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний | ....................................... |
| ерөнхий газрын дарга | ахмадын ТББ-ын захирал |
| ................................. | ........................ |
| /гарын үсэг, тамга/ | /гарын үсэг, тамга/ |
| Хаяг ______________ | Хаяг ______________ |
| Утас ______________ | Утас ______________ |

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

1. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан тайлант хугацааны мэдээллийг тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгож, сар бүрийн 28-ны дотор аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст маягт, эсвэл цахим хэлбэрээр ирүүлнэ.
2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс мэдээллийг дараа сарын 1-ний дотор Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар мэдээллийг нэгтгэн дараа сарын 3-ны дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлнэ.

# ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН УР ЧАДВАР ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ... ОНЫ ...-Р САРЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

МАЯГТ ХЭДХ-2

<table>
<tr><th colspan="4">Хөтөлбөр/Арга хэмжээ</th><th>Мөрийн дугаар</th><th>Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, харьяа байгууллагын нэр</th></tr>
<tr><td rowspan="19">Хөдөлмөрт бэлтгэх</td><td rowspan="6">Зөвлөгөө, мэдээлэл</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>1</td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>2</td><td></td></tr>
<tr><td>Сургууль завсардсан хөдөлмөрийн насны хүүхэд</td><td>3</td><td></td></tr>
<tr><td>Ажил олоход хүндрэлтэй иргэн</td><td>4</td><td></td></tr>
<tr><td>15-34 насны ажилгүй залуучууд</td><td>5</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө(мян.төг)</td><td>6</td><td></td></tr>
<tr><td rowspan="7">Сургалт</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>7</td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>8</td><td></td></tr>
<tr><td>Сургууль завсардсан хөдөлмөрийн насны хүүхэд</td><td>9</td><td></td></tr>
<tr><td>Ажил олоход хүндрэлтэй иргэн</td><td>10</td><td></td></tr>
<tr><td>15-34 насны ажилгүй залуучууд</td><td>11</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Сургалтын байгууллагын тоо</td><td>12</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө(мян.төг)</td><td>13</td><td></td></tr>
<tr><td rowspan="6">Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний нийт дүн</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>14</td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>15</td><td></td></tr>
<tr><td>Сургууль завсардсан хөдөлмөрийн насны хүүхэд</td><td>16</td><td></td></tr>
<tr><td>Ажил олоход хүндрэлтэй иргэн</td><td>17</td><td></td></tr>
<tr><td>15-34 насны ажилгүй залуучууд</td><td>18</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө(мян.төг)</td><td>19</td><td></td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Хөдөлмөр эрхлэлтийн сургалт** | Үйлдвэрлэл дээрх сургалт | Хамрагдсан хүний тоо | | 20 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 21 | |
| | | | Ажилгүй иргэн | 22 | |
| | | | Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн | 23 | |
| | | | Чадамжийн гэрчилгээ авсан иргэний тоо | 24 | |
| | | Ажлын байртай болсон иргэний тоо | | 25 | |
| | | Үүнээс: | Байнгын ажлын байртай болсон иргэн | 26 | |
| | | | Хадгалагдсан ажлын байр | 27 | |
| | | Хамрагдсан ажил олгогчийн тоо | | 28 | |
| | | Сургалтын байгууллагын тоо | | 29 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 30 | |
| | Мэргэжлийн болон давтан сургалт | Хамрагдсан хүний тоо | | 31 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 32 | |
| | | | Ажилгүй иргэн | 33 | |
| | | | Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн | 34 | |
| | | | Чадамжийн гэрчилгээ авсан иргэний тоо | 35 | |
| | | Ажлын байртай болсон иргэний тоо | | 36 | |
| | | Үүнээс: | Байнгын ажлын байртай болсон иргэн | 37 | |
| | | | Хадгалагдсан ажлын байр | 38 | |
| | | Сургалтын байгууллагын тоо | | 39 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 40 | |
| | **Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын арга хэмжээний нийт дүн** | Хамрагдсан хүний тоо | | 41 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 42 | |
| | | | Ажилгүй иргэн | 43 | |
| | | | Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн | 44 | |
| | | | Чадамжийн гэрчилгээ авсан иргэний тоо | 45 | |
| | | Ажлын байртай болсон иргэний тоо | | 46 | |
| | | Үүнээс: | Байнгын ажлын байртай болсон иргэн | 47 | |
| | | | Хадгалагдсан ажлын байр | 48 | |
| | | Хамрагдсан ажил олгогчийн тоо | | 49 | |
| | | Сургалтын байгууллагын тоо | | 50 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 51 | |
| **Бүгд** | Хамрагдсан хүний тоо | | | 52 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 53 | |
| | Хамрагдсан байгууллагын тоо | | | 54 | |
| | Үүнээс: | Сургалтын байгууллагын тоо | | 55 | |
| | | Ажил олгогчийн тоо | | 56 | |
| | Бий болсон ажлын байрны тоо | | | 57 | |
| | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 58 | |

**БАЛАНСЫН ШАЛГАЛТ:**

Мөр(14)=Мөр(1+7); Мөр(15)=Мөр(2+8); Мөр(16)=Мөр(3+9); Мөр(17)=Мөр(4+10); Мөр(18)=Мөр(5+11); Мөр(19)=Мөр(6+13); Мөр(41)=Мөр(20+31); Мөр(42)=Мөр(21+32); Мөр(43)=Мөр(22+33); Мөр(44)=Мөр(23+34); Мөр(45)=Мөр(24+35); Мөр(46)=Мөр(25+36)=Мөр(57); Мөр(47)=Мөр(26+37); Мөр(48)=Мөр(27+38); Мөр(49)=Мөр(28)=Мөр(56); Мөр(50)=Мөр(29+39); Мөр(51)=Мөр(30+40); Мөр(52)=Мөр(14+41); Мөр(53)=Мөр(15+42); Мөр(54)=(12+49+50); Мөр(55)=Мөр(12+50); Мөр(58)=Мөр(19+51)

НЭГТГЭЛ ГАРГАСАН: .................................. мэргэжилтэн ................................ .....................................

Гарын үсэг Нэр

ХЯНАСАН: ........................................................... дарга ................................................ ..................................

Гарын үсэг Нэр

ОГНОО: ........................

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

1. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан тайлант хугацааны мэдээллийг тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгож, сар бүрийн 28-ны дотор аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст маягт, эсвэл цахим хэлбэрээр ирүүлнэ.
2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс мэдээллийг дараа сарын 1-ны дотор Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар мэдээллийг нэгтгэн дараа сарын 3-ны дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлнэ.

# ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ... ОНЫ ...-Р САРЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

МАЯГТ ХЭДХ-3

| **Хөтөлбөр/Арга хэмжээ** | | | | **Мөрийн дугаар** | **Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, харьяа байгууллагын нэр** |
|---|---|---|---|---|---|
| **Гарааны бизнесийг дэмжих** | Гарааны бизнесийн сургалт | Хамрагдсан залуучуудын бүлгийн тоо | | 1 | |
| | | Хамрагдсан залуучуудын тоо | | 2 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 3 | |
| | | Зарцуулсан хөрөнгө(мян.төг) | | 4 | |
| | | Сургалт зохион байгуулагчийн тоо | | 5 | |
| | | Үүнээс: | Бизнес инкубатор төв | 6 | |
| | | | Бизнесийг дэмжих төв | 7 | |
| | | | Сургалтын байгууллага | 8 | |
| | | Бэлтгэгдсэн сургагч багш, зөвлөхийн тоо | | 9 | |
| | Гарааны санхүүгийн дэмжлэг | Хамрагдсан залуучуудын бүлгийн тоо | | 10 | |
| | | Хамрагдсан залуучуудын тоо | | 11 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 12 | |
| | | Үйл ажиллагааны чиглэл | Хөдөө аж ахуй | 13 | |
| | | | Барилга | 14 | |
| | | | Үйлчилгээ | 15 | |
| | | | Боловсруулах үйлдвэрлэл | 16 | |
| | | | Бусад | 17 | |
| | | Бий болсон ажлын байрны тоо | | 18 | |
| | | Зарцуулсан хөрөнгө(мян.төг) | | 19 | |
| | | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт(мян.төг) | | 20 | |
| | | Санхүүгийн дэмжлэг эргэн төлж байгаа хүний тоо | | 21 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний нийт дүн | Хамрагдсан залуучуудын бүлгийн тоо | | 22 | |
| | | Хамрагдсан залуучуудын тоо | | 23 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 24 | |
| | | Нийт хөрөнгө(мян.төг) | | 25 | |
| Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг | Хамрагдсан төгсөгчдийн бүлгийн тоо | | | 26 | |
| | Хамрагдсан төгсөгчийн тоо | | | 27 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 28 | |
| | | ХАА-н чиглэлийн мэргэжилтэй төгсөгч | | 29 | |
| | | Барилгын чиглэлийн мэргэжилтэй төгсөгч | | 30 | |
| | | Үйлчилгээний чиглэлийн мэргэжилтэй төгсөгч | | 31 | |
| | | Боловсруулах үйлдвэрлэлийн мэргэжилтэй төгсөгч | | 32 | |
| | | Бусад чиглэлийн мэргэжилтэй төгсөгч | | 33 | |
| | Үйл ажиллагааны чиглэл | Хөдөө аж ахуй | | 34 | |
| | | Барилга | | 35 | |
| | | Үйлчилгээ | | 36 | |
| | | Боловсруулах үйлдвэрлэл | | 37 | |
| | | Бусад | | 38 | |
| | Бий болсон ажлын байрны тоо | | | 39 | |
| | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 40 | |
| | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт(мян.төг) | | | 41 | |
| | Санхүүгийн дэмжлэг эргэн төлж байгаа хүний тоо | | | 42 | |
| Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт | Аж ахуй эрхлэлтийн сургалт | Хамрагдсан төгсөгчдийн бүлгийн тоо | | 43 | |
| | | Хамрагдсан төгсөгчийн тоо | | 44 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 45 | |
| | | Сургалт зохион байгуулагчийн тоо | | 46 | |
| | | Үүнээс: | Сургалтын байгууллага | 47 | |
| | | | Бизнес инкубатор төв | 48 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 49 | |
| | Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт | Хамрагдсан төгсөгчдийн бүлгийн тоо | | 50 | |
| | | Хамрагдсан төгсөгчийн тоо | | 51 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 52 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 53 | |
| | | Хамрагдсан залуучуудын бүлгийн тоо | | 54 | |
| | | Хамрагдсан залуучуудын тоо | | 55 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 56 | |
| | | Зарцуулсан хөрөнгө(мян.төг) | | 57 | |
| | Борлуулалтын дэмжлэг | Борлуулалтын цэгийн тоо | | 58 | |
| | | Хамрагдсан төгсөгч, залуучуудын бүлгийн тоо | | 59 | |
| | | Хамрагдсан төгсөгч, залуучуудын тоо | | 60 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 61 | |
| | | | Төгсөгч | 62 | |
| | | | Залуучууд | 63 | |
| | | | Борлуулалтын цэгт хамрагдагч | 64 | |
| | | | Үзэсгэлэн яармагт хамрагдагч | 65 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 66 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийн нийт дүн | Хамрагдсан төгсөгч, залуучуудын бүлгийн тоо | | 67 | |
| | | Хамрагдсан төгсөгч, залуучуудын тоо | | 68 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 69 | |
| | | | Төгсөгч | 70 | |
| | | | Залуучууд | 71 | |
| | | Зарцуулсан хөрөнгө(мян.төг) | | 72 | |
| Бүгд | Хамрагдсан төгсөгч, залуучуудын бүлгийн тоо | | | 73 | |
| | Хамрагдсан хүний тоо | | | 74 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 75 | |
| | | Төгсөгч | | 76 | |
| | | Залуучууд | | 77 | |
| | Бий болсон ажлын байрны тоо | | | 78 | |
| | Нийт хөрөнгө (мян.төг) | | | 79 | |

**БАЛАНСЫН ШАЛГАЛТ:**

Мөр(22)=Мөр(1+10); Мөр(23)=Мөр(2+11); Мөр(24)=Мөр(3+12);Мөр(25)=Мөр(4+19+20);Мөр(67)=Мөр(43+50+54+59); Мөр(68)=Мөр(44+51+55+60); Мөр(69)=Мөр(45+52+56+61); Мөр(70)=Мөр(44+51+62); Мөр(71)=Мөр(55+63); Мөр(72)=Мөр(49+53+57+66); Мөр(73)=Мөр(22+26+67); Мөр(74)=Мөр(23+27+68); Мөр(75)=Мөр(24+28+69); Мөр(76)=Мөр(27+70); Мөр(77)=Мөр(23+71); Мөр(78)=Мөр(18+39); Мөр(79)=Мөр(25+40+41+72); Мөр(5)=Мөр(6+7+8); Мөр(27)=Мөр(29+30+31+32+33)>Мөр(28); Мөр(60)=Мөр(62+63)>Мөр(61);

НЭГТГЭЛ ГАРГАСАН: .................................. мэргэжилтэн ................................ .....................................

Гарын үсэг Нэр

ХЯНАСАН: ........................................................... дарга ................................................. ..................................

Гарын үсэг Нэр

ОГНОО: ........................

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

1. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан тайлант хугацааны мэдээллийг тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгож, сар бүрийн 28-ны дотор аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст маягт, эсвэл цахим хэлбэрээр ирүүлнэ.
2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс мэдээллийг дараа сарын 1-ний дотор Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар мэдээллийг нэгтгэн дараа сарын 3-ны дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлнэ.

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ... ОНЫ ...-Р САРЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

МАЯГТ ХЭДХ-4

<table>
<tr><th colspan="5">Хөтөлбөр/Арга хэмжээ</th><th>Мөрийн дугаар</th><th>Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, харьяа байгууллагын нэр</th></tr>
<tr><td rowspan="14"></td><td rowspan="14">Хөдөлмөрт бэлтгэх</td><td rowspan="7">Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хүнтэй харилцах, өөрийгөө ойлгуулах чадвар эзэмшүүлэх</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>1</td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>2</td><td></td></tr>
<tr><td>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</td><td>3</td><td></td></tr>
<tr><td>Ажил олоход хүндрэлтэй иргэн</td><td>4</td><td></td></tr>
<tr><td>Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд</td><td>5</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Сургалтын байгууллагын тоо</td><td>6</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө(мян.төг)</td><td>7</td><td></td></tr>
<tr><td rowspan="7">Сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, нийгэм, хамт олны дунд биеэ авч явах сургалт</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>8</td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>9</td><td></td></tr>
<tr><td>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</td><td>10</td><td></td></tr>
<tr><td>Ажил олоход хүндрэлтэй иргэн</td><td>11</td><td></td></tr>
<tr><td>Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд</td><td>12</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Сургалтын байгууллагын тоо</td><td>13</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө(мян.төг)</td><td>14</td><td></td></tr>
</table>

<table>
<tr><td rowspan="14"></td><td rowspan="14"></td><td rowspan="7">Ажлын байр, үйлдвэрлэлийн орчинтой танилцуулах, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны анхан шатны мэдлэг олгох, зөвлөгөө өгөх</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>15</td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>16</td><td></td></tr>
<tr><td>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</td><td>17</td><td></td></tr>
<tr><td>Ажил олоход хүндрэлтэй иргэн</td><td>18</td><td></td></tr>
<tr><td>Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд</td><td>19</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Сургалтын байгууллагын тоо</td><td>20</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө(мян.төг)</td><td>21</td><td></td></tr>
<tr><td rowspan="7">Нийт</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>22</td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>23</td><td></td></tr>
<tr><td>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</td><td>24</td><td></td></tr>
<tr><td>Ажил олоход хүндрэлтэй иргэн</td><td>25</td><td></td></tr>
<tr><td>Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд</td><td>26</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Сургалтын байгууллагын тоо</td><td>27</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө(мян.төг)</td><td>28</td><td></td></tr>
<tr><td rowspan="8"></td><td rowspan="8">Ажилд зуучлах</td><td colspan="3">Хамрагдсан хүний тоо</td><td>29</td><td></td></tr>
<tr><td rowspan="5">Үүнээс:</td><td colspan="2">Эмэгтэй</td><td>30</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Ажлын байранд зуучлагдсан хүн</td><td>31</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Хөтөч, дохионы хэлмэрч ашигласан хүн</td><td>32</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Хөтөч, дохионы хэлмэрч</td><td>33</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Хөтөч, дохионы хэлмэрчийн ажилласан цаг</td><td>34</td><td></td></tr>
<tr><td colspan="3">ТББ-ын тоо</td><td>35</td><td></td></tr>
<tr><td colspan="3">Зарцуулсан хөрөнгө (мян.төг)</td><td>36</td><td></td></tr>
<tr><td rowspan="10"></td><td rowspan="10">Эргэн төлөлтэй санхүүгийн дэмжлэг</td><td colspan="3">Хамрагдагсдын тоо</td><td>37</td><td></td></tr>
<tr><td rowspan="5">Үүнээс:</td><td colspan="2">Эмэгтэй</td><td>38</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Хөгжлийн бэрхшээлтэй иргэн</td><td>39</td><td></td></tr>
<tr><td colspan="2">ХБИ-ний асран хамгаалагч(эх, эцэг)</td><td>40</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Бүлэг</td><td>41</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Нөхөрлөл, хоршоо</td><td>42</td><td></td></tr>
<tr><td colspan="3">Бий болсон ажлын байрны тоо</td><td>43</td><td></td></tr>
<tr><td colspan="3">Зарцуулсан хөрөнгө (мян.төг)</td><td>44</td><td></td></tr>
<tr><td colspan="3">Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт(мян.төг)</td><td>45</td><td></td></tr>
<tr><td colspan="3">Санхүүгийн дэмжлэг эргэн төлж байгаа хүний тоо</td><td>46</td><td></td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг | Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг | Хамрагдагсдын тоо | | 47 | |
| | | | Үүнээс: | Эмэгтэй | 48 | |
| | | | | Хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИ | 49 | |
| | | | | Нөхөрлөл, хоршоо | 50 | |
| | | | | Бизнес инкубатор төвийн бойжигч | 51 | |
| | | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 52 | |
| | | Борлуулалтын дэмжлэг | Хамрагдсан ХБИ-ний тоо | | 53 | |
| | | | Үүнээс: | Эмэгтэй | 54 | |
| | | | | Борлуулалтын цэгт хамрагдагч | 55 | |
| | | | | Үзэсгэлэн яармагт хамрагдагч | 56 | |
| | | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 57 | |
| | | Нийт | Хамрагдсан хүний тоо | | 58 | |
| | | | Үүнээс: | Эмэгтэй | 59 | |
| | | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 60 | |
| | Аж ахуй эрхлэлтийн сургалт | Хамрагдсан хүний тоо | | | 61 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | | 62 | |
| | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн | | 63 | |
| | | | ХБИ-ний асран хамгаалагч | | 64 | |
| | | Сургалтын тоо | | | 65 | |
| | | Сургалт зохион байгуулагчийн тоо | | | 66 | |
| | | Үүнээс: | Мэргэшсэн сургагч багш | | 67 | |
| | | | Сургалтын байгууллага | | 68 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 69 | |
| | Хөдөлмөр эрхлэлтийн сургалт | Хамрагдсан хүний тоо | | | 70 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | | 71 | |
| | | | Ажлын байртай болсон хүний тоо | | 72 | |
| | | | Чадамжийн гэрчилгээ авсан иргэн | | 73 | |
| | | Сургалтын тоо | | | 74 | |
| | | Үүнээс: | Мэргэжлийн чадамж эзэмшүүлэх сургалт | | 75 | |
| | | | Үйлдвэрлэл дээрх сургалт | | 76 | |
| | | | Шавь сургалт | | 77 | |
| | | | Нэмэлт сургалт | | 78 | |
| | | Сургалт зохион байгуулагчийн тоо | | | 79 | |
| | | Үүнээс: | Мэргэшсэн сургагч багш | | 80 | |
| | | | Сургалтын байгууллага | | 81 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 82 | |
| | ХБИ-ийг дэмжих арга хэмжээний нийт дүн | Хамрагдсан хүний тоо | | | 83 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | | 84 | |
| | | Бий болсон ажлын байрны тоо | | | 85 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 86 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ажил олгогчийг дэмжих | Урамшуулал олгох | Хамрагдсан ажил олгогчийн тоо | | | 87 | |
| | | Ажлын байраар хангагдсан ХБИ-ний тоо | | | 88 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | | 89 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 90 | |
| | | Шинээр гэрээ байгуулсан ажил олгогчийн тоо | | | 91 | |
| | | Бий болох ажлын байрны тоо | | | 92 | |
| | Санхүүгийн дэмжлэг | Хамрагдсан ААНБ-ын тоо | | | 93 | |
| | | Үүнээс: | ААНБ | | 94 | |
| | | | ТББ | | 95 | |
| | | Ажлын байртай болсон хүний тоо | | | 96 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | | 97 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 98 | |
| | Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний нийт дүн | Хамрагдагсдын тоо | | | 99 | |
| | | Үүнээс: | Аж ахуйн нэгж байгууллага, ТББ-ын тоо | | 100 | |
| | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо | | 101 | |
| | | | Эмэгтэй | | 102 | |
| | | Бий болсон ажлын байрны тоо | | | 103 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 104 | |
| Бүгд | | Хамрагдсан хүний тоо | | | 105 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 106 | | |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо | | 107 | | |
| | Хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага, ТББ-ын тоо | | | 108 | | |
| | Бий болсон ажлын байрны тоо | | | 109 | | |
| | Бий болох ажлын байрны тоо | | | 110 | | |
| | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 111 | | |

**БАЛАНСЫН ШАЛГАЛТ:**

Мөр(22)=Мөр(1+8+15);Мөр(23)=Мөр(2+9+16);Мөр(24)=Мөр(3+10+17); Мөр(25)=Мөр(4+11+18);Мөр(26)=Мөр(5+12+19); Мөр(27)=Мөр(6+13+20); Мөр(28)=Мөр(7+14+21); Мөр(58)=Мөр(49+53);Мөр(59)=Мөр(48+54);Мөр(60)=Мөр(52+57);Мөр(83)=Мөр(22+29+39+40+58+61+70); Мөр(84)=Мөр(23+30+38+59+62+71);Мөр(85)=Мөр(31+43+72);Мөр(86)=Мөр(28+36+44+45+60+69+82);Мөр(99)=Мөр(87+88+93+96); Мөр(100)=Мөр(87+93);Мөр(101)=Мөр(88+96);Мөр(102)=Мөр(89+97);Мөр(103)=Мөр(88+96);Мөр(104)=Мөр(90+98); Мөр(105)=Мөр(83+101);Мөр(106)=Мөр(84+102);Мөр(107)=Мөр(24+29+39+49+53+63+70+101);Мөр(108)=Мөр(27+35+42+50+51+68+81+100); Мөр(109)=Мөр(85+103); Мөр(110)=Мөр(92);Мөр(111)=Мөр(86+104); Мөр(37)=Мөр(39+40+41+42)>Мөр(38); Мөр(47)=Мөр(49+50+51)>Мөр(48); Мөр(61)=Мөр(63+64)>Мөр(62); Мөр(74)=Мөр(75+76+77+78);

НЭГТГЭЛ ГАРГАСАН: .................................. мэргэжилтэн ................................ .....................................

Гарын үсэг Нэр

ХЯНАСАН: ............................................................ дарга .................................................. ...................................

Гарын үсэг Нэр

ОГНОО: ........................

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

1. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан тайлант хугацааны мэдээллийг тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгож, сар бүрийн 28-ны дотор аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст маягт, эсвэл цахим хэлбэрээр ирүүлнэ.
2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс мэдээллийг дараа сарын 1-ний дотор Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар мэдээллийг нэгтгэн дараа сарын 3-ны дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлнэ.

# МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ... ОНЫ ...-Р САРЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

МАЯГТ ХЭДХ-5

<table>
<tr><th colspan="4">Хөтөлбөр/Арга хэмжээ</th><th>Мөрийн дугаар</th><th>Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, харьяа байгууллагын нэр</th></tr>
<tr><td rowspan="14">Малчин өрхийг малжуулах арга хэмжээ</td><td rowspan="14">Мал худалдан авч өгөх</td><td colspan="2">Малчин өрхийн тоо</td><td>1</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Малчин өрхийн гишүүдийн тоо</td><td>2</td><td></td></tr>
<tr><td rowspan="2">Үүнээс:</td><td>15-59 насны иргэн (арга хэмжээнд хамрагдсан малчин)</td><td>3</td><td></td></tr>
<tr><td>Үүнээс: Эмэгтэй</td><td>4</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө (мян.төг)</td><td>5</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Дэмжлэгээр олгосон малын тоо</td><td>6</td><td></td></tr>
<tr><td rowspan="6">Үүнээс:</td><td>Хонь</td><td>7</td><td></td></tr>
<tr><td>Ямаа</td><td>8</td><td></td></tr>
<tr><td>Адуу</td><td>9</td><td></td></tr>
<tr><td>Үхэр</td><td>10</td><td></td></tr>
<tr><td>Тэмээ</td><td>11</td><td></td></tr>
<tr><td>Бог малд шилжүүлсэнээр малын тоо толгойн нийт дүн</td><td>12</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт(мян.төг)</td><td>13</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Санхүүгийн дэмжлэг эргэн төлж байгаа хүний тоо</td><td>14</td><td></td></tr>
<tr><td rowspan="8"></td><td rowspan="8">Аж ахуй эрхлэлтийн сургалт</td><td colspan="2">Хамрагдсан малчин өрхийн тоо</td><td>15</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Хамрагдсан малчны тоо</td><td>16</td><td></td></tr>
<tr><td>Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>17</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Сургалт зохион байгуулагчийн тоо</td><td>18</td><td></td></tr>
<tr><td rowspan="2">Үүнээс:</td><td>Сургалтын байгууллага</td><td>19</td><td></td></tr>
<tr><td>Мэргэшсэн сургагч багш</td><td>20</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Сургалтын тоо</td><td>21</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө (мян.төг)</td><td>22</td><td></td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Сургалт, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах** | Мал маллах арга ажиллагааны сургалт | Хамрагдсан малчин өрхийн тоо | | 23 | |
| | | Хамрагдсан малчны тоо | | 24 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 25 | |
| | | Сургалт зохион байгуулагчийн тоо | | 26 | |
| | | Үүнээс: | Сургалтын байгууллага | 27 | |
| | | | Мэргэшсэн сургагч багш | 28 | |
| | | Сургалтын тоо | | 29 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 30 | |
| | Бусад арга хэмжээ | Хамрагдсан малчин өрхийн тоо | | 31 | |
| | | Хамрагдсан малчны тоо | | 32 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 33 | |
| | | | Хашаа, хороо барих ажилд хамрагдсан малчин | 34 | |
| | | | Хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд хамрагдсан малчин | 35 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 36 | |
| | Туршлага солилцох уулзалт | Хамрагдсан малчин өрхийн тоо | | 37 | |
| | | Хамрагдсан малчны тоо | | 38 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 39 | |
| | | Зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо | | 40 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 41 | |
| | **Сургалт, уулзалтын нийт дүн** | Хамрагдсан малчин өрхийн тоо | | 42 | |
| | | Хамрагдсан малчны тоо | | 43 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 44 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.хүн) | | 45 | |
| **Бүгд** | Хамрагдсан малчин өрхийн тоо | | | 46 | |
| | Хамрагдсан малчны тоо | | | 47 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 48 | |
| | Нийт хөрөнгө (мян.төг) | | | 49 | |

**БАЛАНСЫН ШАЛГАЛТ:**

Мөр(42)=Мөр(15+23+31+37); Мөр(43)=Мөр(16+24+32+38); Мөр(44)=Мөр(17+25+33+39); Мөр(45)=Мөр(22+30+36+41)
Мөр(46)=Мөр(1+42); Мөр(47)=Мөр(3+43); Мөр(48)=Мөр(4+44); Мөр(49)=Мөр(5+13+45)
Мөр(6)=Мөр(7+8+9+10+11); Мөр(32)=Мөр(34+35)>Мөр(33); Мөр(2)>Мөр(3)>Мөр(4)

НЭГТГЭЛ ГАРГАСАН: .................................. мэргэжилтэн ................................. .......................................
Гарын үсэг Нэр
ХЯНАСАН: ........................................................... дарга .................................................. ..................................
Гарын үсэг Нэр
ОГНОО: .........................

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

1. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан тайлант хугацааны мэдээллийг тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгож, сар бүрийн 28-ны дотор аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст маягт, эсвэл цахим хэлбэрээр ирүүлнэ.
2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс мэдээллийг дараа сарын 1-ний дотор Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар мэдээллийг нэгтгэн дараа сарын 3-ны дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлнэ.

# АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ... ОНЫ ...-Р САРЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

МАЯГТ ХЭДХ-6

| Төсөл/арга хэмжээ | | | | Мөрийн дугаар | Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, харьяа байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|
| Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | Хамрагдсан ААНБ-ын тоо | | | 1 | |
| | Хамрагдсан ахмад мэргэжилтний тоо | | | 2 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 3 | |
| | | 45-54 нас | | 4 | |
| | | 55-64 нас | | 5 | |
| | | 65 ба түүнээс дээш нас | | 6 | |
| | | Зөвлөх үйлчилгээний төрөл | Боловсрол | 7 | |
| | | | Эрүүл мэнд | 8 | |
| | | | Хөдөө аж ахуй | 9 | |
| | | | Төрийн захиргаа | 10 | |
| | Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | | | 11 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 12 | |
| | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 13 | |
| Ахмад мэргэжилтний багийн зөвлөх үйлчилгээ | Хамрагдсан ахмадын ТББ-ын тоо | | | 14 | |
| | Хамрагдсан ахмад багийн тоо | | | 15 | |
| | Ахмадын багт ажилласан мэргэжилтний тоо | | | 16 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 17 | |
| | Ахмадын багийн зөвлөх үйлчилгээ авсан ААНБ-ын тоо | | | 18 | |
| | Үүнээс: Салбар | Мал аж ахуй | | 19 | |
| | | Газар тариалан | | 20 | |
| | | Боловсрол, шинжлэх ухаан | | 21 | |
| | | Эрүүл мэнд | | 22 | |
| | | Барилга | | 23 | |
| | | Зам, тээвэр | | 24 | |
| | | Уул уурхай | | 25 | |
| | | Бусад | | 26 | |
| | Ахмадын багийн зөвлөх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | | | 27 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | | 28 | |
| | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | | 29 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг** | Хамрагдсан ахмадын тоо | | 30 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | 31 | |
| | Бий болсон ажлын байр | | 32 | |
| | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 33 | |
| | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт(мян.төг) | | 34 | |
| | Санхүүгийн дэмжлэг эргэн төлж байгаа хүний тоо | | 35 | |
| **Бүгд** | Хамрагдсан ААНБ-ын тоо | | 36 | |
| | Хамрагдсан ахмадын тоо | | 37 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | 38 | |
| | | Ахмад мэргэжилтний тоо | 39 | |
| | Хамрагдсан ахмадын багийн тоо | | 40 | |
| | Ахмадын зөвлөх үйлчилгээнд хамрагдагсдын тоо | | 41 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | 42 | |
| | Бий болсон ажлын байрны тоо | | 43 | |
| | Үүнээс | Түр ажлын байр | 44 | |
| | | Байнгын ажлын байр | 45 | |
| | Нийт хөрөнгө (мян.төг) | | 46 | |

**БАЛАНСЫН ШАЛГАЛТ:**

Мөр(36)=Мөр(1+14);Мөр(37)=Мөр(2+16+30);Мөр(38)=Мөр(3+17+31);Мөр(40)=Мөр(15);Мөр(41)=Мөр(11+27);
Мөр(42)=Мөр(12+28);Мөр(43)=Мөр(39+32);Мөр(44)=Мөр(39); Мөр(45)=Мөр(32); Мөр(46)=Мөр(13+29+33+34);
Мөр(39)=Мөр(2+16); Мөр(2)=Мөр(4+5+6)=Мөр(7+8+9+10)>Мөр(3); Мөр(18)=Мөр(19+20+21+22+23+24+25+26)

НЭГТГЭЛ ГАРГАСАН: .................................. мэргэжилтэн ................................ .....................................

Гарын үсэг Нэр

ХЯНАСАН: ........................................................... дарга .................................................. ..................................

Гарын үсэг Нэр

ОГНОО: ........................

*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

1. Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан тайлант хугацааны мэдээллийг тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгож, сар бүрийн 28-ны дотор аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст маягт, эсвэл цахим хэлбэрээр ирүүлнэ.
2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс мэдээллийг дараа сарын 1-ний дотор Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар мэдээллийг нэгтгэн дараа сарын 3-ны дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ирүүлнэ.

# АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ... ОНЫ ...-Р САРЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

МАЯГТ ХЭДХ-6

| **Хөтөлбөр/Арга хэмжээ** | | | **Мөрийн дугаар** | **Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, харьяа байгууллагын нэр** |
|---|---|---|---|---|
| **Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг** | Хамрагдсан хүний тоо | | 1 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | 2 | |
| | Гадаадад ажиллаж амьдарч байгаад ирсэн иргэн | | 3 | |
| | Бий болсон ажлын байрны тоо | | 4 | |
| | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 5 | |
| | Үүнээс: | Гадаадад ажиллаж амьдарч байгаад иргэнд зарцуулсан хөрөнгө (мян.төг) | 6 | |
| | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт (мян. төг) | | 7 | |
| | Санхүүгийн дэмжлэг эргэн төлж байгаа хүний тоо | | 8 | |
| **Аж ахуй эрхлэлтийн сургалт** | Хамрагдсан хүний тоо | | 9 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | 10 | |
| | | Аж ахуй, бичил бизнес эрхлэгч | 11 | |
| | Сургалт зохион байгуулагчийн тоо | | 12 | |
| | Үүнээс: | Мэргэшсэн сургагч багш | 13 | |
| | Сургалтын байгууллага | | 14 | |
| | Бизнес инкубатор төв | | 15 | |
| | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 16 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг** | **Борлуулалтын дэмжлэг** | Борлуулалтын цэгийн тоо | | 17 | |
| | | Үүнээс: | Бизнес инкубаторын төв | 18 | |
| | | Нийт хамрагдсан хүний тоо | | 19 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 20 | |
| | | | Аж ахуй, бичил бизнес эрхлэгч | 21 | |
| | | | Борлуулалтын цэгт хамрагдагч | 22 | |
| | | | Үзэсгэлэн яармагт хамрагдагч | 23 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 24 | |
| | **Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг** | Ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөнд хамрагдагсдын тоо | | 25 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 26 | |
| | | | Аж ахуй, бичил бизнес эрхлэгч | 27 | |
| | | | Нөхөрлөл, хоршоо | 28 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 29 | |
| | **Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгийн нийт дүн** | Хамрагдсан хүний тоо | | 30 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 31 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 32 | |
| **Ажил олгогчийг дэмжих** | **Урамшуулал** | Ажил олгогчийн тоо | | 33 | |
| | | Ажлын байраар хангагдсан хүний тоо | | 34 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 35 | |
| | | | 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн | 36 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 37 | |
| | | Шинээр гэрээ байгуулсан ажил олгогчийн тоо | | 38 | |
| | | Бий болох ажлын байрны тоо | | 39 | |
| | **Санхүүгийн дэмжлэг (цалингийн дэмжлэг)** | Ажил олгогчийн тоо | | 40 | |
| | | Ажлын байраар хангагдсан хүний тоо | | 41 | |
| | | Үүнээс: | Эмэгтэй | 42 | |
| | | | Хорих ангиас суллагдсан иргэн | 43 | |
| | | | Асрамжаас газраас гарсан хүүхэд | 44 | |
| | | Зарцуулсан хөрөнгө (мян.төг) | | 45 | |
| | | Шинээр гэрээ байгуулсан ажил олгогчийн тоо | | 46 | |
| | | Бий болох ажлын байрны тоо | | 47 | |

<table>
<tr><td rowspan="4">Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний нийт дүн</td><td colspan="2">Ажил олгогчийн тоо</td><td>48</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Ажлын байраар хангагдсан хүний тоо</td><td>49</td><td></td></tr>
<tr><td>Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>50</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө (мян.төг)</td><td>51</td><td></td></tr>
<tr><td rowspan="9">Нийтийг хамарсан ажил</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>52</td><td></td></tr>
<tr><td>Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>53</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Байгалийн гамшигаас үүдэлтэй хор уршиг арилгах, нөхөн сэргээх</td><td>54</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн бүтээн байгуулалт, тохижилт</td><td>55</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Байгаль орчинг хамгаалах, цэвэрлэх, байгуулах, засварлах</td><td>56</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө (мян.төг)</td><td>57</td><td></td></tr>
<tr><td rowspan="3">Үүнээс:</td><td>Байгалийн гамшигаас үүдэлтэй хор уршиг арилгах, нөхөн сэргээх</td><td>58</td><td></td></tr>
<tr><td>Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн бүтээн байгуулалт, тохижилт</td><td>59</td><td></td></tr>
<tr><td>Байгаль орчинг хамгаалах, цэвэрлэх, байгуулах, засварлах</td><td>60</td><td></td></tr>
<tr><td rowspan="17">Цагийн ажилд зуучлах Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах</td><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>61</td><td></td></tr>
<tr><td>Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>62</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Ажилд зуучлагдсан хүний тоо</td><td>63</td><td></td></tr>
<tr><td>Үүнээс:</td><td>Их, дээд сургуулийн оюутан</td><td>64</td><td></td></tr>
<tr><td colspan="2">МСҮТ-ийн оюутан</td><td>65</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Ажил хайгч</td><td>66</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Хамрагдсан ажил олгогчийн тоо</td><td>67</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо</td><td>68</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө (мян.төг)</td><td>69</td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс:</td><td>Бүртгэл, мэдээллийн сан хөгжүүлэх</td><td>70</td><td></td></tr>
<tr><td>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх</td><td>71</td><td></td></tr>
<tr><td>Хөдөлмөрийн өдөрлөг яармаг</td><td>72</td><td></td></tr>
<tr><td>Явуулын хөдөлмөрийн бирж ажиллуулах</td><td>73</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Хамрагдсан хүний тоо</td><td>74</td><td></td></tr>
<tr><td>Үүнээс:</td><td>Эмэгтэй</td><td>75</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Хамрагдсан бүлгийн тоо</td><td>76</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Зарцуулсан хөрөнгө(мян.төг)</td><td>77</td><td></td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бүгд** | Хамрагдсан хүний тоо | | 78 | |
| | Үүнээс: | Эмэгтэй | 79 | |
| | Хамрагдсан ААНБайгууллагын тоо | | 80 | |
| | Бий болсон ажлын байрны тоо | | 81 | |
| | Үүнээс: | Байнгын ажлын байр | 82 | |
| | | Түр ажлын байр | 83 | |
| | | Цагийн ажлын байр | 84 | |
| | Бий болох ажлын байрны тоо | | 85 | |
| | Нийт хөрөнгө (мян.төг) | | 86 | |

**БАЛАНСЫН ШАЛГАЛТ:**

Мөр(30)=Мөр(19+25); Мөр(31)=Мөр(20+26);Мөр(32)=Мөр(24+29); Мөр(48)=Мөр(33+40); Мөр(49)=Мөр(34+41); Мөр(50)=Мөр(35+42); Мөр(51)=Мөр(37+45);
Мөр(78)=Мөр(1+9+30+49+52+61+74);Мөр(79)=Мөр(2+10+31+50+53+62+75); Мөр(80)=Мөр(14+15+28+48+67);Мөр(81)=Мөр(4+49+52+63+74);
Мөр(82)=Мөр(4+49);Мөр(83)=Мөр(52+74);Мөр(84)=Мөр(63); Мөр(85)=Мөр(39+47); Мөр(86)=Мөр(5+7+16+32+51+57+69+77)
Мөр(12)=Мөр(13+14+15); Мөр(25)=Мөр(27+28)>Мөр(26); Мөр(52)=Мөр(54+55+56)>Мөр(53); Мөр(57)=Мөр(58+59+60); Мөр(63)=Мөр(64+65+66);
Мөр(69)=Мөр(70+71+72+73)

НЭГТГЭЛ ГАРГАСАН: .................................. мэргэжилтэн ................................ .....................................
Гарын үсэг Нэр
ХЯНАСАН: ........................................................... дарга ................................................. ..................................
Гарын үсэг Нэр

ОГНОО: ........................

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, 2016 оны 4 дүгээр улирал




Үндэсний статистикийн хороо

# АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, 2016 оны 4 дүгээр улиралд

## Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (ХЭТ), хувиар




$$\text{ХЭТ} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн амын тоо}} \times 100$$

## Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ), хувиар




$$\text{АХОТ} = \frac{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн амын тоо}} \times 100$$

## Ажилгүйдлийн түвшин (АТ), хувиар




$$\text{АТ} = \frac{\text{Ажилгүй иргэдийн тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100$$

Эрэгтэй
Эмэгтэй
Бүгд

Үндэсний статистикийн хороо

## АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үндсэн салбараар, 2016 оны 4 дүгээр улиралд




Үндэсний статистикийн хороо

## АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллгааны салбарын ангиллаар, 2016 оны 4 дүгээр улиралд



## АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллгааны салбарын ангиллаар, 2016 оны 4 дүгээр улиралд



## АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллгааны салбарын ангиллаар, 2016 оны 4 дүгээр улиралд




Үндэсний статистикийн хороо

## АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллгааны салбарын ангиллаар, 2016 оны 4 дүгээр улиралд




Үндэсний статистикийн хороо